

САТАНЫ УРХИ НОМЫН БЭСТСЭЛЛЭР ЗОХИОЛЧ

ЖОН БИВЭР



ХҮНДЭТГЭЛИЙН ШАГНАЛ

Мартагдсан чанарын
хүчийг тайлахуй

Эрхэм найз минь

Хэдийгээр хүндэтгэл нь Хорин нэгдүгээр зуунд устах шахсан чанар боловч, агуулга нь биднийгээ хөдөлгөх хүчтэй хэвээрээ л байна. Кинон дээрх хүндэтгэлтэй үйл хэрэг нь урам зориг, золиосыг харуулж, биднийгээ мэлмэрүүлдэг ч, өнөөдөр бидний амьдралд зориулсан Бурханы төлөвлөгөөг бүрэн эхээр нь хүлээн авахуйн амин түлхүүр хаана байна?


Хүндэтгэл нь аугаа шагнал тээдэг. Бурханы танд өгөхийг хүсдэг шагналыг. Үлэмж мартагдсан энэ үнэмлэхүйг цоо шинээр ухаарахуй нь таныг Бурханы амьдралд тань томилон, зэхсэн бүхнийг хүлээн авах байр суурин дээр гаргана.

Та ойлголтоор дамжуулан хүндэтгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхдээ Бурханы үнэлэмжийн системийг ойлгон, хүндэтгэл хүлээсэн юм болгоны Зохиолч - Бурханы зүрхэнд илүү ойрхон байр суурин дээр гарна.

MessengerX.com дээрх бүхий л мултимедиа материалыг өөрөө ч судлаж, өрөөлтэй ч хуваалцаарай.

Амьдралаа үйлдлээр цэнэглэж, дотоод аугаа чанараа сэрээ!

Таны анд нөхөр



MessengerX.com

Жон Бивэр

JohnBevere@gmail.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Христэд итгэдэг хүмүүсийн зүрхнээс халих ёстой энэ чанарыг Бурхан ямар өндрөөр үнэлдгийг Хүндэтгэлийн шагнал номоос ямар ч эргэлзээгүй сурахаар байна.

— Жойс Мейер

Хүндэтгэлийн шагналыг уншиж дуусгасан хойноо библийн соён гэгээрүүлэгч багш, уран чадварлаг зохиолч Жон Бивэрийг өөрийг нь гүнээ хүндэтгэх сэтгэл төрж байна. Жон хүндэтгэлийг зүрхний асуудал хэмээгээд, уншигчийг хүний төрөл бүрийн харилцааг хамарсан их аялалд дагуулан, бидний хүн нэг бүрийг элбэг шагнал бүхий, энэхүү сүнсний зарчмыг тусган харуулсан арга замаар амьдрахыг уриалан дууджээ.

— Брайн Хьюстон

Хүндэтгэлийн шагналыг уншаад, чуулган, гэрлэлт, гэр бүл, бизнест эн тэгш хүчтэй нөлөөлөх сонгодог их бүтээлтэй учирсан мэт санагдана. Энэ болбоос энэ болоод ирэх амьдрал дахь дэвшил, таалал, амжилтыг тайлах түлхүүр болой. Яриангүй Жон Бивэрийн хамгийн том бүтээл.

— Женцен Франклин

ЖОН БИВЭР



**ХҮНДЭТГЭЛИЙН
ШАГНАЛ**

ЖОН БИВЭР



ХҮНДЭТГЭЛИЙН ШАГНАЛ

**Мартагдсан чанарын
хүчийг тайлахуй**

Honor's Reward, (Mongolian), by John P. Bevere
© 2021 Messenger International
MessengerInternational.org
Originally published in English as *Honor's Reward*
ISBN 978-1-937558-22-2 (paperback edition)
ISBN 978-1-937558-23-9 (electronic edition)

Additional resources in (Mongolian) are available for
free download and video streaming at
MessengerX.com and on the **MessengerX app**

To contact the author: JohnBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is
NOT FOR SALE

Printed in Mongolia

Хүндэтгэлийн шагнал: Мартагдсан чанарын хүчийг тайлахуй
(Монгол хэлээр), Жон Бивэр
© 2021 Мессенжер Интенэйшнэл
MessengerInternational.org
Номын англи хэр: Honor's Reward
ISBN 978-1-937558-22-2 (цаасан ном)
ISBN 978-1-937558-23-9 (цахим ном)

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа
MessengerX.com болон **MessengerX app** -аас
шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиогчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com
Энэхүү ном нь Мессенжер Интенэйшнэл байгууллагаас Монголчууддаа өгч буй
бэлэг.
ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries.
Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

АГУУЛГА

- 1 Шагнал 11
 - 2 Тал шагнал авах ба огт шагналгүй хоцрох 21
 - 3 Бүрэн шагнал 31
 - 4 Удирдагчаас нэг их хамааралгүй 41
 - 5 Эрх мэдэл 51
 - 6 Харгис ширүүн эрх мэдэл 57
 - 7 Төр засгийн удирдагч нарыг хүндэтгэх 77
 - 8 Олон нийтийн удирдагч нарыг хүндэтгэх 91
 - 9 Нутгийн удирдагч нараа хүндэтгэх 101
 - 10 Чуулганы удирдагч нарыг хүндэтгэх 117
 - 11 Давхар хүндэтгэл 133
 - 12 Найз нөхдөө хүндэтгэх 151
 - 13 Хариуцаж авсан хүмүүсээ хүндэтгэх 163
 - 14 Гэр бүл доторх хүндэтгэл - хүүхдүүд 177
 - 15 Гэр бүл доторх хүндэтгэл - гэргий 189
 - 16 Бүгдийг хүндэтгэ 201
 - 17 Бурханыг хүндэтгэхүй 209
- Хавсралт 223

Шагнал

Хүндэтгэл. Хэдийгээр энэ нь Хорин нэгдүгээр зууны бараг л мартагдсан дууль болох шахсан ойлголт боловч, биднийг хөдөлгөх хүчтэй хэвээрээ л. Кинон дээрх хүндэтгэл бүхий үйл хэрэг нь урам зориг, золиост үзүүлбэрээрээ биднийг мэлмэрүүлдэг. Үе үеийн хамгийн том блокбастерын үйл явдал дунд хүндэтгэл заавал шингээгдсэн байдаг. Бид ч үүнийг нь алга ташин тэмдэглэдэг. Тэгвэл өдөр тутмын амьдралд маань хүндэтгэл хаана байна? Хүндэтгэл нь энгийн амьдралаас л үнэртэх ёстой гэдэг ойлголт энэ үеийнхэний хувьд харь ухамсар болжээ.

Бурханы хөвгүүд, охидын дотор хүндэтгэл сэрэхийг би хармаар байна. Энэ нь Бурханаас хүлээж авахуйн гол түлхүүр бөгөөд яг энэ шалтгаанаар бидний сэтгэл хүндэтгэлийг ойлгоод байдаг хэрнээ жинхэнэ хүчийг нь гээгдүүлжээ. Хүндэтгэл нь аугаа шагналтай. Бурханы танд өгөхийг хүсдэг шагналтай. Хүндэтгэл нь таны амьдралыг үлэмж чадваржуулах хүчтэй.

Та яг одоо хүндэтгүүштэй юм болгоны Эх зохиолч - Бурханы зүрх рүү хийх аянд гарах гэж байна. Эдгээр илчлэл бүхий үнэн амьдралд чинь гүнээ бөгөөд бодитой арга замаар нөлөөлөхийн төлөө залбиръя. Олон хүн энэ хичээлийг хождоо сонсдог. Ингэхгүйн тулд элч Иохан:

Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна. (2Иохан 1:8)
хэмээжээ.

Иохан энэ үгийг бараг зуун насалж, зургаадай таяг тулаад байхдаа бичжээ. (*Clarke's commentary*, Abingdon Press (1977) - Accordance 6.6). Тэрбээр хүнд хүчир замаар сурсан сургамжаа өнөөгийн бидний тусын тулд өгүүлрүүн. Урт удаан, сайн сайхан насыг элээсэн эрчүүд, эмэгтэйчүүдийн амьдралаар амьдарсан нь Иоханы давуу тал байв. Энэ нь амьдралын дуудлага дотроо итгэмжтэйгээр явсаар, миний *Өвгөдийн тосолгоо* гэж нэрлэдэг цэг дээрээ буюу зогсоол дээрээ хүрэх явдал юм. Ийм хүмүүсийг үг хэлэх үед ухаантай хүн сонсдог.

Би ч амьдралдаа ийм эрчүүд, эмэгтэйчүүдтэй олонтаа золгож явсан. Тэдгээр элчин сайдууд амьдралаа сайхан элээсэн, эргэж хараад юу хэлэхээ мэддэг улс ажээ. Боловсорсон ахмадууд маань өөртөө тодорхой чадварыг хөгжүүлсэн байдаг бөгөөд энэ номоороо бид гурвыг нь авч хэлэлцэнэ. Нэгдүгээрт - тэд асуудлын амийг нь олж хэлдэг. Тэд ус цавчих юмуу хэрэгцээгүй юмстай зууралдахгүй. Хоёрдугаарт - тэд цөөхөн үгтэй. Гуравдугаарт - тэдний сонгож хэлдэг үг нь жинтэй. Тэр хүмүүсийн ховор үзэгдэл гэж хэлж болох харилцаа нь тийм ч удаан, тийм ч олигтойхон амьдраагүй хүний амнаас гардаг ижил үгээс хавьгүй даацтай. Боловсорсон ахмадуудтай хэсэгхэн ярилцсаныхаа дараа би тэдний ганц, хоёрхон үгийг л хэдэн сараар тунгаан бясалгадаг сан.

Ингэж үзбэл, элч Иохан нүсэр үг хэлжээ. Үнэндээ би түүний энэ онгодтой үгийг олон жил тунгаан бодсон бөгөөд доторх илчлэл нь улам л задарсаар байх юм. Үнэндээ Иоханы үгээс үүдэж, бүхэл бүтэн хоёр ном төрсөн бөгөөд нэг нь *Өнө мөнхөөр хөтлөгдөхүй* ном маань билээ. Тэгэхээр, Иоханы үгийг өгүүлбэр, өгүүлбэрээр нь задалж үзье.

Өв хөрөнгөө бүү алдаарай

Иохан “...өөрсдийгөө хяна” хэмээв. Тэрбээр бидний хүн нэг бүрийг *өөрийгөө анхаарч, шалгаж, сэрэмжтэй байхыг* урамшуулжээ. Энэ тушаал нь түүний үг нь хөнгөн хандалгүй, харин нягт нарийн эргэцүүлэх ёстой үг болохыг илтгэх.

Хүнд хүчир хөдөлмөрлөж байж олж авсан зүйлээ алдахгүйн тулд нарийн анхаарах ёстой аж. Бид хүнд хүчир хөдөлмөрлөж олж авсан зүйлээ алдаж болзошгүй гэхээр... жаахан аймаар. Тухайлбал фермер талбайгаа цэмцийлгэж. Өдөржин халуун наранд бөгтөлзөн, ургацад саад хийх чулуу, хожуулын хогоос хөрсөө сайхан цэвэрлэв. Цэвэрлэж

дуусаад, хөрсөө давтан боловсруулж, үрээ суулгахад бэлэн болгоно. Талбай дүүрэн үрээ суулгаж дуусаад, дараа нь түүнийгээ сайхан ургац болгож цэцэглүүлэх төгс нөхцлөөр хангахын төлөө бордож, шарилжийг нь зулгааж, усална. Ургац цухуйхад, фермер маань талбайгаа хортон, гай гамшгаас хамгаалан хөдөлмөрлөсөөр л байна. Тэгтэл ургацаа хураахад хэдхэн долоо хоног дутуу байтал, фермер маань ядраад, буугаад өгчээ. Эцсийн энэ мунхаг шийдвэрээсээ болоод фермер ургацаа тэр чигээр нь алдаад, бүх хөдөлмөр нь тэглэв. Эсвэл цаг агаарын онц аюултай үзэгдэл болохыг урьдчилан сэрэмжлүүлсээр байтал, фермер маань мэдсээр байж үл тоон, хариу арга хэмжээ авалгүй, ургацаа тэр чигээр нь алдчихсан ч байж болох. Хичнээн ухаарлаа гээд тэр их цаг, мөнгө, хөдөлмөр, эх үүсвэр хэдийнээ хайран болжээ.

Эсвэл компаниа босгох гэж олон жил морь, нохой мэт зүтгэсэн атлаа адаг дээрээ хэдхэн буруу шийдвэр гаргаад л дампуурсан бизнесмэн горьгүй бус уу? Мөн л эмгэнэлтэй. Аль, аль жишээн дээр нь ганцхан буруу сонголтын урхагаар л тэр их хүчин зүтгэлийн ач тус талаар болж байна.

Тиймээс л Бичээс биднийг амьдралаа сайн дуусгахыг ахин дахин урамшуулдаг буюу: “...эцсээ хүртэл тэссэн нь...” (Матай 10:22, 24:13, Марк 13:13). Мөн “Учир нь бид итгэлийнхээ эхлэлийг *эцсээ хүртэл* бат сахиваас Христийн хуваалцагчид болсон байна” (Еврей 3:14), “Ялагч ба үйлсийг минь *эцэс хүртэл* хамгаалагсдад Би үндэстнүүдийн дээгүүрх эрх мэдэл өгнө” (Илчлэл 2:26, тодруулгыг нэмэв) гэх зэргээр бичээс хөвөрнө. Христэд итгэх итгэл нь спринт гүйлт бус, харин холын зайны гүйлт юм. Тиймээс уралдаанаа хэрхэн эхлэх нь бус, хэрхэн дуусгах нь л тооцогдоно. Харин хэрхэн дуусгаах бид гаргах шийдвэр бүрээрээ шийдвэрлэх бөгөөд шийдвэр маань бидний амьдралын явцсын дунд хэлбэршин бий болсон үлгэр загвар байдаг.

Амьдрал шийдвэрлэх эгшин

Нэг хүүд маань ийм нэгэн явдал тохиолдов. Хүү маань аавынхаа таашаагаагүй нэг юмыг хийхийг хүсэв. Тэрбээр миний байр суурийг мэдэж байсан ч, өөрөө шийдвэр гаргах насандаа хүрсэн гэж үзсэн тул эцсийн шийд өөрийнх нь л гарт байлаа.

Цаг хугацаа өнгөрсөөр, хүү маань миний зөвлөгөөг сөрсөн шийдвэр гаргасныг би олж мэдэв. Хожим бид хоёр хүүгийнхээ сонголтын

талаар суугаад ярилцлаа. Би “Миний хүү өөрөө л шийдэх байсан. Аав нь яахав, чамайг сургамж аваасай л гэж хүссэн. Одоо би чамд нэгэн бодит түүх ярьж өгье” гэв.

“Эртээ урьдад Рехобоам гэдэг залуу хаан байжээ. Түүнийг хаан ширээнд залраад удаагүй байтал, албатууд нь асуудал дэгдээв: “Аав тань ард бидний зоо нуруун дээр тэгнэсэн шахан шаардлагаараа амьдралыг маань зовлон болгов. Хаантан та, бидний ачаа дарамтыг хөнгөлбөөс, бид таны төлөө инээгээд л зүтгээд байя.”

Залуу хаан ард иргэддээ хэд хоногийн дараа ирж, шийдийг маань хүлээн аваарай хэмээв. Гэтэл хаанд аавынх нь зөвлөх: “Та энэ хүмүүсийн зарц болж, хэрэгцээг нь бодолцож, сэтгэл гарган хариулж, гар нийлэн ажиллабаас, эцэстээ тэд таны төлөө юу ч хийхээс буцахгүй болно” хэмээн айлдруун (1Хаад 12:7, ЭмЭсЖи Библи).

Сайн бөгөөд ухаалаг зөвлөгөө байсан ч, залуу хаан мэргэдийн зөвлөгөөг үл ойшоон, үеийн нөхөддөө хандав. Тэгтэл нөхөд нь: “Аав тань бидэнд хэт хатуурхлаа, хөнгөлж аль” гэж гоншигнох тэр хүмүүст хэл: “Миний чигчий аавын маань бэлхүүсээс ч бүдүүн. Аавын маань дор амьдрахын аргагүй хатуу байсан гэж бодож байвал, та нар юм үзээгүй байна. Аав маань та нарыг ташуураар ороолгосон бол, би цусыг чинь гинжээр урсгана!” (10-11, ЭмЭсЖи Библи).

Залуу хаан Рехобоам үеийн нөхдийнхөө эмгэлэнт үр дагавартай зөвлөгөөг даган биелүүлэв. Соломон эцгийнх нь байгуулсан хаант улсын зургааны тав нь Рехобоамын төмөр нударга дор үйрч, Израилийн арван овог нь үүрд задран алга болба. Рехобоам ганц мунхаг шийдвэрийнхээ төлөөсийг насаараа төлжээ.”

Дараа нь би хүүдээ: “Цааш нь харцгаая. Магадгүй ханхүү Рехобоам болоод түүний нөхөд эцэг Соломоныхоо ч, цэцэд мэргэдийнхээ ч зөвлөгөөг далдуур басамжлан, эсэргүүцэж байсан байх. Магадгүй тэд хаадын лавриндаа дарстай хундагаа өргөн хөхрөлдөж, үгүй мөн элэрч баларсан зөвлөгөө еэ хэмээн элэглэж байсан байх. Рехобоамын толгойд: *Ханхүү байхдаа амар тайвныг сахиад, амаа үдье. Харин хаан болохоороо хөгийн өвгөчүүлийг сонсохгүй* гэсэн өгөр бодол байсан байх. Тэрбээр ханхүү байхдаа, мэргэдийн ухааныг сонсохгүй байлаа гээд, алдах юм багатай байж. Гэхдээ тэрбээр ийм загвар тогтож, нэг л өдөр өөрийгөө ухаантай хэмээн сэтгэв ч, мунхарсан байхаа ухаарсангүй. Түүний амьдралыг шийдвэрлэх эгшин тулахад, тэрбээр ухаалаг шүүхийг гүйцэтгэхэд шаардлагатай үлгэр загвараар дутах байв” гэлээ.

Тэгээд цааш нь: “Хүн бүрт амьдрал *шийдвэрлэх эгшин гэж бий*. Тэдгээр нь яг л нээлттэй ном шиг шалгалт байх бөгөөд бид ч энэ бүхнийг өнгөртөл шалгуулснаа мэдэхгүй. Миний хүү, аавынхаа зөвлөгөөг сонсохгүй байхаар шийдэж. Энэ удаа чи төлөөс ч төлсөнгүй. Гэвч хэзээ нэг өдөр амьдрал шийдвэрлэх эгшин тулах л болно. Чи мэргэн зөвлөгөөнд чих тавих үлгэр загварыг хэдийнээ хөгжүүлсэн байвал, цаанаасаа л зохих ёсоор үйлдэж, эцэстээ аугаа шагнал хүртэнэ” гэж хэлэв.

Манай хүүг түр орхиод, өөр нэгэн жишээ үзье. Израилийн хүүхдүүд Бурханы Үгийг өөрийн болгох үлгэр загвар хөгжүүлээгүй ажээ. Бурхан тэднийг хүлээснээс чөлөөлсөн ч, тэд ахин дахин гомдоллож, дуулгаваргүй загнасаар байжээ. Заримдаа ч энэ авир үйлдэл нь гай барцад багатай өнгөрч, заримдаа нэг их нөлөөгүй шахам өнгөрч байв. Гэвчиг, явцын дунд үлгэр загвар хэлбэршин тогтов. Эцэстээ *амьдрал шийдвэрлэх эгшин ч* тулав. Бурханы тэдэнд зориулж тусгаарласан Канаан гэдэг нутгийг тандуулахаар арван хоёр туршуулыг илгээхээр болжээ. Туршуулууд нь эргэж ирээд, сөрөг мэдээ гонгинон дуулгахад, ард түмэн бүгдээрээ дагалдан, урьдынх шигээ гомдол гаргасан бөгөөд энэ удаа тэд ингэснийхээ төлөө өндөр төлөөс төлөв. Тэд Амлагдсан газартаа хэзээ ч ороогүй бөгөөд үлдсэн амьдралаа хэрэн тэнүүчилж л өнгөрөөжээ. Тэд эзлэхээр хүчин зүтгэсэн бүхнээ ганцхан эгшинд л алдав. Тэр алдагдлыг буцаах боломжгүй. Бурхан тэдэнд газрыг амлаад байтал, Израильчууд яг л өөрөөсөө авахуулаад үеийн үед арван овгоо нэг мөр алдсан Рехобоам шиг Бурханы амлалтаас зуураагүй юм.

Үүнээс хөгшид, хүүхэд гэлтгүй нэгэн сургамж авах ёстой: Бид Бурханыг зүгээр нэг дагахыг хүсэх бус, харин зүрхийг нь олзолж авах хэрэгтэй. Тэр цагт л бид Бурханы удирдамжийг хориг, хууль гэж харалгүй, цаад цэц ухааныг нь үзэх болно. Залуу ханхүү Рехобоам аавынхаа юмуу мэргэдийн зүрхийг хэзээ ч өвлөөгүй. Израилийн хууч үеийнхэн үнэндээ Бурханы үйлдэж буй зүйлийг ч хараагүй, тэдэнд хандах Бурханы сайхан сэтгэлийг ч үзээгүй бөгөөд бүх юмаа алдсан.

Тэгэхээр, одоо зоосны нөгөө талыг үзье. Бичээс дээр Бурханы зүрхийг халыг үзээд, ухаалаг шийдвэр гаргах үлгэр загвар хөгжүүлсэн хувь хүмүүсийн жишээ байдаг. Тэгээд мөнөөх *амьдрал шийдвэрлэх эгшин* ажиг сэжиггүй ирэхэд, тэд зөв зүйтэй хариу үйлдэн, аугаа шагнал хүлээн авсан байдаг.

Хүчин зүтгэлээ талаар болгохгүй байх хамгийн энгийн арга зам нь Бурханы зөвлөгөөг цаг үргэлж хүндэтгэдэг үлгэр загварыг тогтоох

явдал болой. Бидэнд өдөр бүр, алхам тутамд маань шийдвэр гаргах боломж ирдэг. Харин өнгөрсөн хойно нь л бид эргэж хараад, чухам аль нь амьдрал шийдвэрлэх шийдвэр байсныг нь мэддэг ч, бурханлаг үлгэр загварыг хөгжүүлэн бий болгосон хүн хэзээд үүнийгээ л дагасаар, эцэстээ шагналаа авдаг.

Шагнал

Энэ сэдэв биднийг Иоханы дараагийн санаа дээр авчирч байгаа бөгөөд бүгдээрээ тус эшлэлийг бүрэн эхээр нь үзье: “Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин *дүүрэн шагналыг* хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна.”

Тэр *Шагнагч* (Еврей 11:6).

Энэ бол бидний гүн зүрхэндээ байгуулах ёстой үнэн болой. Үнэндээ Бурхан шагнах дуртай. Бурхан Өөрийгөө Абрахамд хэн гэж танилцууллаа? “Абрам аа, бүү ай! Бамбай чинь Би тул шагнал чинь агуу их (Би *чиний үлэмж аугаа шагнал*)” (Эхлэл 15:1, тодруулгыг нэмэв).

Бурхан “Би чиний ... *үлэмж аугаа шагнал*” хэмээжээ. Пөөх, Аугаа хүчирхэг Бурхан Өөрийгөө ингэж л танилцуулдаг байх нь! Дуулал 19:9-11 “ЭЗЭНээс эмээхүй нь цэвэр, Мөнхөд оршдог. ЭЗЭНий шүүлтүүд үнэн Бүгд зөв шударга. ... *Тэдгээрийг сахин биелүүлснээр Агуу их шагнал байдаг*” гэжээ (тодруулгыг нэмэв). Дуулал 57:2 дээр “Би Хамгийн Дээд Бурханд, Миний төлөө зорилгоо биелүүлдэг (Миний төлөө үйлдэж, *намайг шагнадаг*) Бурханд хашхирна” гэжээ (тодруулгыг нэмэв).

Бурхан шагнагч бөгөөд хүүхдүүдээ шагнах дуртай! Дөрвөн хүүтэй аав хүнийхээ хувьд би энэ таашаалын амтыг олж мэдсэн шүү. Хөвгүүдийн маань сайн сонголт хийж, шагнуулсныхаа гэрэлд ээгдэж, сэтгэл дүүрэн байгааг нь үзэх шиг сайхан юм үгүй. Гэхдээ муу зан авирыг шагнах нь бас ухаалаг бус гэдгийг би бас сурсан. Та зохисгүй юмуу гавъяагүй хүнийг шагнаснаараа, тэмүүллийн хүчийг устгах бөгөөд харин тэмүүлэл нь сайн зүйл болой. Аав нь тэдэнд хайртайг хөвгүүд минь мэддэг ч, том болох явцдаа тэд маань миний хайр, тааллыг ялгаж мэддэг болсон билээ. Бурхан биднийг үнэн голоосоо хайрладаг ба Түүний хайр төгс. Тийм боловч, заримдаа Бурхан бидний үйлдэл юмуу сонголтыг нэгээхэн ч таалахгүй байх үе бий. Бурхан таалснаа

буюу Өөрийнх нь зөвлөгөөнд анхаардгийг шагнадаг.

Иохан “...*дүүрэн шагналыг* хүлээн авахын тулд...” гэсэн байгааг тэмдэглээрэй. Энэ мэдэгдэл дээр тунгаах аваас, *дүүрэн (бүрэн)* гэдэг үг товойн тодорч байна. Тэгээд би бодлоо: *Бүрэн шагнал гэж байгаа болохоор, тал шагнал бас огт шагналгүй хоцрох нөхцөл байдаг байх нь.* (Энд авралын тухай бус, харин шагналын тухай ярьж байгааг санаарай). Тэгээд цааш нь тунгаагаад, Иоханы үг хоёр янзын хэрэгжилттэй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Эхнийх нь Христийн шүүх сэнтий. Паул: “Бид урамтай байдаг бөгөөд биеэс хол, Эзэнтэй ойр байхыг илүүд үздэг” (2Коринт 5:8) хэмээн мэдэгдсэн.

Паул хүн төрөлхтөнд хандаж хэлээгүй болохыг бид шууд мэдэхээр байна. Учир нь итгэдэггүй хүн биеэ орхихдоо, Эзэнтэй хамт байх бус, харин тамд байна. Хатуу сонсогдож болох ч, энэ бол үнэн. Есүс дэлхийг яллахаар манай дэлхийд ирээгүй юм. Харин ч эсрэгээрээ - аврахаар ирсэн буюу. Биднийг мөнхийн үхэлд худалдчихсан Адамаас болж дэлхий хэдийнээ ялагдсан (Иохан 3:17-18). Гагцхүү Есүс амьдралаа бүрэн зориулж, Есүсийг хүлээж авсан хүмүүс л газрын биеэ орхих цагтаа Эзэнтэй хамт байх болно. Паул итгэгч хүмүүст цааш нь ингэж хэлжээ:

Тиймд ойр ч, хол ч Түүнд таалагдах нь бидний эрмэлзэл билээ. Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой (2Коринт 5:9-10).

Итгэгч хүн бүр Христийн шүүх сэнтийн өмнө зогсох болно. Тэр өдөр итгэдэг хүн бүр газар дээрх зуурдын амьдралдаа юу хийснээрээ л хариугаа хүлээн авна. Гүүд Ньюс Транслэйшн дээр “Бидний хүн нэг бүр зохистойгоо л хүлээн авна” гэж мэдэгддэг. Нүгэл маань шүүгдэхгүй. Учир нь Есүсийн цус нүглийг дагалдах мөнхийн шийтгэлийг сөнөөсөн. Оронд нь бид итгэгч хүнийхээ хувьд хийснийхээ дагуу, нэг бол шагнуулна эсвэл алдагдал хүлээнэ. Үйлс, үг, бодол, тэр бүү хэл сэдэл маань ч Бурханы Үгийн гэрлээр шалгагдах болно. Бидний амьдралаа байгуулсан зуурдын юмс нь алдагдсан боломжийг дагуулах бол, бидний амьдралаа байгуулсан мөнхийн зүйлс нь мөнхийн шагнал дагуулна (1Коринт 3:14-15).

Гарз хохирол үзэх, шагнуулах нь гал дундуур гарахдаа хамаг байдгаа залгиулаад, өөрөө амь мөлтөс аврагдахаас авахуулаад Есүстэй өнийн

мөнхөд зэрэгцэн захирах өндөрлөгт гарах хүртэл янз бүрээр төрөлжих аж (1Коринт 3:15; Илчлэл 3:21). Олон янзаар төрөлжиж байна. Эхлээд бүгдээрээ “шагналгүй хоцрох” жишээг үзье. Дараагаар нь “бүрэн шагналын” үйл явдал болно. Тал шагнал нь энэ хоёр туйлын дундуур хавьцаа орж ирнэ.

Шүүх сэнтийн тогтоолыг “мөнхийн шүүх” (Еврей 6:1-2) гэдэг бөгөөд энэ нь тус тогтоолд ямар нэгэн засвар, нэмэлт өөрчлөлт, өөрчлөлт байхгүй гэсэн үг. Тиймээс, бид Христийн загалмайд итгэх эсэхээрээ өнө мөнхийг хаана өнгөрөөхөө шийдэх бол, Христэд итгэсэн хойноо хэрхэн амьдарснаараа өнө мөнхийг хэрхэн өнгөрөөхөө шийдэх нь гэж дүгнэж болохоор байна.

Тэгэхээр, мөнхийн шүүх, шагналын талаар Бичээс юу гэж хэлдгийг няхуур судлах нь ухаалаг буюу. Энэ мэдлэгийг Христийн хамгийн энгийн буюу суурь сургаал гэдэг. Бага сургуульд хүний бүхий л боловсролын тоосгоор унших, бичих, тоо бодох зэрэг ерөнхий эрдмийн суурийг тавьдаг. Уншиж, бичиж, нэмж, хасч мэдэхгүйгээр ахлах сургууль, коллежийн боловсрол олох гэж байна гээд төсөөлж байна уу? Боломжгүй. Гэтэл маш олон итгэгч хүн Христийн сургаалын хамгийн энгийн мэдлэггүйгээр Христэд итгэх итгэлээ байгуулах гэж оролддог. Энэ шаналан намайг *Өнө мөнхөөр хөтлөгдөхүй* номыг бичихэд хүргэсэн бөгөөд би танд энэ сэдвээр нарийвчлан өгүүлсэн тус номыг *Хүндэтгэлийн шагнал* номтойгоо хавсран уншихыг санал болгож болно.

Энэ амьдрал

Бид Шүүх сэнтий дээр шагналын амлалтыг тээдэг бурханлаг үлгэр загварыг тогтоосон. Гэхдээ тэдгээрийн ерөөл нь бидний энэ амьдралд ч давхар нөлөөлдөг юм. “Харин *одоогийн болон ирэх амийн төлөөх* амлалт бүхий итгэл сүсэг нь бүх зүйлд тустай” (1Тимот 4:8, тодруулгыг нэмэв).

Бид зөвлөгөөнд нь анхаарбаас, Бурхан Аав маань биднийг энд ч, тэнд ч шагнахыг хүсдэг ажээ. Бидэнд “Зөвт нь хүртэх ёстойгоо газар дээр хүртдэг бол Буруут хийгээд нүгэлт нь хэр илүү хүртэх бол!” (Сургаалт үгс 11:31) гэдэг. Тэнгэрт төдийгүй, энэ амьдралд шүү. Мөн “Нүгэлтнүүдийг мөшгөдөг нь гай зовлон. Зөвт хүмүүсийг шагнадаг нь сайн сайхан” (Сургаалт үгс 13:21) гэдэг. Иаков “Хайрт ах дүү нар

минь, бүү мэхлэгдэгтүн. Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг. Түүнд өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй” (Иаков 1:16-17) гэдэг.

Сайн нь Бурханаас. Хортой, хөнөөлтэй юмыг Бурхантай бүү хамаатуул. Бурхан бол сайныг л хайрлагч. Бурхан таныг энд ч, тэнд ч ерөөлөөрөө (ашиг тусаараа) шагнахыг л хүсдэг. Бурханы шагнал давхар цохилт дагуулдаггүй. Бидэнд “ЭЗЭНий ерөөл баяжуулах бөгөөд Зовлон зүдүүр үл нэмнэ” (Сургаалт үгс 10:22) гэж хэлсэн. Мөн “Итгэлтэй хүнд ерөөл олшрох” (Сургаалт үгс 28:20) гэдэг. *Ерөөл олирох* гэдэг нь *бүрэн шагнал* юм.

Элч Иоханы үгийг цааш нь тунгаахдаа, миний бие *Ирээдүйд бүрэн шагнал, тал шагнал, шагналгүй хоцрох тохиолдол гарах юм бол, энэ амьдралд ч яг ийм нөхцөл хэрэгжихгүй гэх шалтгаан үгүй* гэж бодож билээ. Энэ дүгнэлт маань Есүсийн амьдралаас ч тод харагддаг. Есүсийг газар дээр хүмүүсийн дунд явах үед зарим хүн тал шагнал хүлээн авч, зарим нь гар хоосон хоцорч, зарим нь бүрэн шагнал хүлээн авч байсан. Тэгвэл эдгээрийн жишээ бүрийг тухайлан үзээд, Есүсийн бидэнд хүсдэг замыг заах үлгэр загварыг тодруулж харцгаая.

Тал шагнал авах ба огт шагналгүй хоцрох

Назар тэр чигээрээ амлагдсан Мессаиаг ирэхийг нь тэсэн ядан хүлээж байлаа. Мессаиагийн ирэх улирал нь байсан учраас, тэд хамаг байдгаараа сэргэг бөгөөд анхааралтай байв. Тэд яг л Христийн хоёр дахь айлчлалын өмнөх цаг үед аж төрж байгаагаа мэддэг өнөөгийн Христэд итгэдэг хүмүүстэй л адил байж. Есүс биднийг Түүний ирэх улирал, үеийг мэдэх боловч, өдөр цагийг нь мэдэхгүй гэсэн. Тиймээс Израильчууд Христийн эхний ирэлтийн улирлыг мэдэж байсан нь хачирхалтай гэж үзмээр зүйл огт биш. Даниел болзолт цагийн хүрээг нь бичиж үлдээсэн (Даниел 9:24-26) бөгөөд Есүсийг хаанаас олж болохыг хуулийн мэргэжилтнүүд мэргэн хүмүүст хэлсэн байдаг (Матай 2:4). Назарын иргэд болзолт цаг ирснийг мэдэж байсан атлаа Мессаиа нь тэдний дунд гарч ирэхэд маш жигтэй байдлаар хандсан байдаг.

Тэнд Тэр хэдэн өвчтөн дээр мутраа тавьж эдгээснээс *өөр хүчит гайхамшигийг үйлдэж эс чадав* (Марк 6:5, тодруулгыг нэмэв).

“*Хүчит гайхамшигийг үйлдэж эс чадав*” гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Хэдэн жилийн өмнө бичээсийг уншиж байхад, энэ үг намайг цочоосон юм. Тэгээд бодлоо: *Байзаарай. Энд чинь “хүчит гайхамшигийг эс үйлдэв” гэж хэлээгүй, харин онцгойлон “хүчит гайхамшигийг үйлдэж эс чадав” гэж байна.* Эхнийх нь тохиолдол байсан бол, Есүсийн

хүсэлтэй холбоотой учраас, ахин дахин эргэцүүлээд байх шаардлага ч байхгүй (Есүс хүсээгүй учраас, үйлдээгүй болно.) Гэтэл “эс чадав” гэдэг чинь Есүс хүсээгүйдээ бус, харин Түүний хүчинд хориг саад тулгарсан гэсэн утгатай. Энэ санааг бусад орчуулга дээр ч тодотгож, тодруулсан байдаг. Тухайлбал, Амплифайд Библийн Сонгодог хэвлэл дээр “Тэрбээр хийх боломжгүй байлаа” гэдэг.

Тэгэхээр “*Яагаад Есүс Назарт хүчирхэг ажил хийж чадсангүй вэ?*” гэж асуух ёстой. Түүнд юу хориг саад учруулав? Есүс бусад хотод аугаа гайхамшиг үйлдсэн: сохор нь хараа орж, дүлий нь нээгдэж, тахир татуу нь явж, үхсэн хүмүүс амилуулагдсан. Тэмдэглэгдэж үлдэж жишээний хэдхэн нь л энэ шүү. Сайн мэдээн дээр Есүсийг бүх төрлийн өвчин, эмгэгийг эдгээсэн гэж тэмдэглэсэн байдаг. Тэгвэл ялгаа нь юундаа байна? Назарт яагаад хэдхэн өвчтэй хүн л эдгэрэв? Хариултыг нь өмнөх эшлэл дээрх Назарчуудын үгээс олж болно:

Амралтын өдөр Есүс синагогт сургаал зааж эхлэхэд, сонссон олон гайхаж —Хаанаас энэ хүн эдгээрийг авав? Түүнд ямар мэргэн ухаан заяасан юм бэ? Гараас нь ямар хүчит гайхамшгууд гарна вэ?

Энэ чинь Мариагийн хүү, мужаан биш бил үү? Иаков, Иосеф, Иуда, Симон нарын ах биш үү? Охин дүү нар нь бидний хамт байгаа биз дээ? гэж Түүнд бүдрэн унтууцав. Есүс тэдэнд —Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, төрөл садангийнхаа дунд болон гэрийнхнээсээ өөр газар хүндлэгдэхгүй байх нь үгүй гэж айлдав (Марк 6:2-4).

Юу болсон байна? Харцгаая. Есүс өссөн хотдоо эргэж ирээд, Саббат өдөр хуран цугласан Бурханы хүмүүс дээр иржээ. Хотынхон бүгдээрээ л синагогт байна. Тэгтэл Есүс гэнэт босоод дараах хэсгийг уншив: “Над дээр Эзэний Сүнс байна. Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм” (Лук 4:18).

Хурсан олон юу болж байгааг мэдэж байсан. Есүсийн уншсан үгийг тэд сайн мэднэ. Тэд Исаиагийн энэ хэсгийг үй олон удаа сонссон. Исаиа нь Мессаиагийн айлчлалын талаар өгүүлдэг, гол эш үзүүллийн номын нэг байв. Тухайлбал, өнөөдөр нэг хүн босоод Эзэний заасан залбирлыг унших юм бол, бид дараа нь юу болохыг мэддэгтэй л адил юм.

Есүс цааш нь “ядууст сайнмэдээг хүргэхийн тулд Намайг Эзэн тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь Олзлогдогсдод эрх чөлөөг

тунхаглах, Сохруудад хараа оруулах, Дарамтад байгсдыг чөлөөлөхийн сацуу...” (18-19) хэмээн үргэлжлүүлсэн.

Энэ тухайд, нутгийнханы толгойд нэг л асуудал үүссэн: Яахаараа албан ёсны рабби биш, нутгийн маань энэ юугаа ч мэдэхгүй шалдан залуу Бичээс уншдаг билээ? Тэгтэл Есүсийг босоод “Энэхүү Бичвэр өнөөдөр сонсголд тань биеллээ гэж айлдахад” (21), бөмбөг дэлбэрсэн. Өөрөөр хэлбэл, “Би Мессаиа байна” гэсэн. Тэгээд бусад хотод ямар, ямар аугаа хүчирхэг үйлс гүйцэлдүүлснээ хэлээд, хүчирхэг эш үзүүллийн үгээр номлолоо дуусгав.

Юу? Худлаа байлгүй дээ? Зөв л сонссон байгаа даа? Тэр Өөрийгөө Исаиагийн эш үзүүлсэн Нэгэн гээд хэлчихлээ гэж үү? Юу гээч вэ? Солиорол! Ийнхүү хүмүүс итгэж ядан, өөр хоорондоо дүнгэнэлдэв. “Энэ чинь Есүс! Тэр яаж байна аа? Юу хэлнэ вэ?”

Тухайлбал, нэгэн ээж “Юу гэсэн хэл вэ! Энэ хүү чинь миний хүүгийн Торагийн ангид л байсан шүү дээ!” гэж хэлэх нь нүдэнд харагдчихлаа.

Тэгтэл балмагдсан нөгөө нь “Тэр чинь манай саахалтын хүү. Бентэй хар багаасаа тоглож өссөн!” гэв.

Бусад нь ч саяхны үү түүхээ сөхнө: “Тэр манай хоолны ширээг хийж өгсөн! Манайд сандал хийж өгсөн! Мужааны хүү. “Эзэний Сүнс над дээр байна” гэдэг чинь юу гэсэн хэл вэ? Өөрийгөө хэн гэж бодоов?”

Өнөөдөр байсан бол хүмүүс: “Хүүтэй минь хөл бөмбөг тоглодог байсан!” гэх юмуу эсвэл “Манай шар охины тооны ангид байсан хүүхэд шүү дээ!” гэх байх.

Тэд Мессаиа хэрхэн ирэхийг Хуучин гэрээний Бичээсийн ойлголтоороо л тархиндаа оюуны дүрслэл хэлбэршүүлжээ. Исаиагийн өөр нэгэн алдартай хэсгийг үзье:

Учир нь бидний төлөө Хөвгүүн төрж, Бидэнд Хүү өгөгдсөн аж. Засаглал Түүний мөрөн дээр байж, Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна. Давидын сэнтий дээр Түүний хаанчлал дээгүүр засаглал хийгээд амар тайван нь тэлэхүйд эцэс үгүй. Шударга ёс, үнэн зөвөөр үүнийг өдгөөгөөс өнө мөнхөд тогтоон тулна. Түг түмдийн ЭЗЭНий зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно (Исаиа 9:6-7).

Иргэд аугаа Хааныг хүлээж байсан. Ер бусын ч мэргэн, хүчирхэг ч байлдан дагуулагч байх Нэгэнийг. Тэгээд ард түмнээ Ромын дарангуйллаас ганц гараараа л чөлөөлөөд, үнэмлэхүй ганц үндэстэн болгож өгөх Нэгэнийг. Давидын сэнтийг дахин сэргээж, өнийн мөнхөд хаанчлах Нэгэнийг. Гэтэл Есүс тэдний л нэг болж ирээд, сургуульд нь сурч, гудамжинд нь инээж, айлын тавилга хийж, эдүгээ мафийн бүлэглэл (татвар хураагч), янхан эмсээр хүрээлүүлээд байсан тул, тэд сохорсон. Тэд ойлгож цөхсөн. “Байзаарай! Бидний хүсэн хүлээсэн Мессаиа ийм байх ёсгүй!” хэмээн дотор, гадаргүй дуу алдсан. “Хүү өгөгдсөн” бөгөөд “Түүний хаанчлал дээгүүр засаглал хийгээд амар тайван нь тэлэхүйд эцэс үгүй” гэдэг мэдэгдлийн бодит биеллийн хооронд хэдэн мянган жил болохыг Есүсийн нутгийнхан ойлгоогүй аж.

Бичээс дээрх энэ мэт олон үйл явдал нь *Бурхан бидэнд хэрэгтэй зүйлийг бидний хүсээгүй богцонд хийгээд илгээх нь олонтаа* гэдэг ойлгохын аргагүй үнэнийг илчилдэг. Яагаад? Өөрийгөө Бурхан мөн бөгөөд Түүнд эргэлзэж болохгүйг бидэнд ойлгуулахын тулд. Бид хариултыг дан толгойгоороо хайгаад байлгүй, Түүнийг бөгөөд Түүний хангамжийг зүрхээрээ хайх ёстой. Бичээсийг хүний хязгаарлагдмал оюунаар хөрвүүлж болохгүй. Бурханы Сүнсний амьсгал байх ёстой. Зөвхөн Бурхан л ухаалаг зөвлөгөө, зөв хэрэгжилтийг өгдөг.

Хатуу харьцуулалт

Өөр нэгэн жишээгээр тайлбарлая. Фарисайчууд ч Бурханы хүмүүсийг Ромын дарлалаас чөлөөлөөд өгөх, хүчирхэг байлдан дагуулагч Мессаиаг хүлээж байсан. Тэдгээр удирдагч нар өөрсдийгөө Иерусалимд байгуулагдах шинэ хаанчлалын дэд захирагч нар болон гэж итгэн, Аврагчийг тэсэн ядан хүлээж байсан. Тэгээд Есүсийг Галилын эгэл жирийн залуу болон тайзан дээр гарч ирэхэд нь Түүнийг элэглэсэн. Есүс тэр улсын Мессаиагийн талаарх дүр төрхтэй нь ч нийцээгүй.

Тэдний Есүстэй хийсэн ээлжит мөргөлдөөний талаар ингэж тэмдэглэжээ:

Бурханы хаанчлал хэзээ ирэхийг асуусан фарисайчуудад Тэр хариулахдаа —Бурханы хаанчлал ажиглагдахуйцаар ирэхгүй. Хэн ч “Хараач, тэнд байна” гэх юмуу эсвэл “Хараач, энд байна” гэж хэлэхгүй. Харагтун, Бурханы хаанчлал нь та нарын дунд байна гэв (Лук 17:20-21).

Фарисайчууд бас л Мессаиагийн газрын хаанчлалын талаарх Исаиагийн эш үзүүллийг сөхжээ. Тэд ч мөн Бурханы Сүнсний удирдамжинд найдахын оронд бичээсийн талаарх оюуны хөрвүүлэг дээрээ үндэслэж л Мессаиаг хайсан.

Тэгвэл үүнтэй сөргүүлэн, ялгаагүй л Мессаиаг хүсэн хүлээж байсан Симеон гэдэг өөр нэгэн хүнийг авч үзье. Лукийн Сайн мэдээ түүний талаар өгүүлж:

Үзэгтүн, Иерусалимд Симеон гэгч зөвт агаад сүсэгт хүн байв. Тэр хүн Израилийн тайтгарлыг хүлээж байсан бөгөөд түүний дээр Ариун Сүнс байлаа. Эзэний Христийг үзэхээс нааш өөрийг нь үхэхгүй хэмээн Ариун Сүнс түүнд илэрхийлсэн байжээ. Тэр, Сүнсэнд хөтлөгдсөөр сүмд ирэв. Хүү Есүсийнхээ төлөө хуулийн ёслол үйлдэхээр эцэг эх нь Түүнийг сүмд авчрах үед... (Лук 2:25-28).

Симеон Есүс дээр шивэгнэсэн үгээрээ тэр сар гаруйтай нялх амьтныг Мессаиа мөн болохыг нь тунхагласан. Тэгэхээр, одоо хамгийн сонирхолтой нь. Энэ хөгшин сар гаруйтай хүүхдийг Мессаиа мөн болохыг нь таньсан бол, хүний үйлдэж чадахгүй гайхамшгийг үйлдэн яваа, гуч гарсан Мессаиаг Назарчууд таниагүй, харин Фарисайчууд доош нь хийж! Яагаад? Мөн л Бурханы Сүнсний улмаас бөгөөд Аврагчийг бөгөөд Түүний арга замыг таних хүмүүс нь гагцхүү үнэнийг илчилдэг Сүнсээр л таних байв. Симеон болоод бусдын хооронд түлхүүр ялгаа байх бөгөөд үүнийг нь одоо бүгдээрээ үзнэ. Энэ илчлэл нь яагаад тийм олон хүн Бурханаас бүтэн өв хүлээж авч чаддаггүйг ойлгуулна.

Хүндэтгэл

Эхлээд бүгдээрээ Есүсийн нутгийнхандаа хандаж эхэлсэн мэдэгдлийг үзье. Тэрбээр “Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, төрөл садангийнхаа дунд болон гэрийнхнээсээ өөр газар хүндлэгдэхгүй байх нь үгүй” (Марк 6:4, тодруулгыг нэмэв).

Түлхүүр үг нь *хүндэтгэл*. Тэр хүмүүс Есүсийг хүндэтгээгүй.

Хүндэтгэлийг Грекээр *тиймий* гэдэг ажээ. Би ч энэ үгийг ч, ойрын холбооны үгсийг нь ч нилээд судлаж үзсэн. Грек эхийнх нь судалгаа агуулсан үй олон Грек толь бичиг, тайлбар толь, ном тэргүүтнийг үзсэн. Түүнчлэн Грекээр ус цас хоёр хүнтэй халуун яриа ч өрнүүлсэн. Нэг нь Грект аж төрдөг бол (гэрийнхэн нь дөрөв дэхь үеийн үйлчлэгч

нар), нөгөө нь Их Британид аж төрнө. Одоо би энэ бүх эх үүсвэрээс хүлээж авсан хариултаа нэгтгэсэн тодорхойлолтыг өгөх болно.

Тиймий буюу хүндэтгэлийн хамгийн энгийн, үгчилсэн утга нь “үнэлж цэнэлэх” ажээ. Тиймий гэдэг үгийг Грек хүнд хэлбэл, түүнд шууд л алт зэрэг ямар нэгэн *үнэтэй, нандин, жинтэй* юм бууна. Бодоод үз л дээ - та алтыг шургуулгандаа хийгээд орхилгүй, харин хүндэтгэлтэй газарт хадгална биз дээ. Хүндэтгэлийг өөрөөр бас *таалан соёрхох, өндрөөр дүгнэх, таатай хандах, хүндэтгэх* гэж тодорхойлж болох ажээ.

Заримдаа эсрэг утгатай үгийг нь үзэж байж, тухайн үгийг сайн ойлгодог. Хүндэтгэхийн эсрэг утга нь *эс хүндэтгэх* ажээ. Грекээр *атимиа* гэнэ. Зарим тодорхойлолтоос нь хэлбэл: *хүндэтгэл үзүүлэхгүй байх юмуу үнэ цэнэ өгөхгүй байх, байдаг л нэг, жирийн юмуу дорд юм шиг хандах*. Үл хүндэтгэлийн талаар Грек хүнтэй ярьбал, түүнд *амархан ууршдаг уур гэх мэт жирийн, хөнгөн* юм бууна. Үл хүндэтгэлийн илүү хурц хэлбэр нь ичээх юмуу доромжлох аястай хандах явдал аж.

Грек толь бичиг, тайлбарын судалгаагаа үзэхдээ, хүндэтгэлийг үйлдлээр ч, үгээр ч, тэр бүү хэл бодлоор ч харуулах боломжтойг олж мэдэв. Гэхдээ бүх үнэн хүндэтгэл нь зүрхнээс л эхтэй. Тиймээс л Бурхан “Энэ ард түмэн амаараа ойртон, *Уруулаараа л Намайг хүндлэвч, Зүрх нь Надаас алс хол байдаг. Тэд Намайг эмээн хүндлэхэд хүний тушаалаар суралцжээ*” (Исаиа 29:13, тодруулгыг нэмэв) хэмээжээ.

Бурхан “*Намайг эмээн хүндэтгэхэд*” хэмээн айлдсан байгааг тэмдэглэнэ үү. Жинхэнэ хүндэтгэл нь Бурханыг эмээн хүндэтгэдэг зүрхний халил ажээ. Энэ чухал зүйлийн талаар бүгдээрээ хойчийн бүлгээрээ суралцана.

Есүс Назарын хүмүүс Өөрийг нь хүндэтгэхээс татгалзсан гэжээ. Нутгийнхан нь Түүнийг үнэ цэнэтэй, эрхэм нандин гэж хандаагүй. Тэд Есүсийг Бурханы хүслийг гүйцэтгэхээр тэнгэрээс илгээгдсэн Тэр нэгэн хэмээн хүлээн зөвшөөрөөгүй. Харин ч, өмнө нь байдаг л нэг хүн, нутгийнх нь хархүү зогсож байна гэж үзсэн. Үүнийхээ улмаас тэд тал шагнал хүлээж авсан юм. Есүс хүчирхэг үйлс хийх боломжгүй байсан. Нэг их онцгой юм ч болсонгүй. Магадгүй хэдэн хүний толгойн өвчин, үе мөчний өвчин арилсан юмуу эсвэл нуруу нь эдгэрсэн ч юм уу.

Бодоод үзнэ үү. Өвчтэйг эдгээж, диаволын дарлалд орсныг чөлөөлөхөөр илгээгдсэн, Бурханы Сүнсээр яндашгүй дүүрэн, Бурханы Хүү Есүс Бурхан тус хотыг эдгээх хүсэлгүй учраас бус, харин хүмүүс

нь хүндэтгэлгүй хандсанаас болж тэнгэрийн даалгавраа биелүүлж чадаагүй байна. Тэд Есүст яг л байдаг л баагийг шиг хандсан. Тиймдээ ч хэдхэн өвчтөн эдгэрэх зэрэг хэдэн жижиг шагнал л хүлээн авчээ.

Шагналгүй хоцрох нөхцөл

Сайн мэдээн дээр өөр нэгэн удаа Есүс нэг айлд баахан Бичээсийн мэргэжилтнүүдэд болоод багш нарт зааж суудаг. Тэр үйлчлэгч нар Есүсийг сонсохоор Галил болоод Иүдеагийн хот болгоноос хүрэлцэн иржээ. “(Эдгээлтийн төлөө *тэднийг эдгээх*) Эзэний хүч Түүнд өгөгдсөн байв” (Лук 5:17, тодруулгыг нэмэв).

Тэднийг гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Энэ нь тэнд байсан хүмүүсийг хэлж байгаа нь тодорхой байна. Тэгэхээр, би одоо нэг үнэн мэдэгдэл хийе: Бурхан юу ч үрэлгэддэггүй. Тийм ээ, Есүс дөрвөн мянган хүнийг ч, таван мянган хүнийг ч хооллож байсныг санаж байна уу? Аль, аль тохиолдол дээр нь Есүс юуг ч хаягдал болгохгүйн тулд бүх үлдэгдлийг цуглуулсан байдаг. Бидний ихэнхийн маань хаячих юмуу хогонд тушаачих байсан юмыг Есүс цуглуулсан. Бурханы арга зам доторх бүхий л Бичээс даяар чи энэ үлгэр загварыг олж харна. Есүс юуг ч үрэлгэддэггүй.

Тэгэхээр, Фарисайчуудыг болоод хуулийн багш нарыг эдгээх Эзэний хүч оршиж байсан гэдэг нь *тэдэн дундаас* нэг юмуу за магадгүй нилээд хэдэн хүн эдгэрэх шаардлагатай байжээ. Энэ тал дээр би туршлагаасаа ярьж байна шүү. Энэ үйл явдлыг өнөө цаг дээр буулгаж үзье л дээ. Нэг өрөөнд хэдэн зуун хүнийг цуглуулбал, тийм том бүлэг дунд ядаж л хэдэн арав юмуу түүнээс дээш тооны хүн өвчин эмгэгтэй байж л таараа. Уг нь тэднийг бүгдийг нь эдгээх Бурханы хүч байгаад байдаг. Гэтэл нэг нь ч эдгэрдэггүй.

Хожим, хэдэн хүн саажсан нөхрөө дамнуурган дээр тээж авчирсан. Байшингийн үүдээр нэвтрэхийн аргагүй битүү хүн шаваатай байсан тул тэд өөр аргаар үзсэн. Тэд бууж өгөхийн оронд байшингийн дээвэр дээр гараад, дээврийн хавтанг нь хуулаад, дээрээс дамнуургатай нөхрөө Есүсийн байгаа газар руу олсоор буулгасан. Үүнийг “Итгэлийг нь харсан Есүс —Анд минь, нүгэл чинь уучлагдсан гэхэд хуулийн багш нар болон фарисайчууд —Бурханыг доромжлон ярьж буй энэ хэн гэгч вэ? Гагцхүү Бурханаас өөр хэн нүглийг уучилж чадах билээ? гэж эргэцүүлэн бодоцгооход” (Лук 5:20-21).

Лук Фарисайчуудыг “эргэцүүлэн бодсон” гэжээ. Үүнийг жаахан задалж үзье. Тэр удирдагч нар дэргэдэх нөхөд рүүгээ бөхийгөөд шивэгнэлдсэн үү? Тэд жижиг, жижиг бүлгээр хуваагдаад, Есүсийн мэдэгдлийг хоорондоо ярилцсан уу? Үүнийг тодруулахын тулд Матайн тэмдэглэлийг үзэх хэрэгтэй. Тэд “(дотроо) *боджээ*” гэсэн (Матай 9:3, тодруулгыг нэмэв). Тэгэхээр, багш нар маань Есүсийг бодол дотроо л үл хүндэтгэжээ. Тэд дотроо л бодсон. Тэд чанга чангаар ичгүүр, шүүмжтэй юмуу доош хийсэн үг хэлэлгүй, дотроо л бодсон төдий. Марк тэднийг “*дотроо эргэцүүлэн (зүрхэндээ тунгаан)*” гэдэг. Тэгвэл Есүс тэдний бодолд хэрхэн хариулсныг үзнэ үү:

Юунд та нар зүрхэндээ ийн эргэцүүлнэ вэ?

Саа өвчтөнд “Нүгэл чинь уучлагдсан” гэж хэлэх эсвэл “Бос, дэвсгэрээ аваад яв” гэж хэлэхийн аль нь амархан бэ? Харин Хүний Хүү газар дээр нүглүүдийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд гээд Тэрээр саа өвчтөнд
— Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэсэнд...
(Марк 2:8-11).

Саажсан хүн тэр даруй босоод, хэвтрээ аваад, тэр олон үйлчлэгч нарын нүдэн дээр нь байшингаас гараад явжээ. Библи тэдгээр удирдагч, багш нарыг “мэл гайхаж, цэл хөхөрсөн” гэдэг (12).

Тэдний нүд орой дээрээ гарсан ч, Эзэний хүч уг нь анх тэднийг эдгээхээр тэнд оршиж байсан боловч, нэг нь ч эс эдгэв! Тэд бодолдоо л Есүсийг үл хүндэтгэснийхээ төлөө шагналгүй хоцорч! Энэ тохиолдол дээр тэд үйлдлээсээ юмуу үгээсээ бус, гагцхүү чимээгүй бодлоосоо болжээ. Хүндэтгэл юмуу үл хүндэтгэл нь үйлдлээр юмуу үгээр юмуу бодлоор үзэгдэж болох ч, жинхэнэ хүндэтгэл нь зүрхнээс л эхтэй байдгийг бүү мартаарай. Энэ тун чухал шүү!

Тэр удирдагч нарын олонх нь хэдийнээ Есүсийг үл хүндэтгэх үлгэр загвар бий болгосон байжээ. Тэд Есүсийг няцааж, элэглэж, олон удаа олны дунд гутаах гэж оролдсон. “Фарисайчууд ба хуулийн багш нар Түүнийг буруутгах шалтаг олохын тулд... ажиглан ширтэж байлаа.” (Лук 6:7) гэдэг. Мөн “Тэд Түүнийг ажиглан, Түүнийг үгэн дээр нь урхидан барьж, захирагчийн эрх мэдэлд тушаах зорилготой, зөвт мэт дүр эсгэгч туршуулуудыг Түүн уруу явуулав” (Лук 20:20) ч гэдэг. Ийм тэмдэглэгээ олон бий. Үнэндээ тэд Есүсийг хүндэтгэхгүйн төлөө юу эсийг үйлдсэн нь харагдаж байна.

Назарын хүмүүс хүндэтгэхээс татгалзаад, өчүүхэн *тал шагнал* хүлээж авсан. Удирдагч нар Есүсийг бодолдоо үл хүндэтгээд, *шагналгүй хоцорсон*. Тэгвэл одоо бүрэн шагнал хүлээж авсан хүмүүсийн талаар үзээд, хүндэтгэлийн зарчимтай холбоо байгаа эсэхийг харцгаая.

Бүрэн шагнал

Есүс үйлчлэлийнхээ эхэн дээр Капернаумд ормогцоо, саажиж, зовон тарчилж байгаа зарцыг маань эдгээж өгөөч хэмээн Есүсээс гуйсан Ромын зуутын даргатай таарсан. Есүс зөвшөөрсөн: “Би очиж, түүнийг эдгээе” (Матай 8:7).

Зуутын дарга: “Эзэнтээн, би Таныг дээвэр дороо оруулах *зохистой нь биш ээ*” (8, тодруулгыг нэмэв) гэж хариулсан.

“Зохисгүй”? Израилийг *булаан эзэлсэн* хүн нь эзлэгдсэн хүн дээ ингэж хэлэх гэж! Ром чинь Израилийг эзлээд байсан. Тэгээд яагаад энэ Ром албан тушаалтан Еврей мужаанд “Эзэнтээн, би Таныг дээвэр дороо оруулах *зохистой нь биш ээ*” гэж хэлэв? Яг л Америкийн тэнгисийн цэргийн хурандаа Иракийн сантехникч хүнд “Би Таны гэрт орох *зохисгүй хүн*” гэж хэлж байгаатай л адил юм. Тэр хүн Есүсийг хичнээн их хүндэтгэж байгааг харж байна уу? Тэгэхээр, Ром албан тушаалтан маань тэр мужаан үнэндээ хэн болохыг мэдэхийн дээдээр мэдэж байж. Тэрбээр Есүсийг чухалчлан үзэж, хүндэтгэхийн дээдээр хүндэтгэж. Дараа нь албан тушаалтан маань “Харин үг л хэлээч, тэгвэл зарц минь эдгэрнэ. Би ч *мөн* эрх мэдэл дор байдаг хүн. Миний дор цэргүүд бий. Би нэгэнд нь “Яв” гэхэд тэр явдаг. Нөгөөд нь “Ир” гэхэд тэр ирдэг. Зарцдаа “Үүнийг хий” гэхэд тэр хийдэг” гэж хариулав” (8-9)

Эхлээд бүгдээрээ цэргийн даргын цол, байр суурийг авч үзье. Ромын легион нь зургаан мянган цэрэгтэй бөгөөд командлагчтай байжээ. Зургаан мянгат буюу легион дор командлагчдаа захирагддаг жаран зуутын дарга байх бөгөөд зуутын дарга болгоны дор зуун цэрэг байна.

Тэр эрхэм Есүст тавьсан хүсэлт нь хэрхэн бөгөөд яагаад бүтэх ёстойг

тайлбарлажээ. Тэрбээр өөрөө даргынхаа эрх мэдэлд захирагдсанаараа цэргүүдийнхээ хүндэтгэл, дуулгавартай байдлыг олжээ. Тэрбээр дуртайяа даргынхаа ар тал болсон бөгөөд дарга нь эргээд Ромын эрх мэдлийн ар тал болж байв. Тэрбээр үндсэндээ “Би улсынхаа бөгөөд дарга нарынхаа эрх мэдлийг хүндэтгэж, дээдэлснээрээ л эрх мэдэлтэй байгаа юм” гэжээ. Тиймээс намайг үг хэлэхэд л доор байгаа хүмүүс маань удирдамжийн маань дагуу үйлддэг” гэсэн. Тэгээд үүнийгээ бүр ч хялбарчлахын тулд “Би эрх мэдэл дор байдаг учраас, өөрөө эрх мэдэлтэй байдаг” хэмээн мэдэгджээ.

“Би ч мөн” гэдэг утгвар үгийг нь тэмдэглэнэ үү. Тэр даруй тэрбээр үнэний мэдэгдэлдээ Есүсийг багтааж байгааг харж байна. Есүсийн эрх мэдэл ч мөн эрх мэдэл дор байсных нь үр дүн болохыг тэрбээр хүлээн зөвшөөрчээ. (Жич: Есүс Аавдаа захирагддаг тухайгаа Сайн мэдээнд олонтаа мэдэгдсэн байдаг) Хамгийн гайхалтай нь, тэр Ром цэрэг Есүс дээрх Бурханы эрх мэдлийг тодорхойлоод, тийнхүү тэрбээр цэрэг дайны ертөнцөд эрх мэдлийг хэрэгжүүлдэгтэй адил Есүс ч үл үзэгдэх, сүнсний ертөнцөд эрх мэдлийг хэрэгжүүлдэг болохыг нь мэдэж байв. Магадгүй, тиймээс л тэр эрхэм зүгээр л тушаал өгөхөд л өвчин эдгэрэхийг ойлгож байсан байх. Энэ бүхэн нь түүний толгойд - эрх мэдэл дорх хүмүүс нь түүний тушаалд хариу үйлддэгтэй л ижилхэн бууж байв. Тэгтэл Есүс юу гэж хариулсныг үзнэ үү:

Есүс үүнийг сонсоод гайхаж, дагаж явсан олонд — Үнэнээр Би та нарт хэлье. Би ийм агуу итгэлийг Израильд хэнээс ч олоогүй юм байна. (Матай 8:10)

Ямар хүчтэй мэдэгдэл вэ! Есүс тэр Ром цэргийг Иохан Баптистаас ч том итгэлтэй хэмээв! Бодоод үз. Есүс Иохан Баптистыг Израильд “олсон”. Бүр цааш нь лавшруулбал, тэр Ром цэрэг Есүсийн ээж Мариагаас ч том итгэлтэй ажээ. Түүний итгэлийг Есүс гуч наслахдаа Израильд үзээгүй, тийм том итгэл хэмээн мэдэгджээ. Есүс хэзээ ч давслахгүй! Есүсийн мэдэгдлийн хүчийг ойлгож байна уу? Үндсэндээ, Израилийг дарлаж байсан Ром улсын цэргийн албан тушаалтан, иргэн тэр хүн л хамгийн аугаа итгэлийн шагналыг хожчихжээ.

Би итгэлийн хүн бөгөөд та ч бас тийм байхаа гэж найдаж байна. Учир нь итгэлгүйгээр Бурханд таалагдах ямар ч боломжгүй (Еврей 11:26). Бичээс дээр хэлсэнчлэн, “... итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17). Иохан Баптист маань тэр Ром албан

тушаалтнаас хавьгүй олон бичээс сонссон л байгаа. Тийм боловч, тэр албан тушаалтан л илүү том итгэлтэй байв. Түүнчлэн миний таамаглаж байгаагаар (за бараг л үнэн болох байх) Есүсийн ээж Мариа, арван хоёр дагалдагч зэрэг Израильд Есүстэй уулзаж учирч байсан олон хүн тэр Ром албан тушаалтнаас хавьгүй олон Бурханы Үг сонссон боловч, тэр эрхэм л тэдний хэнээс ч илүү том итгэлтэй болж таарсан. Юу түүний итгэлийг аугаа болгов? Есүст үзүүлсэн хүндэтгэл, дээрээс нь эрх мэдлийг ойлгох ойлголт, эрх мэдэлд захирагдах явдал нь гэж хариулж болно (Бурханы Үгийг сонсох нь итгэлийг төрүүлдэг хэдий ч, үүнийг эрх мэдлээ хүндэтгэж, захирагдах явдал бүрэн гүйцэт болгодгийг Лук 17:5-10 харуулдаг).

Тэр эрхэм эрх мэдлийг ойлгож, эрх мэдэлд хүндэтгэлтэй хандсан учраас, *бүрэн шагналаа* хүлээж авсан. Эрх мэдлийг хүндэтгэх хүндэтгэл нь зүрхэн дэхь хүн.

Няцаахын аргагүй эмэгтэй

Маркийн Сайн мэдээний 7-аар бүлэг дээр Сиро - Фойник гаралтай Грек эмэгтэй Есүсээс тусламж эрэн ирсэн тухай гардаг. Бичээс түүнийг Есүсээс охиныг нь чөтгөрөөс чөлөөлж өгөхийг салахгүй гуйсаар байсан гэдэг. Энэ нь Есүс түүний эхний, хоёрдугаар, магадгүй бүр олон удаагийн хүсэлт гуйлтыг хүлээж аваагүйг хэлнэ. Магадгүй бүр түүн рүү хараа ч үгүй байх. Гэсэн ч эмэгтэй гуйсаар байсан. Тэр бууж өгөөгүй бөгөөд эцэстээ хариугаа хүлээж авсан: “Есүс түүнд — Эхлээд хүүхдүүдээ цатга. Учир нь хүүхдүүдийн талхыг авч нохдод хаях нь сайн биш” (27) гэжээ.

Тэгэхээр, бялууг яаж ч хэрчсэн, ялгаа байхгүй гэдэг шиг Есүс түүнийг зүгээр л нохой гэж! Тэр эмэгтэй Америк хүүхэн байгаагүй нь сайн хэрэг. Америк байсан бол, тэрбээр Есүсийг ч зүгээр өнгөрөөхгүй байсан байх. “Юу?! Та намайг нохой гэв үү? Та ер нь үйлчлэгч хүн мөн үү? Намайг ингэж доромжилно гэнэ ээ? Та чинь туслахаар ирсэн биз дээ. Тэгээд ингэж хариулна гэнэ ээ? Яс үндсээр маань ялгаварлаж байгаа биш үү? ... Тийм биз дээ? Би Грек хүн, Та Еврей хүн. Тэглээ гээд Танд намайг нохой гахайгаар дуудах эрх байхгүй шүү! Бүү үзэгд. Та ажилтнуудтайгаа хамт суугаад, ганц охин үрийнхээ төлөө царай алдан гуйж байгаа, нэг муу эмэгтэйг үл тоох. Нөгөө номноод байдаг их хайр чинь хаана байна? Өө хөөрхий, мэдлээ гайхуулах олон хүн

байхгүй, та хэдээс өөр хүнгүй учраас, жинхэнэ төрхөө илчилж байх шив. Хоёр нүүртэн минь, хангалттай... Эндээс зайлах минь.”

Тэр эмэгтэй үсчүүлсээр гарч яваад, охин нь ч эдгэрэхгүй хоцрох байв. Тэрбээр шагналгүй явах байв. Гэвч, эмэгтэй ерөөсөө ингэж авирлаагүй. Харин ч оронд нь Есүсийн үгийн хариуд бүрэн шагналаа авахаар шулуудсан байр сууриа эзэлсэн: “Тийм ээ, Эзэн. Гэвч ширээн доор байгаа ноход ч хүүхдүүдийн үйрүүлснийг иддэг шүү дээ гэж хариулав. Есүс түүнд —Үгийнхээ дагуу яв. Охиноос чинь чөтгөр зайлсан гэлээ” (28-29).

Есүсийн мишээгээд, тэр гадаад эмэгтэйн итгэлийг толгой сэгсрэн биширч байгаа дүр нүдэнд харагдчихлаа. Ийм эмэгтэйд яаж үгүй гэж хэлэх билээ? Есүс түүнд охиныг нь тамлаж байсан чөтгөр зайлсан гэсэн бөгөөд ээж нь хариад, охиноо чөлөөлөгдсөн байхыг үзэв!

Эмэгтэй тэр дороо урвайгаад, гомдчихсон бол, шагнал авах хамаг найдвараа алдах байсан. Эмэгтэй Есүсийг хэн болохыг нь мэдэж байсан тул тууштай хүндэтгэсээр байсан - эхлээд тууштай зангаараа, дараа нь өөрийг нь доромжлох юмуу үл хэрэгсээд байгаа мэт үед ч гомдож, бууж өгөхөөс татгалзсанаараа. Энэ шийдэмгий зан нь түүнд бүрэн шагнал авчирчээ.

Энэ хоёр гайхамшигт итгэл нь хоёулаа Абрахамын гэрээний гадна байдаг, гадаад хүмүүстэй холбоотой байгаа нь бүр ч сонирхолтой. Зуутын дарга, Грек эмэгтэй хоёр Есүст итгэлээ бишрүүлж чаджээ. Тэд зүгээр л өнөөдөр бараг тоодоггүй шахуу зарчмыг ойлгожээ... хүндэтгэл нь цөхрөл дундаас урссан бөгөөд хэн, хэн нь бүрэн шагналаа хүлээн авчээ.

Хүндэтгэлийн зарчим

Сайн мэдээг нягтлах юм бол, бүрэн, тал шагнал хүлээж авсан эсвэл огт шагналгүй хоцорсон, янз бүрийн хүмүүс гарч байгаа. Тохиолдол болгон нь хүндэтгэлийг хэрхэн захиран зарцуулж байгааг нь онцгойлон харуулдаг. Зарим нь хагас хугас хүндэтгэсэн, зарим нь чин сэтгэлээс дээдлэн хүндэтгэсэн, зарим нь ямар ч хүндэтгэлгүй хандсан. Тухайн үйл явдал дээр шууд хүндэтгэлийн талаар өгүүлээгүй байсан ч, цаад зарчим нь хэвээрээ. Энэ нь сүнсний хууль. Учир нь Бурхан:

Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна. (1Самуел 2:30) хэмээн айлдсан.

Хүндэтгэл нь тэнгэрээс хүлээж авахын үндсэн түлхүүр ажээ. Би дээрх эшлэлийг “хүндэтгэлийн зарчим” гэж нэрлэх дуртай. Бурханыг хүндэтгэдэг хүмүүс хүндэтгүүлэх болно. Ердөө л энэ. Есүсийг хүндэтгэсэн нь хүндэтгэсэн хэм хэмжээгээрээ Бурханаас хүлээж авсан. Бодоод үз... зарц, охин хоёр эдгэрэхээс гадна өнөөдөр бид тэдний сонголт, итгэлийг тэмдэглэж байна!

Энэ зарчмыг чухам Алгасал баярын өмнө онцгойлон тодотгосон байдаг. Есүс Бетаны уяман өвчтэй Симоны гэрт сууж байжээ. Түүнийг ширээнд тухалж байтал, сав дүүрэн үнэт тос барьсан нэгэн эмэгтэй дөхөж ирэв. Ажилчин хүний жилийн хөлстэй дүйцэм үнэтэй анхил тос. Эмэгтэй нулимсаараа Есүсийн хөлийг угааж, үсээрээ арчсанахаа дараа тосны саваа онгойлгоод Есүсийн толгой дээр цутгасан.

Тэрбээр Есүсийг толгой түрийгүй тосолж хүндэтгэсэн боловч, үүнд хүн болгон баярлаад байсангүй: “Гэтэл зарим нь зэвүүцэн өөр хоорондоо хэлэлцэж —Юунд энэ тосыг ингэж үрнэ вэ? Энэ тосыг гурван зуу гаруй денараар зарж, ядууст өгч болох байсан шүү дээ гээд, тэд түүнийг зэмлэжээ” (Марк 14:4-5).

Өөр тохиолдол дээр байсан бол, тэдний гаргалгаа тун бодлоготой, ухаалаг сонсогдох байсан байх. Христэд итгэдэг хүмүүс ядуусын талаар бодоод байдаг мэт боловч, тэд том зураглалыг хараагүй. Тэр эгшинд нэг юм илчлэгджээ. Тухайн эгшинд Бурханы Хүү Есүсийг хүндэтгэснээрээ тэнгэр, газрын Бурханыг хүндэтгэх боломж гарчээ. Эзэнтэний хатуу зэмлэлийг сонсоно уу:

Түүнийг орхи. Та нар юунд түүнд төвөг удна вэ? Энэ эмэгтэй Надад сайныг үйлдэв. Учир нь та нар үргэлж ядуустай цуг байна. Хэзээ хүссэн цагтаа та нар тэдэнд сайныг үйлдэж чадна. Харин та нар Надтай үргэлж цуг байхгүй. Тэр хийж чадахаа л хийсэн. Биеийг минь тэр тосолж оршуулгад минь урьдчилан бэлдлээ. Үнэнээр Би та нарт хэлье. Сайнмэдээ бүх ертөнцийн хаа ч тунхаглагдсан, энэ эмэгтэйг дурсаж, үйлс нь яригдах болно гэлээ (Марк 14:6-9).

Пөөх, Есүс тэр эмэгтэйг яаж магтаж байгааг сонсов уу? Есүсийн үед хүмүүс олон мундаг зүйл үйлдсэн боловч, хэн нь ч ийм маягаар сайншаалгах юмуу ийм дайны юм үйлдээгүй. Есүс тэр эмэгтэйн хүндэтгэлийн үзэсгэлэнтэй, сайн үйлсийг тухайн үед төдийгүй, харин Сайн мэдээ хүрсэн газар бүрийд үеийн үед, үүрийн үүрд магтагдана хэмээн эш үзүүлэв!

Тэр эмэгтэй Эзэнтэнээ хүндэтгэхийг л хүссэн боловч, цутгасан тосолгоо нь түүнийг Эзэнтэнээсээ хүндэтгэл хүлээхүйц байр сууринд гаргажээ. *Хүндэтгэлийн зарчим* нь хэзээд хэрэгжих бөгөөд хэзээд хүчин төгөлдөр байна. Бурхан “Намайг хүндэтгэгчдийг Би *хүндэтгэнэ*. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би *үл хайхарна*” (2Самуел 2:30, тодруулгыг нэмэв) гэсэн. Бурханыг үл хүндэтгэсэн хүмүүс өөрсдөө өндрөөр үнэлэгдэхгүй гэснийг тэмдэглэнэ үү. Тэгвэл ЭнАйВи Библи дээр “хүний бодол, хүндэтгэлд үнэ цэнэгүйд тооцогдох мэдрэмж” гэсэн утга бүхий *жигшигдэнэ* гэдэг үг хэрэглэсэн. Бурхан Өөрийг нь хүндэтгэдэггүй хүмүүсийг анхаарлаасаа доогуур үздэг аж. Тэдний залбирал, хэрэгцээ нь ч үл хэрэгсэгдэх.

Есүсийн үгийг үзнэ үү: “Намайг хүлээн авдаг нь Намайг Илгээгчийг хүлээн авдаг” (Иохан 13:20). Есүсийн хэлсэн үгийг агуулгаар нь авч үзбэл, хүлээж авах нь хүндэтгэхийг хэлж байна. Тиймээс Есүс үнэндээ “Намайг хүндэтгэдэг нь Намайг Илгээгчийг хүндэтгэдэг” гэжээ. Тиймээс л Тэрбээр бидэнд “Хүүг хүндэлдэггүй нь Түүнийг илгээсэн Эцэгийг хүндэлдэггүй” (Иохан 5:23) хэмээн маш тодорхой хэлдэг.

Есүсийг хүндэтгэдэг нь өөрөө ч мэдэлгүйгээр Аавыг хүндэтгэж буй ажээ. Есүс “Би хүмүүсээс алдар хүндийг авдаггүй” (Иохан 5:41) гэсэн. Тэрбээр зүрх, оюундаа бүхий л хүндэтгэлийг Аавдаа өргөжээ. Есүс хараахан алдаршуулагдаагүй байв. Алдаршуулагдах л юм бол, Аав нь Хүүдээ “Бурханы бүх тэнгэрэлч Түүнд мөргөгтүн” (Еврей 1:6), “Бурхан минь, Таны сэнтий мөнхийн мөнх. Үнэн зөвийн очирт таяг нь Таны хаанчлалын очирт таяг мөн” (Еврей 1:8, түүнчлэн Филиппой 2:8-10-ыг үзнэ үү) гэдэг тушаалыг өгсөн. Алдаршуулагдах л юм бол, Тэрбээр Аав нь хэрхэн хүндэтгэн мөргүүлдэг шиг л хүндэтгэн мөргүүлнэ.

Гэвч Есүс газар дээр явахдаа, *Хүний Хүү* болж л амьдарч, үйлчилсэн. Амплифайд Библийн сонгодог хэвлэлийн Филиппой 2:6-7 дээр “Бурхандаа үндсэндээ нэг бөгөөд Бурханы хэлбэрт оршихуй Тэрбээр... Өөрийгөө [бүхий л эрх ямба, бүрэн эрхт нэр төрөөсөө] нүцгэлэн, тийнхүү үйлчлэгчийн (боолын) дүрийг өмсөн, ингэснээрээ хүмүүстэй адилхан болж, хүмүүн болон төржээ” гэсэн байдаг. Тэгэхээр, Есүс Хүнийхээ хувьд Өөрт нь ирсэн бүхий л хүндэтгэлийг зүрхнээ Аав руугаа илгээсээр байжээ. Тиймээс л эдгээсэн хүмүүстээ “Хэнд ч бүү ярь! Харин явж, өөрийгөө тахилчид үзүүлээд, тэдэнд гэрчлэл болгон Мосегийн тушаасан өргөлийг өргө” (Матай 8:4) гэх зэргээр байнга хэлдэг байсан юм. Мөн Матай 9:30 дээр ч “Хэн ч

үүнийг мэдэж болохгүйг сана гэж хатуу сануулав” гэж байна. Сайн мэдээ иймэрхүү анхааруулгаар дүүрэн.

Есүс газар дээр байх хугацаандаа газрыг Аавтайгаа холбох холбоос болж байв. Тиймээс Хүүд нь хэрхэн хандсанаараа л Аавыг нь бодитоор хүндэтгэх боломжтой байлаа. Иймээс л үнэт тосоор Хүү Есүсийг нь хүндэтгэсэн нэр нь үл мэдэгдэх эмэгтэйг буруушаагаагүй. Есүс Өөрийг нь хүндэтгэсэн хэнийг ч зэмлэлгүй, харин ч тэднийг Аавтай тогтоох энэ холбооных нь төлөө сайшаадаг байсан. Есүс Өөртөө хүндэтгэл хайгаагүй, харин Өөрийг нь илгээсэн Нэгэнийг хэрхэн хүндэтгэх *Хүндэтгэлийн зарчмыг* Өөрийн биеэр үлгэрлэн харуулдаг байжээ.

Хүндэтгэлийн урсгал

Есүс цовдлогдсон долоо хоногтоо Түүнийг явсны дараа ч үйлчлэл нь үргэлжлэх талаар дараах чанга мэдэгдлийг хийсэн:

“Би та нарт хэлье. “Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ” гэж хэлэх тэр цагийг хүртэл та нар Намайг харахгүй” (Лук 13:35).

Өөрөөр хэлбэл, “Та нар Миний илгээсэн хүмүүсийг “Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй” хэмээн хүлээн зөвшөөрөх хүртлээ дахиж Намайг харахгүй” гэжээ. Бас арай өөрөөр хэлбэл “Миний нэрээр илгээсэн хүмүүсийг *хүндэтгэлээ* та нар Намайг дахиж хүлээж авахгүй юмуу харахгүй” гэжээ. Одоо зогсоод, үүнийг эргэцүүлнэ үү. Есүс биднийг Өөрийнх нь илгээсэн хүмүүсийг ерөөж, хүндэтгэбэл л Өөрийгөө харуулна гэж хэлжээ. Яагаад? Есүс үүнд Бичээсийн хэсгээр хариулсан. Ийм нэг мэдэгдэл нь: Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний илгээх хэнийг боловч хүлээн авч буй нь (*хүндэтгэдэг нь*) Намайг хүлээн авдаг (*хүндэтгэдэг*). Намайг хүлээн авдаг нь (*хүндэтгэдэг нь*) Намайг Илгээгчийг хүлээн авдаг (*хүндэтгэдэг*) гэж айлдлаа (Иохан 13:20, тодруулгыг нэмэв).

Тэгэхээр, хүндэтгэлийн энэ зарчмыг өдөр тутмынхаа амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар Есүс цааш нь:

Та нарыг хүлээн авах нь Намайг хүлээн авсан хэрэг юм.
Намайг хүлээн авах нь Намайг Илгээгчийг хүлээн авсан

хэрэг юм. Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүлээн авах хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна. Үнэнээр Би та нарт хэлье. Ийм өчүүхнүүдийн нэгэнд, шавийнх нь хувьд уух аяга хүйтэн ус өгсөн хэн ч шагналаа эс алдана гэв. (Матай 10:40-42) гэж хэлжээ.

Тэгэхээр, би *хүлээн авах, өгөх* гэдэг үг болгоныг утгыг нь өөрчлөхгүйгээр *хүндэтгэх* гэдэг үгээр орлуулъя.

“Та нарыг *хүндэтгэх* нь Намайг *хүндэтгэсэн* хэрэг юм. Намайг *хүндэтгэх* нь Намайг Илгээгчийг *хүндэтгэсэн* хэрэг юм. Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг *хүндэтгэх* хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр *хүндэтгэх* хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна. Үнэнээр Би та нарт хэлье. Ийм өчүүхнүүдийн нэгэнд, шавийнх нь хувьд уух аяга хүйтэн *усаар хүндэтгэл үзүүлсэн* хэн ч шагналаа эс алдана гэв.”

Энэ үгийг илүү далайцтай ойлгохын тулд дээрх эшлэл дээрх хоёр гол зарчмыг авч үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт - Бурханы хаанчлалд эрх мэдлийн бүтэц гэж бий. Энэ нь Ааваас эхлээд, явах бүх эрх мэдлийг олгон илгээсэн Нэгэн болох Есүс рүү уруудан бууна. Амиллынхаа дараа Есүс “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” (Матай 28:18) хэмээн мэдэгдсэн. Есүс чуулганы тэргүүн бөгөөд Тэрбээр хожим бүх тэрслэл өлмий дор нь орсны дараа Хаанчлалаа Аавдаа эргүүлэн барих өдөр ирнэ (1Коринт 15:24-26).

Хаанчлал дорх удаах эрх мэдэл нь “эш үзүүлэгч” болно. Есүс Шинэ гэрээний Бичээс байхгүй хүмүүст хандаж айлдаж байгааг бүү мартаарай. Тэд бидний нэр томъёоллыг мэдэхгүй учраас, Есүс тэдний мэддэг ойлголтоор нь ярьжээ.

Хуучин гэрээний эш үзүүлэгч нар нь Эзэний хэвлэлийн төлөөлөгч шиг ажилладаг байж (Гэтлэл 4:16; 7:1). Үүнийг Еврей 1:1-2 цааш нь бататгадаг: “Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олонтаа бас янз бүрийн замаар айлдсан Бурхан эдгээр эцсийн өдрүүдэд бүхний өвлөгчөөр томилсон, ертөнцийг бүтээсэн Хүүгийнхээ дотор бидэнд хандаж хэлэв.” Үүнийг Шинэ гэрээ Есүс хэрхэн үхлээс амилуулагдаж, өндөр өргөгдсөн тухай өгүүлэх дараах үгээр давтан хэлдэг: “Тэр, заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайнмэдээ тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгосон нь...” (Ефес 4:11).

Есүс хэрэв өнөөгийн бидэнд хандаж өгүүлсэн бол, нэг иймэрхүү үг хэлэх байсан болов уу: “Элчийн нэрээр элчийг хүндэтгэдэг нэгэн ину элчийн шагналыг хүлээн авна; пасторын нэрээр пасторыг хүндэтгэдэг нэгэн ину пасторын шагналыг хүлээн авна.” За тэгээд, эш үзүүлэгч, сайн мэдээ дэлгэрүүлэгч, багш нарын тухайд ч адилхан.

Матай 10 дээр Есүс эш үзүүлэгчийг (юмуу удирдлагад байгаа хүмүүсийг) хүндэтгэх тухай яриад, дараа нь зөвт хүн рүү ороод, эцэст нь “хамгийн өчүүхэн” нэгнийг хүндэтгэх тухай хэлээд дуусгасан. Есүс үндсэндээ итгэгч хүмүүсийн харилцаа холбоонд ордог бүхий л суурь, эрх мэдлийн бүтцийг бүхлээр нь хөнджээ - бидний дээрх эрх мэдэлтнүүд, бидэнтэй адил төвшний хүмүүс тэгээд бидний халамжинд юмуу төлөөний эрх мэдэл дор байдаг хүмүүс. Бидэнтэй уулзаж учирдаг хүн болгон энэ гурван талбарын аль нэгэнд нь багтдаг.

Энэ маань биднийг хоёр дахь гол зарчим дээр авчирч байна. Бид дээрх хүмүүсээ хүндэтгэбэл... шагнал хүлээн авах нь байна. Бид адил зэрэг зиндааны хүмүүсийг (нөхдөө) хүндэтгэбэл... шагнал хүлээн авах нь байна. Эцэст нь бидний халамж юмуу эрх мэдэл дорх хүмүүсийг хүндэтгэснээрээ... бас л шагнал хүлээн авах нь байна.

“Миний нэрээр илгээсэн хүмүүсийг *хүндэтгэглээ* та нар Намайг дахиж хүлээж авахгүй юмуу харахгүй” гэдэг үгийг санаарай. Үүнийг Матайн ишлэлтэй давхарлах юм бол, дээрх гурван төвшин нь тус бүр тэнгэрийн гайхамшигтай шагналыг тээдгийг мэдэж болно. Түүнчлэн, эдгээр шагнал нь ямагт Есүсийг хэн болохыг улам гүн гүнзгий мэдүүлэх илчлэлийг тээдэг. Тэгэхээр, бүгдээрээ номоо дуусан дуустал үүн дээр л төвлөрөе.

Удирдагчаас нэг их хамааралгүй

Эхний гурван бүлгээрээ бид Бурханаас хүлээж авахад хүндэтгэл нь ямар чухал үүрэг гүйцэтгэдгийг баримттай тогтоож гаргаж ирэхийн тулд маш олон Бичээс үзсэн. Товчхон сэргээн давтахад: элч Иохан бидэнд *бүрэн шагналаа* хүлээж авах арга замаар хичээнгүйлэн амьдрахыг зааварласан буюу. Элч Иоханы хувьд “бүрэн шагнал” хэмээн онцлон бичсэн нь мөн тал шагнал эсвэл огт шагналгүй хоцрох нөхцөл байж болохыг илтгэж байна. Есүсийн үйлчлэлийн хугацаанд зарим нь бүрэн шагнал, зарим нь тал шагнал, зарим нь огт шагналгүй үлдэж байсан бөгөөд энэ нь хүмүүс Есүсийг хэрхэн хүлээж авсантай (хүндэтгэсэнтэй) нь холбоотой байв.

Есүс явахаасаа өмнө “Миний нэрээр илгээсэн хүмүүсийг *хүндэтгэглээ* та нар Намайг дахиж хүлээж авахгүй юмуу харахгүй” гэсэн. (Лук 13:35-ыг утгачлан буулгав) Есүс цааш нь, хэрэв бид удирдагчийг хүндэтгэх юм бол, удирдагчаар дамжуулан Бурханы өгөх шагналыг хүлээн авах бөгөөд найз нөхдийн тал дээр ч тэгээд мэдээж эцэст нь бидний эрх мэдэл дор байгаа хүмүүсийн тал дээр ч ялгаагүй юм. Бүгдээрээ эхлээд эрх мэдэлтнүүдийн талаар авч үзээд, дараа дараагийн бүлгээрээ нөгөө хоёр төвшинг нь авч үзье.

Манай цагийн жишээ

Миний бие Сайн мэдээг номлохын төлөө зогсоо зайгүй аялдаг, олон аугаа үйлчлэгч нарыг хувьчлан танина. Тэдэн дундаас цөөн хэд нь үнэхээр онцгойрдог. Хамгийн эхнийх нь Ти. Эл. Осборн гуай, түүний гэргий Дэйзи Осборн гуай хоёр болно. Үүнийг бичиж байхад, тэр хоёр хэдийнээ мөнхийн шагналаа хүлээн авахаар тэнгэрт дэвшээд буй. 1980-аад оны адгаар Лиза, бид хоёрт тэдэнд хэд хэдэн удаа үйлчлэх завшаан тохиож билээ. Тэр үед би найман мянган хүнтэй чуулганд үйлчилдэг байсан бөгөөд би зочин номлогчдыг халамжлах ажилтай байв. Осборныхон хэд хэдэн удаа айлчилсан учраас, би тэдэнтэй нилээд их цагийг өнгөрөөж билээ. Ихэд дотносож, байнга бичилцэж бас утсаар ярилцана. Ти. Эл гуай хоёр ч удаа надад хайрцаг дүүрэн хувцас илгээсэн бөгөөд бид хоёр нуруу туруугаар яг адилхан байв. Тэр эрхэм өмнө ч миний итгэлийн баатар байсан, одоо ч байгаа.

Тэр үед Ти. Эл гуай, Дэйзи хоёр хэдийнээ сая, сая сүнснийг авралд хүргээд байлаа. Үнэндээ тэдний үйлчлэлээр тавь гаруй сая хүн Есүс дээр ирсэн гэсэн тооцоо бий. Энэ ажил зурагтаар бус, харин даян дэлхийг тойрон хийсэн Сайн мэдээний задгай аяны үйл ажиллагаагаар нь гүйцэлджээ. Гэхдээ дийлэнх нь Африк тивд өрнөжээ. Тэдний цуглаанд 50,000 - 250,000 хүн оролцдог байв.

Цуглаан болгон дээр нь хэд хэдэн хүн хараа орно. Таг сохор ирсэн хүмүүс хараатай болоод явна! Энэ бол мөсөн уулын оройн хэсэг нь л шүү. Зуу, зуун дүлий хүн сонсгол орж, эдгэшгүй өвчтэй нь эдгэрч, дамнуурган дээр зөөлгөн цуглаанд ирсэн үй олон өрөөл татанхай хүн явж чаддаг болоод, хэвтрээ өөрөө зөөгөөд явна. Осборн ах нэн ялангуяа Африкт задгай цуглаан дээр болсон ер бусын, онцгой эдгэрлийн талаар хэдэн боть болгон бичсэн байдаг.

Тэр хоёрын ярих маш дуртай нэгэн түүх нь Африкт хийсэн Сайн мэдээний аяны цуглааны хоорондуур Дэйзитэй уулзсан нэгэн эмэгтэйн тухай яриа байдаг байлаа. Тэрбээр гартаа үхсэн нялх хүүхдээ тэвэрсэн байжээ. Эмэгтэй хүүхдээ өлгийгөөр нүүр амгүй, битүү ороосон байж. Ээж нь хүүхдээ Дэйзид өгөөд, дахин амьдрахын төлөө залбирч өгөөч хэмээн орчуулагчаар дамжуулан гуйжээ. Дэйзи өлгийдсэн шарилыг тэврээд, маш энгийн залбирал хэлжээ. Тэгсэн чинь эгшин зуурын хооронд өлгий дотор дотор хөдөлгөөн мэдрэгдсэнээ, ханиалгаж, найталгах чимээ гарсан байна. Дэйзи өлгийг нээтэл, дотроос нь түүн рүү хөөрхөн амьд хүү бүлтийн ширтэж байв.

Дэйзи хүүхдийг дахин хучаад, ээжид нь буцааж өгчээ. Ээж нь өлгийг нь сөхөөд, хүүгийнхээ нүүрийг үзүүтээ, ухаан жолоогүй баярлан хашхирч эхэлжээ.

Дэйзи жаахан гайхав. Тэр ээж яагаад өөрийнх нь гар дээр байгаа хүүхдийнхээ ханиалгаж, найтаах чимээг сонсоод шууд баярладаггүй билээ хэмээн гайхжээ. Яахаараа заавал өлгийг нь сөхөж, нүүрийг нь харсан хойноо л баясан хөөрдөг билээ?

Тиймээс Дэйзи орчуулагчаар дамжуулан эхээс нь учрыг нь асууж гэнэ. Гэтэл ээж нь “Миний үр ганц л нүдтэй төрсөн юм. Эд эрхтэн нь бүрэн хөгжөөгүй, нэг нүд нь хоосон нүх л байсан. Гэтэл одоо миний хүү хоёр хөөрхөн нүдээр намайг ширтэж байна!” гэж хариулжээ.

Тэр хоёроор дамжин, бидний амьд Аврагч Есүс Христийн нэрээр үйлдэгдсэн, ийм биширмээр түүх үй олон.

Африкт буюу ялангуяа Етиоп, Суданд маш олон аян хийсэн өөр нэгэн анд надад бий. Түүний аянд 50,000 - 200,000 хүн оролцоно. Түүний цуглаан дээр ч бас зуу, зуун нүд, чих нээгдсэн. Тахир татуу хүмүүс явж, үй олон өвчин эдгэрч, хорт хавдар жижгэрч утсан.

Хэдэн жилийн өмнө тэрбээр надад хамгийн содон түүхээ өгүүлэв. Түүний цуглаан хийсэн Африкийн гүний нэгэн газар “Хүн - бич” нэрээрээ алдартай нэгэн хүн байжээ. Чөтгөрт битүү эзлэгдсэн тэр хүнийг амьд амьтан номхруулж дийлдэггүй байсан юмсанж. Тэр модон дунд чармай нүцгэн амьдарч, дөрвөн хөллөж явдаг байж. Гар нь ч хөл шиг нь л эвэршиж, хатуурсан байж.

Гэтэл нутгийн хэсэг иргэд түүнийг хүлж боож байгаад, цуглаан дээр авчиржээ. Найз минь надад “Жон, намайг үй олон хүнд номлож байтал, гэнэт агаар дээр нэг хүн нисээд гараад ирснээ, газар дээр уначихсан - бараг 2 метр хагастай том хүн. Тэгээд хөдлөөгүй. Би түүнийг үхчихлээ л гэж бодсон. Маргааш нь тэрбээр хослол өмсөөд, Бурхан өөрийг нь хэрхэн чөлөөлсөн тухай тайзан дээрээс гэрчилж байсан. Нөгөө хүн - бич гэж ярьсан юм.

Тэгээд дараа нь “Тэр хавьд хүн - бичийг мэдэхгүй хүн байгаагүй учраас, хэдэн арван мянган хүнтэй цуглаан маань хэдэн зуун мянган хүнтэй болж нэмэгдсэн. Хүмүүс тэр хоригдлыг чөтгөрийн хүчнээс сулласан Бурханы Үгийг сонсох гэж оволзсон” гэж ярьсан юм.

Би нэн ялангуяа Африкт ийм хүчирхэг ажил өрнөхийг үзсэн эрчүүд, эмэгтэйчүүдийн үй олон түүх хэлж чадна. Тийм боловч, яг тэр үйлчлэгч нар Америкт юмуу Барууны улсаар яваад, яг л адилхан үйлчлэгч яг л адилхан тосолгоогоор, яг л адилхан үйлчлэлийн

техникээр яг л адилхан үг номноход, цуглаан дээр нь хэдэн тооны толгойн өвчин, нуруун өвчин юмуу үе мөчний өвчин эдгэрдэг байна. Яагаад тэр вэ? Хамаг учир нь хүндэтгэлдээ л бий! Сая миний ярьсан нөхдөд зарим газар үнэхээр үнэ хүндэтгэлтэй ханддаг. Тэднийг Бурханаас илгээсэн эрчүүд, хүүхнүүд хэмээн үзэж, яг л хаад ноёд шиг хүлээн авдаг байна.

“Та чинь Бурханы хүн мөн биз дээ?”

Би ч бас Африк тивийн Кени, Зимбабве, Ангол зэрэг улсад хэд хэдэн удаа үйлчилж явсан. Заримдаа надад үзүүлж буй тэр их хүндэтгэлээс нь зовох ч шиг (Үнэхээрийн зовмоор хүндэтгэхийг нь яана). Бараг л хаан аятай л хүндэтгэнэ. Угтаж авсан хүмүүс маань намайг маш гоё зочид буудалд буулгана. Энэ бүхэн тэдэнд санхүүгийн талаасаа хүндхэн тусч байгааг би мэднэ шүү дээ. Тэд надад юу ч бариулахгүй - бүр Библийг минь ч булаагаад авчихна. Хамгийн тансаг хоол идүүлж, хамгийн шилдэг хүмүүсээрээ үйлчлүүлнэ.

Нэг удаа намайг хэдэн мянган хүнд номлосны маань дараа, хөргүүртэй өрөөнд маань буцааж авчирсныг санаж байна (тэр цуглаанд оролцож байгаа олон хүн амьдралдаа нэг ч удаа хөргүүр үзээгүй байв). Бусад үйлчлэгч нараа тэргүүлсэн нэгэн эмэгтэй өмнө маань толгой бөхийн өвдөглөн суугаад, том сав барьтал, өөр нэг эмэгтэй гарыг маань угаалгахаар ус цутгаж өгөв. Миний өмнөөс гарыг маань угааж өгсний дараа бас нэг эмэгтэй шууд дээрх алчуураа аваад, гарыг маань хуурай болтол нь арчиж өгөв. Тэд намайг хүндэтгэхдээ, дээд зэргээр үйлчилж байлаа.

Эмэгтэй хүн өмнө минь сөгдөөд унахаар, надад хичнээн тавгүй байсныг ойлгож байгаа байх. Би *“Би өөрөө гараа угааж чадна, та нар угаах шаардлагагүй”* гэж бодсон ч, Ариун Сүнс надад *“Бүү татгалз. Зүгээр үйлчлүүл”* хэмээн хатуу анхааруулах шиг санагдав.

Хүндэтгэл, мөргөлийн хооронд ялгаа бий. Бид өнийн мөнхөд *ганцхан* Эзэн, Хаан, Бурхандаа л мөргөнө. Гэхдээ бид өнийн мөнхөд хүндэтгэх ёстой хүмүүсийг хүндэтгэнэ. Бурханы хаанчлалд ийм л зүй зохицолдолгоо тогтоно.

1990 онд надад нэгэн алдартай элчийн удирдагч нарт номлох завшаан тохиож билээ. Тэр эрхмийн удирддаг чуулганууд 5 сая гаруй хүнтэй. Чуулганууд нь Африк тивийн 18 улсад байдаг. Жил бүрийн 2-аар сард

зургаан мянган тэргүүн пасторыг (туслах пасторуудыг урьдаггүй байв) цуглуулаад, Америк болоод бусад тивийн удирдагч нарыг урин, пасторууддаа номлуулна. Миний л мэдэхийн ерээд оны арван жилд миний хамгийн хүчирхэг тосолгоотой үйлчилсэн нэг тохиолдол маань байв. Би яг л өөр ертөнцийн хүн шиг л номлов. Бурханы оршихуй ч уушги зүрх сорж байлаа.

Цуглааны хоорондуур надад түрүүн ярьсантай л адил үйлчилж байв. Үйлчилсэн хүнийг гарсан хойно, удирдагч нь над руу хараад “Сая танд үйлчилсэн эмэгтэйг харав уу? Улсынхаа тагнуулын газрын дарга шүү дээ” гэж хэлсэн юм.

Би ч нам цохиулав. Тэгээд ухаан балартахгүйн тулд толгойгоо сэгсрээд “Тагнуулын газрын дарга хүн надад ингэж үйлчиллээ гэж үү дээ? Тийм том хүн миний төлөө ингэтэл даруугаар үйлчлэх гэж. Миний хувьд, түүгээр үйлчлүүлэх нь байтугай, дэргэд нь байх нь л өндөр хүндэтгэл байтал” гэж ирээд л итгэж ядан хэллээ.

Тэгтэл аугаа элч маань гайхсан янзтай намайг хараад “Та чинь Бурханы хүн мөн биз дээ?” гэж хэлэв. Надад *“Америкчууд - бид чинь ийм юм ойлгодоггүй шүү дээ”* гэж л бодогдлоо.

Төлөөлөгчийг хэрхэн хүлээж авах

Би Бурханы Үгийг гучин таван жил гаруй жил аялан, зааж явна. Тэгээд нэг зүйлийг байнга анзаардаг юм. Хөгжиж байгаа улс, шорон, цэргийн бааз, ангиуд дээр үйлчлэх хамгийн амархан байдаг (том, том гайхамшиг, нөлөө өрнөж, номлоход ч амархан, Бурханы оршихуй ч хүчтэй байдаг). Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, тэд эрх мэдлийг дээдлэн, хүндэтгэл үзүүлдэг. Тэгвэл, эсрэгээрээ - тэнгэрлэг эрх мэдлийг хүндэтгэдэггүй Христэч ахлах сургууль, чуулган дээр үйлчлэх хамгийн хэцүү байдаг.

Тэгээд энэ нь үйлчлэгч - миний биетэй холбоотой гэхээсээ илүү хүмүүсийн хүлээж авч байгаа хандлагатай холбоотой байдгийг ойлгосноо санаж байна. Би Америкийн Зүүн - Өмнөдийн нэгэн чуулганд номлох хуваарьтай байлаа. Тэр газарт мөн мянга таван зуу гаруй хүнтэй, тус мужийн хамгийн чанга дэглэмтэй шорон байдаг байв. Чуулганы тэргүүн пастор нь давхар шоронгийн туслах тахилчаар үйлчилнэ. Тэгээд надаас Бүтэн сайны өглөө шоронгийн хоригдлуудад номлох тухай бодолцож үзэхийг хүслээ. Цуглаан нь өглөө 8.00 цагт

эхэлдэг бөгөөд чуулганы цуглаан 11:00 цагт эхэлдэг болохоор, бидэнд аль, алийг нь хийх цаг байв. Би ч дуртайяа зөвшөөрлөө.

Бүтэн сайны цуглаанд зуу гаруй хоригдол суув. Магтаал нь биширмээр байв. Эрчүүд хамаг л зүрхээрээ дуулж байлаа. Би ч цуглааны дараа магтаалын удирдагчаас хэдэн жил суухыг нь асуух хүртлээ чанга дэглэмтэй шоронд байгаагаа ч таг мартсан байв. Тэрбээр нүдэнтэй цогтой, бөөн баяр болсон хүн байсан болохоор нь хоёр, гурван жил л гэж хариулах юм байх гэж бодож байлаа.

Гэтэл тэрбээр намайг амгалан бөгөөд даруу гэгч нь хараад “Эрхэм ээ, би насаараа суух ялтай” гэж хариулсан юм. Би ч нам болов. Тэрбээр надад дээд зэргийн хүндэтгэл үзүүлж байлаа. Ер нь тэнд байсан хүн бүрээс ийм хүндэтгэл мэдрэгдэж байлаа. Өөр газрын үйлчлэгч тэдэнд Есүсийн тухай ярихын тулд цаг гаргаж байгаад ирсэн гэдэгт тэд итгэж ядан гайхжээ. Тийнхүү надад үзүүлсэн хүндэтгэл нь үгээр илэрхийлэшгүй байв. Тэдний хүлээн авах хандлагад нь би гүнээ даруусав.

Тэр өглөө микрофон авсныхаа дараа би чухам өөр ертөнцийн хүн шиг л номнож гарлаа. Тийм хүчтэй тосолгоо, тийм дүүрэн эрч хүч... би ч яг л багаа аваргын цомд бэлтгэж байгаа хөл бөмбөгийн дасгалжуулагч шиг л жирийлгэж байлаа. Эрчүүд ч бөөн эрч хүч... уухайлж хашхиралдаад л... бид ч ёстой л алж өгч байв!

Би цаг гаруй номлосон бөгөөд дараа нь Бурханы Сүнс зааланд залран мориж, бүтэн цаг хагасын турш ер бусын юмс өрнөх нь тэр. Эрчүүд аврагдаж, Ариун Сүнсээр дүүрч, эдгэрч, бүтэн цагийн үйлчлэлд дуудагдав.

Цуглааны дараа манай аяллын туслах гарч ирээд, микрофоныг аваад, хоёр хацраараа нулимс бөмбөрүүлсээр “Би энд амьдардаг байсан бол, энэ л цуглаанд явах байсан” хэмээн үнэн голоосоо хэлсэн юм. Хариуд нь танхим доргиом уухай хадаж, эрчүүд галзуу аятай баярлан хөөрөв.

Бид 10:30 гээд шоронгоос явлаа. Пастор, манай туслах, бид 3 савлаж байлаа. Тэгээд пасторын чуулганы цуглаан бүр ч ер бусын болно гэсэн итгэл найдвараар ярилцаж явав. Би “Ийм зүйлийн дараа ер бусын цуглаан болох нь тодорхой” гэж хэлэв. Биднийг ирэхэд, бидний дээрх алдар тэр чуулганаар халин дүүрнэ гэдгийг би зүгээр л мэдэж байлаа.

Тэгээд үнэхээр ч юу болсныг би хэзээ ч мартахгүй. Би цуглаанд явж ороод... бараг дуугарч ч чадахгүй байлаа. Уур амьсгал маш хүнд, дарамттай, номлоход бөөн саадтай. Тэгээд дотроо бодлоо: *Байзаарай,*

би чинь хоёр ч хүрэхгүй цагийн өмнө өөр ертөнцийн хүн шиг л номлож, зааж байсан. Юу болоод байна аа? Ойлгох юм байсангүй. Би өөрийгөө босгож ч чадахгүй, ер нь яаж ч чадахгүй, зүгээр л хөшчихөөд байлаа. Амьдралын маань тосолгоо чөдөрлөгдөв. Тэр үед би хүндэтгэлийн зарчмыг мэддэггүй байв. Суралцаж явсан гэх үү. Харин одоо бүх хүнд мэдүүлэхийг хүснэ!

Тэгэхээр, нөгөө шоронд болсон үйл явдлын хүчийг дүгнэе! Арван зургаан жилийн дараа намайг Небраска мужийн Омахагийн нэгэн том чуулган номлуулахаар урив. Намайг тэнд юу хүлээж байгааг би гадарласан ч үгүй. Эхний цуглаан дээр л би тус чуулганы саунд самбар дээр ажиллаж байгаа, бүтэн цагийн ажилтан нь нөгөө шоронд Бүтэн сайны өглөөний цуглаан дээр магтаал удирдаж байсан хүн мөн болохыг танив. Миний цочирдож бас баярласныг ээ. Тэгээд асуулаа: “Та яаж гарсан бэ? Та чинь ямар ч тэнсэнгүй, гурван удаагийн насаараа хоригдох ялтай байсан биз дээ?”

Тэгтэл тэр эрхэм ч надад чөлөөлөгдсөн гайхамшигт түүхээ хүүрнэлээ. Нарийн бичих гэвэл, бүтэхгүй. Гэхдээ тэр эрхэм надад арван зургаан жилийн өмнө Бурханы Сүнс эрчүүдийн дунд хөдөлж байх үеэр миний түүнд өгсөн эш үзүүллийг үзүүлсэн юм. Шоронгийн цуглааныг хуурцаг дээр бичсэн байсан нь түүнд миний хэлсэн үгийг хуулж бичих боломж олгожээ. Тэр олон жилийн хугацаанд тэмдэглэл хөтөлжээ. Тэгээд надад тэмдэглэлээ гардуулаад, олон жилийн өмнө шоронд миний түүнд хэлсэн үгийг уншиж өгөв. Тэр үгэнд Бурхан түүнийг хаанчлалын төлөө бүтэн цагаар үйлчлэх бөгөөд шоронгийн дөрвөн хана нь гадаад ертөнц дэхь хожмын үйлчлэлийнх нь бэлтгэл төдий гэжээ. Би энэ үгээ тэр эрхмийг гурван удаагийн насаараа хоригдох ялтай гэдгийг нь мэдэхээсээ өмнө хэлсэн байв. Ял нь хэр хүнд болохыг мэдсэн хойноо хэлсэн бол, тун хүнд байх байв.

Энэ явдал шоронгийн цуглаан дээр Бурхан хичнээн хүчтэй хөдөлсөн ч, цаг хүрэхгүй хугацааны дараа чуулган дотор уур амьсгал хичнээн хүнд бөгөөд хөшүүн байсныг харуулж байна. Би номлож ч чадахгүй байсан. Тэр өдөр би энэ бүхэн надтай холбоогүй, харин намайг Бурханаар илгээгдсэн хүний маань хувьд хэрхэн хүлээж авсантай маань холбоотой байсныг сурсан юм. Хоригдлууд намайг үнэлсэн, хүндэтгэсэн, эрхэмлэсэн. Чуулганы гишүүд биеийнхээ хэлээр л “Бид мэднэ ээ. Олон номлогч нарыг сонссон. Танд хэлчих өөр юм байна уу?” гэдгийг хэлсэн. Үр дүнгийн том ялгаа нь хүндэтгэл гэдэг ганц үгээс л үндэслэн гарчээ.

Доромжлуулсан ч, хүндэтгэсэн

Хамаг учир нь үйлчлэгчдээ бус, харин тэр удирдагчийг хэрхэн хүлээж авахтай холбоотой болохыг өөр нэгэн Бичээсээр батлан харуулахыг болгооно уу. Хуучин гэрээнд Елкана гэдэг нэгэн эр байв. Тэрбээр Ханна, Пенина гэдэг хоёр эхнэртэй (Өнөөдөр ийм ёс байхгүйд би ёстой башийдаг. Би ганц эхнэртээ л хайртай.)

Пенина нь хүүхдүүдтэй бол, Ханна нь хүүхэдгүй, хүүсэр байв. Тэр үед эмэгтэйчүүд нөхөртөө нэн ялангуяа хөвгүүд төрүүлж өгснөөрөө хайраа харуулдаг байж. Яагаад? Удам залгах гэдэг утгаараа тэр.

Жил бүр тэр гэр бүл Шилод очоод, Эзэнд өргөл өргөдөг байж. Пенинагийн хүүхдүүд олширсоор байсан бол, Ханнад Эзэнд даатгах үр хүүхэд байхгүй. Ханна нүүр хийх газаргүй болж, дээрээс нь Пенина түүнийг тавлана. Бичээс “Пенинна түүнийг бухимдуулах гэж байдгаар нь өддөг байлаа” (1Самуел 1:6) гэдэг. Пенинагийн галзууруулмаар доромжлолыг төсөөлж байна уу? “Хөөе хүүхээн, хэн нь нөхөртөө илүү хайртай байх нь? Би түүнд олон ийм олон хүүхэд төрүүлж өглөө. Чиний хүүхдүүд хаана байна? Нойтон сормуустай амьтан төрүүлж үзээгүй чамайг хэн эмэгтэй хүн гэх билээ дээ? Эр нөхөр чинь чамайг ор дэрэндээ жигшээд байгаа юм уу? Тоохгүй байгаа юм уу? Тэр надад л хайртай болтой” гэх мэтээр тавласан л байх.

Тэгээд нэг удаа Ханнагийн тэвчээр барагджээ. Ханна дайснаасаа зайлаад, майхан сүмд очоод, Эзэний оршихуйгаас амар амгалан олохыг хүсч. Ханна тавгүй байсан тул Эзэнд залбирахдаа, гашуудан уйлжээ.

Ханна үнэн голоосоо өгүүлэхдээ ам нь хөдлөх боловч, үг авиа гарсангүй. Тэр Эзэнд хандан түүний умайг нээж, хүүхэд заяабал, тэр хүүг насаар нь бөгөөд мөнхөд Эзэнд үйлчлүүлэхээр өргөнө гэсэн хүсэлт өргөжээ.

Ханна зүрхэндээ ярьж, зөвхөн уруул нь хөдөлж, харин дуу нь сонсогдохгүй байлаа. Тэгэхэд Ели түүнийг согтуу байна гэж боджээ. Ели түүнд —Хэдий болтол чи согтуу байх юм бэ? Дарснаасаа сал гэв (1Самуел 1:13-14).

Мөн л Ханна Америк хүүхэн байгаагүйд талархах юм. Америк байсан бол, Елиг зүгээр өнгөрөөхгүй дэг ээ. Жигтэйхэн хилэгнээд л ингэж бодох байсан болов уу: *Энэ одоо пастор хүн үү? Би мацаг*

барьж, Бурханы өмнө зүрх сэтгэлээ уудалж байхад, намайг согтуу гэв үү? Худлаа байгаа даа. Чихэндээ ч итгэмээргүй юм. Буруу л сонссон байгаа? Гэхдээ энэ хүн тэгж л хэллээ шүү дээ. Ямар хорон, бурхангүй, мэдрэмжгүй, хог вэ. Ийм этгээд чуулганы тэргүүн байж таарах уу? Дээш нь мэдэгдэж, халж, ажилгүй болгох хэрэгтэй!

Тэгээд шууд л “Та намайг согтуу гэв үү? Хүн наана чинь мацаг барьж, хэрэгцээнийхээ төлөө Бурханд зүрх юугаан уудалж байхад, та намайг архичин гэнэ ээ. Бурханыг үнэн голоосоо хайж байгаа хүнийг ялгаж салгаж мэдэхгүй байна уу? Та ер нь пастор мөн үү? Энэ ер нь чуулган мөн үү? Би нөхөртөө хэллээ. Бид хоёр эндээс явлаа. Баруун гудамжны чуулганд явах минь!” гэх байх.

Ханна ингэсэн бол, шагналаа авахгүй байх байв. Хүүхэд ч олохгүй тэгээд Эзэнд ч бөөн гомдолтой үлдэх байсан биз. Тэгээд Бурхан залбиралд хариулдаггүй Бурхан гэсээр чад хийх байсан байх. *Би мацаг барьсан, хичээнгүйлэн залбирсан. Гэвч Бурхан хариулаагүй.* Гэхдээ Ханна ийм юм хийгээгүй. Ханна өөрийг нь доромжилсон удирдагчид хэрхэн хариулсныг үзнэ үү:

Үгүй, эзэнтэн минь, би сүнсээрээ цөхөрсөн эмэгтэй байна. Би дарс ч, сархад ч уугаагүй, харин ЭЗЭНий өмнө сэтгэлээ уудалж байна. Шивэгчнээ үл бүтэх эмэгтэй гэж бүү үзэгтүн. Зовлон шаналал, гашуудлаасаа болоод ийм удаан ярилаа гэв” (1Самуел 1:15-16).

Ханна удирдагчаа гүнээ хүндэтгэсэн нь шууд л харагдаж байна. Эхлээд “Эзэнтэн минь” гэсэн. Дараа нь өөрийгөө “шивэгчин” гэсэн. Ханна удирдагчаа дээдийн дээдээр эрхэмлэсэн. Ханна түүнийг хүндэтгэсэн. Тэгтэл Ели Ханнад “Амар тайван явагтун! Израилийн Бурхан чиний гуйсан гуйлтыг биелүүлэх болно гэв.” (1Самуел 1:17)

Дараа дараагийн хэдэн сард нь Ханна хүүхэд олоод, жилийн дотор Самуел жаалыг төрүүлэв. Самуел Израильд сэргэлт авчирсан хүн болсон билээ. Ханнагийн олон жил хүссэн бас залбирсан зүйл нь өөрийг нь гутаасан тахилчийг хүндэтгэх хүртэл нь биелээгүй байна. Одоо бүр ч сонирхолтой. Энэ тахилчид хожим Бурхан “Түүний хөвгүүд өөрсдөдөө хараал авчирсан бөгөөд тэр тэднийг хазаарлаагүй тул түүний мэдсэн хилэнцийн учир өөрийнх нь гэрийг мөнхөд шийтгэхээр зэхэж байгаа хэмээн Би түүнд хэлсэн билээ. Тиймээс Би Елигийн гэрийн хилэнц нь өргөлөөр ч, тахилаар ч мөнхөд арчигдан

цэвэрлэгдэхгүй гэж Елигийн гэрт андгайлав” (1Самуел 3:13-14) хэмээн айлдсан байдаг.

Пээш, Бурханаас өөрийнхөө болоод гэр бүлийнхээ талаар ийм үг сонсохыг хэн ч, хэзээ ч хүсэхгүй. Хэзээ ч уучлахгүй гэж! Гэвчиг Ханна ийм л хүнийг хүндэтгэснээрээ Бурханы хайр хишгийг хүлээн авсан. Хамаг учир нь Елигийн үйлдэлтэй холбоотой бус, харин Ханна эрх мэдэлтнийг хүндэтгэснээрээ, Бурханаас хүлээн авч чадсанд л байгаа юм. Бид дээрх эрх мэдэлтнүүдээ хүндэтгэх аваас, тэдний байр сууриар дамжуулж өгөх, Бурханы шагналыг хүлээн авна.

Эрх мэдэл

Эш үзүүлэгчийн юмуу удирдагчийн шагналын талаар үргэлжлүүлэн ярихаасаа өмнө эхлээд эрх мэдлийн үнэ цэнэ ямар чухал болохыг тогтоох хэрэгтэй. Энэ үнэн зүрхэнд маань нэгэнт тогтоод авбал, бид дээр байгаа хүмүүсээ үнэн голоосоо бөгөөд хавьгүй үр нөлөөтэй хүндэтгэдэг болно.

Хүндэтгэл гэдэг үгийн утгыг санацгаая: “үнэлж цэнэлэх, жинтэй бөгөөд нандин хэмээн үзэх”. Хүндэтгэлийн объект маань бидний дараа дараагийн хэдэн бүлгээрээ үзэх сэдэв болох эрх мэдэлтэн бол, хүндэтгэхүй нь хүндэтгэл, тэр бүү хэл дээдлэл гэсэн утга агуулаад явчихна. Уэбстэрийн толь бичиг дээр (1828 оны хувилбар) *хүндэтгэлийг* “өндрөөр хүндэтгэх, хүндэтгэх, *эрхэмлэх* ба *захирагдаж* хандах, *тухайн хандлагынхаа дагуу хариуцлагатай үйлдэх*” гэж тодорхойлжээ. Тэгэхээр, эрх мэдэлд захирагдах нь жинхэнэ хүндэтгэлийн бүтэц болохыг энэ тодорхойлолтоос харж байна.

Эрх мэдлийг хүндэтгэдэг гэх атлаа эрх мэдэлд дуулгаваргүй, захирагдахгүй байвал, өөрийгөө л мэхэлсэн хэрэг болно. Эрх мэдлийг хүндэтгэхүй нь эрх мэдэлд захирагдах явдал бөгөөд бид эрх мэдэлд захирагдахгүй бол, эрх мэдлийг үл хүндэтгэж байгаа явдал болно. Ромын цэргийн албан тушаалтныг сана: тэрбээр эрх мэдлийг мэддэг, хүлээн зөвшөөрдөг, үүндээ захирагддаг хүн байсан. Энэ нь түүний зүрхэнд амьдардаг, оршихуйнх нь нэгээхэн цул байсан. Иймээс ч тэрбээр Есүсийг хүндэтгэхийн дээдээд хүндэтгэж, бүрэн шагналаа хүлээж авсан.

Эрх мэдлийн дөрвөн төрөл

Нэн ялангуяа өнөөгийн нийгэмд эрх мэдлийг баттай ойлгохгүй бол, хаанчлалын - төлөөний эрх мэдлийг авч хэлэлцэхгүй байх юмуу огт хүндэтгэхгүй байх амархан. Зүрх маань энэ үнэн дээр л суурилах ёстой. Бидэнд товч тодорхой хэлсэн:

Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд. Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэн хэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсдөдөө шийтгэл хүртэх болно (Ром 13:1-2).

Нэгдүгээрт - энэ нь санал төдий үг биш байгааг тэмдэглээрэй. Зөвлөгөө бус, харин тушаал шүү. Түүнчлэн “хүн бүхэн” гэж байгааг тэмдэглээрэй. Тэгэхээр, үүнээс гадуур үлдэх хүн байхгүй гэсэн үг. Есүсийн нэрийг дууддаг бүхэн энэ хариуцлагыг хүлээнэ.

“Эрх мэдэл” гэдэг нь хэнийг хэлээ вэ? Яг энэ хэсэг дээр Паул нийгмийн болоод төр засгийн эрх мэдэлтнийг хэлжээ. Тийм боловч, энэ ятгалгын үг нь төрийн засгийн удирдагч нарт төдийгүй мөн төлөөний удирдагч нарт хэрэгжих ажээ.

Шинэ гэрээ дөрвөн төрлийн төлөөний эрх мэдлийн талаар өгүүлдэг: иргэний, чуулганы, гэр бүлийн, нийгмийн. Нийгмийн төрөлд би ажил олгогч, дарга, багш, дасгалжуулагч тэргүүтнийг оруулна. Шинэ гэрээ талбар бүрт тусгайлан тодорхой удирдамж өгдөг боловч, дийлэнх тохиолдолд энэ зөвлөгөө нь дан энэ хүрээгээр хязгаарлагдалгүй, төлөөний эрх мэдлийн бүх талбарт хэрэгжих юм.

Есүс эш үзүүлэгчийг эш үзүүлэгчийн нэрээр хүлээж авах тухай айлдахдаа, үүнийгээ зөвт хүнтэй, хамгийн сүүлд нь өчүүхэн нэгэнтэй холбож ярьсныг санаарай. Эндээс бид хүн: удирдагч нар, найз нөхөд, бидний эрх мэдэлд даатгагдсан хүмүүс гэсэн гурван төвшний хүмүүстэй харилцдаг болохыг харж болно гэж өмнө үзсэн. Удирдагч нарын тухайд, Есүс хэдийгээр чуулганы эрх мэдлийг нэр заан хаяглаж ирээд, “эш үзүүлэгчийн” тухай өгүүлсэн ч, зарчим нь дан энэ цар хүрээгээр хязгаарлагдахгүй, эрх мэдлийн бүхий л талбарт хэрэгжих юм. Үүнийг ч дараагийн бичээсээр баталж болно:

Ийм учраас та нар ч гэсэн татвар төлдөг. Учир нь захирагч нар Бурханы зарц нар бөгөөд энэхүү ажилд өөрсдийгөө зориулдаг юм. Бүгдэд өгөх ёстойгоо өг. Татвар авах ёстой хүнд татвараа, гаалийн татвар авах ёстой хүнд гаалийн татвараа төл, айж эмээвэл зохих хүнээс айж эмээ, *хүндэтгэл хүлээх ёстой хүнийг хүндэл* (Ром 13:6-7, тодруулгыг нэмэв).

Иргэний эрх мэдэлтнүүд нь Бурханаар л томилогддог бөгөөд Түүний төлөө ажилладаг. Бид тэр хүмүүсийг хүндэтгэснээрээ, тэднийг тохоон томилсон Нэгэнийг хүндэтгэж байгаа болно. Хариуд нь Бурхан эргээд биднийг хүндэтгэнэ. Энэ бол хүндэтгэлийн зарчим.

Нийгмийн эрх мэдлийн тал дээр ч ингэж хэлжээ:

Боолын ёсоор буулган доор байгаа бүгд өөрсдийн эздийг *хүндэлбэл* зохистой хэмээн үз. Тэгснээр Бурханы нэр ба сургаал муу хэлэгдэхгүй (1Тимот 6:1, тодруулгыг нэмэв).

Үүнийг өнөөдөр “Ажилтны ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бүхэн ажил олгогч, даргаа *хүндэлбэл* зохистой хэмээн үз” гэж ойлгож болно. Эсвэл “Оюутан сурагчийн ёсоор боловсрол эзэмшиж байгаа бүхэн багшаа хүндэлбэл зохистой хэмээн үз” гэж ч ойлгож болно. Энэ нь багийн удирдагч - багийн гишүүн, тамирчин - дасгалжуулагч юмуу харилцан захирч - захирагдах бүх төрлийн харилцаанд хамаатай. Гэр бүлийн эрх мэдлийн тухайд ингэж хэлжээ:

“Эцэг эхээ *хүндэл*.” Энэ бол амлалт бүхий эхний тушаал агаад “Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно” (Ефес 6:2-3, тодруулгыг нэмэв).

Аав, ээжээ хүндэтгэсний шагнал нь тушаалтайгаа хамт явж байна. Энэ талаар хожим дэлгэрэнгүй ярина. Тэгээд эцэст нь чуулганы эрх мэдлийн тал дээр ингэж хэлжээ:

Ах дүү нар аа, дунд чинь зүдэн зүтгэдэг ба Эзэн дор та нарыг удирдаж, зааварладаг хүмүүсийг *хүндэлж*, ажлынх нь төлөө та нар хайраар тэднийг өндрөөр үнэлэхийг хүсэж байна. Өөр хоорондоо эв найртай бай (1Тесалоник 5:12-13, тодруулгыг нэмэв).

Эрх мэдлийн талбар бүрт хамаатай өөр олон бичээс байдаг ч, дараа нь авч үзье. Хамгийн гол санаа нь Бурхан бидэнд төлөөний эрх мэдлийн талбар бүрийг хүндэтгэ, ингэснээр хүндэтгэлийн зарчим ч хэрэгжинэ гэдгийг л хэлж байна. Бид бүрэн байна уу, тал байна уу - шагналаа авах нь авах боловч, энэ маань эрх мэдлийг хэр үнэлсэн зэргээр маань л шийдэгдэх аж.

Хаанчлал

Бурханы хаанчлал нь хаанчлал гэдгийг бид санах ёстой. Тэнд зэрэг зиндаа, эрэмбэ дараа, төлөөний эрх мэдэл гэж бий. Энэ олон жил даян дэлхийгээр, (Антарктикаас бусад) бүх тивд сайн мэдээг номлож явахад минь Бурханы юмсыг хүргэх хамгийн хэцүү хүмүүс манай Барууныхан л байдгийг би байнга хэлдэг. Яагаад? Хариулт нь тун энгийн.

Бид чинь Хаанчлалын зарчмыг ардчилсан үзэл бодлоор ойлгох гэж хичээдэг хүмүүс.

Бурханы хаанчлал чинь ардчилал биш. Тиймээс, ардчилсан үзэл бодлоор Бурхантай холбогдох гэвэл, бүтэхгүй. Бид Түүний эрх мэдлээр хамгаалагдахгүй бөгөөд дорхноо буруу замаар орно. Магадгүй иймээс л Есүс манай үеийнхэн дундаас олон хүн маш амархан мэхлэгдэнэ гэсэн юм болов уу? Өнөөдөр бид урьд хожид байгаагүйгээрээ нийгмийн эрх мэдлийг үл хүндэтгэх болсон. Гэхдээ үл хүндэтгэгч нарын тоонд нийгэм төдийгүй, өөрсдийгөө итгэгч гэдэг хүмүүс явж байгаа нь хамгийн аюултай. Хууль ёсны бүх эрх мэдэл нь Бурханаас бөгөөд хамгаалж, хангаж, амар тайвны төлөө байдгийг бид цаг үргэлж санаж явах ёстой.

Барууны үзэл бодлоос болж л Америкт чуулган салж бутарч, үй олон хүн чуулганаас явж, гэртээ чуулган хийдэг болж байна. Өөрийгөө итгэгч гэдэг эдгээр хүмүүс Есүс Христийн Өөрийн биеэр тогтоож өгсөн эрх мэдэл дор байхыг үл хүснэ. Та *Гэхдээ Жон минь, Хятадууд гэр чуулган хийдэг шүү дээ* гэж хэлж магадгүй. Тэр үнэн. Гэхдээ тэд чинь нээлттэй уулзаж чадахгүй учраас л, аргагүйн эрхэнд гэрээр хийдэг. Түүнээс гадна тэд Бурханы Үгийн зарчмын дагуу дээд зэргийн зохион байгуулалттай байдаг.

Олон жилийн өмнө надаас Хятадын газар дорх нууц чуулганы таван удирдагчтай уулзахыг гуйж билээ. Тэр таван эр хэдэн арван сая хүний амь амьдралыг хариуцна. Тэд нууц чуулганы гол удирдагч нар байлаа. Тэд маш нарийн зохион байгуулалттай бөгөөд манай үйлчлэл чуулгануудад

нь бараг хагас сая ном илгээхэд, хэдхэн өдрийн дотор л тарааж дууссан юм. Тэд библийн эрх мэдэлтэй эгнэж урсдаг бүтэцтэй ажээ.

Гэтэл Америкт олширч байгаа гэр чуулганууд нь ийм арга замтай байдаггүй. Тэдэнд Шинэ гэрээний засаглал, үүрэг хариуцлага дутдаг.

Захидлаас үзэх юм бол, Паул Тит, Тимот зэрэг элч нарт илгээгдэж очсон чуулгандаа ахлахуудыг томил хэмээн байнга зааварладаг байсан бөгөөд ахлахууд нь чуулганаа засварлаж, зэмлэж, ятгаж, байгуулах үүрэгтэй байв. Есүсийн байгуулж өгсөн эрх мэдлээр тогтоогдсон хариуцлагын тогтолцоо байжээ. Тэгвэл манай улсын гэр чуулганд ийм зүйл бараг байхгүй. Харин ч шархлах юмуу гомдсондоо чуулганд юмуу бүх төрлийн бүтцэд ой гутсан итгэгч л дүүрэн байх. Тэд ямар ч үүрэг хариуцлагагүй чуулган хийхийн тулд өөртөө зассан, “гэр” хувилбарыг сонгожээ.

Чуулганыг хүн бус, Есүс байгуулсныг бүү март. (Чуулган ч хэзээд төгс байгаагүйг Паулын захидлаас үзэж болно) Үйлс номыг унших юм бол, итгэгчид нийтээрээ ч *бас* айл болгонд ч цугласан байдаг. Гэрээр цуглах сайн ч, удирдлага бөгөөд үүрэг хариуцлага маань төлөвшсөн ахлахуудаас ирэх ёстой.

Нэг зүйлийг ойлохыг хичээнгүйлэн гуйя: би гэр чуулганы эсрэг кампанит ажил явуулаагүй шүү. Даян дэлхийгээр дүүрэн амьд гэр чуулган бий. Гэхдээ тэд өөрсдийгөө Христийн илүү том биеийн нэгээхэн хэсэг гэж үздэг юм. Тэд гонсойсондоо, өвдсөндөө, маргасандаа тусгаар тогтноогүй.

Чуулган нь гишүүн - бус хүмүүсийн төлөө оршдог цорын ганц байгууллага гэдгийг умартах амархан. Бид чуулганыг “хэрэглэгч - хаан” гэдэг сэтгэлгээний бас нэгэн золиос болгочихсон боловч, угтаа чуулган нь бидний тав тухыг цатгадаг бас нэг газар ерөөс биш юм. Чуулган - бидний статус квотой тулж, Бурханы туулах гайхамшигт аялалд зоригжуулан зүтгүүлж байдаг удирдагч нар тэргүүтэй хүмүүстэй мөр зэрэгцүүлэх газар болой.

Хууль ёсны бүх эрх мэдэл Бурханаас

Ромын бичээс рүүгээ дахиж очъё. Тэгэхээр, хүн болгон засаглах эрх мэдэлд захирагдаж явах ёстой аж. Яагаад? Яагаад гэвэл “Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй...” (Ром 13:1). Ертөнц дээрх бүхий л

хууль ёсны эрх мэдэл нь бүгд Бурханаас эхтэй болой. Хэрэв та үнэхээр Бурханы Сүнсээр төрсөн бол, эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, үнэлэх л болно. Үнэндээ, та надад эрх мэдлийг хүндэтгэдэггүй хүнийг харуулах юм бол, би танд Бурханы хүүхэд биш хүнийг харуулаад өгнө. Бурхантай уулзсан хүн эрх мэдэлтэй уулздаг. Яагаад гэвэл Бурхан бөгөөд Түүний эрх мэдэл салшгүй болой. Тэр этгээд нүгэлтний залбирлыг хэлсэн, долоо хоног тутам чуулганд явдаг ч байж болно. Зүрхэндээ эрх мэдлийг хүндэтгэдэггүй этгээд нь жинхэнэ ариунтан биш юм.

Та “Жон, та арай л хатуурхаад байгаа юм биш үү?” гэж асууж болох. Есүс жинхэнэ итгэгч томъёолсон залбирал хэлснээрээ бус, харин үр жимсээрээ танигдана гэсэн. Бурханыг жинхэнээсээ мэддэг, хайрладаг хүн нь Бурханы эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг. Учир нь Бурханыг мэднэ гэдэг чинь эрх мэдлийг мэднэ гэсэн үг.

Паул Ром дээр цааш нь “эрх мэдлүүд... Бурханы тогтоосноор л байгаа...” (Ром 13:1) гэж хэлжээ. Энд эрх мэдлийг хүмүүс шилж, сонгодог гэж хэлээгүй байгаа биз? Үгүй ээ, эрх мэдлийг Бурхан Өөрөө л тохоон томилдог болой. Үнэндээ, энэ эшлэл дээрх тогтоосноор гэдэг үг нь “даалгах, томилох, байгуулах” гэсэн утга бүхий тассо гэдэг Грек үг байна. Энд “тохиолдлын чанартай” юу ч алга. Харин ч шууд томилгоо байна. Бурхан бүх эрх мэдлийг тохоон томилсон учраас, бид тэдгээрт захирагдахаас татгалзах юм бол, тэдний цаад Эрх мэдлийг нь эсэргүүцэж буй явдал болно. Мэдэх, мэдэхгүй маань хамаагүй - бид Бурханы томилгоо, захиргааг эсэргүүцнэ. Бид Бурханы төлөөний эрх мэдлийг эсэргүүцэхдээ, Бурханыг Өөрийг нь эсэргүүцнэ. Тиймээс л элч маань “Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэн хэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсдөдөө шийтгэл хүртэх болно” (Ром 13:2) гэж бичжээ.

Би анх энэ үнэнийг ухаарснаа санаж байна. 1992 онд Билл Клинтон Америкийн ерөнхийлөгчөөр сонгогдсон юм. Би ч үүнээс болж гурав хоног навс гутрав. Тэгтэл Өөрийнх нь мэдлээс гадуур хэн ч албан тушаалд очдоггүйг Ариун Сүнс надад ухааруулав. Зүрхэнд маань амилсан энэ илчлэлийн үр дүнд би ерөнхийлөгч Клинтоньг шүүмжлэхээ болиод, харин мэхийн хүндэтгэдэг, түүний төлөө залбирдаг, талархдаг болсон юм. Бурхан бидэнд элч Паулаар дамжуулан “Тиймээс бүх хүний төлөө гуйлт, залбирал, зуучлан залбирал хийгээд талархал өргө гэж юуны өмнө чамайг ятгая. Хаад болон эрх мэдэлтэй бүхний төлөө залбир. Тэгвэл бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах болно” (1Тимот 2:1-2) гэж хэлсэн билээ.

Эрх мэдлийг мэхийн хүндэтгэсний үр дүнд л амар тайван амьдрал ирдэг гэж хэлснийг тэмдэглэнэ үү. Эрх мэдлийг хүндэтгэсний хариуд ирдэг Бурханы нэгэн бэлэг нь энэ болой. Хэрэв итгэгч нар бид эрх мэдэлд байгаа хүмүүсийг хүндэтгэхгүй бол, толгой дээрээ л асуудал авчирна.

Хоёр төрлийн хавчлага бий. Нэг нь хүний өөрийн бий болгосон хавчлага бол, нөгөө нь зөвийн төлөө эдэлдэг хавчлага. Элч Петр аль алийнх нь тухай хэлсэн. Тэрбээр эхний хавчлагын тухайд “Хэрэв та нар нүгэл үйлдэж цохиулаад тэвчлээ ч, үүнд ямар гавъяа байх билээ? Харин та нар зөвийг үйлдээд зовохдоо, үүнийг хүлцэн тэвчвэл, энэ нь Бурханы нигүүлсэл юм” (1Петр 2:20) гэж хэлжээ. Товчхондоо, буруу юм хийбэл, үүнийхээ төлөө шийтгүүлнэ. Бүр энгийнээр хэлбэл, зогсох тэмдгээр давхиж гарчихаад, хажуугийн толиндоо улаан, цэнхрээр эргэлдсэн гэрэл харахаараа, чөтгөр рүү бүү чих. Яагаад? Бурхан эрх мэдлийг тогтоосны нэг шалтгаан нь энэ л байхгүй юу: “Учир нь сайныг үйлдэхэд захирагч нар нь айдас болдоггүй, харин мууг үйлдэхэд айдас болдог. Та эрх мэдлээс айхгүй байхыг хүсэж байна уу? Сайныг үйлд” (Ром 13:3). Тиймээс, өөрийн биеэр бий болгодог хавчлагаас сэргийлэх амархан. Зүгээр л эрх мэдлийг дага - тэгээд л асуудалгүй.

Тэгвэл зөвийн төлөө эдэлдэг хавчлага. Энэ нь бид зөв зүйл хийсэн байлаа ч, эрх мэдэлтнүүдээр шийтгүүлэх явдал юм. Петр ингэж хэлжээ: “Хэрэв та нар нүгэл үйлдэж цохиулаад тэвчлээ ч, үүнд ямар гавъяа байх билээ? Харин та нар зөвийг үйлдээд зовохдоо, үүнийг хүлцэн тэвчвэл, энэ нь Бурханы нигүүлсэл юм. Учир нь та нар үүнд дуудагдсан билээ. Яагаад гэвэл та нарыг мөрөөрөө дагуулахын тулд та нарт үлгэр дуурайл үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн”. (1Петр 2:20-21)

Бид шударга бус хандлага үзсэн атлаа сайн ажилтан, оюутан, иргэн, чуулганы гишүүн зэрэг хэвээрээ байсаар байвал, энэ маань дээд зэргийн хүндэтгэл болно. Зүрхэнд маань Эзэнээс эмээхүй байж байж л бид өөрт маань шударга бус хандаж байгаа хүмүүсийг үнэ цэнэтэйд тооцсоор байна.

Гэтэл өнөөдөр олон хүн энэ үгд анхаарахын оронд “Би эрх чөлөөтэй хүн. Би чинь итгэгч хүн. Би эрх чөлөөт улсад аж төрдөг хүн. Ийм утгагүй юмыг хүлээж авахгүй!” гэж ирээд л эсэргүүцдэг. Тийм ээ, та эрх чөлөөтэй. Гэхдээ Бурханы үг мөн “Ах дүү нар аа, та нар эрх чөлөө өөд дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махбодын төлөөх таатай боломж болгож бүү ашигла” (Галат 5:13) гэж мэдэгддэг юм шүү. Бид шударга

бус хандлагыг зөвөөр зохицуулах амьдралд дуудагдсан. Петр цааш нь: “Учир нь та нар үүнд дуудагдсан билээ. Яагаад гэвэл та нарыг мөрөөрөө дагуулахын тулд та нарт үлгэр дуурайл үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн” гэдэг. (1Петр 2:21)

Есүс ямар үлгэр жишээ үзүүлээ? Есүс дандаа зөв юм хийсэн атал Түүнийг эрх мэдэлтнүүд буруу хэмээн шийтгэсэн. Энэ нь нэгэн мөнхийн асуултыг төрүүлдэг: *Бид бурханлаг бус эрх мэдэлтнүүдийг, тэд бидэнд шударга бус хандаад байхад ч, хүндэтгэсээр байх ёстой юм уу?*

Бурханлаг бус эрх мэдэл?

Намайг ингэж хэлэхээр олон хүн “Жон, би маш харгис хатуу, өгөр гэмээр эрх мэдэлтнүүдийг мэднэ. Тэднийг тэгээд Бурхан гаргаж ирсэн гэж та хэлэх гээд байна уу? Үүгээр ч тогтохгүй, бид бүр тэдэнд захирагдах ёстой юм уу? Дүрмийн бус тохиолдол гэж байхгүй юу?” гэж ирээд л эсэргүүцлээ илэрхийлдэг.

Үнэн. Дарлан мөлжигч, харгис хатуу эрх мэдэлтнүүд олон байдаг. Үнэндээ Библи дээр ч дүүрэн бий. Гэхдээ Бурханы Үг юу гэдгийг бид ухаандаа санах ёстой. Бурханы Үг “*бүхий л эрх мэдэл нь Бурханых*” гэсэн боловч, *бүх эрх мэдэл бурханлаг* гэж хэлээгүй.

Бурхан Шинэ гэрээний бичээч нараар хүүхдүүдээ эрх мэдэлд захирагд хэмээн зааварлан бичүүлэхдээ, бурханлаг бус эрх мэдэл байхыг мэдэж л байсан. Үнэндээ, Бичээс дээр бурханлаг бус үй олон бурханлаг бус эрх мэдэлтний талаар хэдийн бичигдсэн байв. Жишээ нь Фараон байна. Тэрбээр Абрахамын удам - Бурханы гэрээний хүмүүст харгис хатуу хандсан. Тэднийг дарангуйлж, төмөр нударга дор байлгаж, тэр байтугай нялхсыг нь хядсан.

Фараон тэр эрх мэдлээ хаанаас авсан? Бичээсээс үзбэл, Бурхан Фараонд “Би чамайг босгосон” (Гэтлэл 9:16) гэж хэлсэн. Үүнийг Паул ч захидалдаа батлан хэлсэн (Ром 9:17) бөгөөд үнэнийг хоёр гэрчийн амаар тогтоодог (Иохан 8:17). Хүн юмуу диавол биш, харин Бурхан Өөрөө Фараоныг эрх мэдлийн байр сууринд босгож ирсэн гэдэгт эргэлзэх юм алга. Энэ нь ч “Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй” (Ром 13:1) гэдэг мэдэгдэлтэй яг таарч байна.

Вавилоны хаан Небухаднезарыг л үз. Тэрбээр Иудаг сөнөөгөөд, Бурханы хүмүүсийн орон гэрийг ч, Бурханы сүмийг ч сүйрүүлсэн.

Тэгээд дэлхийг сонорыг чичрээсэн их гүрнийг байгуулсан байдаг. Тэрбээр Бурханы замаас байнга гажиж байсан тул хаанчлалынхаа дундуур галзуу солиотой хүн болоод, хүний нийгмээс тасарсан. Тэгээд хээр араатан амьтдын хамт байж, үхэр мал шиг өвс идэж, үс нь бүргэдийн өд мэт, хумс нь шувууны савар мэт ургах хүртэл бие нь тэнгэрийн шүүдэрт норжээ (Даниел 4:33). Тийм боловч Бурхан тэр хүний талаар “Үзэгтүн, *Миний зарц*, Вавилоны хаан Небухаднезарыг Би авчирч, Өөрийн нуусан энэ чулуунуудын дээр түүний сэнтийг тогтоох гэж байна” (Иеремиа 43:10, тодруулгыг нэмэв) хэмээн маш тодорхой айлдсан. Бурхан түүнийг “Миний зарц” гэсэн нь “Бурханаас гадуурх эрх мэдэл гэж үгүй” болохыг л дахин хэлэх.

Саул хааныг л үз. Олон үйлчлэгч “Саул бол хүмүүсийн сонголт, харин Давид Бурханы сонголт байсан” гэж хэлж байхыг нь би зөндөө сонссон. Ийм хайхрамжгүй мэдэгдэл нь Бурханы хүмүүсийг хохирооно. Яагаад гэвэл энэ нь тойруу аргаар “зарим хууль ёсны эрх мэдлийг Бурхан томилдог бол, заримыг нь хүн томилдог” гэдэг санааг илэрхийлдэг. Энэ нь эргээд хүмүүсийг хүндэтгэлгүй авир гаргаж, зарим эрх мэдэлд захирагдахгүй байх, үүнээсээ болоод эргээд өөр дээрээ хор хохирол авчрахад хүргэнэ. Гэтэл тэр бурханлаг бус, хулчгар, галзуу удирдагчийн талаар Бурхан юу айлдсаныг сонсоно уу: “Би Саулыг хаан болгосондоо харамсаж байна. Учир нь тэр Намайг дагахаас буцан эргэж, Миний үг зарлигийг үл сахив гэв” (1Самуел 15:11).

Бурхан “Би Саулыг хаан болгосон” хэмээн айлдсан байгааг тэмдэглэнэ үү. Тэгэхээр, Саулыг хүмүүс бус, Бурхан томилсон байна. Мөн л “Бурханаас гадуурх эрх мэдэл гэж үгүй” гэдэг мэдэгдэлтэй таарч байна.

Библи дээр “Бурханы зүрхийг хөөдөг хүн” хэмээн дуудуулсан, цорын ганц хүн - Давид ч Саулын эрх мэдэл дор байсан. Энэ явдал Бурхан Саулыг хаан болгосондоо харууссаны дараа болсон шүү. Тэгэхээр, тохиолдол бус, харин Бурханы нарийн төлөвлөгөө л байж таарна.

Анхандаа Давид Саулын гар хөл болсоор байгаа цагт Саул Давидад нааштай сайхан хандаж, таалан соёрхож байв. Харин аюулгүй байдлынхаа заналт дайсан хэмээн харж эхэлсэн цагаасаа эхлэн, машид хэрцгий, хар сэртэй хүн болоод, Давидыг алахаар хөөцөлдөх болсон тул Давид амиа авран зугтах болжээ.

Тэгээд арван дөрвөн жилийн турш хад агуй, цөл, хүний нутаг зэрэг эзгүй хээрээр тэнэв. Бодоод үз дээ. Арван зургаагаас гучин нас

хүртлээ Давид гэртээ харих нь бүү хэл, ороод гарч ч чадаагүй. Төрсөн гэрийнхэн, багын нөхдөөсөө цөлөгдсөн. Саулд алуулах аюулаас болж хайрт анд Ионатантайгаа ч уулзаж учирч чадаагүй. Давид дээр нь Бурханы тавьсан удирдагчаас болж, бүтэн арван дөрвөн жил аюулгүй байдал, тав тух, хүүхэд ахуй наснаасаа зугаацсан, дуртай газар зэрэг залуу халуун эр хүний хамаг л нарийн нандин бүхнээсээ хагацжээ. Бурхан Өөрийнх нь зүрхийг хөөдөг хүнд яахаараа ингэж ханддаг байна аа?

Эзэн Саулыг гаргаж ирсэндээ харууссанаа илэрхийлсэн хойно ч Давид Саулыг хүндэтгэсээр, захирагдсаар байв. Түүний өмнө буруугүй болохоо ахин дахин баталсан ч, Саул түүнийг алах гээд л байсан. Ийнхүү олон жил цөлөгдсөн хойно Давидад тэр удирдагчийн бий болгосон аймшгийг эцэслэх хосгүй боломж заяав. Ен Гедийн цөлд Саулыг цааш нь харуулчих сайхан боломж гарч иржээ. Саул болоод түүний цэргүүд Давидыг эрчүүдтэйгээ хамт агуйн гүнд нуугдаж байгааг нь мэдэлгүй, тэр агуйд зэр зэвсгээ тайлан амарчээ. Давидын эрчүүд ч яахав, Саулыг алчих л гэв. Тэр бүү хэл “ЭЗЭН танд “Харагтун. Би чиний дайсныг гарт чинь өгнө. Түүнийг нүднийхээ тааллаар болгогтун” гэж айлдсан тэр өдөр нь болов” (1Самуел 24:4) хэмээн Бурханы Үгийг ташаа хэрэглэн, ятгаж ч үзсэн.

Үндсэндээ, “Давид минь, Саул бол улс үндэстнийг маань сүйрүүлж, гэмгүй тахилч нарыг гэр бүлээр нь алсан маньяк. Эх эш үзүүлэгч Самуел чамайг Израилийн дараагийн удирдагчаар сонгосон болой. Бурхан ч үгээ буулгасан. Чи л урьтаж алахгүй бол, тэр чамайг ална. Энэ чинь аргагүй хамгаалалт. Бүх шүүх үүнийг зөвшөөрч, чамайг зөвтгөнө!” гэж л ухуулжээ. Энэ нь ч онцсайн шалтгаан байсан бөгөөд гадаад шалтгааны талаар дурьдах ч шаардлага байсангүй: Давидыг чиглэсэн Саулын үндэслэлгүй ял, дайралт нь Давидын ч, тэдний ч амьдралыг там болгож байв.

Давид тэдний шахалтад орсонгүй. Гэхдээ нэг санаа төржээ. Тэрбээр Саулын нөмрөгнөөс огтолж аваад, үүгээрээ гэм буруугүй гэдгээ нэг мөр батлахаар шийдэж. Давид түүнийг алах нь бүү хэл, түүнд өөрөө ч гараа хүрээгүй, эрчүүдээ ч гар хүргээгүй гэдгийг үзэх юм бол, Саул дахин Давидыг хаан ширээ, эрх мэдлийг нь булаах бий гэхээс айхаа больж, араас нь элдэж, амийг нь хороохоо болих нь лавтай.

Тэгээд хааныхаа нөмрөгөөс огтолж авсан хойноо Давид хүн чанартаа баригдаж, сэтгэл нь хямарсан гэж Бичээс хэлдэг. Тэрбээр хаанаа үл хүндэтгэжээ. Яаж ийм зүйл хийж зүрхлэв ээ гээд л. Тэгээд бушуухан

шиг сэхээ ороод, эрчүүдээ хатуу тушаав: “Түүнийг ЭЗЭНий тосолсон хүн гэдгийг мэдсээр байж, ЭЗЭНий тосолсон өөрийн эзэнд би ийнхүү үйлдэж, дахин гар сунгаж ийм хэрэг хийхийг ЭЗЭН надаас хол байлгаж гэж хэлэв” (6-7).

Тийм боловч, Давид нэгэнт хааныхаа нөмрөгийг огтлоод авчихсан болохоор, гарч очоод, гэм буруугүй гэдгээ харуулахаар шийджээ. Тэгээд удирдагч руугаа холоос хашхирав:

Та юунд “Харагтун, Давид таныг хорлох гэж байна” гэж хэлдэг хүмүүсийн үгийг сонсоно вэ? Харагтун, өнөөдөр энэ агуйд ЭЗЭН таныг миний гарт өгснийг энэ өдөр та өөрийн нүдээр харсан билээ. Зарим маань таныг алъя гэсэн боловч би таныг өрөвдөж, “Би өөрийн эзний эсрэг гар сунгахгүй. Учир нь тэр ЭЗЭНий тосолсон хүн” гэж хэлсэн билээ. Хараач эцэг минь, гарт минь буй дээлийнхээ хормойг хараач. Таны дээлийн хормойг би огтлон авсан боловч таныг алаагүй нь хорон муу болоод гэмт үйлдэл нь миний гарт үгүй гэдгийг танд мэдүүлэг. Таны эсрэг би нүгэл үйлдээгүй боловч та амийг минь авахаар мөрдөж байна. ЭЗЭН та бид хоёрыг шүүж, ЭЗЭН танаас өшөөг минь авах болтугай. Харин би танд гар хүрэхгүй.
(1Самуел 24:9-12)

Өшөө авах хэрэгцээ мэдээж байсан ч, үүнийг Давид Бурханд л даатгажээ. Харин түүний зүгээс Саулыг хүндэтгэхээс өөр авир үйлдэл гаргаагүй. Тэр байтугай өөрийнх нь амьдралыг там болгож байгаа хүнийг Давид “аав минь” гэж дуудсан.

Давидын сайхан сэтгэлийг үзсэн Саул үнэн голоосоо бишрээд “Чи надаас илүү зөвт байна. Учир нь чи надад сайн хандаж байтал би чамд бузар мууг санав” (17) хэмээн хариу хашхирсан байдаг. Тэгээд Саул эрчүүдээ аваад яваад өгсөн.

Давид хүндэтгэлийн тал дээр хамгийн том шалгалтаа өгөв

Ийнхүү Давид маань гэм буруугүй болохоо баталсан болохоор, Саул түүнд амар заяа үзүүлсэн гэж та бодож байгаа байх. Гэвч тэр харгис

хатуу удирдагч тэгсэнгүй. Хэсэг хугацааны дараа Саул Давидыг Хачиллагийн агуланд бүгэж явна гэж дуулаад, барьж авч, цааш нь харуулахаар Израилийн гурван мянган шилмэл дайчдыг дагуулаад элдчихсэн.

Давидын зүрх яаж эмтэрснийг төсөөлж байна уу? Саяхан л гэм буруугүй гэдгээ Саулд баталсан байтал, Саул түүнийг алахыг санаарсаар л. Энэ бүхэн нь Давидын найдлага талаар болж, удирдагч нь үнэхээр хүйтэн цуст алуурчин болохын баг нотолгоо байв. Ийм явдал дийлэнх хүмүүсийг хилэгнүүлнэ. *Биеэ хамгаалах зорилгоор ядах юмгүй алчихаж болох байхад л би удирдагчаа хүндэтгэж, амь хэлтрүүлсэн. Тэгээд үзүүлсэн хүндэтгэлийнхээ хариуд ийм хариу хүртэв гэж үү?* Олон хүн “Чи хариугаа авна аа, гайгүй!” гэж занах байх.

Тэгээд Давид удалгүй Саулын цэргүүдийг гүн нойронд автуулсан хэргийн эзэн нь Эзэн Өөрөө байсныг мэдэв (1Самуел 26:12). Давид цэргүүдээсээ хэн өөртэй нь Саулын хуаран руу явахыг асуудаг. Тэгтэл төгс сайн дурынхан гарч ирсэн нь Иоабын дүү хүү Абишай байв (ах, дүү хоёр хоёулаа өс хонзондоо улайрсан хоёр байлаа).

Тэгээд Давид, Абишай хоёр шөнийн харанхуйгаар Саулын цэргийн хуаранд нэвтрээд, Абнерийн дэргэд хүрчээ. Абишай ч Давидад “Бурхан өнөөдөр таны дайсныг гарт тань өгчээ. Тийм учраас энэ жадаар түүнийг нэгмөсөн газарт хатгаж алахыг надад зөвшөөрнө үү. Би хоёр дахин хатгахгүй” (8) гэж хэлэв.

Давидын хариултаас эргэлзээ ханхалж байна. Тэрбээр эргэцүүлэв: *Би өөрийнхөө төдийгүй, энэ олон амьтан, хайрт ард түмнийхээ зовлон зүдгүүрийг яг одоо цэглэж болж байна. Өдий хүртэл надад үнэнчээр зүтгэсэн журамт цэрэг минь надаар тогтохгүй, намайг дагаж байгаа бүхнийг бодсон, учир зүйтэй л хүсэлт гаргаж байна. Журамт цэргүүд маань ч ар гэрээ санагалзаж байгаа. Яахаараа би цэргүүдээсээ илүү Саулд үнэнч байх ёстой билээ. Саул намайг ард түмний өмнө урвагч хэмээн зарлаж, нэр хүндийг маань хулгайлсан. Тэр миний төрсөн эцгийнхээ хүү байх, Израиль улсын иргэн байх нэр хүндийг хулгайлсан. Тэр миний гэргийг булааж, өөр эрд өгсөн (1Самуел 25:44). Тэр миний бүх өмчийг хулгайлсан.*

Давидын энэ эргэцүүллийг Давидын сайн сайхны төлөө морь нохой мэт, амь тавин зүтгэдэг Абишайгийн дуу тасалдуулав. “Давид, чи яана вэ? Арай энэ мангасыг устгах тушаал буулгахаас хойш суугаад байгаа юм биш биз дээ?”

Тэгээд цааш нь “Үгүй л гэж бүү хэл. Чи гэм зэмгүй гэдгээ ахин

дахин баталсан. Ен Геди агуйг л сана. Тэр чиний гарт ороод ирсэн ч, чи тавиад явуулсан. Чи түүнд үнэнчээ өчүүхэн ч эргэлзэхээргүй батлаад өгсөн ч, тэр чамайг авлахаар байна. Энэ чинь аргагүй хамгаалалт. Ямар ч хууль өршөөнө” гэсэн.

Давид таг.

Абишай ч тэвчээр алдав. “Давид, чамайг аугаа эш үзүүлэгч Самуел өөрийн биеэр Израилийн дараагийн хаанаар томилсон. Чи л энэ увайгүй хааны гараас улс түмнээ чөлөөлнө. Энэ этгээд Нобын наян таван тахилчийг бидэнд талх тариа өглөө гэж эхнэрүүдтэй, нялх нярайтай нь алсныг санахгүй байна уу? (1Самуел 22) Энэ чинь цуст алуурчин!”

Тэгээд эцэстээ “Давид, Бурхан энэ цэргүүдийг яагаад нам унтуулсан гэж бодож байна? Чамаар дамжуулж ард түмнийг энэ увайгүй хаанаас чөлөөлөх гэж!” хэмээн үгээ түс тас өндөрлөсөн.

Давид журамт нөхрийнхөө зөвлөгөөг наанатай цаанатай үзэв. Тун ч учир зүйтэй сонсогдов ч, Бурханы зөвлөгөөтэй нэг л эгнэж өгсөнгүй. Тиймээс Давид Абишайн үгийг ч, биеэ өмөөрсөн бодлуудаа ч таягдаж хаяад, “Түүнийг бүү алагтун. ЭЗЭНий тосолсон хүний эсрэг гар сунгаад хэн шийтгэлгүй үлдэж чадах вэ? гэв. Давид цааш нь —ЭЗЭН амьд! ЭЗЭН түүнийг заавал устгана эсвэл түүний үхэх өдөр ирнэ эсвэл тулалдаанд явж устгагдана. ЭЗЭНий тосолсон хүний эсрэг намайг гар сунгахыг ЭЗЭН хорих болтугай. Харин одоо толгойнх нь хажууд байгаа жад, устай домбыг аваад явъя” (1Самуел 26:9-11) хэмээн ширэн нүүрлэв.

Тэгээд Давид цэргээ дагуулсаар хуаранг орхижээ.

Бурхан юуны учир цэргүүдийг нам унтуулав? Давидын зүрхийг л шалгах гэж. Давид Бурханы зүрхийг дагадаг хүмүүн хэвээрээ үлдэх нь үү эсвэл Саул шиг бүгдийг өөрийн гараар шийддэг болох нь уу? Бурханы томилсон хүнийг үл хүндэтгэснээрээ Бурханыг үл хүндэтгэх нь үү? Давидын хувьд энэ хувь тавиланг нь шийдвэрлэх эгшин байв.

Хаан нь Давидыг байдгаараа доош хийж байсан ч, Давид хаанаа хүндэтгэв. Гэтэл шагнал нь Давидын төсөөлснөөс ч том байж. Харгис дарангуй удирдагчаа үнэлж, хүндэтгэсэн энэ хүний тухайд Бурхан юу хэмээснийг үзнэ үү:

“Өөрийн зарц Давидыг Би олсон.

Би түүнийг ариун тосоороо тосолсон.

Гар минь түүнтэй хамт байж,

Мутар минь ч бас түүнийг хүчтэй болгоно.
 Дайсан түүнээс нэхэн шаардаж чадахгүй,
 Хорон муугийн хүү ч түүнийг зовоож чадахгүй.
 Харин Би түүний өмнө өстнүүдийг нь бяцалж,
 Түүнийг үзэн ядагчийг бут цохино.
 Үнэн ба хайр энэрэл минь түүнтэй хамт байж,
 Миний нэр дээр түүний эвэр өргөмжлөгдөнө.
 Ариунаараа Би нэгэнт тангарагласан тул
 Давидад Би худал эс хэлнэ.
 Үр удам нь мөнхөд амьдарч,
 Сэнтий нь Миний өмнөх нар шиг байна.
 Тэр нь сар лугаа адил мөнхөд тогтоно.
 Тэнгэр дэх гэрч итгэмжит билээ.”
 (Дуулал 89:20-24, 35-37)

Давид Саулын харгис хатуу талаас даваад, түүний дээрх эрх мэдлийг олж харсан. Давид хүндэтгэлийн зарчим дор амьдарчээ. Тэрбээр өөрийнх нь дээр Бурханы тавьсан хүнийг хүндэтгэх аваас, үнэндээ Бурханыг Өөрийг нь хүндэтгэнэ. Харин Бурханыг хүндэтгэсэн хүнийг Бурхан Өөрөө хүндэтгэнэ. Бурхан Давидыг яаж хүндэтгэснийг дээрх эшлэлээс харж болно. Үнэхээрийн аугаа шагнал!

Энэ явдлаас нэг их удалгүй Бурхан Саулыг шүүсэн байдаг - дайнд Филистинчүүдэд алагдсан. Давид Саулын үхлийн талаар дуулахдаа, Саулын болоод Ионатаны гэгээн дурсгалд дуу зохиогоод, Иудагийн иргэдэд зааж өгөөд дуулуулсан. Давид шүүхээр орсон удирдагчаа хүндэтгэсээр байна.

Тэгэхээр, бүгдээрээ хүмүүнийг хууль ёсны эрх мэдэл дээр хүн ч биш, чөтгөр ч биш, Бурхан Өөрөө тавьдгийг тодорхой харуулсан библийн цөөхөн хэдэн жишээг авч үзлээ. Сайн, муу үйл хэргээс нь үл хамааран, хүн төрөлхтний түүхэн дэхь удирдагч болгоныг Бурхан Өөрөө тохоон томилсон болой. Тухайн эрэгтэй, эмэгтэй тохиолдлоор бус, чухам тодорхой нэгэн шалтгаанаар л тохоон томилогддог. Бурханы хөдлөшгүй үгийг харцгаая: “Оршин байх эрх мэдэл инү Бурханаар тохоон томилогдов.”

Харгис удирдагчийн тал дээр ч түүний эрх мэдэл нь Бурханаас авай. Гэвчиг харгис хатуу зан үйлдэл нь Бурханаас эхгүй юм. Тэд Бурханы өмнө тооцоогоо хийх боловч, хамгийн гол нь түүнийг захирах хугацаанд захиргаан дорх хүмүүс нь Давидын адил шалгагддаг. Тэгээд

хүндэтгэж чадбал, аугаа ихээр шагнуулна.

Тэгэхээр, бүгдээрээ бүх эрх мэдлийг Бурхан тохоон томилдгийг үзлээ. Тэгвэл удаах бүлгээрээ “*Бид харгис хатуу, тэр байтугай ёрын муу эрх мэдэлд ч захирагдах ёстой юу?*” гэдэг асуултаа үргэлжлүүлэн судалцгаая.

Харгис ширүүн эрх мэдэл

Бурхан бүхий л хууль ёсны эрх мэдлийг - тэр дундаа харгис ширүүн эрх мэдлийг ч тохоон томилдог болохыг бид өнгөрсөн бүлгээрээ сурсан. Яахаараа сайн Бурхан улай үзэгч нарыг эрх мэдлийн байр суурин дээр томилдог билээ? Хариулт нь энгийн: Бурхан эрх мэдлийн зохиогч боловч, харгислалын зохиогч биш. Харгис муу үйлдлийн төлөө Бурхан биш, хүн хариуцлагатай. Дараах үнэнийг тархиндаа хадаад ав: *Бүх эрх мэдэл Бурханых боловч, бүх эрх мэдэл бурханлаг байдаггүй.*

Тэгэхээр, бүгдээрээ урт настай удаан жаргалтай нэгэн асуултыг авч хэлэлцэх хэрэгтэй. Эрх мэдэлтнүүд бидэнд буруу хандаад байхад ч бид тэр харгис хатуу удирдлагад захирагдах ёстой юу? Хариултыг нь Давидын амьдралаас үзэж болно. Түүний үлгэр жишээ бидэнд Бурхан биднийг бурханлаг бус эрх мэдэлд ч захирагдаж байгаасай гэж хүсдгийг харуулж байна. Тэгвэл нэг алхам лавшраад, шууд сонсьё. Ингэхийн тулд элч Петр рүү хараагаа хандуулъя:

Боолууд аа (*ажилтан албан хаагч, оюутан, чуулганы гишүүд гэх мэт*) бүхий л хүндлэлээр зөвхөн сайн, дөлгөөн төдийгүй бас гажууд эздэдээ (*ажил олгогч, дарга, багш, чуулганы удирдагч, иргэний эрх баригч нартаа*) ч захирагд. (1Петр 2:18, тодруулгыг нэмэв)

Сайн бөгөөд төлөв удирдагч нартай байх сайхан бөгөөд бидний өсөлт, хөгжилд чухал. Тийм боловч Петр дан ганц *сайн бөгөөд төлөв*

удирдагч нарын талаар яриагүй, харин харгис хатуу удирдагч нартаа ч захирагдаж явахыг онцгойлон мэдэгдсэн байна.

Үнэндээ “эмээн байж” гэж хэлсэн байдаг. Энэ үг дотор түүний тушаалын нууц орших. Жинхэнэ хүндэтгэл нь зүрхнээс эхтэй бөгөөд Эзэнээс эмээхүйн халил гэдгийг санаарай. Америкчууд бид эрх мэдэлд “Та нөхөд миний хүндэтгэлийг хүлээсэн нөхцөлд л би та нөхдийг хүндэтгэж, та нарт захирагдана” гэж хэлэх гээд байдаг. Гэвчиг эш үзүүлэгч Исаиагийн хэлснээр бол, “Таалал нь ЭЗЭНээс эмээхүйд. Тэр нүдэндээ үзэгдсэнээр шүүхгүй, Чихэндээ сонсогдсоноор шийдэхгүй” (Исаиа 11:3) ажээ. Тиймээс хүмүүний зүрхэн дэхь Эзэнээс эмээхүй нь удирдагч нартаа “Би таны дээрх эрх мэдэл Бурханаас эхтэй болохыг мэднэ ээ. Тиймээс би таныг үг дуугүй хүндэтгэн, дээдэлнэ. Би таны зан үйлдлийг бус, байр суурийг хүндэтгэж байгаа учраас, та миний хүндэтгэлийг хүлээх гэж гавъяа байгуулах гэж оролдох хэрэггүй” гэж хэлдэг.

Тушаалын төгсгөлийг санана уу: “*гажууд (хатуу ширүүн)* эздэдээ ч захирагд”. Нэг өдөр энэ эшлэлийг тунгааж байтал “*Байзаарай. Хатуу ширүүн гэв үү? Кинг Жэймс Вержн Библи арай л чанга үг сонгосон болтой. Грек үгийг нь үзье байз*” гэсэн бодол орж ирэв.

Тэгээд *Тайерийн* тольч бичгийг шалгатал, “хатуу ширүүн” гэдэг нь Грекээрээ сколиос гэдэг үг байх юм. Энэ үгийг толь бичиг “шударга бус, завхарсан, ёрын, жудаггүй, түрэмгий” хэмээн тодорхойлжээ. Би ч суудал дээрээ нэг огло харайгаад “*Энэ чинь бүр аймаар байна! Гэхдээ магадгүй бас алдсан байж болох юм. Өөр эх сурвалжаас үзье*” хэмээн тайтгарал хайлаа. Тэгээд Грек Шинэ гэрээний үгсийн өөр нэгэн мэргэжилтэн болох Даблью. Ий. Вайнд хандлаа. Гэтэл тэрбээр тус үгийг “дарангуйлагч юмуу шударга бус эзэн (удирдагч)” гэжээ.

Би ч хайгуулаа үргэлжлүүлсээр байлаа. Гэтэл бусад орчуулагч нар ЭнКэйЖэйВи библийн орчуулагч нараас ч хатуу үг хэрэглэсэн байв. Тухай нь, Ди Нью Сентри Вержн дээр “Сайн бөгөөд зөөлөн төдийгүй, жудаггүйг ч...” гэдэг. Ди Контемпорари Инглиш Вержн дээр “Зөөлөн бөгөөд бодолтойг төдийгүй, харгисыг ч...” гэдэг. Ди Нью Американ Стандарт Библи дээр “ухаангүй” гэдэг.

Тэгэхээр, бид “Бурхан хүүхэд хүчирхийлэгч үү?” гэж асуух ёстой. Үгүй ээ, мянгантаа үгүй! Бурхан бол ертөнц дээрх хамгийн сайн Аав. Бурхан зүгээр л хайрыг тээдэг Бурхан бус, харин Өөрөө хайр болой. Тэгэхээр, үүнийг тунгаацгаая: Миний хайрт Аав Өөрийнхөө хүүхэд болох надад ширүүн, харгис, увайгүй, завхарсан, дарангуй, шударга

бус, үнэнч бус удирдагчдаа захирагд гэж хэлж байна уу? Зүгээр хэлэхээр барахгүй, бүр тушааж байна уу? Энэ нь түмэн шалтгаантай боловч, бүгдийг нь ганц мэдэгдлээр базаад хэлбэл: *миний л тусын тулд ажээ*.

Энэ удирдагч нарыг хүндэтгэх нь гурван тустай. Нэгдүгээрт - бид шударга бус хандууллаа ч, захирагдах дуулгавартай байдал маань бидний хэргийг шударга Шүүгч Бурханы мутарт даатгах болно (1Петр 2:21-23). Бид хэрэг явдлыг гартаа авбал, Бурхан гэдрэг ухрах учраас, бид ганцаараа үлдэх буюу хамгийн золгүй байдалд орно. Энэ нь ихэвчлэн эрх мэдэлтэй холбоотой асуудал байдаг учраас, эцсийн дүнд бид ямагт ялагдана. Яахав, цөөн тохиолдолд ялаад гарч болох ч, сүнсэнд маань үлдсэн Христтэй адилгүй шарх юмуу үндэс нь эцэстээ асуудал ургуулах юмуу эсвэл бүр хожим үр дагавраа харуулах ялзрал үүсгэнэ.

Хоёрдугаарт - бид шударга бус хандлагад хүндэтгэлтэй юмуу ерөөлтэй хариу хандбал, дараах зүйл болохыг Петр хэлжээ: *“Ерөөлийг өвлөхөөр дуудагдсан тул та нар мууг муугаар эсвэл доромжлолыг доромжлолоор хариулахын оронд ерөөгтүн (хүндэтгэгтүн)”* (1Петр 3:9, тодруулгыг нэмэв).

Бид өөрт маань хатуу хандаж байгаа, шударга бус хандлагыг хүндэтгэлтэйгээр (үнэ хүндлэлтэй, захирагдаж, ерөөж) буюу зөв зүйтэй шийдвэрлэхээр дуудагдсан ажээ. Бид яагаад үүний төлөө дуудагдсан бэ? Ерөөгдөхийн (шагнуулахын) төлөө. Тиймээс нэн ялангуяа эрх мэдэлтний зүгээс шударга бус хандлага үзбэл, том шагналын өмнө зогсож байгаа учраас, баярлаж үз!

Тушаал дэвших шагнал

Би өмнө товхимолдоо бичиж байсан нэгэн түүхийг хуваалцмаар байна. Энэ нь бид өөрт маань өөдгүй хандсан хүмүүсийг хүндэтгэсэн нөхцөлд Бурхан биднийг хэрхэн шагнадгийг харуулсан сонгомол жишээ юм.

Эл Брайс гэдэг миний нэг анд бий. Тэрбээр хэдэн жилийн өмнө Далласын нэгэн чуулганд үйлчилж байхдаа, нэг бүтэн сайны өглөө 1Петр номоос номожээ. Түүнийг дуусах үед чуулганых нь нэгэн гишүүн (Брайнгэе) түүндээр явж ирээд, их ламин чухал асуулт тавьжээ: “Брайс пастор аа, би маш том даатгалын компаний бага менежер. Би

есөн жил хичээнгүй хөдөлмөрлөсөн бөгөөд дэд ерөнхийлөгч болох дараагийн хүн байлаа. Ажилтнууд маань ч бүгдээрээ л намайг тушаал дэвших бүхий л болзлыг хангасан хүн гэдгийг мэдэж байлаа. Би ч үнэхээрийн байдгаараа л хөдөлмөрлөсөн. Гэтэл тушаалд дэвшүүлэх цаг болмогц, компани маань өөр хүнийг дэвшүүлсэн.

Эл пастор “Яагаад тэр вэ?” гэж асуув.

“Яагаад гэвэл би хар, тэр хүн цагаан. Пастор аа, энэ чинь ялгаварлал. Би ч үүнийг баталж чадна гэдгээ мэднэ. Үнэндээ би ирэх долоо хоногт албан ёсоор шүүхдэх гэж байсан юм. Гэтэл та өнөө өглөө ийм номлол хэлээд, намайг бүр хоёрдуулж орхилоо!”

Брайс пастор Брайн руу хараад “Та үүнийг Бурханы замаар хийхийг хүсч байна уу эсвэл өөрийнхөө замаар хийхийг хүсч байна уу?” гэж асууж.

Брайн ч шууд л “Пастор аа, би Бурханд үнэн голоосоо хайртай. Тиймээс Түүний замаар хиймээр байна. Тэгээд л тантай ярьж байгаа минь энэ. Та надтай хамт залбираач?” гэж хэлэв.

Эл ч “Тэгье” гээд тэд толгой бөхийгөөд, хэргийг шударга Шүүгч Бурхан Аавын мутарт даатгасан байна.

Маргааш өглөө нь Брайн ажилдаа очоод, тушаал дэвшсэн хамтран зүтгэгчдээ хүндэтгэл үзүүлсэн хамгийн түрүүний хүн болж таарчээ. Тэрбээр нөгөө хүний албан өрөөнд явж очоод, гараа сунгаад, нүүр дүүрэн мишээгээд “Тушаал дэвшсэнд баяр хүргэе. Би танай багт чадлаараа зүтгэнэ ээ” гэж хэлэв. Нөгөө хүн ч тушаал нь буруу хүнд очсоныг мэдэж байсан тул үүнд хичнээн тавгүйтсэн бол. Дарга нарын явуулга байгаагүй бол, Брайн ямар ч асуудалгүй түүний дарга болоод, түүний ширээнд сууж байх байсан.

Хэдэн долоо хоног өнгөрсөн ч, юу ч болсонгүй. Яг ийм л байдгийг та, бид ойлгох хэрэгтэй. Бурханы шүүх юмуу чөлөөлөлт ирдэг ч, бидний хүссэнээс оройтох нь элбэг! Гэвч Брайн өөрийгөө хохирогч болсон гэдэг баримттайгаа зууралдсангүй. Тэр хүндэтгэх замыг сонгожээ. Тэгээд үргэлжлүүлэн хамаг л сайнаараа ажиллав.

Нэг өдөр Брайнтай тэдний өрсөлдөгч болох, олон улсын даатгалын бүр том компаний Далласын салбараас ярьжээ. Утасны цаана байгаа хүн “Бид таныг хэлгүй үйлчлүүлэгч нартай харилцаж байгааг чинь харсан. Үнэхээр биширсэн шүү. Та манайд ажиллахгүй биз?” гэж асуужээ.

Брайн ч нэг их бодсонгүй. Тэгээд “Үгүй ээ, би сонирхохгүй байна. Би ажлаа өөрчилмөөргүй байна. Би энэ компанид арван жил ажиллаж

байна. Сайн ч хангамжтай, тогтвортой сайхан ч үйлчлүүлэгч нартай. Манай үйлчлүүлэгч, хамтран зүтгэгч нар миний нэр төрийг ч, зан авирыг ч мэднэ. Би сайн байгаа. Тиймээс өөрчилмөөргүй байна. Маш их баярлалаа. Гэхдээ би сонирхохгүй байна” гэж хэлжээ.

Гэтэл нөгөө компаний хүн ч бууж өгсөнгүй. “Та бидэнтэй ганц л удаа өдрийн зоогт орооч. Үүнд буруудах юм байхгүй шүү дээ.”

Брайн ч өөдөөс нь бууж өгсөнгүй. “Та цагаа үрж байна. Би сонирхохгүй байна.”

Нөгөө хүн ч дүлий аятай л “Тэг л дээ. Ганц удаагийн л өдрийн хоол шүү дээ!” хэмээн давтжээ.

Сүүлдээ Брайн ундууцан “За яахав, би тантай уулзъя” гэжээ. Тэд өдрийн хоолны цагаа тохирч, товлосон өдөр ч ирэв. Брайн нөгөө хүмүүстэй мэндлээд, хоолоо захиалжээ. Тэр том даатгалын компаний нэг менежер нь “Брайн, бид таныг ажиглаад, таны ажил хэргээ явуулдаг арга барилыг биширсэн гэв. Бусад нь ч “Бидэнтэй ажиллалал, тун их баярлах байна” гэгцгээж.

Брайн толгой сэгсрэв. “Би өмнө утсаар хэлсэн. Та цагаа үрж байна. Би ажлаа сольдоггүй. Би тогтвортой байдалд дуртай. Манайх супер хангамжтай. Би компанидаа хөрөнгө оруулсан. Би ийм юм хиймээргүй байна.”

“За за, Брайн бид ойлголоо. Гэхдээ бүгдээрээ ингэе. Та гэртээ хариад гэргийтэйгээ ярилц. Тэгээд та, хоёр биднээс авахыг хүссэн цалингийн хэмжээгээ гарга. Тэгээд долоо хоногийн дараа эндээ уулзаад ярилцъя.”

Брайн ч санаа алдаад, дуртай дургүй зөвшөөрсөн байна.

Брайн гэртээ харив. Тэгээд нөгөө яриаг нухацтай авч үзсэн ч үгүй. Товлосон өдрийн зоогийн өмнөх орой болтол нь энэ саналын талаар гэргийдээ ч нэг их юм хэлсэнгүй. Тэгж тэгж гэргийтэйгээ амран сууж байхдаа “Би үнэхээр ажлаа сольмооргүй байна. Тэр хүмүүс биднийг цалингийн хэмжээгээ өөрсдөө тогтоо гэсэн. Би залхаж байна. Тиймээс ингэлээ. Цалингийн хэмжээ тогтоох тал дээр би ёстой солиотой юм хийе. Би тэдэнд одоогийн цалингаасаа гурав дахин их цалин авмаар байна гэж хэлье! Тэд ч хөхөрч унаад, намайг ресторанаас хөөгөөд гаргах байлгүй. Тэгээд энэ яриаг бушуухан дуусгая” гэжээ.

Тэгээд товч захидал бичээд, одоогийн цалингаасаа гурав дахин их цалингийн тоо тавьжээ. Брайн өөрийнхөө компанид ч нилээд өндөр цалин авдаг байсныг бүү мартаарай. Тиймээс ийм сансрын тоо хэлнэ гэдэг солиорол байв.

Маргааш нь Брайн өдрийн хоолондоо очлоо. Хоолоо захиалсныхаа дараа даатгалын компаний менежер Брайнаас цалингийнхаа дүнг гаргасан эсэхийг асуулаа.

Брайн ч гаргасан л гэлээ. Тэгээд захидлаа гаргаж ирэхээр халаас руугаа явтал, нөгөө хүн түүнийг зогсоогоод “Байзаарай. Үнэндээ бид таны биднээс хүсч байгаа цалинг хармааргүй байна. Эхлээд бид танд өгөхийг хүсч байгаа цалингаа харуулмаар байна!” гэжээ.

Тэгээд тэр хүн ширээн дээгүүрээ дугтуйгаа захидал дамжуулав. Брайн ч захидлыг аваад, хэдхэн мөр уншаад, золтой л ухаан алдчихсангүй. Тэд Брайнд одоогийн цалингаас нь дөрөв дахин их цалин өгөхийг санал болгосон байх! Брайн юу ч хэлэхээ мэдэхгүй, хөшчихөв. Тэрбээр захидал руу ширтээд л суугаад байв. Гэтэл нөгөө компаний ажилтан Брайны энэ байдлыг ташаа хөрвүүлээд, саналыг нь голчихлоо хэмээн ойлгожээ. Тиймээс тэд цалинг нь нэмээд, дээрээс нь өөр олон хангамж амлав!

Эцэстээ Брайн бодлоо цэгцлээд “Ноёд оо, би Христэд итгэдэг хүн. Тиймээс би энэ саналыг чинь авч хариад, гэргийтэйгээ хамт залбираад, буцаад холбогдъё” гэжээ.

Нөгөөдүүл ч “Тэгэлгүй яахав” л гэгцгээж.

Брайн хариад, гэргийдээ хэлэв. Тэр хоёрыг залбиртал, Бурханы Сүнс хоёулантай нь яриад, Эзэний “Хүү минь, чи хэргээ Миний мутарт даатгасан. Би чамайг зөвтгөв. Энэ миний албан тушаалын шагнал. Хүлээж ав!” гэдэг үгийг айлтгажээ.

Өнөөдөр Брайн Далласт аж төрөхөө больсон. Тэрбээр тэр аварга том компаний Виржиниа дахь олон улсын төвийнх нь ахлах менежер болсон. Тэр компаний хажууд Брайнд шударга бус хандаж, зохих тушаалд нь дэвшүүлээгүй компани үнэхээр жулдана.

Тэгэхээр, үүнээс ямар дүгнэлт гаргах уу? Мэдээж, Брайн өөрийгөө өмгөөлж, тэр бүү хэл өшөө хонзонгоо ч авч болох байсан. Түүнд энэ бүхнийг хийх бүх хууль ёсны эрх нь бий. Түүнийг доромжилж, шударга бус хандсан бөгөөд Брайн ч шүүх дээр ялалт байгуулах боломжтой байсан. Гэхдээ шүүхдээд ялсан байсан ч, өнөөгийн байр сууринд хүрэхгүй байх байсан. Тэрбээр Бурханы тогтоосон ерөөлийг алдах байв! Гэтэл Брайн шударга бус үзэгдсэн ч, эрх баригч нараа хүндэтгэх сонголт хийжээ. Тэрбээр өшөө авахыг сонголгүй, хэргээ Бурханы мутарт даатгасан бөгөөд шагналаа бүрэн хүлээн авч!

Захирагдах бөгөөд дуулгавартай дагах

Харгис эрх мэдэлд захирагд хэмээн тушаасан гурав дахь шалтгаан нь өөрийгөө зөвтгөхийн оронд Бурханд найдсанаар бидний дотор бурханлаг зан чанар байгуулагддаг байх нь. Петр цааш нь: “Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан” (1Петр 4:1) гэжээ.

Захидлын агуулгаас нь авч үзбэл, Христ эрх баригчдын шударга бус хандлагаас л болж зовжээ. Бид өөрийгөө яг ийм бодлоор хуяглах хэрэгтэй. Яагаад? Яагаад гэвэл бид эрх баригч нар маань бидэнд шударга бус хандаж байсан ч, тэднийг хүндэтгэхээр дуудагдсан билээ.

Ингэвэл, бид нүгэл үйлдэхгүйг Петр мэдэгджээ. Үүнийг өөрөөр бас бид сүнсний төлөвшилд хүрэх гэдэг. Паул ч үүнийг баталсан: “Түүгээр ч барахгүй мөн зовлонтойдоо баярладаг. Учир нь зовлон нь тэвчээрийг, тэвчээр нь батжилыг, батжил нь найдварыг төрүүлдгийг мэднэ” (Ром 5:3-4). Дотор маань хүчтэй зан чанар байгуулагдахад, хүндэтгэл хүлээх зохисгүй авир үйлдэлтэй хүмүүсийг ч хүндэтгэх амархан болно. Эдүгээ бид эргээд илүү том шагнал авчрах Эзэнээс эмээхүйн илүү өндөр төвшин дотор алхалж байна.

Тэгэхээр бүгдээрээ ярианыхаа сэдвийг зохих библийн эшлэлтэй тэнцэтгэх хэрэгтэй. Библи биднийг эрх мэдэлд үг дуугүй захирагд гэснээс биш, эрх мэдлийг ямар ч болзолгүй дага гэж хэлээгүй.

Захирагдах, дуулгавартай дагахад ялгаа бий. Захирагдахуй нь бидний хандлагатай холбоотой бол, дуулгавар нь бидний үйлдэлтэй холбоотой. Тиймээс л бидэнд “Уриалгахнаар та нар дагах аваас Уул газрын сайныг иднэ” (Исаиа 1:19) гэсэн билээ. Би нэг удаа Ариун Сүнсэнд эмлүүлэв. Ажил байдал маань явцгүй байгаад би ундууцаж байлаа. Зургаан сарын турш би чуулгандаа Бурханаас юм хүртэхгүй, пасторынхаа номнолд цадсангүй. Тэгээд залбирч байтал, Эзэн намайг энэ эшлэл рүү чиглүүлээд, миний энэ нөхцлийн шалтгааныг хэлэв.

Би ч мөчөөгөө өгсөнгүй. “Би дуулгавартай хүн! Пасторынхаа, эрх мэдлийн хийгээрэй гэсэн бүхнийг л хийдэг!”

Ариун Сүнс ч шууд л хариуллаа. “Би “Дуулгавартай байвал, уул газрын сайныг иднэ” гэж хэлээгүй, харин “Хүсэлтэй бөгөөд дуулгавартай байвал, уул газрын сайныг иднэ” гэж хэлсэн. Дуулгавар чинь чиний үйлдэлтэй холбоотой, хүсэл чинь чиний хандлагатай холбоотой. Гэтэл чиний хандлагад авах юм алга!”

Тэр үед л би миний хандлага хичнээн чухал болохыг гэнэт ухаарав. Энд л Эзэнээс эмээхүй орших бөгөөд хүндэтгэл нь ариун эмээхүйн урсгал болохыг дахин хэлье.

Үүнийг Шинэ гэрээнээс дахин харж болно. Паул “Удирдагчдаа дагаж, тэдэнд захирагдагтун. Учир нь тэд тооцоо хийгчид адил сэтгэлийг чинь сэрэмжилдэг. Тэд үүнийг санаа алдалгүйгээр, баяртайгаар хийг. Эс бөгөөс та нарт ямар ч ашиг болохгүй” гэжээ (Еврей 13:17, тодруулгыг нэмэв). Паул биднийг дээрх эрх мэдлээ дагаж бас захирагдах ёстойг онцлон мэдэгдсэн байгааг тэмдэглээрэй. Дуулгавартай байдал нь үйлдэлтэй холбоотой бол, захирагдахуй нь эрх мэдэлд хандах хандлагатай маань холбоотой. Дээрх хүмүүсээ хүндэтгэхгүй байх нь удирдагчид бус, харин бидэнд л ашиггүй болохыг дахин тэмдэглээрэй. Бид л шагналаа алдана.

Өмнө хэлсний дагуу, Библи эрх мэдлийг болзолгүй дагахыг бус, харин эрх мэдэлд болзолгүй захирагдахыг заадаг болой. Гэхдээ Библи нэг л нөхцөлд - би дахин хэлье - нэг л нөхцөлд эрх мэдлийг дагаж болохгүй гэсэн нь эрх мэдэл биднээр нүгэл үйлдүүлэхийг хүссэн тохиолдол болно. (Бурханы бичигдсэн Үгтэй тэрсэлдсэн зүйл үйлдэхийг хэлэх)

Энэ талаар хэлсэн бичээсийн жишээ ч олон жишээ бий. Гэвч бүгдээрээ ганцыг л үзье. Вавилоны хаан Небухаднезар ард түмэнд хөгжмийн дуунаар нэгэн зэрэг алтанд шүтээнд мөргөх зарлиг гаргадаг. Зарлигийг дагаагүй хүнийг зууханд хаях шийтгэлтэй.

Тэр үед Вавилоны хаант улсад Шадрех, Мешах, Абедрнего хэмээх гурван залуухан Еврей хөвгүүд ажиллаж, амьдардаг байжээ. Тэд сод ухаантай, авъяас бэлэгтэй байсан тул хаантан ч тэднийг таалан соёрхдог байж. Гэтэл жинхэнэ амьд Бурханаас эмээдэг тэр гурвын хувьд хааны зарлиг нь Бурханы Мосегоор Тора дээр бичүүлсэн хоёр дахь тушаалыг нь шууд зөрчиж байлаа.

Мэдээж гурван залуу хааны тушаалыг эс дагав. Тэгээд мэдээж тэдний эсэргүүцэл ч төд удалгүй хааны сонорт хүрэв ээ. Тэдний үйлдэлд уур нь хүрч, уушги нь сагсайсан хаан залуусыг үтэр түргэн өмнөө авчруулан байцаав. Гэтэл тэдний хариултыг үзнэ үү: “Небухаднезар аа, энэ хэргийн талаар танд хариулах хэрэг бидэнд байхгүй. Бидний үйлчилдэг Бурхан биднийг аврах бол дүрэлзсэн галтай зуухнаас ч хаантан таны гараас ч биднийг Тэр аварна. Хэдийгээр тэгэхгүй байсан ч, өө хаантан, бид бурхдад тань үйлчлэхгүй мөн таны босгосон алтан хөрөгт мөргөхгүй гэдгийг та мэдсүгэй” (Даниел 3:16-18).

Тэд Бурханы тушаалыг ч бат дагасан, хаанаа ч хүндэтгэсэн. Тэд “Муу нохойн гөлөг минь, чиний хэлснийг хэзээ ч хийхгүй!” гэж хэлээгүй, харин “Хаантаан (Эрхэм дээдэс ээ)” хэмээн хүндэтгэсэн. Хааныгаа доромжилсон бол, тэр хааныг удирдлагад тохоон томилсон Бурханыг үл хүндэтгэсэн хэрэг болох байв. Бид эрх мэдэлтнүүдийн тушаалыг дагахгүй байлаа ч, захирагдах (хүндэтгэх) ёстой.

Шадрах, Мешах, Абеднего гурав Бурханыг ч, хаанаа ч хүндэтгэсэн. Нэгдүгээрт - тэд зууханд амьдаараа хаягдана гэдгээ мэдсэн ч, нүгэл үйлдэхгүй хэмээн Бурханаа хүндэтгэсэн. Хоёрдугаарт - хаан нь тэднийг үзэн ядаад байхад ч, тэд хааныхаа эрх мэдлийн байр сууринд захирагдан, хүндэтгэлтэйгээр ярилцан, эрх мэдлийнх нь байр сууринд захирагдсан. Тэд элэглээгүй, доромжлоогүй, занаагүй. Тэд хүндэтгэлийн зарчмаар л амьдарсан. Хэдийгээр анхандаа бүрхэг байсан ч, тэд аугаа том шагналаа бүтнээр нь хүлээн авах нь тодорхой байлаа.

Хаан ч шууд л тэднийг зууханд хаяхыг тушаав. Үнэндээ асар хилэгнэсэндээ, зуухыг долоо дахин хүчтэй галлахыг тушаажээ. Тэгээд гурван Еврей хөвгүүдийг дөнгөлж хүлээд, зууханд хаяхыг цэргүүддээ тушаав.

Зуух нь үгээр хэлэшгүй халуун байсандаа, хөвгүүдийг аман дээр нь авчирсан цэргүүдийг ч шатаагаад алчихсан гэдэг. Тэгээд:

Харин Шадрах, Мешах, Абеднего гэх эдгээр гурван эр хүлээтэй чигээрээ дүрэлзсэн галтай зууханд унажээ. Дараа нь Небухаднезар хаан гайхаж, яаран босож ирлээ. Тэрээр дээд түшмэддээ —Бид гурван эрийг хүлж, гал уруу хаясан биш үү? гэсэнд тэд хаанд хариулан —Тийм ээ, хаантан гэв. Хаан хариулан —Хараач! Хүлээсгүй, дөрвөн хүн гал дунд явааг би харж байна. Тэд гэмтээгүй байна. Дөрөв дэх нь бурхдын төрхтэй юм гэв. Небухаднезар дүрэлзсэн галтай зуухны аманд ойртож очоод, —Хамгийн Дээд Бурханы зарц Шадрах, Мешах, Абеднего нар аа, гараад ир, нааш ир гэжээ. Тэгэхэд Шадрах, Мешах, Абеднего нар гал дундаас гарч ирэв. Бүх аймгийн удирдагч, цэргийн ноёд, түшмэд хийгээд хааны зөвлөгч нар тойрон бүчиж, гал энэ эрсийн биед ямар ч нөлөөгүй байсныг харав. Үс нь ч хуйхлагдаагүй, дээл нь ч хувираагүй, тэднээс түлэнхий үнэр ч үнэртсэнгүй (Даниел 3:23-27).

Гурван залуу галын гашуун зовлонгоос аврагдаад барахгүй, тэнгэрийн хамтран зүтгэгчтэйгээ хамт байжээ. Тэднийг боож хүлээд хаясан ч, зуухан дотор сул чөлөөтэй явжээ. Хүлсэн олс нь шатсан ч, хувцас нь яагаа ч үгүй. Улаан гал дундаас гарч ирсэн тэднээс хиншүү, хярвас ч үнэртсэнгүй. Тэд гарч ирээд шагналаа хүлээн авчээ:

Ингээд хаан Шадрах, Мешах, Абеднего нарыг Вавилоны мужид тушаал дэвшүүлэв (30).

Тэд тушаал дэвшсэн! Бидэнд шударга бус хандсан эрх мэдэлтнийг хүндэтгэх аваас, бид шагналаа хүлээн авна. Дөнгөж саяхан уншсан даатгалын менежер шиг мөн гурван Еврей залуу шиг. Бидний дээр Бурханы тохоон томилсон хүмүүсийг хүндэтгэснээрээ, бид Бурханыг хүндэтгэх бөгөөд эргээд Бурхан биднийг хүндэтгэдэг нь сүнсний хууль болой. Ил нөхцөл байдлаас даван, сүнсний хууль дээр төвлөрсөн хүн хэзээ ч алдахгүй.

Иймийн учраас л Петр цааш нь “Та нар сайны төлөө зүтгэгч болбоос хэн та нарт хор учруулах юм бэ?” (1Петр 3:13) гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, зүрхэндээ хүндэтгэлийн зарчмыг суулгасан хүнийг хэн яах юм бэ? Нэн ялангуяа эрх мэдэлтний зүгээс ирэх шударга бус хандлагыг зөв зүйтэй шийдвэрлэж чадах аваас, та тушаал дэвших юмуу шагналд тодорхойлогдоно. Тиймээс: би хүндэтгэлийн зарчмаар амьдарч чадаагүйнхээ улмаас хичнээн олон шагнал, дэвшлээс хоцорсон бол? гэж асуу.

Төр засгийн удирдагч нарыг хүндэтгэх

Учир нь сайныг үйлдэхэд захирагч нар нь айдас болдоггүй, харин мууг үйлдэхэд айдас болдог. Та эрх мэдлээс айхгүй байхыг хүсэж байна уу? Сайныг үйлд. Та түүнээс магтаал хүртэх болно. Тэр таны сайн сайхны төлөөх *Бурханы үйлчлэгч* юм. Хэрэв та муу муухайг үйлдвэл айгтун. Илдийг тэр дэмий зүүгээгүй. Тэр бол муу муухайг үйлдэгчдээс Бурханы уур хилэнгийн өшөө авагч, Түүний үйлчлэгч мөн. Тиймээс зөвхөн уур хилэнгийн улмаас бус *мөн мөс чанарынхаа учир захирагдах (хүндэтгэл үзүүлж, бүгдийг нь хүндэтгэх)* хэрэгтэй. Ийм учраас та нар ч гэсэн татвар төлдөг. *Учир нь захирагч нар Бурханы зарц нар* бөгөөд энэхүү ажилд өөрсдийгөө зориулдаг юм (Ром 13:3-7, тодруулгыг нэмэв).

Дээрх бичээс дээр иргэний удирдагч нарыг “Бурханы зарц” гэсэн бөгөөд тэднийг хүндэтгэхийг үүрэгдсэн байгааг тэмдэглээрэй.

Түүнчлэн Паул заримыг нь бус, харин *бүгдийг нь* хэмээн онцолсон. Миний хувьд цагдаа, гал сөнөөгч, төрийн албан хаагч, хотын дарга, хууль боловсруулагч, захирагч, шүүгч, конгрессийн гишүүн, сенатор юмуу төр засгийн шат шатны хүмүүстэй таарах үедээ дээрх үгийг зүрхэндээ лав мэдэрдэг. Хот, муж, төр захиргааны газраар орохдоо, дотроос минь өөрийн эрхгүй хүндэтгэл оргихыг мэдэрдэг. Зүрхэнд

минь Эзэнээс эмээхүй оршиж байгаа учраас л тэр гэдгийг би сурсан билээ.

Саяхан ажилчдынхаа тун чухал нэгэн хуралд яарч явав. Тэр долоо хоногт хичээлийн шинэ жил эхэлсэн бөгөөд өмнөх зуны гурван сар нь би хорооллоороо 60-тай л давхиж явдаг байлаа. Гэтэл сургууль эхэлмэгц тодорхой цагт 30-аас хэтэрч болдоггүй дүрэмтэй байв. Би ч хуралдаа яарсандаа, жолооч нарын хязгаартай бүсэд хурдаа хэтрүүлээд байна хэмээн анхааруулан, гэрлээ улалзуулан дохиод байгааг ч анзааралгүй, 60-тай л давхиад гарчихав. Гэтэл бутны цаана улаан, цэнхэр гэрлээ асаасан, мотоциклтэй цагдаа нуугдсан байхыг үзээд, шууд л жолоогоо татлаа.

Цагдаа надаас жолооны үнэмлэх, даатгал асууж байхдаа, цагдаа нарын ёсоор албан царайлав. Би ч намайг зогсоосон учрыг нь бүрэн ойлгож байгаагаа хүлээн зөвшөөрөөд, их л хүндэтгэлтэйгээр буруугаа хүлээлээ. Тэгээд миний гаргасан зөрчлийн тал дээр дахин хэд гурван үг солилцов. Тэгтэл цагдаа дийлэнх хүмүүсийг зогсоохоор ихэвчлэн гомдол гаргаж, шалтаглаж, уурладаг гэлээ.

Би ч “Эрхэм ээ, миний буруу” л гэв.

Цагдаа сургуулийн бүсэд хурд хэтрүүлэх нь \$220 долларын торгуультай гэснээ, миний үнэмлэх, даатгалыг эргүүлж өгөөд “Амжилт хүсье” гэж хэлээд, мотоцикл руугаа яваад өгсөн нь намайг баахан гайхшрууллаа.

Би ч ангайж хоцров. Тэгээд бараг л “Торгуулийн хуудсаа авъя өө!” гэтэл цагдаа над руу инээмсэглээд, даллав. Би хөдлөхдөө, дотроо аугаа өршөөл мэдрэв. Талархсан гэхэд ч багадаа.

Гэхдээ дандаа ингэхгүй л дээ. Би олон жилийн турш цагдаа нарыг яг л ижил хүндэтгэсэн боловч, хэд хэдэн удаа торгуулийн хуудас хүлээн авч байсан. Тухай нь, нэг удаа ажилчдынхаа хамт нисэх буудал руу явж байсан тохиолдол санаанаас гардаггүй. Би бас л өөрийнхөө дүүрэг хорооллоор хурдаа анзааралгүй давхиж яваад, цагдаад баригдчихав. Туслах маань надад таалагдах гэсэндээ тэр үү - цагдааг манай машин руу хүрч ирэхээс өмнө хэд гурван доромж үг, бүдүүлэг нэр ус хэлж орхив. Би зөвшөөрөгдсөн хурдаас яльгүй л хэтрүүлсэн бөгөөд цагдаа нарын ихэвчлэн тоолгүй орхидог зөрчлийг тооцож, зогсоосон тэр цагдаад туслах маань уурлажээ.

Би ч тэр цагдаад ялгаагүй л хүндэтгэлтэй хандсан боловч, тэрбээр дээр өгүүлсэн цагдаа шиг эелдэг, зөөлөн байсангүй. Харин ч тун хатуу хандаж, бүрэн торгууль бүхий хуудсыг надад гардуулав. Би ч

торгуулийн хуудсыг нь хүлээн автлаа хүлээгээд, “Эрхэм ээ, намайг уучлаарай. Миний буруу. Улс нийгмийнхээ төлөө зүтгэж байгаа таны ажилд баярлалаа” гэж хэлэв. (Нэгэнт хэвлэж гаргасан торгуулийн хуудсыг буцаах боломжгүйг би мэдэж байлаа)

Цагдаагийн албан хаагчийн зан авир орвонгоороо өөрчлөгдөөд, дуу нь шингэрээд явчихав. Тэрбээр эрх мэдлийг хүндэтгэж байгааг минь үзээд, зөөлөрчээ. Одоо тэрбээр бичсэн торгуулийн хуудсаа буцаамаар байгаа юм шиг л үйлдэж байлаа. Гэхдээ ингэх боломжгүйг бид хоёр хоёулаа мэднэ. Би Ром номын “Бурханы зарц” гэж хэлсэн тэр хүнийг ерөөмөөр байв. Тэгээд бид хоёр тун нөхөрсгөөр салав.

Цагдааг явсны дараа би туслах руугаа хараад “Цагдааг муулахыг чинь таална гэж байхгүй шүү, нөхөөр” гэж хэлээд, түүнд хүндэтгэлийн хичээлийг зааж өгсөн юм.

Туслах маань ч цагдаа нарт хүндэтгэлгүй хандах нь байх л, хэвийн зүйл хэмээн өдий хүртэл бодож явсан нь төр засгийн эрх мэдлийн талаар заадаг Бурханы Үгтэй тас зөрчилдөж байгааг газар дээрээ ухаарсан билээ. Ийнхүү энэ тохиолдол түүнд иргэний эрх мэдэлтнүүдийг хүндэтгэх зарчмыг зааж өгсөн юм.

Төр засгийн эрх мэдлийг хүндэтгэсний шагнал

Би тантай төр засгийн эрх мэдэлтнүүдийг хүндэтгэхийн шагналыг тодруулсан нэгэн гэрчлэл хуваалцмаар байна. Миний бие наяд оны адгаас эхлэн аялж эхэлсэн юм. Аяллынхаа эхний жилүүдэд хэд хэдэн удаа Мидвэстийн нэгэн чуулганд заадаг байлаа. Тэр чуулган 150 хүнтэй болтлоо өсөөд, гагцхисан байв. Жил тутам очиж заагаад байхад л, тэд урагшаа ч үгүй, хойшоо ч үгүй. Сүүлдээ би очихоо болив. Хэдэн жилийн дараа би тэднээс жил тутмын конференцдээ урьсан урилга хүлээн авлаа. (Тэд өмнө ийм конференц хийж байсангүй) Тэнд маш алдартай, алдартай номлогч нарын нэрс байхыг би анзаарсан бөгөөд конференцэд найман зуугаас олон хүн оролцоно гэж мэдээллэв) Миний гайхсан гэж.

Тэгээд сонирхлоо. Залбирсныхаа дараа би урилгыг нь хүлээж авахыг туслахдаа хэлэв. Тэгээд нөгөө хотод очоод, тэдний шинэ барилгын зогсоол дээр буулаа. Зогсоол дүүрэн машин байх нь шууд л нүдэнд өртлөө. Шинэ танхимд нь ормогцоо, 8-9 зуун хүн пиг дүүрэн байхыг үзээд сэтгэл хөдлөв. Тэнд Бурханы оршихуй урьд урьдаасаа хүчтэй оршиж, цутлаан ч хүчирхэг байлаа.

Цуглааны дараа би пастортай нь ганцаарчлан уулзахдаа “Юу болоов ээ? Та нар чинь олон жил гацаанд ороод байсан. Цуглаан чинь яаж ийм хурдан өсөв? Би ирэлгүй гуравхан жил л болсон шүү дээ” гэж хэллээ.

Пастор ч шууд л нууцаа дэлгэлээ. “Жон, хүмүүсийн татвар төлөхдөө гомдол гаргаж байгаа байдал, төр засгийнхаа эрх баригч нарыг муулж байгаа байдал намайг залхаасан. Тиймээс энэ талаар ямар нэг юм хийе л гэж бодсон. Тэгээд залбиртал, Бурхан надад санаа өгсөн.”

Пастор хотын захиргаан дээр явж очоод, хамгийн том хэрэгцээг нь лавлажээ. Гэтэл тэд гал сөнөөгч нарт нь утаан дундуур хардаг, онцгой баг хэрэгтэй байгааг хэлсэн байна. Гал түймэртэй холбоотой үхлийн дийлэнх хувь нь түлэгдлээс бус, утаа угаараас болдог ажээ. Гал сөнөөгч нар ч өтгөн утаан дунд яг өмнөө байгаа хүнийг ч олж хардаггүй нэг зовлонтой байдаг ажээ. Харин тэр онцгой багтай бол, хохирогч хүнийг үтэр түргэн олж хараад, аврах боломжтой аж. Хотын захиргаанд ийм нэгэн нүсэр хэрэгцээ байсан ч, төсөв байсангүй. Тэр баг нь ширхэг нь \$25,000 үнэтэй эд юмсанж.

Пастор дараагийн Бүтэн сайнд нь индрийнхээ ард гараад, Ром 13-аар бүлгээс номложээ. Тэгээд хотынхоо захирагч нарт гомдоллож байгаа гишүүдээ хайраар зэмлэсэн байна.

Тэрбээр төр захиргааны хүмүүс нь Бурханы зарц нар бөгөөд итгэгч хүмүүс татвараас хойш сууж, иргэний удирдагч нарыг дорд үзсэнээрээ ерөөгдөхгүй гэдгийг нь хүмүүстээ хэлжээ. Пастор үүнийгээ бичээсээс ул суурьтай баталсныхаа дараа хотын төв гал командад галын баг хэрэгтэй байгааг хэлээд, тэр багийг худалдаж авах мөнгийг цуглуулах онцгой өргөл хүлээж авна гэдгээ зарлажээ. Тэгээд энэ нь тэдний төлөө үйлчлүүлэхээр Бурханы томилсон хүмүүсийн нийгэмдээ үйлчлэх үйлчлэлийг нь хүндэтгэх сайн арга болохыг хэлжээ.

Чуулган ч хандлагаа гэмшиж, \$25,000-ын өргөл цуглуулжээ. Пастор хотын даргатай яриад, чуулган нь баг худалдаж авах мөнгийг гардуулж өгөх учраас, тэр долоо хоногт хотын удирдагч нарыг цуглуулж болох эсэхийг нь асуужээ. Пастор, чуулганы удирдагч нар хотын захиргаан дээр хүрэлцэн ирэхдээ, тэдний үлэмж өндөр хүндэтгэлийг гэрчлэн харахаар төр захиргааны хичнээн олон ажилтан, албан хаагч цугласныг үзээд нүд орой дээрээ гарсан байна.

Пастор чекээ гардуулж өгөхөөсөө өмнө Ром 13-аас уншаад, чуулганых нь гишүүд хотын захиргааны ажилтан, албан хаагч нарыг хэрхэн хүндэтгэж, Бурханы зарц нар гэж үздэг талаар үг хэлжээ.

Тэгээд иргэдээ хамгаалж, тэдэнд үйлчлэхийн төлөө хийж байгаа ажил хөдөлмөрт нь талархлаа илэрхийлжээ. Хүмүүс ч чуулганы зүгээс үзүүлж байгаа хүндэтгэл, өгөөмөр байдалд ихэд догдолж. (Хүн бид хүндэтгэлийг ихэвчлэн санхүүгийн дэмжлэгээр илэрхийлдэг. Хүндэтгэл нь үнэ цэнэ өгөх явдал гэдгийг санаж байна уу? Хүн үнэ цэнэ өгч байгаа зүйлдээ мөнгө зориулдаг)

Дараа нь пастор надад ингэж хэлэв: “Хэдэн сарын дараа бид шинэ барилгаа Бурханд даатгах ёслол хийсэн. Хотын захиргааны маш олон ажилтан, албан хаагч ирж оролцсон шүү. Олон ч хүн аврагдаж, манай чуулганд явах шийдвэр гаргасан. Ийм нэгэн явдал нийгмийг маань бидэнд нээж өгөх түлхэлт болсон.”

Есүс “Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах (хүндэтгэх) хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна” хэмээн айлдсаныг бид санах ёстой. Есүс онцлон чуулганы эрх мэдлийн талаар өгүүлсэн боловч, эрх мэдлийн сүнсний хууль нь бүх төрлийн эрх мэдлийн хил хязгаар дотор хэрэгждэг болохыг санаарай. Тиймээс өөрөөр хэлбэл “Төр засгийн эрх мэдэлтний нэрээр төр засгийн эрх мэдэлтнийг хүндэтгэдэг хүн нь төр засгийн эрх мэдэлтний тээдэг шагналыг хүлээн авна” гэж хэлж болно.

Тэгвэл тэр шагнал нь юу вэ? Хариулт нь нийгмийн маань түлхүүр болно. Төр засгийн эрх баригч нар бол манай хот, төв, муж, улс үндэстний сахиулууд бөгөөд Бурханаас томилогдсон улс болой. Чуулганууд маань төр засгийн удирдлагаа шүүмжилж, татвараас зайлахын оронд санаа нэгтгэйгээр хүндэтгээд эхэлбэл, хичнээн олон улс үндэстэн, нийгмийн үүд хаалга ярайтал дэлгэгдэхийг хэн мэдлээ?

Иж бүрэн их засвар

Надад Данни гэдэг сайн анд бий. Тэрбээр Австралийн Адилэйн нэгэн том чуулганд үйлчилдэг байлаа. (Найз маань чуулганаа өөр нэгэн мундаг удирдагчид шилжүүлж өгөөд, өөрөө эдүгээ аялж, залуу удирдагч нарыг босгон байгуулах үйлчлэл хийж яваа) Намайг анх түүний конференцэд үйлчлэх үед тэрбээр нэгэн гайхамшигтай түүх ярьж өгсөн юм. Данни чуулганыхаа өмнө гараад, тэдний төлөө үйлчилж, тэднийг хамгаалж байгаа хотын захиргааны ажилтнуудыг хүндэтгэх чин хүслээ дэлгэжээ. Тэгээд нилээд залбирч, бодсоны эцэст хамгийн том хэрэгцээ нь улсын сургуулийн системд оршиж байгааг

мэдэрсэн байна. Тийнхүү хотынхоо хамгийн л гэгдэх ядарсан сургууль дээр очоод, үнэхээрийн сүйрчихсэн газар, барилгатай байгааг үзжээ. Тэгээд удирдагч нартай уулзаад, нэг Хагас сайн өдөр чуулганаараа ирээд, иж бүрэн их засвар хийж өгөх зөвшөөрөл асуусанд, хотын удирдлага ч баяртайгаар зөвшөөрөв.

Найз маань чуулганыхаа өмнө гараад, хотоо ерөөх алсын хараагаа хуваалцаж. Тэгээд бүх мужаан, худалдаа эрхлэгчдээс ганц өдөр бэлэг авъяасаараа хөрөнгө оруулахыг хүсчээ. Дараа нь чуулганыхаа үлдсэн хүмүүсээс ч тусламж хүссэн байна. Чуулганы удирдлага энэ том ажиллагааг хэдэн долоо хоног төлөвлөв. Тус сургуулийг цоо шинэ мэт болгохын төлөө материалаа захиалж, багаж хэрэгслээ бэлтгэв.

Тэгээд найз маань надад тэр том өдрийн видеог үзүүлж билээ. Мужаанууд хуучирсан, илжирсэн, нурсан хэсгийг нь хуулаад л, ажилчид хуучин шүүгээнүүдийг нь гаргаж, оронд нь цоо шинийг тавиад л, баахан эрчүүд, эмэгтэйчүүд замаск татаж, нааж, будаад л. Хуучных нь суурин дээр шинэхэн самбар, шинэхэн эд хэрэгсэл суурьлуулаад л, шинэ мод, бут, цэцэг тариад л. Тэд засварын өмнөх сургуулийн ерөнхий байдлыг нэг бичээд, засварын яг дараах байдлыг нэг бичсэн байв. Үгээр хэлэхийн аргагүй. Цоо шинэ мэт харагдаж байлаа.

Чуулган ч хотынхоо төлөө үйлчилсэндээ жигтэйхэн баяртай. Нэг зүйл хэзээд үнэн: Хүнийг санаандгүй байхад нь хүндэтгэсэн хүний зүрхэнд төрдөг баяр хөөр шиг жаргал үгүй. Чуулганы хувьд Эзэн Есүс Христийн нэрээр хотоо ерөөж чадаж байгаа баяр бахдал нь л өөрөө ер бусын том шагнал байв. Гэтэл тэднийг бүр том шагнал хүлээж байж. Энэ явдлын талаар Австралийн ерөнхий сайд Жон Ховард агсан дуулаад, өөрийн биеэр тус чуулганд зочилж, талархал илэрхийлэхээ мэдэгджээ. Тэгээд би тэр улсын удирдагч чуулганд нь айлчлан ирээд, чин зүрхнээсээ талархаж буй видеог үзсэн юм. Үүнийх нь үр дүнд тэр чуулган хотынхоо хамгийн нэр хүндтэй чуулганы нэг болжээ. Тэдний нэр хүнд, нөлөөлөл улс нийгэмдээ ер бусаар өссөн байна.

Ингээд ч дууссангүй! Пастор Данни засварын түүхээ энд тэндгүй хуваалцаж эхлэхэд, давхар, давхар үржил бүхий давалгаа үүсжээ. Үүний хариуд, олон чуулган өөр, өөрийн гэсэн төслөө эхлүүлж, Австрали, Англи, Швед, Сингапур, Малайз даяар хоёр зуу гаруй сургууль шинэчлэгджээ.

Пастор Даннигийн чуулган цаашид ч нийгэм дээрх төвлөрлөө хадгалан, эмэгтэйчүүдийн хорих газрыг сэргээн засварласан байна. Энэ төслийнхөө явцад тус чуулган Засан хүмүүжүүлэх газартай хамтын

ажиллагаа тогтоосон нь хоригдлуудад цуглаанд суух “өдөр” гаргаж өгсөн бөгөөд эдүгээ олон эмэгтэй аврагдаж, шоронд цуглаан хийх болжээ.

Сайн нэр

Та яахаараа заавал хотдоо нэр хүндтэй байх ёстой билээ гэж бодож байна уу? Шалтгаан нь маш энгийн. Нэгдүгээрт - энэ чинь бичээсийн үнэн. Элч Паул чуулганы удирдагч нарыг “Тэрээр буруутгалд хийгээд диаволын урхинд орчихгүйн тулд (чуулганы) гадна байгсдын зүгээс сайн гэрчлэлтэй байх ёстой” (1Тимот 3:7) гэсэн. Бид чуулганаас гадуурх хүмүүсийн дунд сайн нэргүй бол, Сайн мэдээнд балагтай. Үүнээс болж эргээд Сайн мэдээ ахицгүй болох нь диаволын урхи болно.

Ромын үл итгэгч нэгдүгээр зууны Христэд итгэдэг хүмүүсийн талаар “Тэд газар дээр хоног төөрүүлж байгаа ч, тэнгэрийн харъяатууд. Тэд зарлигдсан хуулийг дагадаг ч, нөгөөтэйгүүр тэр хуулиас давсан амьдралтай” (Диогнетуст хандсан захидал, 5-аар бүлэг) гэж бичиж байжээ.

Үйлс ном Иерусалимын чуулганы талаар дараах мэдэгдлийг хийжээ: “(Чуулганаас) Гадна үлдэгсдээс хэн ч тэдэнтэй нийлж зүрхэлдэггүй байсан боловч тэднийг ард олон өндөр үнэлдэг байв” (Үйлс 5:13, хашилтан доторх үгийг нэмэв). Иргэд яагаад тэднийг тийм өндрөөр үнэлдэг байв? Өндөр амьдралынх нь улмаас. Жинхэнэ ариун байдал нь хаанчлалын зиндааны сэтгэлгээ, амьдралаар амьдрах чадвар болой.

“Гэхдээ Жон, төр засгийн удирдагч нарыг хүндэтгээд, тэдэнтэй хамтран ажиллахаар чинь Сайн мэдээг хөсөрдүүлж байгаа хэрэг биш үү?” Яалаа гэж! Иохан Баптист Херодод ах дүүгийнхээ эхнэртэй нэг хөнжилд орсон, хууль бус явдлыг нь анхааруулж хэлсэн. Үнэндээ үүнээсээ л болж толгойгоо авахуулсан.

Ерөнхийлөгч Клинтонтой уулзаад, үр хөндөлтийг буюу нялхсын аллагыг хуульчлаад өгбөл, түүн дээр болоод улс үндэстэн дээр буух шүүхийн талаар анхааруулж хэлсэн Бурханы нэгэн зарцыг би мэднэ. Гэхдээ энэ хүн Херод Иохан Баптистыг хүндэтгэж байсан шиг л ерөнхийлөгч Клинтон түүний анхааруулгыг гүнээ хүндэтгэн хүлээж автал нь хэлсэн юм.

Херод Иоханаас эш үзүүлэгчийнх нь хувьд эмээдэг байв. Олон хүн албаны хүмүүс дээр хүндэтгэх нь бүү хэл, нэг л их пээдийсэн,

шүүмжилсэн, шүүсэн янзтай явж очдог. Шадрах, Мешах, Абеднего хааныхаа шүтээн мөргөлийг эсэргүүцсэн ч, хүндэтгэлтэй ярьсан юм шүү.

Эсрэг тэсрэг байдал

Гэргий маань хэзээ ч мартагдахааргүй нэгэн зүүд зүүдэлж билээ. Ерөнхийлөгч Клинтонь захиргааны үеэр гэргий маань харанхуй шөнөөр бөмбөгнөтөл чичирсээр сэрсэн юм. Тэгээд “Жон, би нэг зүүд зүүдэллээ. (Бурхан Лизатай зүүдээр нь их ярьдаг)

Тэгээд “Чи, бид хоёр том танхимд номлогчийн үгийг сонсож байх юм. Номлогч нь хэн байсныг мэдэхгүй ч, ямар ч байсан итгэгчдийн дунд алдартай хүн. Тэрбээр ерөнхийлөгч Клинтоньг гутаан, түүний эсрэг ярьж байсан. Түүнийг ямар гээчийн муу болохыг нь зогсоо зайгүй зандарсан. Хүмүүсийн дийлэнх хувь нь номлогчийн үгийг уухайлан, “Амень” хэмээн хөөрцгөөсөн. Харин бид хоёрт маш таагүй байсан.

Тэгтэл сүүдэр дундаас нэг хүн босоод, тэр том танхимын захаас гараад явчихсан. Би ч түүнийг дагамаар санагдсан. Намайг тэр байшингийн үүдэн хэсэг рүү гартал, нөгөө хүн эргээд над руу харсан. Тэр хүн ерөнхийлөгч Клинтон байсан! Тэрбээр гуниг гашуудалдаа автаад, элэг нь эмтэрсэн байсан. Тэгээд унаад өгсөн.

Жон, ерөнхийлөгч чуулган дээр тусламж, дэмжлэг авахаар ирснийг нь би зүүдэндээ ойлгосон. Гэтэл чуулган түүнийг ямар ч хайр найргүйгээр зандарч загнасан. Бид ерөнхийлөгчийнхөө зүрхийг хатууруулж, хувьд нь ч, хувьсгалд нь ч хэрэгтэй зүйлээс буруулахад хүргэж байгааг Бурхан надад ойлгууллаа” гэж ярьсан юм.

Энэ зүүдийг Баруун Америкийн том чуулганд үйлчилж байсан нэгэн найзтай минь жишиж үзье. Найз маань мөн Америкийн Залбирлын төвийг удирддаг байв. Бурхан түүнд Вашингтон дахь Сенат, Төлөөлөгчдийн ордон болоод бусад удирдагч нарт үйлчлэх зүрхийг өгсөн тул тэрбээр энэ тал дээр олон жил үйлчилсэн юм. Пастораар үйлчлэнгээ, хажуугаар нь жилд ойролцоогоор 22 долоо хоног Вашингтон Ди. Си рүү аялж байсан ч, мянга мянган хүнтэй чуулган нь цэцэглэсээр, өссөөр байлаа.

Тэрбээр нэг удаа надад ингэж ярьсан юм. “Жон, Би тэр удирдагч нартай ердөө ганцхан зүйл л хийх гэж уулздаг юм. Улсынхаа төлөө зүтгэж байгаад нь талархаж, тэдний төлөө залбирч болох эсэхийг нь асуух гэж л.”

Тэгээд төр засгийн төлөөлөгч нарыг айлчлан ирэх үед нь хэрхэн угтаж авч, үйлчлэхийг пастор, чуулганы хүмүүст хичнээн олон удаа зааж өгөх хэрэгтэй болсныг ярьж билээ. Олон ч удаа тэднийг удирдагч нартай уулзалдахаас нь өмнө удирдагч нараа чиглүүлсэн шүүмжлэлийг нь тайлж авах шаардлагатай болдог байж. Хүмүүсийн либерал гэгдэх үзэл нь удирдагч нараа хүндэтгэж, залбираарай гэдэг Бурханы үгийн үнэнийг харах нүдийг нь сохолсон байжээ.

Дараа нь найз маань удирдагч нар үнэндээ ямар зөөлөн, нээлттэй хүмүүс болохыг үзээд, хүмүүс нь байнга гайхдаг тухай хэлсэн юм. Чуулганыхан юм нэхэх юмуу бодол санаагаа илэрхийлэхийн оронд зүгээр л хүндэтгэсэн учраас л тэр шүү дээ. Би танд найзынхаа хоёр гэрчлэлийг хуваалцъя. Уншингаа, түүний өгүүлсэн хоёр удирдагч нь туйлын либерал хүмүүс болохыг ойлгоно уу.

“Би тэр конгрессийн гишүүнтэй өмнө хэд хэдэн удаа уулзаж байсан юм. Тэрбээр манай чуулганы хөгжимчин - оюутан залуусыг хэсэг ажилтнуудынхаа хамт албан өрөөндөө урин, хүлээж авсан юм. Тийнхүү бидний яриа хөөрөө албан маягийн танилцуулгаар эхлэв. Бид түүнд дүүргийнхээ хүмүүсийн төлөө, улс орныхоо төлөө итгэмжтэй зүтгэж байгаад нь талархлаа.

Дараа нь тэрбээр ганц хоёр санаагаа хуваалцаад, биднээс хэдэн асуулт асуусан.

Үүний дараа би түүнээс дуу дуулаад, түүний төлөө залбирч өгч болох эсэхийг асуусан чинь тэр эрхэм дуртай нь аргагүй зөвшөөрсөн.

Биднийг дуулж эхлэхэд, өрөө тосолгоогоор хальж, төдөлгүй хүн бүрийн нүдийг нулимс бүрхсэн. Эх орны сэдэвтэй болоод магтан дуу дуулсныхаа дараа бид залбираад дуусгасан. Энэ бүхэн маш хүчтэй нөлөөлсөн. Биднийг дууссаны дараа хэн ч, юу ч хэлээгүй. Конгрессийн гишүүн ч тэр.

Тэгж тэгж тэр эрхэм над руу хараад, юу мэдэрснээ, яаж догдолсноо өөрийнхөө үгээр дүрслэх гэж оролдсон ч, чадаагүй. Эцэстээ тэрбээр “Пастор аа, би хоёр жаалтай. Тэднийгээ чуулганд нь явуулах ёстой байх, тийм үү?” гэж хэлсэн юм.

Тэгээд биднийг ирсэнд талархав.

Найзын маань хуваалцсан өөр нэгэн түүх бий:

“Тэр конгрессийн гишүүн анх чуулганы арван тав орчим хүн, тэдний пастор нийлсэн манай багийг албан өрөөндөө хүлээж авахдаа, Үндэсний залбирлын төвийг төлөөлсөн чуулганы энэ хүмүүс юу хүссэн юм бол гэсэн янзтай байсныг биеийнх нь хэл илтгэж байлаа.

Тэрбээр тун нигүүлсэнгүй хандан, бидний төлөө хийж өгч чадах зүйл байгаа эсэхийг асуусан. Би ч бид ямар нэг юм авахаар ирээгүй, харин зүгээр л улс орныхоо төлөө зүтгэж байгаад нь талархаж, түүний төлөө залбирч өгөхөөр л ирснээ хэлсэн.

Тэрбээр уужирснаа “Хөөх, жинхэнэ бэлэг байна даа” гэж хэлсэн юм. Тэгээд өдөр бүр хүмүүс албан өрөөнд нь ирээд, мөнгө хүсдэг тухай хэлээд, ханан дээрээ өдөр бүр хүмүүсийн хүссэн мөнгөн дүн нэмэгдэж байдаг дижитал самбар зураглан хардгаа хэлэв. Тэгснээ над руу хараад “Гэтэл та нөхөд надад өгөхөөр иржээ. Би ийм юм үзэж байсангүй” гэсэн юм.

Дараа нь бид түүний төлөө залбирч өгсөн хойно тэрбээр “Та нар манай ажилтнуудын төлөө бас залбирч өгөөч?” гэж хэлсэн. Ажилтнууд нь орж ирээд, бид ч тэдний төлөө залбирч өгсөн.

Биднийг дуусахад, тэрбээр цагаа хараад “Би нэг уулзалтаа цуцалчихлаа. Би та нарыг нийслэлээр дагуулж, ойр хавьтайгаа танилцуулбал, яаж байна?” гэсэн юм. (Ийм ажлыг конгрессийн гишүүн хүн хэзээ ч хийхгүй, бага тушаалын хүн хийдэг юм)

Тэгээд хагас цагийн турш биднийг нийслэлээр дагуулж явсан. Аялал дуусахад, конгрессийн гишүүн, бид хоёр хоёулаа хөөрөн, нэрийн хуудсаа солилцоод, салцгаасан.

Хоёр долоо орчим хоногийн дараа нөгөө чуулганы пастор бөөн баяр болчихсон ярьж байна. Гэтэл нөгөө конгрессийн гишүүн пастортай яриад, ирэх бүтэн сайнд чуулганд нь оролцож болох эсэхийг асуужээ. Бид ч энэ үйл явдлыг хэрхэн зохион байгуулах талаар ярилцав. Тэгээд мэдээж Бүтэн сайн өдөр нь конгрессийн гишүүн маань гэргий, ажилтнуудаа дагуулан чуулганд нь айлчилжээ.

Хүндэтгэлийн цуглааны дараа пастор конгрессийн гишүүнийг гэр бүлийнх нь хүнтэй танилцуулахад, тэд ч үг хэлэв. Дараа нь чуулган сэтгэл хөдөлсөн конгрессийн гишүүний төлөө бас гэр бүлийнх нь хүний төлөө залбирч өгсөн байна. Энэ бүхэн конгрессийн нэгэн гишүүний албан өрөөнд очиж хүндэтгээд, залбирч өгсний үр дүн шүү дээ.

Манай пастор найзад ийм гэрчлэл дүүрэн бий. Та “Бид удирдагч нарт үнэнийг хэлэх ёсгүй юм уу?” гэж гайхаж байгаа байх. Ёстой. Иохан Баптист шиг, ерөнхийлөгч Клинтонд анхааруулсан пастор шиг, үүнийг хийсэн бас хийсээр байгаа олон хүн шиг л. Гэхдээ, чуулган удирдагч нартаа өөрсдийгөө Есүс Христийн хайр, энэрэл дотор явдаг хүмүүс бөгөөд тэдний эрх мэдлийн байр суурийг үнэн голоосоо хүндэтгэдэг гэдгээ ойлгуулахгүй бол, тэд бидний үгийг сонсох уу

даа. Бид үнэнийг хэлэх ёстой. Гэхдээ хайр дотор, Эзэнээс эмээхүй дор хэлэх ёстой.

Бурхан зарцдаа (зарц нартаа) Хуучин гэрээний эш үзүүлэгч нарыг хаан руу илгээдэг байсан шиг л хатуу үг дайлгаад, иргэний удирдагч руу илгээх үе байна. Гэхдээ хэрэв бид гэртээ, жижиг бүлэгтээ, цуглаан дээрээ удирдагч нараа өөрсдөө ч муучлаад, муучилж байгаа хүмүүсийг ч дэмжээд байвал, ямар хэрэг байх билээ? Араас нь хутгалж байгаагаас ялгаагүй. Удирдагчийнхаа улаан нүүрэн дээр хайр, хүндэтгэлээр дүрэлзсэн зүрхээр хэлж чадах үгээ л хувьдаа ярь. Ингэхгүй бол, бид зүрхээ хордуулах бөгөөд энэ маань удирдагч нарын маань нүүрэн дээр ил болно.

Хааныг хүндэтгэх

Элч Петрийн үгийг сонс. Тэрбээр биднийг “Бүх хүнийг хүндэл. Ахан дүүсийн барилдлагааг хайрла. Бурханаас эмээ. Хааныг хүндэл” (1Петр 2:17) гэжээ.

Петр “Та нарын дээр Бурханы томилсон, нүдэндээ харагдах удирдагч нарыг хүндэтгэхгүй байж, харагдахгүй Бурханыг хүндэтгэдэг гэж яаж хэлж чадах билээ, та нар?” гэсэн байна. Бурханаас эмээдэг бол, иргэний байна уу, нийтийн байна уу, гэр бүлийн байна уу, чуулганы байна уу - удирдагч нарыг бүгдийг нь хүндэтгэнэ.

Өмнөх бүлэгт хэлсэнчлэн, Америкчууд бид удирдагчдаа “Хүндэтгэлийг минь олоод ав” гэдэг. Гэтэл Эзэнээс эмээхүй “Би таны дээр Бурханы байршуулсан эрх мэдлийг харж байгаа учраас, үг дуугүй хүндэтгэнэ” гэдэг.

Би Петрийн онцлон заагаад байгаа хааны талаар судласан юм. Мэдээж бичээсийг хувь хүнд нялзааж орчуулж болохгүй бөгөөд улсынхаа удирдагч нарыг хүндэтгээрэй гэсэн Петрийн үг инү үе үеийн бүх итгэгч нарт хандсан болно. Гэвч Петрийн яриад байгаа хаан нь туйлын завхарсан, амиа хичээсэн I Херод Агриппа хаан юм.

Тэрбээр Есүсийг амилуулдсаны дараа МЭ 37 онд эрх хүчинд гарч иржээ. Үүнийгээ ч овжин санаа, арга заль хэрэглэн байж хийж. Холч ухаантай тэрбээр тушаал дэвшихийн төлөө чадахаасаа чадахгүйгээ хүртэл явжээ. Ромын эзэн хаан Калигулаг алуулсны дараа Кладиусыг хаан ширээнд суухад туслах нь улс төрийн чухал маневр байв. Кладиус ч Агриппагийн улс төрийн уран нүүдлийг шагнан, хаанаар

томилохдоо Иудеа, Самарийн нутаг дэвсгэрийг нэмж өгчээ. Ийнхүү Агриппа өвөг эцэг Их Херодтайгаа ижил дайны хаант улсыг захирах болсон байна.

I Херод Агриппа аргагүй эрхэнд Иүдеизм, Христэд итгэдэг хүмүүсийн бүлгийн хооронд хавчуулагджээ. Тэгээд шууд л Христэд итгэдэг хүмүүсийг хяхан хавчигчийн дүрийг авав. Шинэ гэрээнд “Энэ үед Херод хаан тэднийг хорлох зорилгоор чуулганаас заримыг нь баривчлав. Иоханы ах Иаковыг тэр цавчин алуулжээ. Иудейчүүдэд энэ нь таалагдсаныг ажигласан тэрээр Петрийг ч мөн баривчлахаар шийдэв. Энэ нь Исгээгүй талхны баярын өдрүүдэд болжээ” (Үйлс 12:1-3) гэдэг. Энэ захирагч улс төрийн зорилгынхоо төлөө Иудейчүүдийн тал тохойг татсандаа, итгэгч хүмүүст хайр найргүй ханджээ. Тэрбээр Есүсийн хамгийн дотны элчийн нэг болох Иаковыг алаад, дараа нь Петрийг ч алахыг оролдсон.

Петрийг цаазлах Агриппагийн төлөвлөгөөг чуулганы залбирал, дуулгавартай үйлдэл нураасан юм (5-19). Энэ чөлөөлөлт нь итгэгч хүмүүсийг маш хүчтэй бэхжүүлсэн. Тэдний дуулгавартай үйлдлийн шагналыг дараах Бичээс хэлжээ: “Харин Эзэний үг түгэн түгсээр (өсөн, үржсээр) байлаа” (24).

Ариун хүмүүсийн тасралтгүй залбирал, эрх мэдлийг дуулгавартай хүндэтгэсэн явдал нь дараа дараагийн үйл өрнөлд хүчтэй нөлөөлжээ. Цааш нь уншбал, Херод Агриппа хаан товлосон өдрөө ард түмний өмнө гарч ирээд, хааныхаа дээлтэй сэнтийдээ заларч байгаад үг хэлжээ. Тэгтэл “Ард олон —Хүний дуу биш, бурхны дуу байна гэж хашхирч байлаа. Бурханд алдрыг өргөөгүй тул түүнийг тэр даруй Эзэний тэнгэрэлч цохижээ. Тийнхүү тэр өт хорхойд идүүлж үхэв” (22-23).

Шүүх буусан - гэхдээ Бурханы хүмүүс бус, харин Эзэн Өөрөө цавчжээ. Эрх мэдлийг шүүдэг нь Бурхан Өөрөө болой. Бидэнд удирдагч нарынхаа төлөө залбирч, тэднийг хүндэтгээрэй л гэж тушаасан. Шүүх буух ёстой бол... Бурханд зай тавьж өг гэжээ. Бид удирдагчийнхаа төлөө залбирч, хүндэтгээрэй гэсэн Бурханы тушаалыг дагахгүй бол, Бурханы шударгаар шүүнэ гэсэн амлалтыг хойш чангаана. Тэгээд үндсэндээ манай үндэстэн юмуу нийгэмд хэрэгтэй амин зүйлийг нь буюу тэнгэрийн оролцоог булаах нь байна.

Орчин цагийн жишээ

Яг ийм нэгэн явдал саяхан Нигери улсад болжээ. Сани Абаха гэдэг дарангуйлагч 1993 оны ерөнхийлөгчийн сонгуулийг хүчингүй болгоод, ялах өндөр магадлалтай нэр дэвшигч - Мошүүд Абиолаг шоронд хорьж байгаад төрийн эрхийг гартаа авчээ. Тэгээд олон тооны ардчилсан удирдагч нарыг цаазлаад, дарангуйллыг тогтоов. Түүний дарангуйлал дор гэм зэмгүй олон хүн алуулж, гурав орчим тэрбум доллар түүний Европ дахь хувийн дансанд хууль бусаар төвлөрөв.

Миний найз Марк Нигери рүү байнга аялдаг юм. Тэгээд маш том Христэч хөдөлгөөнийг хариуцдаг Ий. Эй. Адебое, бишоп Давид Ойдепо нарын Нигери пасторуудтай найзууд болжээ. Тэдний сар тутмын залбирлын уулзалтад дунджаар сая итгэгч оролцоно. Харин жилд хоёр удаа буюу 6, 12-аар сард болдог онцгой залбирлын цуглаанд нь тус бүр хоёр сая гаруй хүн оролцдог байна.

Нигери итгэгч нар иргэний удирдагч нараа үнэн голоосоо хүндэтгэдгийг манай найз ч, Нигерид байнга зочилдог хүмүүс ч хэлдэг. Нөгөөтэйгүүр, тэд улс оронд нь шударга үнэн тогтохын төлөө удирдагч нарынхаа төлөө хичээнгүйлэн залбирдаг байна.

1998 оны эхээр болсон сар тутмын залбирал дээр Нигерийн хойд нутгийн, улсдаа дээрээсээ гурав дахь алдартай пастор Иммануэл Күре үүлс ярагдан, үлэмж том илд барьсан, аварга том хоёр тэнгэрэлч гарч ирэхийг үзсэнийг Марк пастор надад хэлсэн юм. Эдүгээ Абахагийн өдрүүд гүйцэж байгаа бөгөөд үнэндээ гуравхан сар үлдсэнийг Бурхан түүнд харуулсныг тэрбээр эш үзүүлжээ. Гэмшихгүй аваас, түүнд зугтах газар үгүй.

Пастор Күрегийн үг ерөнхийлөгчийн чихэнд хүрэв. Тиймээс Абаха тэр эш үзүүллийг эргүүлнэ гэж найдсандаа, “эвлэрлийн өргөл” буюу маш их хэмжээний мөнгө явуулжээ. Гэтэл Эзэн “Наанаа бүү хүр. Эс бөгөөс Абахагийн уяман өвчин чам дээр бууна” хэмээн айлдсаныг Күре пастор Марктай хувцаалцжээ. Тэгээд Күре пастор гэмшиж, Эзэн рүү эргээрэй гэсэн үгийг ерөнхийлөгчдөө илгээсэн байна.

Бурхан залбирлын хөдөлгөөнийг удирддаг Ий. Эй. Адебоед ерөнхийлөгч Абахатай уулзах үүд нээж өгчээ. Пастор ч бас ерөнхийлөгчийг гэмшихгүй бол, үхэж, албан тушаалаасаа зайлуулагдана гэдгийг анхааруулав.

Күре тэнгэрэлч нарыг үзсэнээс гурван сарын дараа буюу 1998 оны 6-аар сарын том залбирлын цуглаан дээр Адебое пастор цугласан

хүмүүст эргэн тойрныхоо хүмүүст “Шинэ жилийн мэнд хүргэе!” гэж хэлэхийг хүсчээ. Хүмүүс гайхав. Гэтэл тэрбээр буулга эвдэгдсэн бөгөөд гудамжинд бүжиг хатирах болно гэж хэлжээ.

Энэ үгээс хорин дөрвөн цагийн дотор ерөнхийлөгчийнх нь зүрх гэнэт хаагдсан байна. (Интернэтээс олж авсан) Мэдээн дээр “Нигери даяар Абахагийн үхлийг баярлан тэмдэглэсэн хүмүүс гудамжинд бүжиж байна гэсэн Нигерийн мэдээнээс БиБиСи агентлагийн радио суваг эш татав” гэсэн байлаа. Адебое дарангуйллын буулгын талаар хэлснийг залбирлын цуглааны хүмүүс ойлгожээ.

Удалгүй Нигери улс Христэд итгэдэг ерөнхийлөгчөөр ерөөгдөж, ерөнхийлөгч ч нөгөө хоёр пасторыг сүнсний удирдагчаа болгон хардаг болжээ. Тэр улсад Бурхан хүчтэй нүүв. Үнэндээ Абахагийн захиргааны үеэр Нигери улс Сайн мэдээ дэлгэрүүлэгч Рейнхард Боннкег улсдаа нэвтрүүлдэггүй байсан бол, Абахаг үхсэний дараа шинэ ерөнхийлөгч Олүсеган Обасанжо тангараг өргөх ёслол дээрээ Рейнхард Боннкег урьжээ. Тэгээд ёслол дээр түүний өмнө улсынхаа үүдийг дэлгэсэн байна.

1999 оны 10-аар сард Рейнхард Боннкегийн анхны Сайн мэдээний аян болсон бол, 2006 оны 10-аар сард Нигери дэхь түүний Сайн мэдээний аянаар 42 сая хүн Есүс Христийг амьдралынхаа Аврагч болгосон хэмээн тэмдэглэн бичсэн байна. Үүнийг шийдвэр гаргасан хуудсын тоогоор нь баталсан бөгөөд үүнийг ч тухайн үед Боннкегийн үйлчлэлийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан найз маань батлан хэлсэн билээ.

2000 онд Нигерийн хүн ам 123,337,822 байжээ. Тэгэхээр 42 сая хүн гэдэг чинь тэр улсын хүн амын 1/3 аж! Энэ чинь Нигери пасторууд, бусад Сайн мэдээ дэлгэрүүлэгч нар, 1999 оноос эхлэн Нигерид хөдөлмөрлөсөн хүмүүсийн үр жимсийг оруулаагүй тоо шүү. (Нигери нь Африк тивийн хүн амын 1/4 - ийг эзэлдэг нь сонирхолтой) Би л хувьдаа үүнийг сүнсний аугаа ургац гэнэ. Бичээс Херодыг үхсэний дараа “Харин Эзэний үг түгэн түгсээр байлаа” (Үйлс 12:24) гэж хэлснийг санаарай. Херод яагаад үхэв? Мөн л Эзэнээс эмээхүй дор явдаг (үүнд удирдагчаа хүндэтгэх явдал ч багтана) ариун хүмүүс болоод чуулган нэгдэн залбирсан учраас тэр.

Бурханы хүмүүс эрх мэдлийг хүндэтгэж, тэдний төлөө залбирч, Эзэний Үгд дуулгавартай байх үед Бурханы Сүнс хот, газар, улс үндэстэн дээр маань зүгээр л цутгахыг бид үзнэ. Тэгээд юугаа хүлээнэ вэ?

Олон нийтийн удирдагч нарыг хүндэтгэх

Боолын ёсоор буулган доор байгаа бүгд өөрсдийн эздийг хүндэлбэл зохистой хэмээн үз. Тэгснээр Бурханы нэр ба сургаал муу хэлэгдэхгүй. 1Тимот 6:1

Энэ эшлэлд Паул олон нийтийн удирдагч нарын тухай өгүүлжээ. Энэ нь ажил олгогч, дарга, багш, дасгалжуулагч зэрэг хүмүүсийг багтаана. Өмнөх бүлэгт хэлсэнчлэн, “Ажилчдын ёсоор буулган дор байгаа бүгд өөрсдийн ажилч олгогч нарыг хүндэтгэбэл зохистой хэмээн үз” гэж хэлж болно. Эсвэл “Оюутны ёсоор буулган дор байгаа бүгд өөрсдийн багш нарыг хүндэтгэбэл зохистой хэмээн үз” гэж хэлж болно. Тамирчид, дасгалжуулагч зэрэг бусад бүх төрлийн нийтийн захирах - захирагдах харилцаанд хамаатай болно.

Паул Бурханы нэр бөгөөд сургаал (Сайн мэдээ) муу хэлэгдэхгүйн (гутаагдахгүйн) тулд нийтийн удирдагч нарыг хүндэтгээрэй гэсэн байгааг тэмдэглэнэ үү. Амплифайд Библи дээр “Бурханы нэр бөгөөд (Түүний тухай) сургаал *нэр хүндээ алдах* буюу *доромжлогдохгүйн тулд* гэдэг. *Нэр хүндээ алдахыг* “олон нийтэд дорд үзэгдэх” гэж тодорхойлсон бол, *доромжлох* гэдэг үгийг “Бурханы ариун нандин юмст хүндэтгэлгүй хандах” хэмээн тодорхойлдог.

Энэ хоёрыг хамтатгаж үзбэл, итгэгч хүмүүс ажил олгогч, багш зэрэг олон нийтийн удирдагч нараа хүндэтгэхгүй бол, нийгэм Бурханы

хаанчлалыг дорд үнэлж, Бурханд юмуу ариун юмст хүндэтгэлгүй хандах цэгт ч хүргэх боломжтой ажээ.

Олон нийт хэрхэн Бурханы юмст хүндэтгэлгүй ханддаг вэ? Сургуулиас залбирлыг хасч, Арван тушаалыг шүүхийн танхимаас хасч, цэнгээнт юмсын дийлэнх хувь нь нүгэлтэй - бас бурхангүй үзэлтэй, дуу хөгжмийн дийлэнх хувь нь Бурханыг эрээ цээргүй доромжилсон, боловсролын систем маань бүтээлд итгэдэг хүмүүсийг хавчиг ухаантай - тэр бүү хэл мэдлэгийн хөгжил цэцэглэлд заналхийлэгч хэмээн үздэг гэх мэт - ийм л янзтай болжээ. Итгэгч - бид олон нийтийн удидагч нарт хандах хүндэтгэлгүй байдлаараа нийгмийнхээ бурханлаг бус зан авирыг улам л сэвж байгаа бус уу? Дээрх Бичээс дээрх Паулын үгээс үзбэл, бид жинхэнэ хүндэтгэл дотор явахгүй бол, яг л ийм зүйл болох нь байна.

Сайн мэдээний эмгэнэлтэй дүрслэл

Би энэ тал дээр олон жишээ хэлж чадах ч, Паулын хэлсэн үгийг нүдэнд үзэгдтэл дүрслэх нэгэн жишээ хэдэн жилийн өмнө надад тохиолдсон юм. Би нэгэн томоохон хотоос нисэхээр онгоцондоо суув. Байнгын нислэгийн хуваариасаа болоод бизнес ангиллаар нисдэг болоод байлаа. Миний дэргэд сайхан хувцастай нэгэн бизнесмэн холимог ундаагаа шимэн сууна. Түүнтэй танилцаж, Сайн мэдээ хэлэхийг хорхойссондоо, шууд л яриа дэлгэлээ. Бид хоёрын яриа ч тос шиг л урсаж, бодол, мэдээлэл маань ар араасаа л ундрал. Товчхондоо яг л бууз, хуушуур хоёр оо.

Тэр гялалзсан эрхэм харваас л удирдагч хүн. Тиймээс би түүний ажлыг асуутал, тэрбээр хотынхоо дээрээсээ хоёр дахь том такси компаний эзэн болохоо яриу. Би ч яриагаа залан, компаниа хэрхэн удирддаг талаар нь яриулж чадлаа. Тэр эрхэм ажлынхаа талаар хэсэг ярьснаа, намайг юу хийдэг хүн болохыг асуулаа. Би ч “Би Бурханы Сайн мэдээний үйлчлэгч хүн” л гэлээ.

Тэр эрхмийн царай хувьс хийснээ, нэг юм бувтнаад, цаашаа харчихав. Би ч гайхлаа. Хачин нөхөрсөг байсан хүн гэнэт л надаас цэрвээд, зайгаа авчих юм. Гэхдээ энэ хүртэл сайхан ярилцсан учраас, би учрыг нь олж чадна гэдгээ мэдэж байлаа. Тиймээс би зөөлөн дуугаар “Хөөх, та чинь яав аа? Юу болоов?” гэж хэлэв.

Тэрбээр над руу хүрлэгээр царайгаар эргэж харснаа “Юу гээч,

та надад таалагдсан. Тиймээс Христийн үйлчлэгч нартай холбоо харилцаа тогтоох дургүй байдаг учраа хэлье л дээ” гэлээ.

Миний ч сонирхол хөдлөв.

Тэрбээр “Манайд хүн ажилтан байлаа. Нөгөө “дахин төрсөн” хүн. (Би ч юм хэлсэнгүй) Тэр хүүхэн хамаг ажлын цагаар ажилтнуудад “аврагдах” хэрэгтэй гэдгийг нь хэлж номлоно. Өөрөө үр бүтээлгүйгээс гадна ажилтнуудын маань ажлын үр бүтээлийг ч хумсална.

Тэгж тэгж ажлаас гарсан. Гэхдээ компаний эд юмсыг хулгайлаад, дээрээс нь намайг Германд байдаг хүүтэйгээ хийсэн холын дуудлагын төлбөр гэж найман мянган долларын өр төлбөрт оруулаад явсан. (Ерээд оны дундуур олон улсын дуудлага маш үнэтэй байсан юм)

Миний элэг эмтрэв. Тэр хүүхний авир үйлдлээс болж Бурханы Үг нэр хүндээ алдсан тул эдүгээ тэр компаний хүмүүс Бурханы Үгийг зүдэрч сонсоно. Тэр хүүхэн ажлаа хийх ёстой байтал, олон таван юм номлож бас хулгай хийснээрээ эзнээ ч, компаний ажилчдыг ч хүндэтгэсэнгүй. Уг нь хамгийн итгэмжтэй ажилчин нь байх ёстой байтал. Тиймээс л Паул ажилчдад:

Боолууд аливаа зүйлд эзэндээ захирагдан, таалалд нь нийцүүлж, зөрж эсэргүүцэлгүй, шамшигдуулалгүй, харин алив сайн итгэлийг харуул. Тэгвэл тэд бидний Аврагч Бурханы сургаалыг бүх талаар чимнэ (Тит 2:9-10) гэжээ.

Тэр хүүхэн номлосон зүйлээ өөрөө гутаажээ. (Хүний үйлдэл хүний үгээс хавь илүү чанга байдаг) Тэрбээр Сайн мэдээнээс дайжих нөхцлийг бий болгожээ. Уг нь Бурханы Үгийн хэлснийг хийгээд, ажил оллогчоо хүндэтгэсэн бол, бизнестээ тэс өөрөөр хандах байсан юм. Хүндэтгэх нь үнэлэх, захирагдах, дээдлэн нандигнах явдал. Тэр эмэгтэй хүндэтгэл бүхий зүрхтэй байсан бол, хандлага, зан авир нь тэс өөр байх байсан. Сайн ажиллаж, шударгаар гүйцэтгэсэн бол, Сайн мэдээг улам л урагшлуулах байжээ.

Ярианыхаа үлдсэн хагаст би тэр хүүхний өмнөөс уучлал гуйсаар л таарч билээ. Мөнөөх эрхэм сонсож хүлээж авсан ч, энэ маань түүнд нэг их тайтгарал авчирсангүй. Хохирол нь амархан эдгэшгүй, гүн байв. Үүнээс болж бидний цаашдын яриа хэзээ ч урьдынх шигээ байсангүй.

Хэдэн жилийн дараа би энэ түүхийг нэгэн чуулганд заасан юм. Манай нэг санхүүгийн түнш мөнөөх түүхийг CD дээрээс сонсоод, манай үйлчлэлтэй холбогдон, нэг хүсэлт тавив. Тэрбээр нөгөө хүний компаний мэдээлэл, хаягийг олж өгч болох уу гэсэн юм. Түүнд уучлал

гуйсан захидал бичээд, Бурханы хайрын гэрчлэл болгон найман мянган долларын чек илгээх хүсэл төржээ.

Би тэр хүний эвлэрлийн хүсэлтэд баярлан, өөрийн биеэр нөгөө компанитай холбоо барьлаа. Гэтэл эзэн нь зургаан сарын өмнө зүрхний шигдээсээр нас барчихсныг дуулаад, дотор пал хийгээд л явчихлаа. Тэгээд тэр хүн онгоцонд миний хэлсэн үгийг хүлээж авсан болов уу гэж горьдсон ч, үнэндээ түүний сүнс таг хаалттай байсан болохоор Сайн мэдээ хуваалцах зай завсар ч олдоогүй билээ. Хэн нэгэн үйлчлэгч түүнтэй учраад, Сайн мэдээ хүргэсэн байгаасай л гэж найдахаас өөр аргагүй. Тэгээд *тэр хүн Есүс Христээр дамжуулан Бурхантай энх тайван тогтоосон болов уу* хэмээн хэсэг гайхаж билээ. Тэр ажилчин эмэгтэйн хийсэн хэргийн уршгаар гагцхүү гайхамшиг л энэ бүхнийг боломжтой болгох байв.

Тэр эрхэм өөрийг нь бөгөөд компанийг нь хүндэтгэдэг ажилчинтай байсан бол, онгоцонд түүнд Сайн мэдээ ямар амархан ярих байсан бол. Үнэндээ, тэрбээр хүлээж авах байсан байх. Яагаад? Тэрбээр “Жон, би таны үгийг ойлгож байна. Миний хамгийн мундаг ажилчид дандаа Есүст итгэдэг хүмүүс. Миний амьдрал аймшигтай байна. Би Есүсээс мөнхийн амьдрал хүсч байна. Тийм ээ, би тантай хамт залбирмаар байна” гэж хэлэх байсан.

Нөгөөтэйгүүр, номлодог үгээрээ бус, харин хүнд хэцүү үед харуулдаг Христийн зан чанараараа бас ёс зүйтэй ажил үйлсээрээ жинхэнэ Христэд итгэх итгэлийг гэрчилдэг ажилтнуудынх нь талаар үл итгэгч эздээс бас сонсдог. Эзэд нь “Тэд бусдаас илүү ажилладаг” эсвэл “Тэд манай хамгийн шударга, найдвартай ажилчид”, “Тэд хэзээ ч маргадаггүй, урдаас цор цор хийдэггүй, гомдоллодоггүй” гэдэг.

Юу энэ хүмүүсийг дээрх эмэгтэйгээс өөрөөр ажиллах чадвартай болгов? Хариулт нь ердөө л Эзэнээс эмээхүй. Эзэнээс эмээхүй л зүрхэнд маань Бурханы халамжилдаг, хайрладаг хүмүүсийг гэх жинхэнэ хүндэтгэлийг төрүүлнэ.

Ангид

Би энэ олон жилийн хугацаанд итгэгч нар нийгэм дээр хүндэтгэл үзүүлснээрээ эсвэл эс үзүүлснээрээ Сайн мэдээний нэрийг өргөсөн юмуу баастсан мэдээ, түүх зөндөө сонссон. Энэ хоёр туйлын аль алийг сургуульд байхдаа харж байлаа.

Би Пердю их сургуулийн ахан дүүсийн холбоонд байхдаа Есүс

Христэд итгэсэн юм. Би чинь Католик гэр бүлд өссөн бөгөөд сүмдээ итгэмжтэй явдаг байсан ч, надад авралаар юу юунаас илүү дутаж байлаа. Ахан дүүсийн холбооны маань нэгэн залуу миний анхаарлыг хэрхэн татсаныг санаж байна. Эхлээд түүний хайрын атлаа хүчтэй зан чанар, үйл хэрэг нь намайг олзолсон. Тэрбээр маш өндөр сахилга баттай, мундаг тамирчин байлаа. Ахан дүүсийн холбооны үдэшлэгийг дөнгөж эхлүүлчихээд л явчихдаг бол, бидний хэдэн амьтад мал болтлоо согтоод, ухаан мэдрэлээ алдацгаана. Үдэшлэг дээр мань хүн зөвхөн ундаа уунгаа хөвгүүдтэй ч, охидтой ч яг л нэг янзаараа харилцана.

Тэрбээр намайг сүсэгтэй мөртлөө Бурханаас холуу байгааг хардаг байжээ. Тиймээс эхлээд надтай найзлав. Тэгээд хэсэг хугацааны дараа нэг орой тэрбээр манайд ирсэн юм. Тэрбээр надтай Бурханы Үгийг хуваалцаж байхдаа “Жон, чи надад Америкийн ерөнхийлөгчийн талаар ярьж чадах уу?” гэж асуув.

Би ч “Чадна. Жимми Картер. Гэргий нь Розалин. Тэрбээр өмнө нь Жоржиа мужийн захирагч байсан. Түүнээс өмнө газрын самар тариалдаг байсан” гэлээ.

Тэрбээр “Тийм ээ. Тэгвэл чи надад Есүсийн тухай ярьж өгөөч” гэв.

Би ч “За. Тэр онгон бүсгүйгээс төрсөн. Хойд эцэг нь Иосеф. Есүс арван хоёр дагалдагчтай байсан. Загалмай дээр алуулсан” л гэлээ.

Тэрбээр “Мундаг байна. Тэгвэл чи ээжийгээ мэддэг шигээ Жимми Картерыг мэдэх үү? гэв.

Би ч “Үгүй” л гэлээ.

Тэрбээр ялгааг нь асуув.

Би ч “Миний ээж чинь миний ээж. Би ээжийгээ хувьчлан мэднэ. Ерөнхийлөгчтэй бол хэзээ ч уулзаж байгаагүй шүү дээ” гэлээ.

Тэгтэл тэр “Тэгвэл чи ээжтэйгээ ойр дотно харилцаатай. Харин ерөнхийлөгчийнхөө тухай зөндөө мэддэг ч гэлээ хувийн харилцаа байхгүй нь” гэв.

Би ч “Тийм ээ” л гэлээ.

Гэтэл нөгөөх чинь “Тэгвэл чи ээжийгээ мэддэг шигээ Есүсийг мэдэх үү?” гэв.

Би зог тусав. Би юу хэлэхээ мэдэхгүй мэлийн суув. Тэгтэл нөгөөх чинь надад Бурхан биднийг чуулганд явдаг сүрэг болгохын төлөө Есүсийг явуулаагүй, харин бидэнд хайртайдаа бас үгүйдэгтээ бидэнтэй хувийн харилцаа тогтоох гэж явуулсан, Бурханы төлөвлөгөөг харууллаа. Би өөрийнхөө бүтээгдсэн зорилгыг олж мэдээд хачин их догдлов.

Дараагийн жил нь би өдөр шөнөгүй Библи үзэв. Тэгээд ч ханасангүй. Би Бурханы Үгийг мэдэхийг хүсч байлаа. Амьдралаа Есүст өгөхөөс өмнө Библи гэдэг миний хувьд баахан дүрэм, түүх л байв. Гэтэл одоо зүрхэнд минь амилсан учраас, надад хувьчлан хандсан Бурханы Үг болж хувирчээ.

Би инженерийн оюутан учраас, хэд хэдэн сонгонтой байв. Сонгоны жагсаалтад Пердю кампусын резидент профессорын заадаг Нотр дамын хэд хэдэн хичээл байв. Би ч Хуучин гэрээний тойм 101-ийг сонгохоор шийдэв. Шинэхэн итгэгч надад Хуучин гэрээний сургаал жаахан бэрх байсан болохоор, ерөнхий ойлголт авахад маань хэрэгтэй гэж үзсэн маань тэр.

Хичээл Нэг дэхь өдөр бүр гурван цагаар орно. Анхны хичээл дээр профессор бидний өмнө гарахдаа, намайг ёстой л алмайруулав. Багш маань Бичээс дээр зургаан зуугаас олон зөрчилтэй хэсэг байдаг бөгөөд Есүс Христийг үхлээс амилуулагдсан, Мосе Израилийн хүүхдүүдийг дагуулаад улаан тэнгисээр жагсаж гаталсан түүхийг Библиэс батлах боломжгүй гэж хэлсэн юм. Хүмүүс Библийн эдгээр түүхийг үе уламжлан ярихдаа, улам л хэтрүүлэгтэй, улам л давсалсаар байгаад нөгөө ус нь далай болчихсон учраас л Библийн эдгээр түүх нь ийм ер бусын уран байдаг гэнэ.

Тэр семестр надад хэр хүнд байсныг хэлэх илүүц байх. Би профессортайгаа ч, бусад оюутнуудтай ч олон удаа нүүр тулсан маргаан мэтгээн өрнүүлж билээ. Нэг хичээлийн цагаар профессор, бид хоёроос гурван цаг мэтгэлцэж байлаа. Би багштайгаа ярьж байхдаа, шийдэмгий байсан ч, түүний багшийнх нь байр суурийг хэзээд хүндэтгэсээр байсан билээ.

Улирлын эхэнд бидэнд маш том судалгааны ажил даалгасан бөгөөд семестрийн төгсгөлд хийж дуусгах ёстой байв. Эцсийн дүнгийн маань гурваны нэг нь үүнээс хамаарах байв. Би ч ажил дээрээ хичээнгүй ажиллаа. Сүүлчийн хичээл дээр бидэнд судалгааны ажлыг маань тарааж өгөв. Би өөрийнхөө ажлыг хүлээж автал, дүн тавилгүй томоо гэгчийн “Г” үсэг тавьсан байлаа. Миний гайхсан гэж. Би хичээлийн дараа багш дээрээ хүрч очтол багш “Жон, чи манай ажлын өрөөнд ирээрэй. Чамд тавьсан дүнгийн талаар ярих хэрэгтэй байна” гэж хэлэв.

Хэдэн өдрийн дараа би багшийнхаа өрөөнд явж очтол, тэрбээр “Жон, чи бид хоёр 2 өөр ертөнцөд амьдарч байна. Тиймээс би чиний судалгааны ажлыг дүгнэж чадахгүй байна. Тиймээс л “Г” гэдэг үсэг бичлээ. Үндсэндээ чиний төгсгөлтийн дүнд тооцогдохгүй л гэсэн

үг. Тэгэхээр, би чиний эцсийн хоёр шалгалтын дүнгийн дунджаар семестрийн эцсийн дүнг чинь гаргахаар болж байна” гэж хэлэв.

Тэгээд дараа нь “Жон, манай ангид хэд хэдэн “фундаменталист” байсан. Ёстой л шүдний өвчин. Тэд бараг бүгдээрээ гурван юм хийсэн: хичээл үймүүлнэ, хичээлийн дундаас хаяна эсвэл зарим нь бүр итгэлээсээ няцсан” гэж хэлснээ, зөөлрөөд:

“Жон, гэтэл чи өөр байлаа. Чи итгэлээсээ өчүүхэн ч няцсангүй. Чи итгэл дээрээ бат зогслоо ч, намайг хүндэтгэж харилцсан. Бас ангийнхаа нөхдийн ч хүндэтгэлийг олсон. Чиний зориг, хүндэтгэлийг үзээд хязгааргүй талархаж байна чамд” гэсэн юм.

Энэ ярианаас Бурхан надад нэг зүйл харуулсан юм. Бурханы Үгийн илчлэл дээр бат зогсохдоо, удирдагч нараа хүндэтгэсэн арга замаар хийх юм бол, Бурханы үнэний төлөө нүүдэл хийдэг. Багшийн ангид байсан нөгөө “фундаменталистууд” нь дахин төрсөн итгэгчид л байсан байх. Гэвчиг анги дээрээ багшдаа болоод бусад оюутнуудад Есүс Христийг ойлгуулах гэсэн тэдний оролдлого нь эсрэгээрээ эргэжээ. Тэд байнгын хүндэтгэлгүй авир үйлдлээрээ багшийнхаа болоод ангийнхаа нүдэнд Сайн мэдээг гутааж, эцэстээ багшийн хичээлийг үймээн самуун болгож орхижээ. Хүндэтгэлийн зарчим дотор алхаагүй учраас, бид том том боломжоо алддаг.

Бид Бурханы Үгийн үнэнээс хэзээ ч ухрах ёсгүй. Харин ч бат зогсох ёстой. Тийм боловч, эсэргүүцлийг номхон, зөөлөн сүнсээр засах ёстой юм. Дарга, дасгалжуулагч, багш нарынхаа өмнө Христийн үлгэр дууриалаар амьдар. Боломж гарах аваас, амаа нээгээд, удирдагч нараа хүндэтгэж, хайрласан сэтгэлээр үнэнийг ярих хэрэгтэй юм.

Олон нийтийн эрх мэдлийг хүндэтгэх

Нийтийн удирдагч нарыг хэрхэн хүндэтгэх вэ? Хүндэтгэл гэж юу болохыг дахиад харцгаая. Үнэлэх, үнэ цэнэтэй, жинтэй хэмээн хандах, өөрөөр хандах, захирагдах, Бичээстэй зөрчилдөхгүй байгаа нөхцөлд дуулгавартай дагах.

Энэ тодорхойлолтыг эргэцүүлээд, залбирал болгох юм бол, зан үйлдэл маань бидний ажлын газар, анги танхим, тэмцээний талбай дээр эерэг нөлөө авчирна. Бурханаас зүрхийг маань нийтийн удирдагч нараа хүндэтгэх хүндэтгэлээр дүүргэхийг гуйбал, тийм л үйлдэлтэй болно. Эрхийнхээ төлөө тэмцэхийн оронд, өөрийнхөө бус, тэдний

хүслийг нэгдүгээрт тавьдаг болно. Өөрөө алдаршина уу, байна уу, шударга цалин хөлс авна уу, байна уу - хамаагүй, бид удирдагч нарынхаа л амжилтын төлөө зүтгэдэг болно. Үүнийг хэрхэн хийх билээ? Бичээс айлдруун:

Боолууд аа (ажилчид аа), Христэд ханддаг шигээ та нар махбодын дагуух эздэдээ (ажил олгогч нартаа) ч эмээхүй ба чичрэлээр, чин сэтгэлээсээ дуулгавартай бай. Хүнд нийцүүлэгчид шиг нүдэн дээр үйлчлэлгүй, харин та нар Христийн боолууд ёсоор Бурханы хүслийг зүрх сэтгэлээсээ үйлд. Хүмүүст бус харин Эзэнд хэмээн сайн хүслээр үйлчил. Боол эсвэл чөлөөт байх нь ялгаагүй алив хүн сайн зүйл хийвэл тэрээр Эзэнээс түүнийгээ буцааж авна гэдгээ мэд (Ефес 6:5-8, тодруулгыг нэмэв).

“Хүмүүст бус, харин Эзэнд хэмээн сайн хүслээр үйлчил” гэсэн үгийг тэмдэглэнэ үү. Бид ийм зүрхтэй байвал, боол биш, харин үйлчлэгч болно. Та “би боол биш” гэж хэлэх байх. Ингэж хэлэхээс чинь өмнө би танд боол, үйлчлэгч хоёрын ялгааг хэлж өгье. Боол шаардлагыг л биелүүлдэг бол, үйлчлэгч хүчин чадлаараа зүтгэдэг. Боолоос авах ёстой бол, үйлчлэгч хүн өөрөө өгдөг. Боол ёстой, үйлчлэгч хүсэлтэй. Үйлчлэгч хүн тушаал хүлээхийн оронд өөрөө боломжийг хайдаг. Тэрбээр үйлчилгээ үзүүлж байгаа нэгнийхээ хэрэгцээг олж хараад, гуйлгуулалгүйгээр өөрөө хийгээд өгдөг.

Дарга чинь шударга бус хандаж, танд хатуурхаж байна гэж үзэж байгаа бол, хариу урвал үзүүлээд байх биш, харин үйлдэх хэрэгтэй. Хариу урвал үзүүлдэг хүмүүс өөрийгөө хохирогч хэмээн гомдоллож, унжгинаж, үр бүтээлгүй байдаг бол, үйлдэгч нь мууг сайнаар дийлдэг (Ром 12:21). Тэрбээр хатуу дарга дээрээ явж очоод, ингэж хэлнэ: “Эрхэм ээ, хийх ёстой нэмэлт ажил байгаа. Тиймээс би дараагийн долоо хоногийн турш ажил дээрээ хоёр цагийн өмнө ирээд, хийгээд дуусгачихъя. Илүү цагийн мөнгө авахгүй.”

Асуудлыг ийм маягаар шийдбэл, та Бурханы ч тааллыг олно, эцэстээ хүний ч тааллыг олно. Яаж мэдэж байгаа юм гэж үү? Сургаалт үгс 3:3-4 бидэнд хэрэв бид өршөөл, үнэнийг зүрхнийхээ самбар дээр бичбэл, “Бурханы болоод хүмүүсийн нүднээ Таалал хийгээд сайн нэрийг чи олно” гэдэг.

Харин мянга хүндэтгэлээ ч, даргадаа таалагдахгүй бол, Бурхан

таныг цэцэглүүлэх өөр газрын үүдийг нээж өгнө. Яг л өмнөх бүлэгт өгүүлсэн, даатгалын менежер шиг. Тэрбээр өөрийг нь доромжилсон даргаа хүндэтгэсэн. Эцэст нь Бурхан түүнийг илүү том компанид оруулж, эдүгээ тэрбээр хамгийн том менежерүүдийн эгнээд элсэн, бүрэн шагналаа авчээ.

Энэ бол хууль. Та амьдралдаа буй нийтийн удирдагч нарыг хүндэтгэбэл, Бурхан таныг хүндэтгэж, эцэстээ та бүрэн шагналаа хүлээн авна. Танай дарга, багш, дасгалжуулагч шагнахгүй байж болох ч, шагнал ирэхдээ л ирнэ. Бурхан Үгээ биелүүлэхдээ л биелүүлнэ.

Нутгийн удирдагч нараа хүндэтгэх

Бүгдээрээ хараагаа гэр бүл дээр хандуулъя. Хүүхдүүдээс эхэлж ярья л даа. Бичээс “Эцэг эхээ хүндэл. Энэ бол амлалт бүхий эхний тушаал агаад Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно” (Ефес 6:2-3) гэдэг.

Аав, ээжээ хүндэтгэх нь санал бус, зөвлөмж бус, харин тушаал болой. Шинэ гэрээний итгэгч бид Бурханы тушаалыг сахих ёстойгоо мартаагүй биз? Энэ нь бидний дотор орших Бурханы хайрын жинхэнэ гэрчлэл болой. Есүс “Миний тушаалуудыг хүлээн авч сахигч нь Намайг хайрлагч мөн” (Иохан 14:21) хэмээсэн. Элч Иохан ч үүнийг бичээсээрээ баталсан “Бид Түүний тушаалын дагуу явах нь хайр юм. Та нар эхнээсээ сонссончлон хайр дотор явах нь тушаал юм” (2Иохан 6).

Нэгэнт Есүс Христ Эзэнд итгэсэн л бол, бид өөрчлөгдсөн гэсэн үг. Өмнө байсан хүн эдүгээ амьдрахаа больсон. Бид яг үгчлэн шинэ бүтээл болсон. Зүрхэнд маань Эзэний эмээхүй, хайр нутаглан, шинэ болсон. Эдүгээ хүслүүд маань Бурхан руу тэмүүлэн, өөрийнхөө мөн чанарт бус, харин Бурханд л таалагдахыг хүснэ. Бид цаашид “Харин Бурханы тушаалуудыг сахих нь чухал” (1Коринт 7:19) гэсэн арга замаар л амьдарна.

Тонгоруулбал, Бурханы тушаалыг байнга үл тоодог хүмүүс нь Ариун Сүнсээр дамжуулан Бурхантай жинхэнээсээ уулзаагүй хүмүүс юм. Тэд өөрийгөө Христэд итгэдэг гэж хэлж болох ч, жинхэнэ мөн чанар нь амьдралаас нь харагдахыг Есүс бидэнд зааж өгсөн (Матай 7:20). Тэр хүмүүс Бурханы тушаалыг үл хүндэтгэх юмуу хөнгөн

хийсвэр авч үзээд байвал, тэд нөхдөд Бурханы зүрх алга гэсэн үг. Иохан “Түүнийг (Есүс Христийг) би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч (мэхлэгдсэн) бөгөөд түүнд үнэн алга” (1Иохан 2:4, тодруулгыг нэмэв) гэж бичсэн. Тэр хүн Бурханы хүүхэд биш, харин мэхлэгдсэн болохыг Иохан тодорхой хэлж байна. Тэрбээр өөрийгөө аврагдсан гэж бодож болох ч, хэрэг дээрээ аврагдаагүй ажээ.

Бүгдээрээ дахиад хүндэтгэлийн утгыг давтъя: үнэлэх, цэнэлэх, хүндэтгэх, таатай хандах, өндрөөр үзэх. Аав, ээжээ хүндэтгэлийн нүдээр харбал, тэдэнтэй хүндэтгэл, хайраар харилцана. Хүндэтгэлийг үйлс, үг, тэр бүү хэл бодлоор харуулж болох ч, бүх жинхэнэ хүндэтгэл нь зүрхнээс л эхтэй юм. Тиймээс залуус аав, ээжтэйгээ байнга хөнгөн, хайхрамжгүй юмуу хүндэтгэлгүй байдлаар харилцдаг бол, аав, ээжээ жинхэнээсээ хүндэтгэдэггүйгээ л гаднаа харуулж байгаа ажээ. Зүрхний бялхлаар ам ярьдаг гэдэг шүү дээ (Матай 12:34). Тэдний хүндэтгэлгүй байдал нь мөн дууны өнгө, нүдээ эргэлдүүлэх, муухай харах, хүсэлтийг нь дуртай дургүй хийхжаан болох, гомдол гаргах гэх мэт үйлдлээр нь илэрнэ.

Аав, ээжээ хүндэтгэхгүй байх нь өнөөдөр Америкт байдаг л зүйл болсон. Соёлтой маань хутгалдсан. Би л хувьдаа хүүхдүүддээ үзүүлэхийг хэзээ ч зөвшөөрөхгүй, хүмүүсийн дунд тун алдартай “гэр бүлийн кино” хэд хэд бий. Зарим нь бүр хүүхэд үзэхийг зөвшөөрдөг бөгөөд “баталгаатай кино компаниудын” бүтээл байдаг. Тэдгээрийг хүмүүс аюулгүй л гэж үзнэ. Кино зохиол нь ч хүний зүрхийг хөндөхөөр. Гэвчиг тэнд хүүхдүүд нь аав, ээжтэйгээ харилцаж, ярилцаж байгаа нь - ээ, бүү үзэгд л гэмээр. Тэд аав, ээжтэйгээ яг л нэг мангар мал шиг харилцана. Аав, ээжийнхээ зааврыг эрээ цээргүй үл тоох бөгөөд кино нь аав, ээждээ дээрэнгүй тэр хүүхдүүдийг баатар болгох юмуу зүрхнийхээ хүсэлд хүрч байгаагаар төгсөнө. Та намайг хэтрүүлж байна гэж бодож байж болох ч, Бурханы үгийг үз: “Эцэг эхээ хүндэлдэггүй хүн нь хараагдсан!” гэхэд бүх ард түмэн “Амен!” гэнэ (Дэд хууль 27:16).

Пөөх, *хараагдсан* гэж ямар хүчтэй үг болохыг мэдэх үү? Бурханаар хараагдах нь ноцтой асуудал. Бид “алуурчин, хулгайч, гаж завхай, илбэ жатга үйлчдэгч хараагдсан” гэдэг үгийг л хүлээн зөвшөөрөх байх. Гэтэл Бурхан аав, ээжээ үл хүндэтгэгч нь хараагдсан гэж байна. Тэгвэл үл хүндэтгэх гэдэг үгийг дахин давтъя: байдаг л, жирийн юмуу дорд мэт хандах. Арай хатуухан хэлбэл, ичээж, гутааж хандах гэх байх.

Удам дамжсан хараал

Аав, ээжээ үл хүндэтгэснээрээ амьдрал дээрээ хараал авчирсан жишээ Бичээс дээр хэд хэд бий. Үүний нэг тодорхой жишээ нь Ноагийн хүү Хам болно.

Үерийн дараа Ноа газар тариалангийн ажил эрхлэх болжээ. Нэг үдэш шал согтоод унаад өгч. Яагаад тэр вэ? Магадгүй, газар дээрх сүүлчийн аав хүн болж үлдсэндээ гуньж гутарсан ч юм уу эсвэл үерийн дараа амьдралаа босгон байгуулах хүнд хүчир хөдөлмөрөөс амсхийх гэсэндээ ч юм уу. Ямартаа ч дарамтаас л чөлөөлөгдөхийг хүссэн ч, буруу аргаар үйлджээ. Тэгээд согтоод, майхан дотроо явж ороод, хамаг хувцсаа тайчаад, тасраад өгч.

Хам аавынхаа хэвтэж байгаа майханд явж ороод, нүцгэн биеийг нь харж байснаа, уулга алдаад, гараад бүх хүнд хэлчихжээ. (Бүх хүнд ч юу байхав, тэр үед Шем, Иафет хоёроос өөр эр хүн байх биш) Түүнийг хи-хи-хи гэснээ доогтой дуугаар “Манайхаан, та нар ёстой итгэхгүй дээ. Цаана чинь аав мал болоод, чармай нүцгэн хэвтэж байна. Очоод үз” гэж хэлэхийг нь төсөөлж байна.

Шем, Иафет хоёр Хамын доогтой мэдээг сонссон ч, тэс өөрөөр хариу үйлдсэн. Тэд хучилга аваад, майхан руу ухарч ороод, буруу харж байгаад аавыгаа хучжээ. Тэд аавынхаа ичгүүрийг үзэхийг хүсээгүй.

Маргааш нь Ноа сэрээд, Хамын үйлдлийг мэджээ. Тэгээд:

Канаан хараал идэж, ах нарынхаа боолын боол болог! гэжээ.
Бас тэрээр Шемийн Бурхан ЭЗЭНийг би магтъя. Канаан
Шемийн боол болох болтугай! Бурхан Иафетыг үлэмж өсгөж,
Иафетыг Шемийн майханд амьдруулж, Канаан түүний боол
болох болтугай! гэжээ (Эхлэл 9:25-27).

Ноагийн амнаас гарсан энэ зөгнөл үг нь хэдэн үеийн турш ажилласан юм. Хамын удам болох Канаанчууд эцэстээ хараагдаж, Бурханы тушаалаар Израилийн хүүхдүүдэд эзлэгдсэн.

Хам аавыгаа үл хүндэтгэснээрээ өөр дээрээ бөгөөд үр удам дээрээ хараал авчирчээ. Ноагийн согтуурал ямар нэгэн үр дагавар авчирсан талаар Бичээс дээр байхгүй боловч, Хамын авир үйлдэл өөр дээр нь хатуу үр дагавар авчирсан нь сонирхолтой. Үнэндээ Еврей 11 дээрх аугаа итгэлийн магтаал дунд тийм ээ, нөгөө унатлаа согтсон эр - Ноа маань явж байдаг. Ноа нүглээ гэмшиж, уучлагдсан нь тодорхой байна.

Тийм боловч Еврей 11 дээрээс та Хамын тухай уншихгүй - үнэндээ Библи түүний талаар дахиж эерэг өнгөөр дурьддаггүй.

Ноагийн ёс суртахууны зөрчил нь гурван хүүгийн хувьд хүндэтгэлийн хамгийн том шалгалт байжээ. Энэ явдал тэдний зүрхийг илчилсэн. Нэг нь хүндэтгэлээр дутуу бөгөөд тэрслүү байсан бол, нөгөө хоёр нь хүндэтгэлтэй бөгөөд хариуцлага хүлээхгүй зүйлээсээ биеэ татжээ. Ноагийн зан авир бурханлаг байгаагүй хэдий ч, үүнийг хөвгүүд нь бус, Бурхан Өөрөө шийдвэрлэх байв. Үүнийг хоёр хүү нь ойлгоод, аавыгаа зүрхнээсээ хүндэтгэсээр байсан бол, нэг хүү нь өөрийн биеэр аавыгаа шүүгээд, хүндэтгэлгүй үйлдэлд унаад, эцэстээ харагдаж дууссан.

Тэмдэглүүштэй бас нэгэн сонирхолтой зүйл нь Хам үнэндээ яг л үнэнийг хэлсэн байдаг. Аав нь нээрээ л шал согтоод, чармай шалдан хэвтэж байсан. Гэхдээ Хам зарчим дээрээ алджээ. Учир зүйн ухаан түүний үйлдлийг зөвтгөнө л дөө. Тэр харсан зүйлээ л хэлсэн, “үнэнээрээ” л байсан. Гэвчиг хүндэтгэлийн зарчим, хаанчлалын эрх мэдэл өөрийг хэлдэг.

Хүндэтгэлгүй байдал цаг хугацааны аясаар даамжирдаг

Бичээс дээр аавдаа хүндэтгэлгүй хандсан өөр нэгэн хүн нь Рубен билээ. Тэрбээр Иаков, Леа хоёрын ууган хөвүүн. Рубен аавыгаа хэрхэн үл хүндэтгэсэн билээ? Аавынхаа шивэгчин Билхатай унтсан.

Тийм боловч, Рубений үйлдэл нь аавдаа хамаатай хүнтэй бэлгийн харилцаанд орохоос арай том асуудал байв. Иаков Леа, Рахел гэдэг албан ёсны хоёр эгч дүүс - эхнэртэй байв. Билхах нь Рахелын шивэгчин. Рахел, Леа хоёр нь насан туршийн өрсөлдөгчид. Иаков Рахелыг таалдаг байсан болохоор, энэ өрсөлдөөн ч улам л даамжран, улам л хүчижсээр. Иаков Рахелд гэрлэхээсээ өмнө дурласан бөгөөд насан турш хайрласан.

Бурхан нөхөртөө гологдсон Леаг үзээд, умайг нь нээгээд, Леа Рубенийг төрүүлсэн. Леа Рубенийг төрөхөд нь “ЭЗЭН, миний зовлон зүдүүрийг харсан учир одоо миний нөхөр намайг хайрлах болно” (Эхлэл 29:32) гэж хэлсэн байдаг.

Хэсэг хугацааны дараа Леа хоёрдугаар хөвүүнээ төрүүлсэн. Түүнийг төрөхөд нь Леа “Хайр хүртээгүйг минь ЭЗЭН сонсоод надад

энэ хүүг бас өглөө гээд түүнийгээ Симеон (*“сонсов” гэх утгатай нэр*) гэж нэрлэжээ” (Эхлэл 29:33, тодруулгыг нэмэв).

Леа гурав дахь хүүгээ төрүүлжээ. Түүний цөхрөлийг хэлсэн үгээс нь үзэж болно: “Би түүнд гурван хүү төрүүлж өгсөн учир миний нөхөр одоо надтай холбогдох болно гээд түүнийгээ Леви (*“татагдав” гэх утгатай нэр*) гэжээ (Эхлэл 29:34, тодруулгыг нэмэв).

Рахел эгчийнхээ үржлийг, өөрийнхөө үр тогтохгүй байгааг үзээд, Леагийн түрэмгийлэн эзэлж байгаа газар нутгийг булаах төлөвлөгөө боловсруулна. Рахел Иаковт шивэгчнээ өгөөд “Энд миний шивэгчин Билха байна. Түүн дээр ор! Тэр миний өвдөг дээр төрж, түүгээр би хүүхэдтэй болно” (Эхлэл 30:3) гэдэг. Хүү төрөхөд нь Рахел “Би эгчтэйгээ ширүүн өрсөлдөж дийллээ гээд түүнд Нафтали гэдэг нэр өгчээ” (Эхлэл 30:8).

Ууган Рубен ээж, эгч хоёрынхоо ширүүн тэмцлийг үзэж өсчээ. Тэрбээр аавынх нь хайрыг хүртээгүй ээжийнхээ сэтгэлийн зовлонг ойлгохтойгоо том болсон байлаа. Нэг удаа Рубен хээр явж байгаад хүндэс олоод ээждээ авчирч өгчээ. Рахел хүүгээсээ хүндэс цэцэг хүлээн авч байгаа Леад атаархан, наймаа эхлэв. Рахел Леад Иаковтай ганц шөнө унтахыг зөвшөөрчээ.

Тэр шөнө Иаков талбайгаас ирэх үед Леа тосоод “Хүүгийнхээ хүндсээр би таныг зольж авсан учир өнөө шөнө над дээр орох ёстой гэв” (16). Энэ явдлаас Иаков шөнөөр гол төлөв Рахелтай унтдаг байсан бөгөөд Леа нөхрөө бараг төлбөр төлж авдаг байсан нь харагдаж байна.

Гэр бүл доторх энэ хатуу хахир нөхцөл байдлыг Рубен хүү ажиглаж өсчээ. Ээжид нь хандах аавынх нь таагүй, ширүүн авир байдлыг жигшин зэвүүцэх сэтгэл хүүгийн сэтгэлд өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байсан л байх.

Энэ бүхэн ор хөнжлийн явдлаар хязгаарлагдалгүй, олон талбар дээр илрэх болов. Цаг хугацаа өнгөрсөөр, Иаков арван хүүтэй болж, эцэстээ Рахел ч Иосеф гэдэг хүү төрүүлсэн. Гэтэл аав нь Рахелын хүү Иосефт амиа тавьж байгааг үзээд Рубены зэвүүцэл улам л үржив. Аав нь Иосефыг хамгаас хайрлаж, арван ахынх нь дээр гаргаж, үүнийгээ ч нуулгүй, хачин сайхан дээл бэлэглэжээ.

Тэдний гэр бүлийг Леа, Рахел хоёрын аав - Лабанаас зугтах үед энэ тухай Есав дуулаад, дөрвөн зуун эрчүүдтэйгээ тэдний өөдөөс угтаж очдог. Иаков айсан. Яагаад гэвэл ууган хүүгийн эрхийг нь хулгайсных нь төлөө ах нь түүнийг ална гэж тангарагласныг Иаков мартаагүй.

Тэгээд Иаков амиа ч, эд хөрөнгөө ч аврахын тулд гэр бүлээ хуваагаад,

хэсэг хэсгээр нь Есавын өөдөөс явуулсан. Тэрбээр Есав эхний бүлгийг алсан ч, тэрбээр өөрийнхөө болоод хамгийн дотно хүмүүсийнхээ амийг аврах цаг хожно гэж боджээ. Иаковын гэр бүлээ хуваасан аргыг нь үзэх үү: “...шивэгчингүүд болон тэдний хүүхдүүдийг өмнө нь, Леаг хүүхдүүдтэй нь хамт дараа нь, Рахел Иосеф хоёрыг хойно нь оруулав” (Эхлэл 33:2) Рубены уур, шархыг төсөөлж байна уу? Аав нь тэднийг ээжтэй нь бамбай болгож үхэл рүү илгээгээд, хайртай Рахел, хүүгээ өөртэйгээ хамт хамгийн сүүлийн эгнээнд үлдээсэн.

Цаг хугацаа өнгөрсөөр, зэвүүцэл ч өссөөр. Рахел хоёр дахь хүүгээ төрүүлэхдээ нас барсан. Иаков аймшигтай гашуудаж, эхнэрийнхээ булшин дээр үеийн үед орших багана босгов. Гэтэл та бид Леагийн баганы талаар юу ч сонсохгүй, зөвхөн Рахелын баганы талаар сонсдог нь сонирхолтой. Тэгэхээр, тэр булшны багана нь аварга бөгөөд сүр жавхлантай байсан нь тодорхой байна. Рубен ч үүнд хорсоо л байх.

Библи Рахелыг үхээд, төд удалгүй “Рубен Билхатай унтсан” (35:22) гэдэг. Рубен гэр бүлийнхээ ана мана, ач тач үзэлцээний зовлон дунд өссөн. Аав нь ээжийг нь бус, Рахелыг хайрлаж буйг тэрбээр үзэн ядсан л байгаа. Рубен Билхатай унтах гэж бус, харин Рахелын майханд ичгүүр авчирч, учруулсан шарх, зовлонгийнх нь төлөө ааваасаа өшөө авах гэсэн байх.

Тэдний ахан, дүүсийг нас барснаас хаа хойно Бурхан Рубений талаар юу хэлснийг үзнэ үү: “Израилийн ууган хүү Реубений хөвгүүдийг тоочвол, (Реубен ууган хүү байсан боловч тэр эцгийнхээ орыг *бузарласан (үл хүндэтгэсэн)* тул түүний ууган хүүгийн эрх нь Израилийн хүү Иосефын хөвгүүдэд өгөгдсөн юм. Иймээс тэр удмын бичигт ууган гэж бичигдсэнгүй” (1Шастир 5:1, тодруулгыг нэмэв).

Гэхдээ Рахелыг л хайрлаад, Леаг үл тоосон Иаковын үйлдэл буруу байсныг тэмдэглэх нь хамгийн сонирхолтой. Үнэндээ “Леа хайр хүртээгүйг ЭЗЭН үзээд Леагийн умайг нээв” (Эхлэл 29:31) гэдэг учраас, Бурхан ч энэ явдлыг үзээд таалаагүй байна. Амплифайд Библийн Сонгодог хэвлэл дээр “Эзэн гологдсон Леаг үзээд...” гэдэг. Нөхрийнх бий болгосон зовлонгийн талбар дээр нь Бурхан Леаг ерөөжээ.

Рубен зөв л харсан. Тэрбээр аавынхаа талаар зохиогоогүй. Тийм боловч, тэрбээр зүрхэндээ хорыг тордсон. Рубен хүүхэд бүрийн зүрхэнд Бурханы суулгадаг хүндэтгэлийг тавьж явуулаад, үл хүндэтгэлийг борддог үзэн ядалтын хандлагыг хүлээн авсан. Тэгээд аавыгаа үл хүндэтгэх зан авираа зөвтгөх хэмжээнд тултал нь ургахыг зөвшөөрчээ. Эцэст нь өндөр үнэ төлсөн. Ууган хүүгийн эрхээ алджээ.

Өмнөх бүлэгт тахилч Елид доромжлуулсан Ханнаг санацгаая. Ханна Елигийн хүндэтгэлгүй зан авираас болж, эрх мэдлийг хүндэтгээрэй гэсэн Бурханы тушаалыг огоороогүй. Тэгээд бүрэн шагналаа хүлээн авсан. Гэтэл Рубен шагналаа - өвлөх өвөө алджээ. Тэрбээр даалгавартаа 100 хувь зөв байсан ч, 100 хувь буруу хариу үйлдэл хийжээ.

Хүний буруу үйлдлийн нөлөөнд бүү ор

Бид бусдын буруу үйлдлийн нөлөөнд автаад, зөв хэмээн мэддэг зан үйлдлээ өөрчилж болохгүйг би өнгөрсөн он жилүүдэд маш тодорхой ойлгож авсан билээ. Үүнийг Мосегийн амьдралаас тодорхой харж болно.

Израилийн хүүхдүүд Иаков шиг л байнга Бурханд тааламжгүй зүйл хийдэг байв. Иаков эхнэрээ голсон бол, Израильчууд зогсоо зайгүй гомдоллосон. Тэдний буруу авир үйлдлээс болж Мосе ч Рубен шиг л зүдэрчээ. Тэдний үйлдлээс болж Мосе Амлагдсан газартаа орж чадалгүй, дөчийн дөчин жил цөлд тэнүүчилсэн юм.

Одоо Израильчууд усгүй болчихлоо гэж гомдоллосон. Тиймээс Бурхан Мосед хаданд хандан үг хэлбэл, тэндээс ус гарна гэжээ. Тэр үед Израильчуудын ааш авираас залхсан Мосе тэднийг цуглуулж байгаад “Сонсогтун, тэрслэгчид ээ. Бид энэ хаднаас та нарт ус гаргах ёстой юу?” (Тооллого 20:10-11) хэмээн бархираад, таягаараа хадыг хоёр удаа цохижээ.

Мосе энэ үйлдлээсээ болоод хүмүүсээ Амлагдсан газар руу дагуулж орох завшаанаа алдсан. Олон жилийн дараа магтаалч юу гэж бичсэнийг үзнэ үү: “Тэд бас Мерибагийн их усны дэргэд хилэгнэхэд хүргэсэн Түүний хилэнг өдөөсөн бөгөөд тэднээс болж Мосе хэцүүдсэн. Тэд Сүнснийх нь эсрэг тэрсэлсэн учраас Тэрээр гоомой үгс хэлсэн юм” (Дуулал 106:32-33).

Израильчуудын муу үйлдэл Мосед нөлөөлжээ. Тиймээс Мосе Бурханы Үийг зөрчив. Тэгээд өндөр төлөөс төлсөн! Би Библи дээр тус эшлэлийн дэргэд “Өөрийнхөө бурууг бусдын буруу үйлдэл рүү бүү чих” гэж бичсэн байдаг. Энэ бол хүн бүрийн сурах ёстой сургамж.

Аав нь ижийд нь хүндэтгэлгүй хандсан хэдий ч, энэ нь Рубенийн хүндэтгэлгүй хандлагыг болоод аавдаа гаргасан зан үйлдлийг зөвтгөхгүй. Аав, ээж маань бидний нүдэнд зөв, буруу харагдаж байна

уу үгүй юу, зан авир нь хүндэтгэлтэй байна уу, үгүй юу хамаагүй - Бурхан бидэнд аав, ээжээ хүндэтгээрэй л гэсэн.

Энэ дашрамд би та нарт өмнөх бүлгээрээ заасан амин чухал зарчмыг дахин сануулмаар байна. Бид эрх мэдлийг ямагт хүндэтгэж, захирагдаж бас дагах ёстой ч, дуулгавартай байдлын тал дээр - эрх мэдэлтнүүд бидэнд Бурханы Үгтэй зөрчилдсөн юм хийхийг хэлсэн тохиолдолд - бид тэднийг дагах ёсгүй. Тухайлбал, аав, ээж нь хүүхдээсээ багшдаа худлаа ярихыг хэлбэл, хүүхэд нь аав, ээждээ хүндэтгэлтэйгээр “Аав аа, ээж ээ, би таныг хүндэтгэдэг. Гэхдээ би худлаа хэлж чадахгүй. Энэ чинь Бурханы эсрэг нүгэл” гэж хэлж болно. Эсвэл бүр ноцтой тохиолдол ч байна. Хэрэв аав нь хүүхдээ хүчиндбэл, хүү охин нь бусад эрх мэдлээс тусламж эрэх ёстой. Тэд аавдаа ч, өөртөө ч хэрэгтэй тусламжийг эрэлхийлснээрээ, аавыгаа үл хүндэтгэсэн хэрэг болохгүй.

Давхар хүндэтгэл

Бүгдээрээ хамгийн эхэнд үзсэн бичээсээ дахин гаргая: “Эцэг эхээ хүндэл.” Энэ бол амлалт бүхий эхний тушаал агаад “Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно” (Ефес 6:2-3).

Хүндэтгэлийн энэ давхар шагналыг дээрх эшлэлд тодорхой хэлжээ. Нэгдүгээрт - энэ нь чамд л сайн (тустай). Та амьдралдаа амар тайван, баяр хөөр, хайр дурлал, урт насыг үзэж болно. Таныг ямар нэгэн үхлийн өвчин, осол зэрэг гэнэтийн явдлаар цаг бусаар үхнэ гэсэн амлалт өгөөгүй.

Та “Гэхдээ аав, ээжээ хүндэтгэсэн ч, залуугаараа нас барсан хүмүүс байдаг” гэж бодож байгаа байх. Тийм ээ, үнэн. Тиймээс та одоо “Тэгээд энэ амлалт чинь яагаад тэдэн дээр биелээгүй юм?” гэж асуух байх. Товчхондоо, Бурханы амлалт нь автомат байдаггүй. Амлалт нь итгэлийг шаарддаг. Энэ үг таныг цочирдуулах байх. Гэхдээ энэ үнэнийг Бичээсээр үлгэрлэхийг минь болгооно уу.

Бурхан Абрахамд түүний хүү Исаакаар дамжин амлагдсан Үр төрнө гэдэг гэрээний амлалт өгчээ. Бурхан нарийндаа “Үгүй ээ, чиний эхнэр Сара чамд хүү төрүүлж өгнө. Чи түүнийг Исаак гэж нэрлэнэ. Би түүнтэй гэрээ байгуулж, түүний үр удамтай энэ гэрээгээ мөнхийн гэрээ болгон байгуулна” (Эхлэл 17:19) гэжээ. Үүнийг бас дахин ч бататгасан “Тэд Абрахамын үр ч гэлээ бүгд түүний хүүхдүүд гэсэн үг биш, харин Исаакаас гарсан нь л чиний үр удам гэж нэрлэгдэх болно”

(Ром 9:7). Энэ үг биелэхийн тулд Исаак заавал үр хүүхэдтэй болох ёстой байж, тийм үү?

Исаакийн гэргийг хэн сонголоо? Хариулт нь: Бурхан Өөрөө. Абрахамын зарц Исаакт гэргий олж өгөхөөр Абрахамын садан төрөл рүү явсныг санана уу. Зарц ирэхдээ, ингэж залбирсан:

Миний эзэн Абрахамын Бурхан ЭЗЭН! Та өнөөдөр намайг тэр бүсгүйтэй уулзуулж, миний эзэн Абрахамд хайр энэрэл үзүүлнэ үү? Хотын хүмүүсийн охид ус авахаар гарч ирэх цаг болжээ. Би худгийн дэргэд зогсож байя. “Чи ваараа тонгойлгож, уснаасаа надад уулгана уу?” гэж намайг асуухад “Уу, уу! Би бас таны тэмээг ч усалж өгье” гэж хариулагч эмэгтэй нь Таны зарц Исаакт Танаас *заяасан (тослогдсон)* хүн байг! Та миний эзэнд хайр энэрэл үзүүлснийг тань үүгээр би мэднэ гэв (Эхлэл 24:12-14, тодруулгыг нэмэв).

Үнэхээр ч, маш тодорхой залбирал бөгөөд тохиолдлын чанартай юм нэгээхэн ч алга. Тэмээ чинь маш их хэмжээний ус уудаг бөгөөд Бурхан хөдөлгөхгүй аваас, тийм их хэмжээний ус татах нигүүлсэнгүй үл таних хүмүүс тун цөөхөн л байх. Абрахамын зарц баттай байх үүднээс л ийм нарийн, хэцүү хүсэлт гаргажээ. Түүнчлэн энэ даалгаврыг хийх хүн нь тослогдсон нэгэн байх буюу өөрөөр хэлбэл Исаакт сонгогдсон гэргий байх ажээ.

Зарц залбирлаа хэлж дуусахаас өмнө Абрахамын садны охин Ребека мөрөн дээрээ саваа тавьсаар худаг дээр хүрч иржээ. Абрахамын зарц бушуулан угтаж очоод: “Чи надад ваартай уснаасаа жаахан балгуулна уу?” (17) хэмээн гуйв. Тэрбээр тэмээний тухай дуугараагүйг тэмдэглээрэй. Зарц залбиралд хэлсэн яг тэр зүйлээ л бүсгүйгээс хүссэн. Бүсгүй ч дуртайяа зөвшөөрөөд, зарцад ус өгчээ. Тэгээд дараа нь ингэж хэлсэн: “Би бас ус утгаж, таны тэмээнүүдийг ч ханатал нь усалъя” (19).

Яг л Абрахамын зарцын хүсэлтээр болж. Зарц бишрэн, баяр хөөрөөр цалгисан. Залбирал нь тийм хурдан хариултаа хүлээж авсанд тэрбээр сэтгэл дүүрэн байв.

Гэхдээ ажил дуусаагүй байлаа. Эдүгээ Исаакт зориулан баталсан Бурханы сонголтын эцсийн гүүрийг гатлах ёстой байв. Бүсгүйн гэр бүл нь охиноо хэзээ ч уулзаж байгаагүй эртэй ханилуулахаар, танихгүй мэдэхгүй газар руу явуулах болов уу?

Абрахамын зарц хэрэг явдлаа Ребекагийн гэр бүлд өгүүлсний дараа тэр айлын эрчүүд “Энэ нь ЭЗЭНээс заяагддаг учраас бид чамд сайн муу аль нь болохыг хэлж чадахгүй” (50) гэж хэлсэн. Маргааш нь гэр бүл нь охиндоо явахыг зөвшөөрөхөд, Абрахамын зарц охиныг Исаакт авчирч өгөөд, тэд гэрлэжээ.

Тэгэхээр, одоо энэ түүхийн гайхлыг хэлье. Бурхан тэр бүсгүйг Исаакт гайхамшгаар сонгосон. Гэхдээ гэрлэсэн хойноо Ребека үргүй бөгөөд үр хүүхэд төрүүлж чадахгүй нь мэдэгджээ. Юу?! Бурхан Исаагаар дамжин Үр төрөхийг амласан атлаа яахаараа үргүй хүүхнийг Исаакт сонгож өгдөг билээ? Хариулт нь: Бурханы амлалт автомат бус, харин итгэлээр байлдан дагуулж, олж авдаг гэдэг баримтанд оршино. “Эхнэр нь хүүсэр учир Исаак түүний төлөө ЭЗЭНд залбирсанд ЭЗЭН хариулж, эхнэр Ребека нь жирэмсэлжээ” (Эхлэл 25:21).

Амплифайд Библийн Сонгодог хэвлэл дээр “Эхнэр нь хүүхэд төрүүлэх чадваргүй байсан тул Исаак гэргийнхээ төлөө Эзэнээс ихэд залбирсан бөгөөд Эзэн залбирлыг нь баталгаажуулан, Исаакийн эхнэр Ребека хүүхэд олжээ” гэдэг. Исаак юу гэж залбирсан? Тэрбээр “Бурхан минь, Та надаар дамжин үндэстнүүд, хаад төрнө гэсэн, миний удмаар дамжин Үр төрнө гэсэн. Гэтэл эхнэр маань хүүхэд төрүүлж чадахгүй бол, энэ бүхэн хэрхэн биелэх билээ? Эзэн минь, Таны амласан Үр Таны амлалтын дагуу төрөхийн тулд Ребекагийн умайг нээгээч” хэмээн хашхирчээ.

Сүнсний хууль

Бидний ойлгож, мэдэх ёстой сүнсний хууль бий. Бичээс “Аяа ЭЗЭН, үг тань тэнгэрт Мөнхөд бат тогтжээ” (Дуулал 119:89) хэмээн тунхагладаг.

“Таны үг тэнгэр газарт тогтсон” гэж хэлээгүй байгааг тэмдэглээрэй. Үгүй ээ, энд газрын талаар юм хэлээгүй, зөвхөн тэнгэрт л тогтсон гэж байна. Тэгвэл Бурханы үг газар дээр хэрхэн байгуулагддаг юм бол? Бичээсийг цааш нь судлалбал, “Хоёр юмуу гурван гэрчийн амаар ямар ч үг батлагддаг (байгуулагддаг)” (2Коринт 13:1, тодруулгыг нэмэв) гэжээ. Үг нь хоёр юмуу эсвэл гурвын амаар байгуулагддаг гэж байгааг тэмдэглэнэ үү. Тэгвэл Бурхан юу хэмээснийг одоо үзнэ үү: “Амнаас минь гарсан Миний үг Над уруу хоосон буцаж ирэхгүй, Харин юу хүссэнийг минь хэрэгжүүлж, Юунд илгээснийг минь гүйцэлдүүлнэ” (Исаиа 55:11, тодруулгыг нэмэв).

Бурханы Үг Бурхан руу хэрхэн буцдаг вэ? Хариулт нь энгийн - бидний амаар. Нэгдүгээрт - Бурхан, хоёрдугаарт - бид. Тиймээс Бурханы амнаас хэдийнээ гарсан үгийг бид амаараа хэлэх үед Түүний үг газар дээр байгуулагддаг байх нь! Энэ гайхамшигт үнэнийг харж байна уу? Бурхан Исаакаар дамжин Үр дуудагдана хэмээн амласан ч, энэ үг газар дээр Исаакийн амьдралд ч, гэр бүлд нь ч байгуулагдахын тулд тэрбээр амаараа гаргаж хэлэх ёстой байжээ.

Бурхан биднийг аав, ээжээ хүндэтгэбэл, урт удаан амьдрал амласан. Энэ үнэнийг итгэлээр гаргаж хэлбэл, бид амьдралд маань Бурханы хэдийнээ хэлсэн үгийг байгуулах нь байна. Бид энэ үгийг энэ газар дээр байгуулдаг хоёр дахь ам нь ажээ. Би энэ үгийг хэлж байхдаа хөөрсөндөө байж сууж ядаж байна! Энэ нь бид өвчний улаан нүүр рүү харж байгаад, урт удаан нас амласан Бурханы гэрээг тунхаглабал, өвчин зайлахаас аргагүйд хүрнэ гэсэн үг. Бид аялахдаа, гэртээ болоод аюул осол отоож байгаа бүхий л газарт хамгаалалтыг итгэл дүүрэн мэдэгдэж чадна. “Тойрч бүслээд ирсэн түмэн хүнээс ч би айхгүй” (Дуулал 3:6), “Би түүнийг урт амьдралаар хангаж, Түүнд авралаа үзүүлнэ” (Дуулал 91:16) хэмээн итгэл дүүрэн хэлж чадна.

Түүнчлэн бид амьдрал маань сайн сайхан байхын амлалтыг хэлж чадна. Бэрхшээлтэй тулгарсан бол, нөхцөл байдал найдваргүй, бүрхэг харагдаж байсан ч, бид “Би аав, ээжээ хүндэтгэсэн бөгөөд Бурхан миний бүх юм сайн сайхан байна гэж амласан!” Есүсийн нэрээр би гачигдал, тэмцэл, дарамт, өвчин зэргийг гэдрэг зайлж, зам тавьж өгөхийг тушааж байна” гэж хэлж чадна.

Би Бурханы ямар ч амлалтыг яг ингэж хэлж чадна. Баялаг амьдралаар юмуу гачигдалтай амьдралаар амьдарч байгаа хүмүүсийн цорын ганц ялгаа нь амаар нь гарч байгаа үгс болой. Бурхан “Би өнөөдөр тэнгэр газрыг дуудаж та нарт гэрч болгон чиний өмнө амь ба үхэл, ерөөл ба хараалыг тавья. Чи бас чиний үр удам амьдрахын тулд амийг сонго...” (Дэд хууль 30:19) хэмээн айлдсан. Бид сонгоно гэснийг тэмдэглэнэ үү. Яагаад? Яагаад гэвэл бид амийг (гэрээний ерөөлийг) сонгохгүй бол, үхэл хэдийнээ газар дээр ажиллаж байдаг. Тэгвэл хэрхэн амийг сонгох вэ? Мөн л “Хэл гэдэг амилуулах бас үхүүлэх хүчтэй Хэн үүнд дурлана үр жимсийг нь хүртэнэ” (Сургаалт үгс 18:21) гэдэг.

Бид нэг бол Бурханы гэрээний амлалттай зөвшилцөнө, үгүй бол Сатаны гачигдал, өвчин, үхлийн хараалтай зөвшилцөнө. Маш энгийн энэ үнэнд олон хүн бүдэрдэг. Ийм шалтгаанаар л Иаков:

“Учир нь бид цөмөөрөө олон юман дээр бүдэрдэг. Үгэн дээрээ бүдэрдэггүй нэгэн байваас, тэрээр бүх биеэ хазаарлах чадвартай төгс хүн болой. Морьдыг залахын тулд бид амыг нь амгайвчилж, бүх биеийг нь жолооддог. ...Түүнчлэн хэл ч гэсэн биеийн жижиг эрхтэн атлаа агуу том зүйлсээр сайрхдаг ажээ. Харагтун, өчүүхэн гал ч ямар их ой модыг түймэрддэг билээ” (Иаков 3:2-3, 5) гэжээ.

Өчүүхэн цог ой модыг галдах чадалтай. Үүнчлэн айдас дор хэлэгдсэн үг ч амьдралыг чинь сүйрүүлэх чадалтай. Сайн мэдээ болбоос бидэнд Бурханы гэрээний амлалт бий. Тэдгээрийг зүрхэндээ хадгалбал, ам маань тийнхүү л ярина. Иаков хэлийг булагтай жишсэн. Нэгэн зэрэг цэнгэг ч, гашуун ч ус гаргаж чадахгүй. Тэгэхээр, хамаг учир нь хэлдээ ч биш, харин зүрхэнд маань орших эх ундаргад л оршдог байх нь. Учир нь Есүс “Сайн хүн зүрхнийхээ сайн баялгаас сайныг гаргана. Муу хүн нь муу баялгаасаа муу муухайг гаргадаг. Учир нь зүрх юугаар бялхана, ам түүнийг нь ярьдаг” (Лук 6:45) хэмээн мэдэгдсэн буюу.

Бурхан биднийг аав, ээжээ хүндэтгэбэл, урт удаан, сайн сайхан амьдарна гэсэн. Энэ үгийг уншиж байхад чинь Ариун Сүнс энэ үнэнийг зүрхэнд чинь дүрслэн урлах бөгөөд та ч үүнчлэн ярих болно. Бурханд итгэх итгэлээ бусдын туулсан туршлага дээр бус, харин Бурханы Үгийн үнэн дээр л суурьлуул. Би цаг бусаар нас барахгүй гэдэг итгэл миний зүрхэнд гүн үндэслэсэн бөгөөд Бурхан Үгийнхээ биеллийг Өөрөө хариуцна.

Эхнэр хүн хүндэтгэх дуудлагатай

Эхнэр хүний үүргийн тухайд “Эхнэр нь нөхрөөсөө эмээж бай (эхнэр нь нөхөртөө анхаарлаа хандуулж, хүндэтгэж, дээдэлж, соёрхож, таалж, үнэлж, орон зай тавьж өгч, магтан сайшааж, харамгүйгээр хайрлан, бишрэх)” (Ефес 5:33).

Ёстой янзтай үг байна! Эхнэр хүн эр нөхрөө хүндэтгэхийг Паул нарийвчлан зааж өгснийг харж байна уу. (Эр нөхөр нь эхнэрээ хүндэтгэх талаар хожим нарийн өгүүлэх болно)

Нөхөр нь өрхийн тэргүүн. Үүнийг шовинист эрчүүд зохиогоогүй. Энэ бол Бурханы санаа. Эр нөхрөө өрхийн тэргүүнийх нь хувьд

хүндэтгэдэггүй гэр бүлд жинхэнэ амар тайван, ерөөл байх боломжгүй. Харин ч эсрэгээрээ, Бурханы эмэгтэй хүн эр нөхрөө гэр бүлийнхээ тэргүүн хэмээн үнэлбэл, тэрбээр хүндэтгэлийн шагнал хүлээн авна. Энэ нь шууд нөхрөөр нь ирж болох ч, заримдаа өөр газраас ч ирдэг.

Саяхан би Европын нэгэн том чуулганд үйлчлэв. Нэгэн эмэгтэй надад “Жон, би энэ чуулганд таныг сонсохоор л ирлээ” гэлээ.

Би ч гайхлаа. Гэтэл тэрбээр түүхээ өгүүлэв. Хэдэн жилийн өмнө чуулган нь удирдлагын шилжилт хийжээ. Тэрбээр нөхрийнхөө хамт цуглаандаа суух хол зам туулж ирдэг байсан болохоор, гэрийнхээ ойролцоо байдаг чуулгануудад айлчилж үзэх боломж гарлаа гэж үзжээ. Тэгээд хэд хэдэн чуулганаар зочилж үзээд, саахалтынхаа нэгэн чуулганыг таалж гэнэ. Гэвч тэр чуулган нөхөрт нь таалагдсангүй. Нөхөр нь хуучин чуулгандаа буцаж очих хэрэгтэй гэж санажээ. Эмэгтэй ч дуртай дургүй дагасан ч, Бүтэн сайны орой нөгөө чуулгандаа зочилсоор байж.

Эмэгтэй шинэ чуулгандаа ихэд ижилдэн дасчээ. Тийнхүү эцэстээ удирдагч нь “Та хэзээ нөхөртэйгээ нүүр тулж, манай чуулган руу удирдаж байгаа Бурханы чиглүүлгийг дагах хэрэгтэй гэдгээ хэлэх гэж байна?” хэмээн нүүрэлджээ. (Би ийм удирдлагаас айдаг шүү)

Тэдний үг нь эмэгтэйг дайвалзуулжээ. Эмэгтэй чуулганаа солих шийдвэрээ нөхөртөө хэлээд, нөхөр нь үлдэж байгаа ч, тэрбээр өөрөө явах гэж байгаагаа хуучин пастортаа хэлэхээр уулзах цаг авсан байна. Тэгээд уулзалтын өмнөх шөнө эмэгтэй миний бичсэн, Бурханы эрх мэдлийн дизайныг тайлсан *Батлан хамгаалалт дор* номыг уншжээ.

Тэгээд “Жон, би шөнөжин уншсан. Уншаад л, Бурхантай ч, нөхөртэйгээ ч тэрсэлдсэнээ ухаараад, уйлаад л байсан. Маргааш нь би нөхрийнхөө өмнө ч, пасторынхаа өмнө ч гэмшсэн” гэж хэлсэн юм.

Тэгээд дуртай нь аргагүй хуучин цуглаандаа буцаж очжээ. Хэдэн сарын дараа пасторынх нь гэргий нь мөнөөх эмэгтэйг цуглааныхаа өөр нэгэн бүсгүйтэй танилцуулжээ. Гэтэл тэр хоёр хоёулаа бизнесийн ижил алсын хараатай байж таарсан болохоор, шинэ бизнес эхлүүлсэн байна. Өнөөдөр тэр хоёр маш амжилттай яваа бөгөөд бизнесийнхээ ашиг орлогоос Бурханы хаанчлалд маш ихийг өргөдөг.

Тэгээд “Жон, би нөгөө шинэ чуулган руу явсан бол, яваандаа нөхрөөсөө салаад, бизнес хийх дуудлагаа хэзээ ч биелүүлэхгүй байх байсан” гэсэн юм. Тэрбээр бас шинэ чуулганы удирдлага нь нөхөр хүний удирдлага эдүгээ хүчингүй болсон учраас, тоолгүй хүрээд ирэхийг ятгаж байсан тухай ярьж билээ. Гэтэл эмэгтэй хамгаалалт бөгөөд шагнал бүхий хүндэтгэлийг дагажээ.

Аврагдаагүй нөхөртэй эхнэр

Элч Петр ч Паултай адил үг бичсэн:

Түүнчлэн эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд үггүйгээр эхнэрүүдийнхээ биеэ авч явах байдлаар аврагдана. Тэд та нарын журамт байдал болоод эмээхийг чинь ажиглана шүү дээ. (1Петр 3:1-2)

Эхнэрийнх нь номнол, сургаал бус, харин хүндэтгэл аврагдаагүй эр нөхөрт нь хүрдгийг Петр харуулжээ. Эхнэрийнхээ ааль үйлдлээр дамжин Эзэн дээр ирсэн нөхрүүдийг би мэднэ. Үүний нэг том жишээ нь 1900 оны эхээр Европт амьдарч байсан, Бурханы аугаа эр хүн Смит Уиглесуорт болой.

Уиглесуорт сантехникч байсан бөгөөд нас явах тусам, Бурханд улам л хөндий хүйтэн хандах болжээ. Тэр Христэд итгэх итгэлийг мэдэхийг ч хүссэнгүй. Нөгөөтэйгүүр, гэргий - Поли нь маш үнэнч итгэгч байж. Үнэндээ энэ хооронд Полигийн Бурханыг гэх зүрх сэтгэл улам л бадарсаар байж. Полигийн үнэнч зүрх Уиглесуортын урвуу байдлыг улам л илчилсэн болохоор, тэрбээр эхнэрээ тээршаав.

Итгэлээс нь болж эхнэрээ хяхаж хавчиж, тодорхойгүй шалтгаанаар зүгээр л чуулганд явахыг нь хориглов. Тушаал нь Бурханы хүсэлтэй сэргөлдөж байсан болохоор (Өмнө хэлсэнчлэн, эрх мэдэл Бурханы бичмэл Үгийг зөрчөөгүй тохиолдолд л бид эрх мэдлийг дагах ёстой), Поли ч дагасангүй.

Поли Бүтэн сайны орой хоолоо хийчихээд л, цуглаандаа яваад өгдөг байв. Нэг орой ирдэг цагаасаа нилээд оройтож иртэл, гэртээ орохоос нь өмнө Смит “Би энэ гэрийн эзэн. Ингэж оройтож ирсэн хүнийг би гэртээ оруулахгүй!” гэжээ.

Поли ч тэр даруй “Тийм ээ, та миний нөхөр. Гэхдээ Христ миний Эзэн” хэмээн намуун дуугаар хариулжээ.

Хилэгнэж, дүрэлзсэн Уиглесуорт арын хаалгаараа эхнэрээ хөөж гаргаад, араас нь хаалгаа хаав. Өглөө нь Смит сониноо авахаар үүдээ нээтэл, эхнэр нь дотогшоо уначижээ. (Поли шөнөжин хаалгаа дэрлээд унтсан байна) Поли бушуухан босоод, “Смит, өглөөний цайндаа юу идмээр байна?” хэмээн баяртайгаар асуусан байна. Тэгээд өглөөний цайгаа хийж эхэлжээ.

Бурханыг дуулгавартай дагаж, эр нөхрөө хүндэтгэх гэсэн Полигийн шийдвэр нь Уиглесуртод гүнээ нөлөөлсөн байна. Тэрбээр эцэстээ Есүс Христэд бүрэн бууж өгсөн бөгөөд насан турш үнэнчээр үйлчилсэн үйлчлэл нь өнөө хэр яригдан, хайр хүндэтгэл хүлээдэг. Түүний үйлчлэлээр олон хүн аврагдаж, эдгэрч, тэр бүү хэл үхлээс амилуулагдсан юм.

Нөхрийнх нь үйлчлэлээр ерөөгдсөн мянга мянган хүний улмаас, Христийн шүүх сэнтийн өмнө Поли үлэмж шагнал хүлээж авах болно. Тэрбээр өөрчлөгдсөн нөхрийнхөө улмаас шагнуулахаар барахгүй, ирээдүйн аугаа их ургацын улмаас ч шагнуулна.

Одоо тодорхой болж ирж байна уу? Бид хүндэтгэж байгаа хүмүүсийнхээ тусын тулд төдийгүй мөн хаанчлалын тусын тулд хүндэтгэх заавар хүлээн авсан билээ. Бид хүндэтгэх ёстой хүмүүсийг хүндэтгэхгүй аваас, өөрөө л хохирох болно.

Чуулганы удирдагч нарыг хүндэтгэх

Өмнө хэлсэнчлэн, Бурханы хаанчлал нь хаанчлал юм. Тиймээс чуулган дотор томилогдсон эрх мэдэл, зэрэг дэв гэж байна. Чуулганыхаа удирдагчийг хүндэтгэснээрээ, бид эргээд Есүсийг хүндэтгэнэ. Есүсийг хүндэтгэснээрээ эргээд Бурхан Аавыг хүндэтгэнэ (Матай 10:40-41). Бидний хариу үйлдэл, яриа, тэр бүү хэл бодол маань ч тэр удирдагчийг илгээсэн Нэгэнд хандаж байгаа байдал юм.

Бурхан дараа нь “Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна” (1Самуел 2:30) хэмээсэн. Бид чуулганыхаа удирдагч нарт хандах хандлагаараа Бурханд хандах хандлагаа тусган харуулдаг. Чуулганы эрх мэдлийг хүндэтгэдэггүй хүн Бурханаас эмээхгүй.

“Би хүнээс биш, Бурханаас эмээдэг!”

Энэ үнэнийг нүдэнд үзэгдтэл дүрсэлсэн, чуулган дээрх нэгэн явдлыг би хэзээ ч мартахгүй. Гомдлоос чөлөөтэй байх талаар заасны минь дараа олон хүн залбируулахаар урагшаа гарч ирэв. Олон залуусын дунд амьдралдаа маш том шарх олсон хүн гэж бодсон нэгэн залуу нүдэнд туссан юм. Би түүнд үргэлжлүүлэн үйлчлэхээр тайзан дээр дуудаж гаргаж ирлээ. Түүнийг гарч ирэх хооронд олны дундаас өөр нэгэн эр сугарч гарч ирээд, бидэнтэй хамт тайзан дээр зогсов.

Хоёр дахь эр үсээ ар дээрээ боосон, жийнсэн өмдтэй, хар арьсан хантааз, футболк цамц, мөрнөөсөө бугуй хүртлээ шивээстэй залуу байв. Шируун харцтай, шийдчихсэн л гэмээр харагдав. Тэрбээр тэр даруй чангараад, Бурханаас юм хүлээж авах ямар ч аргагүй болсныг би ажиглалаа.

Би хоёр дахь хүн рүү хараад, тайзнаас буухыг эелдгээр хүслээ.

Тэрбээр над руу муухай харснаа “Буухгүй!” гэв.

Миний хүсэлтэд тийм эрээ цээргүй пал хийтэл хариулсанд нь би хэсэгхэн балмагдсанаа, дахин цэгцрээд “Эрхэм ээ, таныг буухаас нааш би цааш үргэлжлүүлж чадахгүй” гэлээ.

Нөгөө хүн “Буухгүй!” л гэнэ.

Одоо би жаахан ундууцаад, угтагч нар тэр хүнийг тайзнаас буулгахад надад туслахгүй байгааг гайхлаа. Тэгтэл хүмүүс бүгдээрээ тэр хүнээс айгаад байгааг би ойлгов. Тийнхүү эдүгээ эрх мэдлийг огт хүндэтгэдэггүй, тэрслүү хүнтэй нүүр тулаад байгаагаа ойлгосон болохоор, би Бурханд найдан, эрх мэдлээ хадгалан, бат зогсох ёстой болсон юм. Энэ янзаараа би тэр залууд нөлөөлж чадахгүй гэдгээ ойлгохдоо, “Эрхэм ээ, би таныг тайзнаас буухыг тушааж байна” хэмээн өөрийнх дээрээ бат зогслоо.

Залуу дахиад л муухай харснаа “Буухгүй!” гэв. Тэгээд хэсэгхэн нэг их хачин таг болсноо “Би хүнээс биш, Бурханаас эмээдэг!” гэв.

Тэр хүн Бурханаас эмээдэггүй байв. Тэрбээр тархи, зүрхэндээ зохиосон бурхныхаа дүр төрхөөс эмээдэг байж болох ч, тэр нь тэнгэр, газрын жинхэнэ Бурхан биш байв. Тэрбээр Бурханаас жинхэнээсээ эмээдэг байсан бол, намайг Бурханы зарц хэмээн хүндэтгэж, хүсэлтэд минь захирагдах байсан.

Би ч ухарсангүй. Тиймээс дотроо Ариун Сүнснээс тусламж хүслээ. Гэнэт яг л хүн надад хэлсэн юм шиг, би тэр хүн нөгөө эхний хүүгийн аав болохыг нь мэдэв. Тэгээд асуугаад, баталгаажууллаа. Би “Эрхэм ээ, хүү чинь Бурханы тусламжийг аваасай гэж хүсч байвал, та тайзнаас буух хэрэгтэй. Тэгэхгүй бол, та хүүгээсээ Бурханы эдгэрлийг чангаах болно” гэсэн юм.

Энэ үг түүний хатуурлыг зөөлрүүлсэн болтой, тэрбээр над руу муухай харсаар, дуртай дургүй тайзнаас буув. Эцэстээ хүү нь үйлчлэлд нээгдэн, Бурханы ер бусын хүрэлцээг хүлээн авлаа. Бурхан хүүгийн дотор үнэхээрийн гайхамшиг үйлдэж, хүү Бурханы өмнө сөхрөөд, уйлав.

Цуглааны дараа би нөгөө аавтай пасторуудын өрөөнд уулзсан юм.

Тэрбээр хотынхоо байкер - хүнд гаруудын бүлгийн гишүүн ажээ. Ширүүн дориун, төмөр хана шиг л харагдаж байсан ч, би ч бууж өгсөнгүй. Би түүнтэй эелдэг зөөлөн ярилцаж байсан ч, бидний яриа хурцадсаар, сүүлээрээ би түүнийг над руу дайрах нь уу даа гэж бодов.

Би түүнд Бурханы зарцыг хүндэтгэхгүйгээр Бурханыг хүндэтгэх боломжгүйг хэллээ. Бурханыг хүндэтгэнэ гэдэг нь Түүний тохоон томилсон эрх мэдлийг хүндэтгэх явдал. Би түүнд яагаад тайзнаас бууна уу гэсэн хүсэлтээс маань гэжих нь буруу болохыг тайлбарлаж өгөв.

Сүүлээрээ нөгөөх маань жаахан аядав. Би ч ухралгүй, Бурханы Үг дээр тууштай төвлөрсөөр байсан бөгөөд эцэстээ нөгөө хүн маань шалдаа буугаад, уйлж гарсан юм. Мэдэх нь ээ, түүнийг ч төрсөн эцэг нь маш ихээр шархлуулсан ба амьдрал, эрх мэдэл, Бурханд хандах үзэл бодол нь аавынхаа хүчирхийллийн нөлөөллөөр бүрэлдэн тогтжээ. Мань хүн ч аавыгаа уучлалгүй, түүний гаргадаг байсан зарим хүчирхийллийг өөрийнхөө хүүд гаргадаг болжээ. Тэрбээр явахаасаа өмнө яг л нялх хүүхэд шиг эхэр татан мэгшиж байлаа.

Тэрбээр алдаагаа харан, пасторын болоод миний эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, уучлал гуйхдаа, Бурханаас үлэмж ихийг хүлээж авах чадвартай болжээ. Бид хоёрын мөргөлдөөнөөр эхэлсэн, ээдрээт уулзаа эцэстээ тэрбээр намайг баатраа гэж үзсэнээр өндөрлөв. Намайг дайрах нь холгүй байсан тэр хүн, эцэстээ жигтэйхэн хайртай болов.

Анзаарагдамгүй хүндэтгэлгүй байдал

Сая би нилээд хүнд жишээ өгүүлсэн бол, энэ асуудлын үндэс итгэгчдийн зүрхэнд бидний санаснаас ч илүү газар авсан байдаг ажээ. Дээрх эр эрээ цээргүй үл хүндэтгэсэн. Нууж хаалгүй, шууд авир гаргасан нь ч түүнд хүрэхэд харин ч амар болгож байв. Тэр хүн байгаагаараа л байсан. Гэтэл олон хүн яг адил атлаа хүндэтгэлгүй авираа өөрөөр харуулдаг. Тэд соёлгүй, бүдүүлэг гэж нэрлэгдэхээс айсандаа, зөвшөөрч байгаа царай гарган, зөв ярьдаг ч, дотроо үл хүндэтгэх. Энэ нь гаднаа үл анзаарагдам байдлаар харагддаг.

Миний яриад байгаа энэ хүмүүс удирдагч нараа уруулаараа хүндэтгэдэг ч, зүрх нь Бурханы тохоон томилсон удирдагч нарыг хүндэтгэхээс хаа хол байдаг. Тэдний өргөлд хандаж байгаа байдал,

өөрчлөлтөд хандаж байгаа байдал гэх мэт удирдагчийн зүгээс гаргах янз бүрийн хүсэлтэд хандах байдлаар нь илэрнэ. Пастор нь гишүүдээ хүндэтгэлийн онцгой оройн цуглаанд хүрэлцэн ирэхийг хүсэх үед 1/10 нь л ирнэ. Эсвэл сар тутмын Сайн мэдээний цуглаанд оролцохыг хүсэх үед 1/20 нь л ирнэ.

Би Бүтэн сайнд 2-4 цуглаан хийдэг, олон мянган хүнтэй чуулганд очиж үзсэн. Гэтэл ер нь бол, нэгээс бусад нь пиг дүүрдэг. Харин пастор нь Нэг дэхь өдрийн орой нэгдсэн залбирлын цуглаан хийе гэхэд, хэдхэн зуун хүн л ирнэ. Яагаад? Яагаад гэвэл, пасторыгаа хүндэтгэх хүндэтгэл байхгүй учраас л тэр.

Та “*Жон арай л туйлширч байна*” гэж бодож байж болох. Тэгвэл туйлшрал биш гэдгийг харуулах өөр нэгэн жишээ хэлье л дээ. Жишээ нь Бүтэн сайнд пастор нь “Энэ сар Нэг дэхийн орой бүр залбирлын онцгой цуглаан хийнэ. Ирэх дөрвөн удаагийн Нэг дэхийн орой 19-20 цагийн хооронд том танхимдаа хийнэ” гэж хэлжээ. Энэ нь *Нэг дэхийн орой бүрийн хөл бөмбөгийн тоглолттой давхцаж* таарсан учраас, гишүүдийн 80 нь энэ зарлалд баярласангүй.

Тэгтэл пастор нь “Сүүлчийн цуглаан дээр бүх дөрвөн удаагийн залбирлын цуглааныг таслалгүй, суусан хүн бүрт манай хотын том бизнес эрхлэгч нэгэн хатагтай \$500,000-ын чек өгнө” хэмээн нэмж хэлэв.

Ирц яах бол? Суух суудалгүй, пиг дүүрэх л болов уу. Хүмүүс багтахгүй байх бий хэмээн айсандаа уралдаж ирээд, суудлаа эзлэх байх.

Одоо юу гэж бодож байна? Өөрийгөө битгий хуураарай. Зүрхний чинь сэдлийг илчилсэн үнэнээс битгий булзаарай.

Хоёр зүйлийг өөрөөсөө шударгаар асуу. Нэгдүгээрт - Мөнгө амлаагүй байсан бол, та залбирлын цуглаанд бүтэн суух байсан уу? Хоёрдугаарт - хагас сая доллар амласан учраас л та суух байсан уу? Бодоод үз - та байр, машинаа төлчихнө, дээрээс нь өөр бас бус олон юм хийх мөнгөтэй болно.

Та эхний асуултад үгүй, хоёр дахь асуултад тийм гэж хариулсан бол, өөрийгөө пасторынхаа үгийг хэр зэрэг үнэлдэг хүн болохоо мэдэж авлаа. Хүндэтгэх нь үнэлэх гэдгийг санаарай.

Бурхан “Удирдагчдаа дагаж, тэдэнд захирагдагтун. Учир нь тэд тооцоо хийгчид адил сэтгэлийг чинь сэрэмжилдэг” (Еврей 13:17) гэдэг. Энэ нь Бурханы хүмүүстээ өгсөн заавар бөгөөд бид чуулганыхаа удирдлагыг дагах ёстой. Тиймээс та үүнийг зүгээр л пасторынхаа

үгэнд орсондоо бус, харин мөнгөний төлөө хийж байгаа гэдгээ үнэнээр хүлээсэн бол, тэгвэл хэн таны эзэн байна? Есүс “Хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй. Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлах болно. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцнэ. Та нар Бурхан, эд баялаг хоёрт зэрэг үйлчилж чадахгүй” (Матай 6:24) хэмээсэн.

Тэгвэл зарим нэг хатуу асуулт асууя: Та цуглаандаа цагтаа ирдэг үү? Пастор чинь танаас онцгой өргөл хүсэх үед та дотроо дургүйцдэг үү? Чуулгандaa юмуу нийгэмдээ үйлчилж, туслаач гэсэн удирдагчийнхаа уриалга дуудлагыг та байнга үл тоодог уу? Та Бүтэн сайны оройн онцгой цуглаанд оролцож чадахгүй гэсэн шалтаг тоочиж байна уу? Тэгэхээр, одоо хэрэв хүн бүрт \$500,000 өгнө гэж амласан бол, таны шийдвэрт нөлөөлөх байсан эсэхийг өөрөөсөө асуугаарай. Нөлөөлөх бол, яагаад? Энэ хэцүү асуултад та дотроо л хариул. Гэхдээ дотроо “Та нарыг хүлээн авах нь Намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авах нь Намайг Илгээгчийг хүлээн авсан хэрэг юм” хэмээн айлдсаныг санаарай. Үүнийг мөн л “Та нарыг хүндэтгэх нь Намайг хүндэтгэсэн хэрэг. Намайг хүндэтгэгч нь Намайг Илгээгчийг хүндэтгэсэн хэрэг” гэж хэлж болно. Та пасторынхаа үгийг үнэлэхдээ, Бурханы Үгийг үнэлнэ. Учир нь пасторыг чинь Бурхан танай руу илгээсэн болой.

Тэгэхээр, бид яагаад үй олон хүн амьдралдаа хөгжин цэцэглэдэггүйг ойлголоо. “ЭЗЭНий өргөөнд тэд суулгагдаж Бурханы маань хүрээнүүдэд тэд цэцэглэнэ” (Дуулал 92:13) гэдэг. Бид чуулганд суулгагдахдаа, энэ амьдралдаа ч, Христийн шүүх сэнтийн өмнө ч цэцэглэнэ. Магтаалч “Эзэний өргөөнд очдог нь...” гэж хэлээгүйг тэмдэглэнэ үү. Та чуулганд явж болох ч, суулгагдаагүй байж болно. Суулгагдах гэдэг нь Бурханд үйлчлэхээр амь амьдралаа зориулах явдал болой. Энэ бол таны өгдөг, үйлчилдэг, удирдлагаа дагадаг газар. Мод амь авдаг хөрсөө үнэлдэг шиг, бид ч суулгагдахдаа нутгийнхаа чуулганаа үнэлнэ.

Та чуулгандaa суулгагдахгүйгээр цэцэглэл, амжилт, аз жаргалыг амталж болох ч, урт удаан ерөөл эдлэхгүй. Бид амьдралынхаа бөгсөн дээр төдийгүй, хамгийн гол нь бүх зүйл ил болох Христийн шүүх сэнтийн өмнө эдэлж чадах үлэмж таашаал, ханамжтай, урт настай ерөөлийг хүсэх ёстой болохоос биш, амд ч үгүй, хамарт ч үгүй ерөөл бидэнд хэрэггүй.

Та чуулганд суулгагдсан бол, чуулганыхаа удирдагч нарын үгийг үнэлнэ. Танаас хүссэн зүйлийг нь хөнгөн хийсвэр үзэхгүй. Тэр цагт та Бурханаас эмээх бөгөөд Бурханаас эмээдэг хүн Түүний тохоон

томилсон удирдагч нарыг хүндэтгэнэ. Харин Бурханы тохоон томилсон удирдагч нарыг хүндэтгэснээрээ, та Бурханы танд л гэж хадгалсан бүрэн шагналыг хүлээн авна.

Тэднийг өндрөөр үнэл

Бидэнд “Ах дүү нар аа, дунд чинь зүдэн зүтгэдэг ба Эзэн дор та нарыг удирдаж, зааварладаг хүмүүсийг хүндэлж, ажлынх нь төлөө та нар хайраар тэднийг өндрөөр үнэлэхийг хүсэж байна. Өөр хоорондоо эв найртай бай” (1Тесалоник 5:12-13) хэмээн зааварласан.

Миний бие дөчөөд жил үйлчлэхдээ, долоон жил нутгийн чуулганд, үлдсэнийг нь нүүдлийн үйлчлэлд зориуллаа. Хамгийн бүрэн дүүрэн, амар тайван, аз жаргалтай, хөгжин цэцэглэсэн, амжилттай итгэгч хүмүүсийг хараад байхад, голдуу нутгийн чуулганыхаа удирдагч нарыг өндрөөр үнэлдэг, бүтэн хайраар бүрэн зориулагдсан хүмүүс байдаг. Бурхан ч бидэнд ингэж л зааварласан бөгөөд ийм гэрчлэл үнэн байх нь ч аргагүй бус уу? Гэхдээ эсрэг нь ч бас үнэн.

Энэ олон жилийн хугацаанд миний бие энэ спектрын аль аль үзүүрт нь байгаа хүмүүстэй таарч явсан. Зарим хүн пастортайгаа эн зэрэгцээд л уралдаад давхиад байна. Аргагүй пастор гэдэг байр суурь байгаа учраас л, тэснэ. Тэд чуулган удирдах юмуу үйлчлэл дээр өөрийгөө пастораасаа дутахгүй эвсэл бүр илүү сайн ажиллана гэж боддог. Тэд Бурхан өөрийг нь үйлчлэлд “дэвшүүлэх” хүртэл цагаа харан хүлээнэ. Тэд пасторыгаа ядах юмгүй сольчихож болох хүн гэж үздэг учраас, өөр хэнбугайгаас ч өөрцгүй хандана.

Ийм хүмүүсийн тоонд бас үйлчлэх сонирхолгүй, зах зээлийн талбарт ажилладаг, албатай учраас чуулганд явдаг хүмүүс ч орж болно. Энэ хүмүүс пасторынх нь ажлыг хэн ч - тэр байтугай тэр өөрөө ч өлхөн хийж чадах боловч, зүгээр л нийгэм дээр ажиллах замыг сонгосон гэж боддогоороо түрүүний хүнээс ялгаатай. Тэд пасторыгаа оюуны тал дээрээ сул учраас, чуулганд үйлчилж таарсан гэж үздэг.

Аль нь ч байлаа гэсэн, энэ хүмүүс амьдралдаа тултал амжилтанд хүрэхгүй. Түүнчлэн, тэд бизнестээ ч, үйлчлэлдээ ч сайн явж болох ч, чуулгандаа суулгагдаж, Бурханы бэлгийг аминчилж, пастораа үнэ цэнэтэй хэмээн үзсэн тохиолдолд хүртэх байсан хэмжээнээс хол дутна. Тэд голдуу гэр бүл, үр хүүхэдтэйгээ асуудалтай байдгаас гадна эрүүл мэнд, санхүү зэрэг амьдралын олон талбар дээр зүдэрдэг.

Элэг эмтлэм түүх

Би удирдагч нараа үнэлдэггүй, тэр бүү хэл хүндэтгэдэггүй хүмүүсийн олон жишээ хэлж чадна. (Тэгээд мэдээж спектрын нөгөө, эерэг үзүүрийн талаар ч тун удахгүй ярина) Гэхдээ энэ байдлыг нүдэнд үзэгдтэл харуулсан нэгэн явдал миний таньдаг хэдэн эрчүүдтэй тохиолдсон билээ. Том чуулганд пастораар үйлчилдэг, миний нэг найз бий. Би тэдний чуулганд тогтмол зочилж, заадаг болоод 25 гаруй жил болж байна. Гэхдээ бид хоёр 35 жил сайхан нөхөрлөж байна.

Найзыг маань чуулганых нь гишүүд төдийгүй, манай улс, олон улсын олон удирдагч нар ч хүндэтгэдэг.

Хэдэн жилийн өмнө найз маань нэгэн залууд амьдралд нь хандсан Бурханы удирдамжийг олоход нь тусалсан юм. Билл (зохиомол нэр) гэдэг тэр залуу Бурханы Үгийн олон үнэт үнэнд итгэдэггүй урсгал чиглэлийн бүлэгт өсч бойжсон байв. Рэнди (зохиомол нэр) гэдэг найз маань Бурханы хүчирхэг чиглүүлгээр Биллийг Ариун Сүнсээр дүүрч, үйлчлэлийн үр жимстэй зам дээр гарахад нь замчилж өгчээ.

Билл Ариун Сүнсний баптисм хүлээн авснаасаа болоод удалгүй чуулгангүй болсон байна. Рэнди пастор хүмүүсээ дагуулж очоод, урсгал чиглэлийнхэн нь гудманд гаргаад хаячихсан байсан Биллийн эд хогшлыг аваад, гэр бүлд нь байр түрээслэн, оруулж өгчээ.

Эцэстээ Билл өөр нэгэн хотод, хөгжин цэцэглэж буй чуулганы пастор болов. Тэрбээр өчүүхнээр эхэлсэн боловч, амьдралд нь хандсан Бурханы хүчирхэг бэлгээр нь дамжин чуулган нь хурдан өсөв. Хэдэн жилийн дараа Билл кино театр худалдаж аваад, түрээсийн байрнаасаа цоо шинээр засч тохижуулсан байр руугаа нүүжээ. Тэрбээр чуулганы байраа Бурханд даатгах ёслолын ажиллагаандаа туслуулахаар амьдралд нь аугаа нөлөө үзүүлсэн Рэнди пасторыг урьсан байна. Үйл ажиллагаа ч гайхамшигтай болж.

Чуулган нь ч хөгжин цэцэглэсээр байсан ч, нууц донтолт нь Биллийг хөнөөж байв. Байдал нь даамжирсаар, яваандаа чуулганы ахлахуудад нь ил болжээ.

Билл үе үе Рэндитай яриад, удахгүй ажлаасаа гарах гэж байгаагаа хэлэв ч, шалтгааныг нь хэлдэггүй байж. Рэнди ч түүнийг зоригжуулан дэмжсээр л байж. Гэхдээ тэр нэгэн өдөр чуулганы нэг ахлах нь Рэнди руу яриад, Биллийн хүлээсийн талаар хэлэх хүртэл. Рэнди шууд л онгоцонд суугаад, Биллийн дэргэд байж, туслахаар очив. Харамсалтай нь, ахлахууд нь Биллийн донтолтын талаар мэдсэн хэрнээ, индэр дээр нь үлдээхийг хүсчээ.

Рэнди ахлахуудын үгийг сонсоод, “Та нар Биллийг индэр дээр нь үлдээх гэж оролдох юм бол, би Бүтэн сайны цуглаан хүртэл эндээ үлдээд, нөхцөл байдлыг олон нийтэд мэдэгдэнэ. Та нар Биллийн гэр бүлийг огт бодохгүй, зөвхөн өөрсдийгөө бас чуулганаа л бодож байна. Харин та нар түүний халагдах өргөдлийг хүлээж авах юм бол, чуулганы шилжилт хөдөлгөөн дээр чинь би тусалъя” гэж хэлжээ.

Рэнди тэр өдрөө л Биллийг гэр бүлээр нь авраад, өөрийнх нь чуулгантай ойр, өөр муж руу нүүх төлбөр тооцоог нь бүрэн зохицуулаад, Биллд сайн цалинтай ажил олж өгсөн байна. Яваандаа Билл ч Рэндигийн үйлчлэл дор илааршив.

Хожим нь Рэнди Биллийг хамт олондоо хүлээн аваад, Биллийг амьдралд нь хандсан Бурханы дуудлагын зам дээр дахин гарахад нь туслахаар туслах пастораараа томилжээ. Энэ хооронд Христэч хэвлэлийнхэн Биллийн чөлөөлөлтийн түүхийг бичиж, гэрчлэлийнх нь улмаас Биллийн нэр хүнд ч суга өсөв. Хэсэг хугацааны дараа өөр нэгэн үйлчлэл Биллийг урамшуулан, хамтарч ажиллаад, яваандаа нүүдлийн үйлчлэл эхлүүлэх санал тавьжээ. Рэнди пастор Биллийг ийм нүүдэлд арай бэлэн бус гэдгийг нь хэлээд, өөр зөвлөгөө өгөв. Гэтэл Билл түүнийг хянан захиргаадлаа, хувь тавиланд нь садаа хийлээ гэж үзээд, Рэндигийн зөвлөгөөг үл хэрэгсэн, өөрийнхөөрөө нүүжээ.

Цаг хугацаа өнгөрсөөр, нэг удаа Билл бид хоёр өөр хэд хэдэн удирдагчийн хамт оройн зоог барьж таарсан юм. Билл ярианыхаа ихэнх хагаст Рэнди пасторын талаар гомдоллов. Чуулганаа удирдаж чаддаггүй л гэнэ, түүнийг ажиллуулж байхдаа ингэж тэгж хандсан л гэнэ, явахад нь дургүйцсэн л гэнэ. Зүрхэнд маань дохио асахыг би тодхон санаж байна. Гомдол нь Биллийг амьдралд нь өчнөөн тусалсан хүнийг тэгтэл урвуугаар харах хүртэл нь дордуулсныг би мэдэв.

Тэр оройн зоог дээр би Рэндиг өмгөөлсөн боловч, энэ маань ямар ч тусгүй байгааг үзэв. Рэндиг байлцуулж өөрийнх нь талыг яриулахгүйгээр, ар нуруугаар нь ингэж муучлах нь буруу гэдгийг би мэдэж байлаа. Тиймээс би Рэнди бол Биллийн хувьд итгэлийн аав нь бөгөөд Рэнди буруу байлаа гэхэд (Рэндигийн буруу байсан гэдэгт би итгэхгүй), Биллийн хувьд Рэндиг ингэж шүүмжилж, үл хүндэтгэх нь буруу гэж хэлээд яриагаа дуусгав. Уг нь би Биллд энэ номын өнгөрсөн бүлгүүдээр хуваалцсан библийн жишээнээс ярьсан боловч, Билл Рэнди пасторыг үгийн зайгүй эсэргүүцэж байлаа.

Хэдэн сарын дараа Рэнди залгаад, яг л хайртай хүнээ алдчихсан юм шиг л гашуудан ярив. Гэтэл Билл ном гаргажээ. Тэгээд нэг бүлэг дээр

нь хянан захиргаадагч чуулган, удирдагч нарыг хэрхэн шийдвэрлэхийг заасан байж. Рэнди “Жон, би чамд Биллийн шинэ номын дөрвөн хуудсыг уншиж өгмөөр байна” гээд, Рэндигийн талаарх, түүний хамт олны талаарх, чуулганых нь талаарх гүтгэлгийн чанартай мэдээллийг уншиж өглөө. Тэнд нэр дурьдаагүй байсан ч, хэний тухай бичсэн нь тодорхой байв. Тэгээд ч Билл ганцхан Рэндигийн чуулганд л туслах пастораар үйлчилсэн бөгөөд Рэндигийн чуулган олон улсын статустай учраас, Биллийн номыг уншигч - олон хэний тухай өгүүлж байгааг нь шууд мэдэхээр байлаа. Биллийн бичсэнээр бол, Рэнди пастор зүгээр л хянан захиргаадах өвчтэй амьтан ажээ. (Хамгийн сонирхолтой нь энэ олон жил Рэндигийн чуулганд зочилж явахад, ажилтнуудынх нь дунд урваж шарвах тохиолдол өдрийн од шиг цөөхөн байсан шүү. Тэд пастортаа үнэхээр хайртай, хамгийн үнэнч хүмүүс)

Рэнди дөрвөн хуудсаа уншиж дуусгаад, “Жон, би яах вэ, тоохгүй. Харин чуулганы маань гишүүд (олон мянган хүн бий) үүнийг уншаад... Билл тэдний пастор байсан учраас, мэдээж уншина... яана даа гэхээс элэг эмтэрч байна. Энэ үг тэднийг амархан хордуулж, тэд ч манай чуулганд урьдынх шигээ Бурханаар ерөөгдөж чадахаа болино” гэж хэлсэн юм.

Миний ч элэг эмтрэв. Чихэндээ ч итгэсэнгүй. Нэг их олон хүн Биллийн төлөө Рэнди шиг гүйхгүй л байсан болов уу. Рэнди Биллийг татаж авсан, халамжилсан, сэргээсэн. Тэгтэл Билл яаж ингэж чадааа? Тэр хүн үл хүндэтгэлийн үр тарьсан учраас, нэг их аятайхан ургац хураахгүйг нь би мэдэж байлаа. Үнэндээ, гэмшихгүй аваас, аймшигтай л ургац хураах байв.

Хэдэн жилийн дараа Билл дахин пастораар үйлчлэх болжээ. Мөн л амьдралд нь хандсан Бурханы бэлгээр чуулганаа өсгөж. (Бид Бурханы зүрхтэй эгнэхгүй байсан ч, Бурханы бэлэг ажиллаж, амжилт авчирч болно) Гэхдээ нөгөө ургац хураах цаг нь хаяанд ирсэн байв. Билл хуучин хүлээсэндээ ороогджээ. Энэ удаа өөр нэгэн гэр бүлийг хөндсөн учраас, бүр ч аймшигтай үр дагавар авчирсан байна. Үр дагавар нь чуулган даяар ч, нийгэм даяар ч түгэв. Чуулган эрэмдэг байдалд орж, олон хүн шархалж, зүг чигээ алдав.

Билл сүнсний ааваа хүндэтгээд, зөв цагтаа үйлчлэлдээ гарсан сан бол, хоёр дахь удаагаа уналгүй, биднийг нүглээс чөлөөлж, сэргээдэг Бурханыг гэрчлэн мандуулсаар явах байсан гэж би итгэдэг. Гэтэл сүнснийхээ аавыг үл хүндэтгэсэн учраас, эдүгээ бид тэр олон хүнийг шархлуулсан эмгэнэлт явдлыг гэрчилж байна. Үүнээс зайлсхийж

болох л байсан. Бусдын амьдралд энэ эмгэнэл бүү давтагдаасай гэсэндээ л би энэ түүхийг хуваалцлаа.

Билл Бурханы Үгийг заах ер бусын бэлэгтэй хүн. Үнэндээ би түүнд өгөгдсөн илчлэлийг сонсоод, биширдэг байлаа. Биллийг таньдаг, үйлчлэл дор нь байдаг хүмүүс ч түүний заах хүчирхэг бэлгийн талаар хэлдэг байлаа. Билл сүнсний ааваа хүндэтгэсэн бол, өөрөө ч, дагалдагч нар нь ч сайн сайхан амьдрах байв.

Элч Паул “Учир нь та нар Христ дор тоо томшгүй сургагчидтай байлаа ч эцэг болох нь олонгүй. Учир нь би Христ Есүс дор сайнмэдээгээр та нарыг төрүүлсэн” (1Коринт 4:15) хэмээн мэдэгдсэн билээ. Бурхан биднийг аавыгаа үл хүндэтгэбээс, хараагдана гэж хэлснийг санах ёстой. Энэ үг нь хүний биеийн аав төдийгүй, сүнсний аавд ч хамаатай болно. Хүмүүс нэн ялангуяа сүнснийхээ аав, ээжийг зүрхэндээ жинхэнээсээ хүндэтгэж сурсан бол, үй олон эмгэнэлт үр дагавраас сэргийлэх боломжтой гэдэгт би л хувьдаа итгэдэг.

Хоёр, гурван гэрч

Намайг анх үйлчлэлд гаргаж өгсөн хүн найман мянган хүнтэй чуулганаа тэр чигээр нь алдсан юм. Пастор нь эхнэрээ залуу хүүхнээр сольсон учраас, тэр чуулган эдүгээ байхгүй болсон. Тэрбээр чуулгандаа эхнэрээсээ салах гэж байгаагаа хэлээд, үүнд дургүй байгаа бол, өөр чуулган руу явж болно гэж хэлжээ. Энэ мэдээ аймшигтай цохилт болов. Хамгийн харамсалтай нь чуулганых нь олон эр түүний мөрөөр замнаж, эхнэрүүдээсээ салсан юм.

Тэр чуулганд надтай мөр зэрэгцэн үйлчилж байсан олон хүн нөгөө хүнийг учир зүйгүй шүүмжилж эхэлсэн бөгөөд би ч бас дутсангүй. Түүнд уур, дургүй хүрч байлаа. Түүнийг сүнснийхээ аавыг хэмээн хүндэтгэх зүрхний маань хүндэтгэл үтэр түргэн буурав. Гэхдээ би тэр чуулганаас яваад таван жил болж байлаа. Тэрбээр Лиза, бид хоёрыг үйлчлэлийн шинэ байр сууринд гарган, ерөөн үдэж өгсөн бөгөөд хэдийгээр би тэр чуулганд явахгаа болиод байсан ч, би түүнд улам бүр л гутарч, уурсаж байв.

Тэгтэл би хуучин пасторынхаа талаар хоёр долоон хоногийн дотор дөрвөн зүүд зүүдэлсэн юм. Би юу зүүдэлснээ бараг санадаггүй. Тиймээс миний хувьд хоёр долоо хоногийн дотор дөрвөн удаа маш тод зүүдэлнэ гэдэг жирийн зүйл биш байлаа. Үүнийг бичихээс ичэж

байгаа хэдий ч, дөрөв дэхь удаагаа зүүдлэхдээ л, Бурхан надад ямар нэгэн зүйл хэлээд байгааг ухаарсан юм. Би Бурханд хандан залбираад “Аав аа, эдгээр зүүдээр Та надад юу хэлнэ вэ?” гэж асуулаа.

Гэтэл гэнэт нэгэн хатуу хоолой “Тэр миний зарц. Миний зарцыг шүүхээ боль!” гэж хэлэхийг сонсов.

Сүнсний минь аав байсан хуучин пастораа шүүмжлэх юмуу шүүх нь миний хийх ажил биш ажээ. Үүнийг ухаармагцаа, би гэмшээд пастораасаа уучлал гуйсан захидал бичив.

Эхнэрээсээ салаад хэдэн сар болсны дараа тэрбээр залуу хүүхэнтэй гэрлээд, төдөлгүй чуулган нь ч дөрвөн зуун хүнтэй болтлоо ширгэв. Тэрбээр чуулганаа аврах гэж оролдсон ч, чуулган нь нэг мөсөн хаалгаа барих нь цаг хугацааны л асуудал байжээ. Пастор чинь ил задгай нүгэл үйлдээд, ичэж гэмших ч үгүй бол, та чуулганаасаа явах ёстой юу? Хариулт нь: мэдээж тийм. Паул:

Садарлагчидтай холбогдож болохгүй гэж би та нарт захидалдаа бичихдээ, энэ ертөнцийн садарлагчид эсвэл шунахайрагчид эсвэл дээрэмчид эсвэл шүтээн шүтэгчидтэй холбогдож болохгүй гэж ерөөсөө хэлээгүй. Хэрэв тийм байсан бол та нар энэ ертөнцөөс гарч явах ёстой болно. Харин би та нарт, ах дүү гэж нэрлэгддэг нэг чинь садарлагч эсвэл шунахайрагч эсвэл шүтээн шүтэгч эсвэл хараалч эсвэл архичин эсвэл дээрэмчин бол тийм хүнтэй холбогдож болохгүй тухай бичсэн юм. Түүнтэй хамт хооллож ч болохгүй. (1Коринт 5:9-11) гэсэн.

Бид ёс бусаар амьдарч байгаа “Христэд итгэгч” хүнтэй ямар ч холбоо харилцаатай байж болохгүйг Паул тодорхой хэлжээ. Удирдагч маань залуу хүүхэнтэй гэрлэхийн тулд хэл амаа олоогүй гэдэг шалтгаанаар эхнэрээсээ салсан нь ёс бус үйлдэл байв. Есүс ч “Би та нарт хэлье. Хэн садар самуунаас өөр шалтгаанаар эхнэрээсээ салж, өөр эмэгтэйтэй гэрлэнэ, тэр нь завхайрсан болно” (Матай 19:9) хэмээн тодорхой хэлсэн.

Бид санаатайгаар нүгэл үйлдэгч “Христэд итгэгч” хүнтэй хооллож ч болохгүй юм бол, сүнснээс нь хүртэж бүр ч болохгүй бөгөөд ийм байдалтай хүний үйлчлэл дор байж болохгүй нь байна. Мэдээж тэрбээр гэмшбэл, дахин хүлээн авч болох юм.

Тэгэхээр та “Гэхдээ Жон, энэ чинь бас л шүүсэн хэрэг биш үү?” гэж асууж болох. Тэгвэл, энэ нь үнэндээ түүний үр жимсийг шүүж

байгаа явдал юм гэж хариулъя. Бид хүний зүрхний сэдлийг бус, харин үр жимсийг нь буюу үйлдлийг нь шүүж болно. Паул “Гадна байгсдыг шүүх хэрэг надад юунд байх билээ? Дотор байгсдыг та нар шүүдэггүй гэж үү?” (1Коринт 5:12) гэж хэлсэн.

Товчхондоо, би пасторынхаа зүрхний сэдлийг шүүж байсан болохоор л Бурхан надад зүүдээр минь дамжуулан анхааруулах хэрэгтэй болжээ. Хүний зүрхний сэдлийг гагцхүү Бурхан л шүүдэг болой. Паул:

Иймд цагаас өмнө, Эзэнийг иртэл юуг ч бүү шүүгтүн. Эзэн харанхуйд нуугдсан юмсыг гэрэлд гаргах бөгөөд зүрхний санааг (сэдлийг) илрүүлнэ. Тэгээд Бурханаас хүн бүрд магтаал ирэх болно. (1Коринт 4:5, тодруулгыг нэмэв) гэсэн.

Энэ шалтгаанаар, би пасторынхаа төлөө найдвар тээдэг.

Энэ үгийг дараах жишээгээр тодорхой болгож өгье. Би нэг удаа өөр нэгэн номлогчийн конференц дээр номлосон үгэнд үймсэн нэгэн үйлчлэгч - хүнтэй ярилцаж байлаа. Тэр найз маань надтай мөнөөх номлолын талаар утсаар ярингаа, түүний номлол дахь алдааг тодорхой заасан Бичээсийг гаргаж хэлэв. Би ч сургаалын талаар түүний хэлж байгаа бүхэнтэй санал нийллээ. (Яг энэ тал дээр өөр олон номлогч санаа зовнисон билээ) Гэхдээ нөгөө хүн маань сүүлдээ “Магадгүй тэр номлогч илүү олон том чуулган, конференц руу гаргах онцгой номлолтой байхын тулд ийм сургаал зохиосон байх” гэж хэлэв.

Би тэр даруй нөхрөө таслан зогсоогоод, “Одоо чи түүний сэдлийг шүүгээд явчихлаа. Энэ чинь буруу шүү дээ” гэж хэлсэн юм.

Би түүнд хүний хэлсэн үг, хийсэн үйлдлийг буюу үр жимсийг шүүж болох ч (тэр тохиолдол дээр номлогчийн сургаалыг шүүж дүгнэх), сэдлийг нь шүүж болохгүй, үүнийг гагцхүү Бурхан л хийнэ гэж хэлэв. Гэтэл би хуучин пасторынхаа сэдлийг шүүсэн учраас, Бурхан надад хатуу анхааруулжээ.

Пасторыг залуу хүүхэнтэй гэрлэсэн хойно ч удирдлага дор нь үлдсэн дөрвөн зуун хүн туйлын завхарсан нөхцөлд оров. Тэдний үнэнч байдал ч бичээсийн бус байсан юм. Тэд Ариун Сүнсний бус, буруу сүнсний уур амьсгал дор байжээ.

Хуучин пастор маань гэмшээгүй ч, би түүнийг өдий хэр нь хүндэтгэж явдаг. (Эдүгээ тэрбээр гурав дахь эхнэртэйгээ амьдарч байгаа) Пастор үйлчилж байсан бол, би түүний үйлчлэл дор байхгүй ч, насан турш

чин зүрхнээсээ л хүндэтгэж явна. Бурхан Саулыг шүүчихээд байхад ч, Давид түүнд зориулан хайр хүндэтгэлийн дуу дуулж, Иудагийн эрчүүдээр ч дуулуулан хүндэтгэсээр байсныг санаарай.

Хуучин пастор маань өнөөдөр надаас тусламж хүсбэл, би аль чадлаараа, аль хурдаараа л тусална. Тэрбээр надад өнөөдөр ч ач тусыг нь эдэлсээр яваа, Бурханы Үгийн олон гайхамшигт үнэнийг зааж өгсөн билээ. Хэн ч надад итгэхгүй байхад, тэр хүн л надад итгэж, боломж олгосон. Намайг шал түүхий, ногооноороо баахан алдаа хийж явахад, тэр хүн л намайг уучилж, урамшуулж байсан. Би түүнийг үргэлж хүндэтгэнэ. Бусдад туслах үүднээс үүнийг бичиж байхдаа ч, тэр хүний хийсэн сонголтын хор уршигт зовиурт өртсөн хүмүүсийн төлөө зүрх өвдөж байна. Тэр хүн гэмшиж, буцаад нэгэн цагт мандаж явсан тэр аугаа удирдагч болоосой хэмээн найдна. Бурханы найдвар нь бүгдийг далдалдаг, бүгдэд итгэдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг (1Коринт 13:7) гэдэг шүү дээ.

Нөгөө талаас, өнөөдөр олон хүн пастор нь нүгэл үйлдэж байна гэдэг цуурхлаар цуглаанаа хаяж явдаг. Ингэж болохгүйг мянгантаа хэлье! Бид цуурхалд итгэж үл болно. Бидэнд “Хоёр, эсвэл гурван гэрч байхгүй л бол ахлагчийн эсрэг буруутгалыг бүү хүлээж ав” (1Тимот 5:19) гэсэн.

Гэрч гэдэг нь шүүхийн танхимд ч батлагдах хөдлөшгүй нотолгоотой хүн юм. Хуйвалдсан хоёр хүний юмуу эсвэл бүр цуурхал дэгдээгч хэд хэдэн хүний үг бус, харин тус тусдаа бие даасан нотолгоотой хоёр юмуу гурван хүний үг шүү. Паул яагаад үүнийг бичих болов? Биднийг л хамгаалах гэж тэр.

Бодоод үз. Хэрэв бид удирдагчийнхаа талаарх цуурхалд итгэбэл, энэ маань сэжигт болоод бүрхэг итгэлд үүд нээж өгнө. Тэр үед зүрхэнд маань үл хүндэтгэл амархан нэвтэрнэ. Бид удирдагчаа үл хүндэтгэбэл, тэр удирдагчаар маань дамжуулан Бурханы бидэнд өгөх шагналыг хүлээн авч чадахааргүй болно. Тиймээс л Барууны үй олон хүн Бурханаар ерөөгдөх гэж зүдэрдэг. Манай энэ үед үйлчлэлийн талбарт үй олон самуунтай явдал гарсан нь олон хүний зүрхэнд хар сэр цутгажээ. Өнөөдөр чуулганд олон хүн цөхрөхөөр барахгүй, хүндэтгэлийг огт бойжуулахгүй хандлагыг хөгжүүлэн, эрээ цээрээ алдаж байна. Биднийг хойш чангааж, тэнгэрийн суваг болох Бурханы удирдагч нараар дамжин ерөөгдөхөөс хорих нь мэдээж дайсны л атгаг явуулга.

Елигийн ховдог, сувдаг амьдрал хожим илчлэгдэж, шүүх буух байсан ч, Ханна түүгээр ерөөгдөж чадсан. Ели дорд зангаараа

өөрийг нь “согтуу хөлчүүгээр” нь дуудаад байхад ч, Ханна эрээ цээргүй хандлагаас зүрхээ чөлөөтэй байлгасан. Ханна хариу урвал үзүүлэлгүй, харин үйлдэл үзүүлжээ. Өнөөдөр олон хүн бүтэлгүйтсэн үйлчлэлийнхээ шархныхаа халуунд хариу урвал үзүүлдэг бөгөөд үүнийх нь хөлд манай Барууны зарим удирдагч нар үрэгддэг.

Энэ олон жилийн үйлчлэлийнхээ хугацаанд би удирдагч нарын талаар олон сөрөг мэдээ сонсож явсан ч, зүрхэнд минь үндэслэсэн 1Тимотын бичээсээр амьдралаа залдаг. Мэдээ нь ганц хүнээс юмуу хоёр хүнээс байсан ч, баттай нотолгоогүй бол, би огт авч хэлэлцдэггүй. Надад тэр мэдээнд итгэж байгаа, дор хаяж хоёр хүний хоорондоо холбоогүй нотолгоо хэрэгтэй. Хэрэв би эдгээр мэдээлэлд ач холбогдол өгөөд унабал, тэнгэрээс хүлээж авах өөрийнхөө чадварыг боогдуулна. Удирдагч нар бүгдээрээ тэнгэрийн шагналтай. Би л хувьдаа Бурханы надад зэхсэн шагналыг алдмааргүй байна. Та ч гэсэн адилхан байх аа.

Спектрийн нөгөө үзүүр

Би спектрийн нөгөө үзүүрийг харснаараа, чуулган дахь олон хүн удирдагч нараа хүндэтгэж, хамаг зүрхээрээ хайрлаж, зориулагддаг болохыг мэдсэн бөгөөд үүнд ч жигтэйхэн хайртай байдаг. Тэдгээрийн зарим нь ажилчид, зарим нь туслах пасторууд, зарим нь чуулганы жирийн гишүүд юмуу тухайн үйлчлэлийн түншүүд байдаг.

Он жилийн явцад Бурхан энэ хүмүүсийг өргөж байгааг харах юутай сайхан. Заримдаа тэд үүрэг хариуцлагын шатаар огцом ахидаггүй, үтэр түргэн тушаал дэвшдэггүй ч, арав, хорь, гучин, тэр бүү хэл дөчин жилийн өндөрлөгөөс эргэж харахад, амьдрал нь сайн сайхан замаар тууштай бөгөөд баттай өөдлөн дэгжсэн байдаг.

Түрүүн миний өгүүлсэн, хуучин пасторт маань олон хүн хилэгнэж, хүндэтгэлгүй хандлагатай болсныг би санаж байна. Тэд шүүмжилсэн бөгөөд эцэстээ эмгэнэлтэй үр дагавар үзсэн. Зарим нь салсан, заримынх нь үр хүүхдэд аймшигтай явдал тохиолдсон, зарим нь санхүүгээр дампуурсан. Зарим нь байдлыг гартаа аваад, чуулган эхлүүлсэн боловч, олон жилийн хүч хөдөлмөрийн эцэст ч чуулган нь хөгжин цэцэглэсэнгүй.

Зарим нэг аймшигтай хүнд жишээ ч бий: Надтай хамт ажилладаг байсан нэг эмэгтэй зурагтаар манай нөгөө чуулганаа тэр чигээр нь алдсан, хуучин пасторыг муучилж ярьсан юм. Тэр эмэгтэй уг

нь цоо эрүүл байдаг байсан ч, хоёрхон сарын дараа тархины хүнд аневризмээр нас барж билээ. Тохиолдол гэж үү? Бурхан л мэдэх байх. Гэхдээ би, олон итгэгч Эзэний биеийг шүүвэрлэн тунгаагаагүйн улмаас “та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна (цаг бусаар нас барсан)” (1Коринт 11:30, хашилтан доторх үгийг нэмэв) гэж Паул хэлсэн байдгийг мэднэ. Паул үүнийгээ Эзэний зоогтой холбож хэлсэн. Гэхдээ зарчим нь Христэч амьдралын бусад талбарт ч хэрэгжих буюу. Эзэний биеийг шүүвэрлэн тунгаана гэдэг нь усан үзмийн шүүс, гамбир идэхээс гүн утга агуулгатай шүү.

Нөгөөтэйгүүр, хуучин пасторын маань хийсэн хэргээр үйлээ үзсэн ч, Давид шиг л хайрын зүрхээ хадгалсаар, хүндэтгэсээр байсан олон эрчүүд эмэгтэйчүүд өнөөдөр амжилттай явна! Тэд үйлчлэл, бизнес, амьдралдаа хөгжин цэцэглэж явна. Гэрлэлт нь бат бэх, үр хүүхэд нь Бурханыг хайрлан, хөгжин цэцэглэсээр. Тэд хүндэтгэлтэй, үнэнчээр явсан тул баян, баялаг бүтэн амьдарсан. Тэд зүрхээ хамгаалж, амаа хянажээ. Тэд Бурханы бахыг хангав.

Бурханы бидэнд хүсэх сайн сайхан амьдралыг хүсэхгүй хүн бий гэж үү? Шүүмжтэй, эрээ цээргүй юмуу хар сэртэй байх тийм хэрэгтэй гэж үү? Үүний үр жимс гэж юу байна аа? Өдий насалсан миний бие - удирдагч маань надад яаж ч хандаж байсан - ийм хандлагатай холбогдохыг хэзээ ч хүсэхгүй. Ямар ч хэрэггүй шүү дээ. Гэхдээ хамгийн гол шалтгаан нь: “Библи дээр удирдагчаа хүндэтгэсэн хүмүүс нь ямагт Бурханы зүрхийг дэрлэдэг хүмүүс байдаг. Тиймээс миний л хувьд, Бурханы зүрхийг мэдэж, Түүнтэй нөхөрлөх шиг өндөр шагнал, аугаа зүйл амьдралд үгүй.

Давхар хүндэтгэл

Сайн удирдаж байгаа ахлагчид, ялангуяа үг ба сургаалд зүдэн зүтгэж буй нь давхар хүндэтгэл авах зохистой хэмээн үз. Учир нь Бичвэр “Тариа цайруулж байгаа үхэрт хошуувч бүү хий”, “Ажилчин хөлсөө авах нь зохистой”. (1Тимот 5:17-18)

Энэ нь эрх мэдэлтэй уялдуулан давхар хүндэтгэлийн талаар өгүүлсэн Бичээсийн цорын ганц хэсэг. Бид Сайн мэдээний үйлчлэгч нарт бусад үйлчлэгч нарт өгдгөөсөө хоёр дахин хүндэтгэлийг өгөх ёстой аж.

Үүнийг амьдрал дээр хэрхэн хийх вэ? Христэд итгэдэг удирдагч нарт хандах үйлдэл, яриа маань туйлын хүндэтгэлийг тээх ёстой юм. Тэд өөрсдөө л дургүйцэхгүй бол, бид тэднийг албан ёсоор “Пастор, Эрхэм, Ноёнтон, Хатагтай” гэх зэргээр хүндэтгэж дуудах ёстой. Ярьж байхдаа, нүд рүү нь харж, тэднийг бидэнд хандан ярьж дуустал нь яваад өгч болохгүй.

Удирдагч хүн Үгийг зааж байхад нь бид анхааралтай сонсох ёстой. Бодол санаагаараа тэнүүлчлэх нь үл хүндэтгэсэн хэрэг юм. Хүндэтгэл нь дан ганц үйлдэл, үгээр бус, харин бодлоор нь харагддаг. Тиймээс л Паул “Намайг очтол Бичвэрийн уншлага, ятгалга ба сургаалдаа анхаар” (1Тимот 4:13) хэмээн биднийг сэнхрүүлжээ.

Номлолын цагаар дэргэдэх хүнтэйгээ ярих нь Ариун Сүнсний төдийгүй, номлогчийг үл хүндэтгэсэн хэрэг. Цуглаан дуустал хувийн харилцаагаа хойш тавих хэрэгтэй. Түүнчлэн нэт орж, найзуудтайгаа

чааталж, утсаа оролдож, цуглаан дуусаагүй байхад гарч явж болохгүй. Бид цуглаандаа хоцорч ирж болохгүй. Хэрэв бид ажилдаа өдөр бүр 15 минут хоцорч ирээд байвал, яах уу? Бид хэзээ ч ингэхгүй. Тэгвэл яагаад удирдагч нарынхаа тогтоосон цуглааны цагт яг адил хандахгүй байна вэ?

Бид гуйлгаж гувшуулалгүйгээр удирдагч нартаа үйлчлэх замыг хайх хэрэгтэй. Тэднээс өмнө төлөвлө. Тэгээд төлөвлөөгүй саадад бэлэн бай. Юмсыг ямагт илүү өндөр жишгээр, илүү сайн сайхан хийхийн төлөө тэмүүлэх ёстой. Бид удирдагч нараа төлөөлөхдөө, хийж байгаа бүх зүйлдээ онцсайн чанарын төлөө зүтгэх ёстой.

Удирдагч чинь танд ойр зуурын ажил даалгасан бол, нухацтай хандан, онцсайн гүйцэтгэ. Хааш яаш бүү хувцасла, унаа тэргээ цэмбэгэр авч яв. Удирдагчаа нэр төртэй төлөөл. Зарим газар намайг хог новшоор дүүрсэн машинаар онгоцны буудлаас тосч л байлаа. Тэр үед дотроо *“Гишүүн нь зочноо ийм янзаар тосч авч байгааг мэдбэл, энэ үйлчлэлийн тэргүүнд ямар байх бол? Энэ хүн намайг төдийгүй, намайг тосч авахыг хүссэн пастораа ч үл хүндэтгэв”* гэж бодно.

Лиза, бид хоёр тавь гаруй маш мундаг ажилчидтай. Тэдний бидэнд хандаж байгаа хандлага намайг бишрүүлдэг. Намайг ажлын өрөөндөө орж ирэх үед ширээн дээр маань заавал аяга цэвэр ус байж байдаг. Намайг анзаараагүй байхад, тэд машины маань түлхүүрийг бэлэн байлгаж, шатахуун маань дуусаагүй байхад ч, шатахуунаар дүүргэчихнэ. Дээрээс нь ямагт цэвэр цэмцгэр байлгана. Олон жил надад албан газрынхаа гадна машинаа байршуулах тогтсон зогсоол байгаагүй ч, ажилчид маань Лиза, бид хоёрыг явах үед хаалганд хамгийн дөт зогсоолыг ямагт олоод л байршуулчихдаг.

Тэд намайг ажилдаа ирэхэд юмуу хурлын танхимд ороход босч угтдаг бас *“Эрхэм ээ”* гэж дууддаг. Тэд аливаа асуудлыг баттай судалж байж л надад танилцуулна.

Тэд миний зүгээс асуулт ирнэ гэдгийг мэдэж, хариултыг нь урьдаас бэлтгэнэ. Миний аливаа хүсэлтийг үтэр түргэн гүйцэтгэдэг бөгөөд ажлыг гүйцэтгэх нэг арга нь бүтэлгүйтэх юм бол, ажлаа хийж дуусгатлаа гүйдэг. Гагцхүү биелүүлэх бүр ямар ч боломжгүй нөхцөлд л гүйцэтгэхгүй. Гэхдээ тэд энэ тухай надад мэдэгдэхээсээ өмнө байж болох бүхий л арга замаар оролдож, анхны хүсэлтээс маань өөр боломжийг ч гаргаж ирнэ.

Тэдний бидэнд үзүүлдэг хүндэтгэл нь зорилготой бөгөөд хүчтэй байдаг. Би ч толгой дотроо энэ хүндэтгэлд хөлчүүрхэхээсээ өмнө

нэгдүгээрт - тэд намайг хүндэтгэснээрээ, Есүсийг хүндэтгэж байгааг санадаг. Хоёрдугаарт - би тэдний хүлээж авах шагналыг мэдэхийн дээдээр мэднэ. Гуравдугаарт - тэд яагаад бидэнд үйлчилж байгааг би санадаг. Тэд биднийг даалгавраасаа сарниж, хэрэгтэй хэрэггүй зүйлст эрч хүчээ тарамдуулахаас сэргийлсэндээ үйлчилдэг. Лиза, бид хоёр Бурханы дуудлага дээр төвлөрөх тусмаа л илүү олон хүнд хүрнэ. Энэ бүхэн чинь хаанчлалд үйлчлэх утга агуулгатай бөгөөд бид бие биеэ хүндэтгэхдээ (ажилчдаа хэрхэн хүндэтгэх талаар дараа дараагийн бүлгээрээ өгүүлнэ), хүн бүр Бурханд илүү тааламжтай байх болно.

Лиза, бид хоёр хүндэтгүүлэх гэсэндээ биш. Учир нь хүндэтгэлийг шахан шаардах нь Бурханы зүрхнээс хальтирсан хэрэг юм. Есүс ч “Би хүмүүсээс алдар хүндийг авдаггүй” (Иохан 5:41) хэмээн айлдсан. Есүс ааваараа л хүндэтгүүлэхийг хүссэн. Тэрбээр “Та нар цорын ганц Бурханаас алдрыг хайдаггүй атлаа бие биенээсээ алдрыг хүлээн авдаг. Тийм байж яаж итгэж чадах юм бэ?” (Иохан 5:44) хэмээн айлдсанаараа, тухайн үеийнхээ удирдагч нарыг зэмлэсэн байдаг. Эдгээр удирдагч нар аминч хүсэл, бардамнал, хянан захиргаадагч зан чанараа цатгахын төлөө хүний магтаал, хүндэтгэлийг хайжээ. Тэгвэл Есүс нэгдүгээрт - Аавынхаа төлөө, хоёрдугаарт - эрчүүд, эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь төлөө хүний хүндэтгэлийг хүлээн авсан билээ.

Итгэгч бид ч бас бидэнд өгч байгаа хүндэтгэл нь зүрхээр маань дамжин Есүс, Аав хоёрт очих ёстой бөгөөд бид хүндэтгэл үзүүлж байгаа тэр хүмүүсийн төлөө баярлах ёстой юм. Биднийг хүндэтгэж байгаа хүмүүсийг эргээд Аав хүндэтгэх бөгөөд шагнахыг бид сайн мэднэ. Би энэ санааг яаж хангалттай сайн цохон тэмдэглэхээ мэдэхгүй байна: та хэн ч байлаа гэсэн - ямар нэгэн шалтгаанаар хүндэтгэл хүлээхийг хүсч байгаа бол, бурханлаг байдал, амь руу аваачихгүй замаар уруудаж яваа ажээ.

Хоёр дахин их мөнгө

Сайн мэдээний үйлчлэгч нарыг “давхар хүндэтгэх” тал дээр би олон төрлийн жишээ хэлж чадна. Гэхдээ, 1Тимот 5:17-18 дээр элч Паулаар дамжуулан Ариун Сүнсний айлдсан тодорхой зүйлийн талаар хараахан яриагүй байна. Цааш нь уншбал, тэрбээр үнэндээ санхүүгийн талаар өгүүлж байгааг нь олж мэднэ. Паул “Сайн удирдаж байгаа ахлагчид, ялангуяа үг ба сургаалд зүдэн зүтгэж буй нь давхар хүндэтгэл авах

зохистой хэмээн үз” гэжээ. Нью Ливинг Транслэйшн дээр “Ажлаа сайн хийдэг ахлахууд сайн цалин авах хэрэгтэй” гэдэг. Орчин цагийн Англи хувилбар дээр “Ажлаа сайн хийдэг чуулганы удирдагч нар нэн ялангуяа номлох бөгөөд заах дээрээ нөр их хөдөлмөрлөж байгаа бол, хоёр дахин их цалин авах зохистой” гэдэг. Гүүд Ньюс Вержн дээр “Удирдагчийн ажлаа сайн хийж байгаа ахлахууд хоёр дахин цалин авах зохистойд тооцогдох ёстой” гэдэг. Эцэст нь Амплифайд Библи дээр үүргээ сайн гүйцэтгэдэг ахлахуудыг “хангалттай санхүүгийн дэмжлэгт” зохистой гэж тооцох” гэжээ.

Энэ сүнсний зарчмыг дагалдагч нартаа хэлсэн Есүсийн үгээс ч харж болно: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний илгээх хэнийг боловч *хүндэтгэж* буй нь Намайг *хүндэтгэдэг*. Намайг *хүндэтгэдэг* нь Намайг Илгээгчийг хүндэтгэдэг” (Иохан 13:20, хүлээн авдаг гэдэг үгийг *хүндэтгэдэг* гэдэг үгээр орлуулав) *Миний илгээх* гэдэг үгийг тэмдэглээрэй. Есүс үүнийг Өөр дээрээ тусган хувьчлан авч үзэж байгааг харж байгаа биз? Түүнчлэн Паул ч яг ийм байдлаар таван талт үйлчлэлийг захирамжлагдаж, илгээгдсэн болохыг дүрсэлснийг харж болно:

(Тийнхүү Түүний (Есүс Христийн) бэлэг инү (төрөлжсөн; Тэрбээр Өөрийн биеэр эрчүүдийг тохоон томилоод, бидэнд өгсөн) заримыг нь элч нар (онцгой мэдээ дамжуулагч нар), заримыг нь эш үзүүлэгч (онгодтой номлогч ба тайлбарлагч), заримыг нь Сайн мэдээ дэлгэрүүлэгч нар (Сайн мэдээний номлогч нар, аялагч илгээлтийн эзэд), заримыг нь пасторууд (Түүний сүргийн хоньчид) болоод багш нар болгох байв. (Ефес 4:11, ЭйЭмПиСи Библи)

“Тэрбээр Өөрийн биеэр” гэдэг үгийг нь тэмдэглэнэ үү. Есүс таван талт үйлчлэлийг Өөрийн биеэр өгдөг. “Сайн удирдаж байгаа ахлагчид, ялангуяа үг ба сургаалд зүдэн зүтгэж буй нь” (1Тимот 5:17) Христийн бие доторх ахлахууд юм. Бурхан тэдэнд “хоёр дахин ихийг” төлж хүндэтгэхийг онцгойлон мэдэгджээ.

Гучин тав гаруй жил аялахдаа, миний бие энэ тушаалыг үл хэрэгсэх нөхцөл гэж байдгийг үзээгүй. Пастор, туслах пастортаа хариугүй цалин өгдөг чуулгануудыг би үзсэн. Гэтэл чуулганых нь олон гишүүн сайхан байранд амьдарч, гоё машин унаж, хүүхдүүд нь үнэтэй сургуульд сурах гэх зэргээр амьдардаг. Хамгийн хоржоонтой нь: гишүүдийнх

нь санхүүгийн нөхцлийг судлаад үзбэл, дийлэнх нь энэ тал дээрээ зөрчилдөж байдаг. Бизнес эрхэлдэг эрчүүд, хүүхнүүд байнга л ухраанд орж, зарим нь бүр урт хугацааны алдагдалд орно. Үр дүнд нь олонх нь хоолойгоо давсан их өртэй болно. Гэр бүлд нь байс хийгээд л хамаг нөөц санг нь хоосолсон асуудал тулгарна. Тэдэнд бусдынхаа хэрэгцээнд туслах илүү мөнгө байхгүй. Энэ бүхэн урирдагчдаа сайн цалин өгөх тушаалыг үл тоосны үр дүн байж болох уу?

Бүгдээрээ яриагаа лавшруулъя л даа. Пастор, туслах пастортаа дөмөгхөн өгдөг чуулгануудыг ч би бас үзсэн. Чуулганых нь хүмүүс үйлчлэгч нарынхаа төлөө байнга онцгой юм хийнэ: тухай нь, бэлэг авч өгөх, сайхан хоолонд урих зэрэг янз бүрийн сайн сайхан юмс хийж өгнө. Тэдгээр чуулганы гэр бүлүүдийг ажихад, хэрэв тэд тодорхой хугацаанд чуулгандаа суулгагдсан бол, ерөнхийдөө хөгжин цэцэглэсэн, амжилттай амьдарч байдаг. Бизнес хийдэг эрчүүд, хүүхнүүд нь байн байн амжилттай ажил гүйцэтгэж, улам л дэгжин дээшилсээр байдаг. Нөөц сантай учраас, бэлбэсэн, өнчин, өрх толгойлсон ээжүүд, гачигдаж дутагдсан гэр бүлүүдэд уриалгахнаар тусална. Ерөнхийд нь дүгнэбэл, энэ чуулган өмнөх чуулганаа бодбол, сайн мэдээнд ч, илгээлтийн ажилд ч хавьгүй илүү өгөх чадалтай байна. Үүнээс өөрөөр байх аргагүй. Үүнд гайхах ч хэрэггүй. Энэ бүхэн нь хүндэтгэлийн зарчмаар л тогтоогдоно.

Бодоод үз. Миний өгүүлсэн эхний төрлийн чуулган пастор, туслахуудад их хэмжээний цалин өгч, санхүүгээ үрэн таран хийгээгүй хэмээн сайрхана. Үүгээрээ хаанчлалын төлөө бүр ихийг хийж чадна гэсэн сэтгэлгээтэй: илгээлтэд өгнө, ядууст тусална гэх мэт. Гэхдээ, ахлахууддаа сайн цалин өг гэсэн Бурханы тушаалыг огоорсных нь гороор зөрчилдөж байгаа бизнесээсээ болоод олигтой орлого олохгүй учраас, бусад чуулгануудтай адил ихийг өргөж чадахгүй. Амжилтанд хүргэх зам нь Бурханы зарчим гэдгийг бид хэзээ ойлгох вэ? Бурханы төлөө өөрийнхөө хүчээр илүү ихийг хийж чадна хэмээн итгэсэндээ, Бурханы заасан Үгээр үйлдэхээс хойш суугаад байх нь үнэндээ хуурамч даруу зан буюу бардамнал юм. Бурхан ядууст хайртай атлаа нөгөөтэйгүүр Түүний Үгд хүчин зүтгэж байгаа хүмүүст хоёр дахин ихийг төлөх гэж хэлсэн тул бид шууд бус замаар өөрийгөө Бурханаас илүү мэднэ гэдгээ л хэлээд байгаа юм.

Гэтэл бас энэ үнэнийг нэн ялангуяа Америк дахь үйлчлэгчийн нарын багахан хувь туйлшруулж байгааг би мэднэ. Удирдагч нар байнга мөнгөний талаар, эд материалын талаар ярихаар би гашууддаг.

Тэд хахаж сагасан амьдралаар амьдарч, алдагдсан хүмүүс, шархалсан сүнсний төлөө явахаасаа илүү улам бүр л амьдралын зугаа цэнгэл, цаг зуурын юмс дээр төвлөрдөг. Тэд Бурханы зүрхний цохилтыг мэдрэхээ больж, хөлсний ажилчдын эгнээнд элсжээ. Тийнхүү тэдний номлол нь далийж, үр нөлөөгөө алджээ. Ийм удирдагч нарын талаар Бурхан юу айлдсаныг үзнэ үү:

Харуулууд нь сохор, Тэд бүгд юу ч мэдэхгүй. Тэд бүгд унтаж хэвтдэг, Зүүрмэглэх дуртай, хуцах чадваргүй хэлгүй ноход юм. Тэд цадахаа мэддэггүй, шуналтай ноход. Тэд ухаангүй хоньчид. Тэд бүгд өөр өөрсдийн мөрөө хөөн Хүн бүр шударга бус олзоо, эцсийн ашгаа эрнэ (Исаиа 56:10-11).

“Хүн бүр өөр өөрийн... ашгаа эрнэ” гэдэг үгийг тэмдэглэнэ үү. СийИВи дээр “Та нар амин хувийнхаа ашгийн төлөө өөрийнхөө хоньдод зүй бус ханддаг хоньчид” гэсэн байдаг. Хувийнхаа тааллын төлөө чуулганы эмэгтэйчүүд, үйлчлэлд зориулагдсан мөнгө, эд хэрэгслийг хэрэглэсэн удирдагч нар бий. (цөөхөн гэдэг нь сайхан юм даа) Тэд хүндэтгэлийн зарчмын энэ үнэнийг аваад, шал завхруулж орхидог. Тэгээд харанхуй сэтгэлгээтэй болно - бүхий л зорилгыг нь урвуу харуулаад, үйлчлэлийг өөрийнхөө төлөө болгож орхих. Тэд Бурханы хүмүүст зохистойгоор үйлчилж, төөрөгдөд хүрэх үйлчлэлийн жинхэнэ төвлөрлөөс нүүжээ. Өөрчлөгдөхгүй аваас, эцэс нь тун харанхуй байх буюу.

Тийм ээ, үйлчлэлийн олон зуун жилийн түүхнээ ч, Библийн түүхнээ ч хүндэтгэлийн зарчмыг завхруулах явдал гарч байсан ч, энэ завхрал биднийг Бурханы зарц нарт санхүүгийн давхар хүндэтгэл өргөөрэй гэсэн бичээсийн тушаалаас холдоход хүргэх ёстой юу гэж асуу. Хоёр буруу Бурханы мэлмийд хэзээ ч зөвийг бүтээхгүй.

Гайхамшигт эргэлт

Аялан үйлчлэлийн маань эхэн дээр тохиолдсон нэгэн түүх чуулганы удирдагчаас санхүүгийн хүндэтгэлийг харамлахын үр дагаврыг надад тодорхой гэгч нь харуулж билээ. Гэргий, бид хоёр 120 орчим хүнтэй нэгэн чуулганд үйлчлэхээр давхисаар ирсэн юм. Тэр чуулган олон жил болсон ч, гишүүд нь 35-120 хүний хооронд л хэлбэлздэг байжээ.

Тэд нийгэмдээ үр нөлөөтэй хүрэх шинэ төвшин рүү цөмөлж гарч чадахгүй байв. Гэтэл эргэн тойронд нь 250,000 гаруй хүн аж төрнө.

Бид ч дөрвөн өдрийн цуглаан хийх хуваарьтай байлаа. Пастор нь биднийг зочид буудалд байлгах гэхээр чуулганы санхүүд хүндрэлтэй байгаа тул манай гэрт байрлаач гэж хүсэв. Бид ч тэдэнтэй аялан үйлчлэл эхлүүлэхээсээ өмнө олон жил нөхөрлөсөн учраас, зөвшөөрлөө.

Бид Хагас сайны шөнө ирэхдээ, тэр хос хаусанд биш, хоёр давхар байшин түрээсэлж амьдардгийг мэдэв. Машин нь ч хуучин, эд хогшил ч гэх юмгүй. Гэхдээ биднийг байгаагаараа л зочлов. Тэр хоёр маш зөөлөн, халуун сэтгэлтэй хүмүүс бөгөөд эхнэр нь зочломтгой гэж жигтэйхэн. Тэгээд би гэргийг нь агаарын тээврийн томоохон компанид үйлчлэгчийн ажлаа хийсээр байгааг нь сонсоод, жаахан гайхав. Тэрбээр сарын 15-18 өдөр нь гэрээсээ эзгүй байдаг аж.

Цуглаан сайн болсон ч, уур амьсгалд нэг юм тороод байлаа. Бурханы оршихуй, хүч, тосолгоо нэг л цүл пал хийтэл сад тавихгүй байв. Тэнгэрийн урсгалд нэгээхэн саад тороод байх шиг л. Чуулганы хүмүүс ч зүрх сэтгэлээсээ л хандаж, олон хүн Бурханыг үнэн голоосоо хайрлаж байв. Би учрыг нь олж ядаж байлаа.

Цуглааны гурав дахь өдөр би нилээд залбирав. Сүнс минь зовниж, би ч гэвж хаях ёстой асуудлыг олж зааж чадахгүй байлаа. Залбирч байхад, тэр пастор гэр бүлийнхээ хүнтэй санхүүгийн ямар их гачигдалд байгаа нь бодогдсоор байв. Тэгж тэгж Бурханы “Өнөө орой чи энэ асуудлыг шийдвэрлэх ёстой” хэмээн айлдахыг сонссон юм.

Би ч хэрхэн хийхийг асуутал, энэ саадыг эвдэхын тулд хүмүүст пастораа санхүүгээр ерөөх нь хичнээн чухал болохыг зааж өгөх гэдгийг Бурхан илчлэв. Тэгээд би зөвхөн тэдэнд зориулж өргөл авах ёстой гэдгийг баттай мэдэрсэн юм. Гэхдээ яг хэрхэн хийхээ сайн мэдэхгүй л байлаа.

Үдээс хойш нь пастор надад “Жон, өнөө орой би танай үйлчлэлд зориулж өргөл авна. Чамайг удирдаасай гэж хүсч байна” гэв.

Би ч үүд нээгдэхийг ойлгоод, инээмсэглэлээ. Үйлчлэлийнхээ төлөө өргөл авахын оронд, тэр пасторын гэр бүлийн төлөө өргөл авъя. Тэгээд тэр орой пастор намайг танилцуулж, намайг тайзан дээр гарах үед пастор надад “Жон, өргөлийн цаг чиний бүрэн мэдэлд шүү” хэмээн шивэгнэв.

Би ч мишээгээд л өнгөрлөө. Миний үйлдэл түүнийг ангайлна гэдгийг мэдэж байв. Би индрийн ард зогсоод, чуулганаас Библиэ нээгээд, 1Тимот 5:17-г гаргахыг хүслээ. Тэгээд дөчин таван минутын турш пастораа санхүүгээр халамжлах нь ямар чухал болохыг заав.

Элдэв чимэггүй хэлбэл, би тэр чуулганыг хатуу зассан юм. Нэг удаа бүр “Танай пасторын гэргий яагаад хагас сар аялсаар байна вэ? Энэ гэр бүлийн хоёр хангалттай санхүү мөнгөтэй байж, эхнэр нь гэртээ байж, нөхрийнхөө дэргэд ажиллах ёстой” гээд хэлээд тавьчихав.

Пасторын нүүр улайсаар, улайсаар, энэ үнэн түүнийг тэвдүүлж байлаа. Хүмүүс тэр л намайг хатган, ийм юм хэлүүлж байна гэж бодоод, олон гэр бүл орхиод явчих бий гэхээс пастор айжээ. (Нэг зүйлийг тодорхой хэлье. Аливаа чуулганы удирдагч нь миний үгтэй санал нийлэхгүй тохиолдолд би хэзээ ч тэр чуулганд суурь доктрин бус санаа заахгүй. Гэхдээ тэр үед би мэддэггүй байв. Зүгээр л номлол өрнөх явцад, пасторын нүүрэн дээр зовнил тодрохыг л анзаарсан юм)

Тэр орой зүрхэнд маань Бурханы суулгасан үгийг тэр чуулган баяртайгаар залгилсныг би баттай хэлж чадна. Номнолынхоо төгсгөлд би “Өнөө орой намайг манай үйлчлэлд зориулсан өргөл аваарай гэсэн. Гэхдээ бид тэгэхгүй. Өнөө оройны өргөл танай пасторын гэр бүлд зориулагдана. Дашрамд энэ өргөлөөс татвар авахгүй шүү. Би та бүхнийг Бурханаас ирсэн бэлэг болох пастортаа талархах талархлаа харуулаасай гэж хүсч байна” гэж мэдэгдэв.

Бид өргөлөө аваад, цуглаан дууслаа. Цуглааны дараа намайг хэд хэдэн хүнтэй уг солих хооронд пастор маань сэм өрөө рүүгээ зугтчихжээ. Би ч түүнийг танхимаас явсныг мэдмэгцээ, араас нь явлаа. Түүнтэй уулзах үед нүүр нь улайхаа болиод, цайсан байхыг үзэв. Би ч сайн мэдээ дуулахаа ойлгосон юм. Тэгээд мушигнаад “Өргөл хэр байв?” гэж асуулаа.

Пастор надад тоог нь хэлэв. Би ч ойчих дөхөв. Бүтэн сайны хамгийн том цуглааны өргөлөөс даруй гурав дахин их тоо байлаа. Энэ тун сайн гэдгийг би мэдэж байсан ч, дараа дараагийн мэдээ нь тэр хэмжээний цуглааны чадлаас хол давсан мэдээ байлаа.

Ирэх Нэг дэхь өдөр нь пастор над руу залгав. Тэгээд хөөрсөн дуугаар “Жон, би чамд Бүтэн сайны цуглааны бичлэгийг явуулъя” гэлээ.

Би ч ийм огцом үгэнд хэсэг барьц алдсанаа “За, би чиний өчигдрийн номлолыг сонсъё л доо” гэлээ.

Гэтэл пастор “Жон, би юу ч номлоогүй ээ. Чуулганы маань гишүүд бүтэн хоёр цагийн турш тайзан дээр уралдаж гарч ирээд л, энэ долоо хоногт гэр, бизнест нь санхүүгийн ямар, ямар гайхамшиг тохиолдсоныг гэрчилсэн. Би биширсэн хэдий ч, огт гайхаагүй. Бурхан гайхамшигтай ажлаа хийнэ гэдгийг нь мэдэж байсан ч, ийм хурдан хийх юм чинээ санаагүй шүү” гэж хариулав.

Гурван жилийн дараа би тэр чуулганд дахин зочилсон юм. Тэд дэлгүүрийн танхимд цуглахаа болиод, ахлах сургуулийн байрыг засаад, нүүж оржээ. Энэ юу ч биш. Тэд ахлах сургуулийн байрыг түрээслээгүй, харин худалдаад авчээ! Чуулган нь ч тав дахин өссөн байна. Пасторыгаа ч санхүүгээр хүндэтгэх болсон учраас, гэргий нь ажлаасаа гарчээ. Үүнийх нь үр дүнд чуулганых нь гэр бүл, бизнесүүд ч хөгжин цэцэглэжээ.

“Дуртай байгаагаа хэлэхээ больсон”

Үнэн. Бид удирдагчаа санхүүгээр хүндэтгэбэл, өөрийн маань амьдрал л цэцэглэнэ. Би Өмнөд Солонгосын Сөүлд байдаг, дэлхийн хамгийн том чуулганы пастор, Доктор Давид Чог хардаг. Тэр эрхэм чуулганаа олон жилийн өмнө эхлүүлсэн бөгөөд үүнийг бичиж байхад, тавин сая гаруй гишүүнтэй болсныг хоёр ажилтан нь хэлсэн юм.

Би хэд хэдэн удаа Доктор Чод үйлчилж, хамт гольф тоглож, түүнтэй болоод хамтран зүтгэгч нартай нь зоог барьж явсан. Тэрбээр ер нь бол заавал хэд хэдэн бизнесмэн, хамтран зүтгэгч нартайгаа хамт явдаг. Тэд Доктор Чог бүхий л талаар халамжилж, хэрэгтэй бүхнийг нь худалдан авч өгч бас зоогон дээр түүнийг суухаас нааш хэн нь ч суудлаа эзэлдэггүйг би онцгойлон анзаарч билээ. Товчхондоо тэр хүмүүс Доктор Чог туйлаас хүндэтгэнэ. Магадгүй иймээс л хотынхоо хамгийн ядуу дүүрэгт эхэлж байсан чуулган нь ийм олон, пастораа харамгүй хүндэтгэдэг баян чинээлэг гишүүдтэй болоо юм болов уу?

Миний нэг дотны нөхрийг Оол Брайс гэдэг. Тэрбээр Хойд Каролина мужийн Фаетвиллийн онцсайн нэгэн чуулганд үйлчилнэ. Оол 1980- аад онд Америкийн сонирхогчдын гольфын тэмцээнд хүчээ үзэж явсан, мундаг гольфчин. Доктор Чо ч маш олон хамтран зүтгэгч, нөхөдтэйгээ гольф тоглож явсан бөгөөд тэр дундаа онцгойлон Оолд ихэд хайртай байж билээ. Нэг удаа Доктор Чо хамтран зүтгэгч нартайгаа Америкт айлчлахдаа, Оолтой гольф тоглох хуваарьтай байв. Доктор Чотой явсан нэг хүн нь түрээсийн машинаасаа буугаад, гольфын хэрэгслээ гаргаж ирлээ. Тэрбээр дөнгөж сая Нью Йоркийн Тавдугаар өргөн чөлөөнөөс хэдэн мянган долларын үнэ бүхий гольфын цүнх худалдаж авчээ. Манай ухаалаг Оол ч цүнхнийх нь сайхныг бишрэн магтав. Гэтэл нөгөө эрхэм гэнэт л цоо шинэ цүнхнээсээ гольфын эд хэрэгслээ бүгдийг нь гаргаад хоосолчихов. Тэгснээ Оолын цохиуруудыг

цүнхнээс нь гаргаснаа, дизайнер - цүнхэндээ хийж эхэллээ. Оол ч тэр даруй “Үгүй, та чинь яаж байна аа?” гэв.

Солонгос эрхэм “Би таныг хүндэтгэж байна. Энэ цүнхийг танд өгмөөр байна” гэж хэлсэн юм. Найз маань болиулахыг хүссэн ч, нөгөө эрхэм халгаасангүй.

Хэдэн сарын дараа Оол Солонгост айлчлаад бас л Доктор Чотой болоод түүний хамтрагч нартай гольф тоглохоор бэлтгэж байхдаа, гольфын дэлгүүрээс хачин гоё гутал олж харснаа “Пөөх, гоё гутал вэ!” гэжээ.

Тэр даруй Доктор Чогийн нэг хүн тавиур дээрх гутлыг аваад, бичүүлэх гэлээ. Оол ч “Өө, үгүй, үгүй. Надад гутал хэрэггүй. Зүгээр л гоё гэж хэлж байна” гэжээ.

Гэтэл нөгөө хүн “Өө, үгүй ээ эрхэм ээ, би таныг хүндэтгэж байна. Би танд авч өгмөөр байна” гэжээ. Оол надад энэ тухай ярихдаа, хайр хүрсэн янзаар инээд алдаад, “Би Доктор Чогийн хүмүүсийн дэргэд юм хумд дуртай байгаагаа хэлэхээ больсон шүү. Тэгэхгүй бол, авч өгөх гээд унадаг” гэж хэлж билээ. Тэр итгэгч нар өндөр хүндэтгэлд итгэдэг ч, үүнийхээ ачаар ерөөгддөг ч улс ажээ.

Ерөөгдсөн амьдрал

Манай өөр нэгэн найзыг Жак гэдэг. Жак маань Эзэнтэйгээ байхаар дээш явсан. Тэрбээр маш амжилттай, хүчирхэг амьдарсан хүн. Түүний үйлчлэлээр хэдэн зуу, мянган хүн ерөөгдсөн билээ.

Жакийг залуудаа, дөнгөж үйлчлэлээ эхлүүлж байхад нь пастор нь Америкийн маш алдартай нэгэн чуулганы үйлчлэгч байжээ. Пастортаа олон жил үйлчилснийхээ дараа Жак улсынхаа өөр нэгэн хэсэгт чуулган эхлүүлжээ.

Чуулган нь хэдхэн жилийн дотор таван мянгад хүрч, би ч байнга очиж номлож бас түүнтэй нөхөрлөх дуртай байлаа. Нэг удаа Жак надад хуучин пастортаа хичнээн хайртай, түүнийг хичнээн үнэлдэг, хүндэтгэдгээ ярьсныг тодхон санаж байна. Жак тэр хүнийг сүнснийхээ аав гэдэг байв. Тэгснээ Жак “Жон, би пастортайгаа уулзах тоолондоо, мянган долларын чек бэлэглэж байхаар шийдсэн” гэж хэлсэн юм. Түүний хүндэтгэлийн зэрэг намайг гайхшруулж билээ.

Жакийн үг надад түүнийг ямар том шагнал дунд амьдарч байгаа талаар бодоход хүргэсэн юм. Үнэндээ, түүний оршуулга дөрвөн

цаг үргэлжлэхдээ, пиг дүүрэн хүнтэй байж билээ. Чуулганых нь гишүүдээс гадна тэдний чуулганд явдаггүй, хотынх нь үйлчлэл нэгт хүмүүсээс бүрдсэн таван мянга орчим хүн цугласан байв. Түүнийг нийгэм даяараа хүндэтгэдэг байжээ.

Жакийн чуулган ч түүнийг хүндэтгэнэ. Тэд Жакт хангалттай цалин өгөхийг хүсдэг байсан ч, Жак ухаалаг хөрөнгө оруулалтынхаа ачаар чуулганаасаа цалин авах шаардлагагүй байв. Тэрбээр буцаагаад үйлчлэлд хандивлахыг илүүд үздэг байсан юм. Түүн шиг Бурханы ерөөл дор алхаж амьдарсан хүнтэй би маш цөөхөн таарч явсан. Эхнэр, охид нь ч түүнд жигтэйхэн хайртай. Тэрбээр маш сайхан байшинд амьдарч, олон сайхан найз нөхдөөр хүрээлүүлсэн. Жак сүнснийхээ аавыг хүндэтгэсэн учраас, амьдралынхаа олон, олон тал дээр цүлхийтлээ ерөөгджээ.

Бидний уулзалт

Хайрт минь, чи ах дүүгийнхээ төлөө, ялангуяа гадныхны төлөө аливааг хийхдээ итгэмжтэй зүтгэж байгаа юм байна.

Тэд хайрын чинь тухай чуулганы өмнө гэрчилсэн юм. Бурханд зохистойгоор тэднийг аян замд нь үдсэнээр чи сайн үйл хийх болно. Учир нь тэд харийнхнаас юу ч авалгүй Нэрийн төлөө явцгаасан юм. Тиймээс тийм хүмүүсийг бид дэмжих учиртай. Тэгснээр бид үнэний хамтран зүтгэгч болох билээ.

(3Иохан 5-8)

Миний бие дэлхий даяар аялж үйлчлэхдээ, манай багийг ер бусаар зочлон хүлээж авч байгаа хүмүүсийн болоод биднийг байдаг л аялагч нар гэж үзэж байгаа хүмүүсийн үйлчлэлийн үр дүн нилээд ялгаатай байхыг ажиглаж билээ.

Зарим газар очоод, энэ хүмүүс ер нь яах гэж намайг урьсан юм бол гэж бодогддог шүү. Тэд биднийг хамгийн хямд зочид буудал, дэн буудалд байрлуулна. Өрөөнд нь савтай цэвэр ус, ойр зуурын идэх юм, өрөөний үйлчилгээ ч байхгүй. Пасторынх нь албан өрөөнд талархалтай, халуун дулаанаар ч угтаж авалгүй, харин Та ингэх, тэгэх ёстой гэсэн янзтай л угтана. Ганц хоёр удаа бүр “Бидний үйл ажиллагаанд номлож байгаа чинь том завшаан шүү” гэсэн янзтай хандаж ч байлаа.

Намайг танилцуулах үед хүмүүс нь суугаад л, ямар ч сонирхсон янзгүй ширтэнэ. *“Бид бүгдийг нь сонссон. Танд хэлчих өөр юм байна уу?”* гэсэн бодол нь бараг л сонсогдоод байдаг. Тэгээд номлож байхдаа яг л шүүх хурлаар орж байгаа мэт санагдана.

Ийм маягийн цуглаан намайг ядрааж гүйцээдэг. Би өлсгөлөн зүрхнүүд дээр уран зураг зурахын оронд дуусан дуусгатлаа сүнсний эсэргүүцлийг сөрөн мацдаг. Эцэст нь пастор нь надад - чуулган нь долоо хоног тутам тийм жаахан өргөл авдаг бол, нэг их удахгүй л болов уу гэмээр - өчүүхэн дүнтэй чек гардуулж өгнө. Гэхдээ ийм явдал хааяа л тохиолддог нь сайхан.

Нэг удаагийн явдлыг тодхон санаж байна: Өөр нэгэн номлогч, бид хоёрыг бүтэн долоо хоног үргэлжлэх конференц дээр номлуулахаар урив. Пастор нь конференцийн үеэр \$250,000 - н өргөл хүлээн авснаа хэлсэн юм. Би ч тэдний төлөө баярлав. Гэтэл намайг явах болоход, тэд манай үйлчлэлд зориулж \$600 өгч билээ. Гар цайлгах мөнгө гэхэд ч хэцүү. Аравхан хувь нь л \$25,000 доллар болох байсан шүү дээ. Тэгэхээр, арван хувийнх 2 хувь л юм уу даа.

Мэдээж үүнээс болж манай үйлчлэл гачигдахгүй. Яагаад гэвэл Бурхан ямагт бидний хэрэгцээг өөр газраас ч хангадаг. Урьд нь чуулганууд бидэнд ийм маягаар хандах тоолонд (Үнэндээ энэ нь гар цайлгах жишгийн хаа ч хүрэхгүй учраас, үүнийг гар цайлгах мөнгө ч гэхэд хэцүү), бид тэр долоо хоногтоо хувь хүнээс шуудангаар том бэлэг авах юмуу бидний очсон дараагийн чуулган маш том хэмжээний өргөл өгдөг байлаа. Үнэхээрийн гоё. Яг л Бурхан “Би бүгдийг нь мэднэ” хэмээх мэт.

Би ч Бурхан биднийг итгэмжтэйгээр хангадгийг мэддэг учраас, энэ мэтээс болж нойр хоолоо хасахгүй. Харин талхны үйрмэг хаяж өгөөд, Есүсийн элч нарыг хүндэтгэсний шагналыг авахгүй тэр хүмүүсийн төлөө л гашуудах.

Гэтэл нөгөөтэйгүүр, зарим газар намайг угтаж авахаасаа авахуулаад л, үдэж өгөх хүртлээ хөл хөөрцөг болж, чин сэтгэлээсээ, ер бусаар зочлон үйлчилдэг.

Зочид буудалд ирэхэд, долоо хоног идээд ч барамгүй чихэр жимс, ундаа, амттан тэргүүтнээр дүүрэн, том сагс тавьсан байна. Чуулган нь ямар амттан, хоолонд дуртайг минь асууж тэмдэглэж авна. Заримдаа зочид буудалд маань гоё үзэг, цамц, гольфын бөмбөг, эрэгтэй сүрчиг зэрэг тансаг бэлэг авч тавьсан байна. Тэд намайг нутгийнхаа хамгийн л шилдэг зочид буудалд буулгаж, аянчин хүнд гэртээ мэт тухлахад

шаардлагатай өрөөний үйлчилгээ зэрэг бүхий л нөхцлөөр хангаж өгнө. Тэгээд ганц надад ч бус, хамт аялж яваа хамтран зүтгэгч нарт маань ч яг адилхан үйлчилнэ.

Намайг индрийн ард гарахад, хүмүүс нь босч зогсоод, чангаар алга ташина. Тэд төлөөний хүнээ илгээсэн Бурханд талархаж, Бурханы Үгийг сонсох гэж тэмүүлнэ. Тэд үгийг анхааралтай сонсож, нэг үг ч алдахгүй гэсэндээ, цуглааны үеэр өөр хоорондоо ярьж, өөр юм хийхгүй. Тэд үйлчлэлийн цагаар Бурханы оршихуйг урин, манай ном, материалыг зарж байгаа ширээ рүү уралдаж очоод хоосолно.

Тэр чуулганууд хэдэн сарын дараа юмуу эсвэл бүр хэдэн жилийн дараа надтай юмуу манай ажилчидтай уулзахдаа “Та нар ирэхдээ, биднийг орвонгоор нь эргүүлсэн. Манай чуулган юмуу ажилчид тэс өөр болсон. Бид цоо шинэ төвшинд гарсан” гэдэг үгсийг хэлдэг. Гэтэл долоохон хоногийн өмнө өөр нэг чуулган бидэнд байдаг л нэг явуулын хүмүүс шиг хандаж байсныг нь санаад, заримдаа дотроо инээд хүрдэг юм. Би яг адилхан зорилгоор, яг адилхан сэдвээр заадаг ч, үр дүн гэх юмгүй, намайг явахад ч хэн ч, юу ч хэлдэггүй. Тэгэхээр, энэ бүхэн нь надаас болоогүй, харин намайг хэрхэн хүлээж авсантай л холбоотой болох нь дахин харагдаж байна.

Есүс “Чамайг хүлээн авсан нь Намайг хүлээн авсан. Намайг хүлээн авсан нь Намайг илгээгчийг хүлээн авсан” хэмээн айлдсан буюу. Есүс танай чуулганы пастор байсан бол эсвэл зарим Бүтэн сайнд танай чуулганд айлчилж ирдэг байсан бол, та Есүсийг хэрхэн халамжлах бол? Үнэндээ, бид Есүсийн бидэн рүү илгээсэн хүмүүст хэрхэн хандана - Есүст тэгж л ханддаг бөгөөд Аавд ч бас тэгж л ханддаг юм.

Эзэнийг хүндэтгэ

Бүгдээрээ хүндэтгэлийн зарчмыг дахин харцгаая. Бурхан “Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна” (1Самуел 2:30) гэсэн.

Энэ бичээсийг сэтгэлдээ сийлээд ав. Бурханыг хүндэтгэдэг хүмүүсийг Бурхан эргээд хүндэтгэдэг. “Би Бурханыг хүндэтгэбэл, Бурхан намайг хүндэтгэнэ” гээд чангаар хэл. Ахин дахин давтаад, тунгаан бодоод, зүрхэндээ уусга. Бурханыг хүндэтгэх гэдэг нь Түүний хүндэтгэлийг өөртөө татах явдал юм. Гайхмаар аа! Цааш нь лавшруулан үзье:

ЭЗЭНээ эдээрээ болоод Бүтээгдэхүүнийхээ дээжээр алдаршуул. (Сургаалт үгс 3:9)

Эд хөрөнгөөрөө Эзэнийг дээдэл гэжээ. Амплифайд Библи дээр “Хөрөнгө чинээ, (шударга хөдөлмөрийнхөө) хангамж, бүхий л орлогынхоо анхны үр жимсний дээжээр Эзэнийг хүндэтгэ” гэдэг. СийИВи Библи дээр “Эзэнд мөнгөө өгч хүндэтгэ” гэдэг. Мөнгөө өгөх нь Бурханыг хүндэтгэх бас нэгэн арга зам ажээ. Тэгвэл, би асууя: Эзэнд хэрхэн мөнгөө өгөх билээ? Бурхан манай мөнгөний нэгжийг хэрэглэхгүй. Хариулт нь энгийн - Түүний илгээсэн хүнд өгөх.

Библиэс арван хувь, өргөлийн талаар нарийн судласан бол, тэдгээр нь үндсэн гурван зорилгын төлөө өгөгдсөн болохыг мэднэ. Нэгдүгээрт - бидэнд үйлчилдэг, томилогдсон удирдагч нарыг хангахын төлөө бөгөөд энэ бүлгийн эхээр үзсэнчлэн, тэдэнд “хоёр дахин их цалин” өгөх хэрэгтэй. Хоёрдугаарт - үйлчлэгч хүнийг үйлчлэлийнхээ ажлыг хийхэд нь хангахын төлөө. Гуравдугаарт - тийнхүү үйлчлэгч хүмүүс ядуу, бэлбэсэн, өнчин, харь хүмүүст тусалж чадахын төлөө.

Би та бүхэнд дээрх гурван зорилго тус бүртэй холбоотой эшлэлээс ганц, ганцыг л толилуулъя. Эхний бичээсийг Коринтод хансдан Паулын үгээс харж болно: “Бид та нарт сүнслэг зүйлсийг тариад та нараас махбодын юмсыг хураавал энэ нь дэндүү их гэж үү? ... Түүнчлэн сайнмэдээг тунхаглагчид сайнмэдээгээр амь зуухыг Эзэн тогтоосон ажээ. (1Коринт 9:11,14)

ЭнЭлТи дээр “Эзэн Сайн мэдээг номлодог хүмүүс нь Сайн мэдээгээр ерөөгдөж байгаа хүмүүсээр тэтгүүлэх хэрэгтэй хэмээн тушаасан” гэдэг. Энэ зарчмыг Хуучин гэрээнээс ч харж болно. Тахилч нар болоод Левичүүдийн өв нь хүмүүсийн арван хувиас гарах ёстой байв. Тэдэнд бусад овгууд шиг хөдөлмөрлөж, үр шимийг нь хүртэх газар хуваарилж өгөөгүй.

Хоёр дахь санааг нь Филиппой чуулганд хандсан Паулын үгээс харж болно:

Сайнмэдээний анхан үед, намайг Македониос явсны дараа авах өгөхийн хэрэгт ганцхан та нараас өөр нэг ч чуулган оролцоогүйг филиппойчууд та нар өөрсдөө бас мэдэж байгаа. Тесалоникт ч хүртэл та нар нэгээс илүү удаа надад хэрэгтэй юмыг маань илгээсэн. Гэвч би бүгдийг хүлээн авч хангагдсан. Би Епафродитоос та нарын юмсыг хүлээн аваад дүүрэн байна.

Бэлэг чинь Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр юм. (Филиппой 4:15-16,18)

Тэр хүмүүсийн санхүүгийн бэлэг нь Паулыг дуудагдсан ажлаа гүйцэтгэх боломжтой болгожээ. Товчхондоо, олон нийтийн үйлчлэл явуулахад мөнгө хэрэгтэй. Паул “бүгдийг хүлээн авч, хангагдсан” гэж хэлсэн байна. Өргөлөөр дамжин тэд Паулын бусдад Сайн мэдээ дэлгэрүүлэх ажлын түншүүд болжээ.

Гурав дахь зорилгын тухайд, Хуучин гэрээнд Бурхан арван хувийг Левичүүдэд (үйлчлэгч нар), харь хүмүүст, эцэггүйд, бэлбэсэнд зориулаарай (Дэд хууль 26:12) гэсэн. Шинэ гэрээний удирдагч нар “Бидэнд ядуусыг санаж байгаарай гэсэн нь чухамдаа хийхийг эрмэлздэг зүйл минь юм” (Галат 2:10) хэмээн санаа нэгтэй зөвшилцсон байдаг.

Ядуусын тоонд харь хүмүүс, өнчин, бэлбэсэн багтах байв. Үйлчлэгч нарт зориулж өргөснөөрөө, бид хэзээ ч уулзаж яваагүй, хэрэгцээ гачигдалд байгаа хүмүүст тусалж чадна.

Бид Бурханы үйлчлэлдээ сонгосон хүмүүст зориулж өгснөөрөө, Бурханыг мөнгөөрөө хүндэтгэдэг болохыг өмнө хэлсэн. Тиймээс, өнөөдөр хичнээн олон хүн үйлчлэлийн ажлаас харамласнаараа Бурханыг үл хүндэтгэж байгаа бол гэж асуух ёстой. Олон хүн арван хувиа өгдөггүй, амьдралд нь сүнсний үнэнийг тариалж байгаа ажилчдад өргөл өргөдөггүй. Тэд үйлчлэгч нарыг байнга мөнгө гуйдаг хэмээн гомдоллож, “Өргөлийн талаар ярихгүйгээр, зүгээр л үгээ зааж болдоггүй юм байх даа? Би өөрөө ч амьдрах гэж ядаж байна” гэх зэргээр үг хаях. Гэхдээ харамч учраас, ядарч зүдрээд байгаа юм биш байгаа? Бурханы ажлыг нэгдүгээрт тавихгүй учраас, тэр биш байгаа? Тэгэхээр, үндсэндээ тэд Бурханаас илүү өөрийгөө хүндэтгэдэг ажээ.

Иймээс одоо, түг түмдийн ЭЗЭН ингэж айлдаж байна. — Өөрсдийн зам мөрийг хянагтун! Та нар ихийг тариалсан боловч ургац нь бага байна. Та нар иддэг боловч цаддаггүй. Та нар уудаг боловч ханадаггүй. Та нар хувцасладаг боловч хэн чинь ч дулаацдаггүй. Хөлсний ажилчин хөлс авлаа ч цоорхой түрийвчинд хөлсөө хийдэг. Түг түмдийн ЭЗЭН ингэж айлдаж байна. —Өөрсдийн зам мөрөө хянагтун! Уул өөд явж, мод авчран өргөөг минь баригтун. Тэгвэл Би үүнийг чинь таашаан, алдаршуулагдах юм гэж ЭЗЭН айлдаж байна. — Та нар ихийг

хүлээсэн боловч өчүүхэн л ирсэн. Та нар гэр уруугаа зөөхөд Би түүнийг чинь хийсгэсэн. Яагаад? Түг түмдийн ЭЗЭН тунхаглах нь —Яагаад гэвэл та нар цөмөөрөө өөр, өөрийн гэр уруу гүйлдэж байхад Миний өргөө эзгүй хоосон байна.
(Хаггаи 1:5-9)

Үүнээс тодорхой байх уу? Бидний биширдэг Бичээсийн зарим хүмүүс ч ийм бэрх үед мөнгө ярилаа хэмээн үйлчлэгч нарыг буруутгадаг өнөөгийн хүмүүстэй л адил хандлагатай байсан болтой. Тухай нь, Элиагийн үеийн их өлсгөлөнгөөр олон бэлбэсэн эмэгтэйчүүд нас барсан. Гэхдээ хүндэтгэлийн зарчмын ачаар нэг бэлбэсэн авгай амьд үлдсэн байдаг. Тэрбээр хүүтэйгээ үлдсэн атга гурил, шавхруу тосоороо сүүлчийн удаа боов хайрч идчихээд, үхье л гэж боджээ. Гэтэл эш үзүүлэгч эхлээд өөрт нь идүүлэхийг хүсчээ. Пөөх, хэрэв өнөөдөр байсан бол, түүнийг чуулганд ч, хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр “Өөрөө туслах ёстой байтал, өлсөж үхэх гэж байгаа, ядарсан авгайг дээрэмдлээ” гээд л нийтээрээ жигшин зэвүүцэж байгаа даа. Гэтэл Бурхан эш үзүүлэгчээрээ дамжуулан тэр эмэгтэйд “зарцыг нь эхэлж хооллох замаар Бурханыг хүндэтгэбэл, Бурхан түүнийг хүндэтгэнэ” гэжээ. Эмэгтэй ч үгэнд нь орсон. Тэгээд Бурхан ч амлалтаа биелүүлж, их өлсгөлөн дуусан дуустал тэр айлын гулир, тос дуусаагүй юм (1Хаад 17).

Бид Бурханы илгээсэн хүмүүсээс арван хувь, өргөлөө харамлахдаа, Эзэнийг үл хүндэтгэдэг бөгөөд үүгээрээ өөрийгөө л хорлодог. Бурхан Өөрөө эш үзүүлэгчээрээ дамжуулан айлдруун:

Бурханыг хүн луйвардах уу? Гэсэн ч та нар Намайг луйвардаж байна! Гэвч та нар «Бид Таныг яаж луйвардсан юм бэ?» гэдэг. Аравны нэгээр ба өргөлөөр. (Малахи 3:8)

Сонголт хийх ёстой болбол, би л хувьдаа Бурханыг бус, банк дээрэмдэх байх. Яагаад? Яагаад гэвэл, би хүнээс илүү Бурханаас эмээнэ. Гэхдээ сонголт хийх албагүй нь сайхан. Угаасаа би дээрэм хийхийг хүсэхгүй. Гэвч Бурхан “Та нар намайг дээрэмдсэн!” гэжээ. “Та нар миний үйлчлэгч нарыг дээрэмдсэн!” гэж хэлээгүй байгааг тэмдэглээрэй. Тэгж хэлээгүй. Бид Бурханы удирдагч нараас арван хувь, өргөлөө харамласнаараа, Бурханыг дээрэмддэг. Учир нь Бурханы илгээсэн зарц нараас харамлах нь Бурханыг үл хүндэтгэсэн

явдал юм. Цааш нь юу гэж хэлснийг үзнэ үү: “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга” гэж түг түмдийн ЭЗЭН айлдаж байна” (10).

Арван хувийн маань хариуд Бурхан биднийг “хальтал буюу хүлээж авах зайгүй болтол” ерөөнө хэмээн Бурхан Өөрийн биеэр айлдсаныг тэмдэглээрэй. Тэгэхээр, ерөөл нь үндсэндээ *агуулахын аргагүй* их эд хөрөнгө байх ажээ. Үйлчлэгч нар Бурхан бидний санхүү, өмчийг агуулах аргагүй болтол маань ерөөнө гэхийг би олон жил сонссон. Би үүнийг жаахан засмаар байна. Мөнгө нь агуулах боломжтой хөрөнгө. Би дэлхийн бүх мөнгийг ч агуулж чадна. Тэгвэл Бурхан өргөл, өглөгийн маань шагналыг бид агуулах аргагүй болно хэмээн мэдэгдсэн нь юу гэсэн үг вэ? Хариулт нь Сургаалт үгс дээр байна:

ЭЗЭНээ эдээрээ (эдгээр нь үйлчлэгч нарт зориулсан бэлэг, өргөл болно) болоод Бүтээгдэхүүнийхээ дээжээр (энэ нь арван хувь) алдаршуул. Тэгвэл агуулах (амбаар сав) чинь арвинаар дүүрнэ. Ингэвэл торхнууд чинь дарсаар бялхана. (Сургаалт үгс 3:9-10, тодруулгыг нэмэв)

Танай амбаар сав бол агуулах юм. Энэ нь таны чекийн дэвтэр, хувцасны шүүгээ, түлшний сав, гараж зэрэг болно. Эдгээр нь бидний агуулж болох эд хөрөнгөө хадгалдаг газар. Тэгэхээр, Бурхан үнэхээр бидний санхүүг ерөөдөг нь үнэн. Гэхдээ, агуулж чадахааргүй ерөөл гэдэг нь юу вэ? Цааш уншбал, хариулт нь байна: “Торхнууд чинь шинэ дарсаар бялхана.” Торх бол дарс хадгалдаг том сав. Бурхан энэ бичээс дээр бялхана гэсэн байгаа учраас, чухам энэ л Бурханы ерөөлийг агуулах боломжгүй тэр зүйл ажээ. Тэгвэл шинэ дарс юуг төлөөлдөг билээ? Библи шинэ дарсаар Ариун Сүнсний шинэхэн оршихуйг төлөөлдөг. Чуулганы удирдагч нарт - чуулганд нь юмуу үйлчлэлд нь өгөх замаар Бурханыг хүндэтгэбэл, Өөрийнхөө хэзээ ч татрахгүй, бялхсан оршихуйгаараа таныг тултал шагнахаа Бурхан айлдруун! Энэ бол амлалт, амлалтын дээд нь.

Сүнснийхээ удирдагч нарыг санхүүгээр өгөөмрөөр хүндэтгэж байгаа хүмүүс нь эд материалаар ч ерөөгдөж, тулгарах сайн үйлс бүрийг гүйцэтгэх хангалттай хөрөнгөтэй байдаг. Гэхдээ үүгээр дуусахгүй. Тэд мөн Бурханы оршихуйн бялхал дотор явдгийг би ажигласан. Үүнд

ч гайхалтгүй. Бурхан амласан шүү дээ. Үүнийг ойлгосон явдал миний хүндэтгэлдээ харам чуулганд - пастор нь зөрчилддөг юмуу эсвэл надад явуулын хүн шиг л хандсан газарт яагаад Бурханы оршихуй хүчтэй мэдрэгдэхгүй байв гэдэг асуултад маань хариулж билээ. Тэндхийн хүмүүс нь өгөөмөр биш. Гэхдээ өгөөмөр зантай болоод, тэр л хэвээрээ байсан тохиолдолд, тэр чуулганд Бурханы оршихуй хүчтэй оршино.

Энэ бүлгийн үнэнийг цээжиндээ тээнгээ, Библиэ бүрэн унших юм бол, Бурханы хүмүүс харамгүй өгч байсан цагт гайхамшиг, эрх чөлөө, аврал, Бурханы оршихуй, хөгжил цэцэглэл хальж байгааг анзаарна. Бид Бурханы ерөөлийг худалдаж авч чадахгүй. Гэхдээ Бурханы нигүүлсэлтэйгээ хэлхэж өгсөн сүнсний зарчим гэж бий. Македоны итгэгч нарт хэлсэн Паулын үгийг л үз: “Ах дүү нар аа, Македоны чуулгануудад өгсөн Бурханы нигүүлслийг та нарт мэдүүлэхийг бид хүсэж байна. Зовлонгийн үлэмж хатуу сорилтод байхдаа тэд баяр хөөрийн бялхалд байж, туйлын хоосрол нь тэдний өгөөмөр зангийн баялагт халгисан юм. Учир нь тэд хэр чадлаараа болон хэрээсээ ч илүү, сайн дураараа өгснийг би гэрчилнэ” (2Коринт 8:1-3).

Паул өгөөмөр чанарыг Бурханы нигүүлслийн шууд үр дагавар гэжээ. Бурханы нигүүлсэл тэдэнд “хэрээсээ ч илүү” үйлдэх хүчин чадлыг хайрлаж. Бид нигүүлслийг ч, тааллыг ч худалдаж авч чадахгүй ч, эдгээрийг хүлээн авах байр суурийг эзэлж чадна. Бидэнд Бурханы үгийг дамжуулж байгаа хүмүүст хоёр дахин их мөнгө санхүү өгснөөрөө, бид Бурханы хүндэтгэлийг хүлээн авах байр сууринд дэвших бөгөөд энэ хүндэтгэлд нигүүлсэл ч, таалал ч багтана. Энэ нь сүнсний хууль болой.

Найз нөхдөө хүндэтгэх

Та нарыг хүндэтгэх нь Намайг хүндэтгэсэн хэрэг юм. Намайг хүндэтгэх нь Намайг Илгээгчийг хүндэтгэсэн хэрэг юм. Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүндэтгэх хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүндэтгэх хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна. Үнэнээр Би та нарт хэлье. Ийм өчүүхнүүдийн нэгэнд, шавийнх нь хувьд уух аяга хүйтэн ус өгсөн (өгч хүндэтгэсэн) хэн ч шагналаа эс алдана гэв. (Матай 10:40-42, зохиолчийн хувилбар).

Одоо бүгдээрээ бидний дээрх эрх мэдэлтэй хүмүүсийг орхиод, нэг зэрэг зиндааныхан буюу найз нөхдийгөө авч үзье. Бид ч тэдний дээр оршихгүй, тэд ч бидний дээр оршихгүй. Есүс энэ бүлгийн талаар “Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүндэтгэх хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна” гэдэг үгээрээ илэрхийлжээ.

Давхар шагнал

Энэ төвшинд хэрхэн хүндэтгэхийг харуулсан нэгэн гэрчлэлээр эхэлюү. Хэдэн жилийн турш манай гэр бүл жил тутмын аялал - амралтанд явдаг байлаа. Дөрвөн хүү маань аав, ээжтэйгээ хамт амьдардаг байхдаа, Лиза, бид хоёрын Бурханы Үгийг даян дэлхийн

хүмүүст хүргэх гэсэн шигүү аялалд хэзээ ч гомдол гаргахгүй. Тэд бид хоёрын дуудлагыг дэмжээд зогсохгүй, бүр баярладаг байв. Тиймээс жилийн адгаар тэднийг шагнаан, гэр бүлээрээ аялж амардаг Бурханы онцгой хангамжинд талархан хөөрдөг байлаа. Аяллынхаа үеэр бид хоёр хүмүүстэй гар утсаар холбогдох юмуу и-мэйлээр харилцдаггүй маань хөвгүүдийг минь хамгийн их баярлуулдаг байв. Бид хоёр долоо хоногийн турш компьютер хэрэглэлгүй, ажил хийлгүй, зөвхөн аав, ээжийн ажлаа хийнэ гэж тохиролцоно.

Нэг удаа ээлжит аяллынхаа дараа би ажилчид хариуцсан захирал руугаа залгахаар шийдэв. Гэтэл тэрбээр намайг тун тааруухан мэдээгээр угтлаа. Биднийг амарч явах хойгуур манай хотын, миний таньдаг нэгэн пастор манайд ажилладаг, гол ажилтныг маань өөрийнхөө ажилд элсүүлчихсэн байв. Тэр ажилтан эмэгтэй маань манай шинэ номыг олон улсад орчуулан гаргах эрхийг хариуцдаг байв. Дэлхий даяны хэвлэлийн газруудтай ажилладаг байсан болохоор, бид ч түүнийг тэр байр сууринд хүргэх гэж нилээд сургаж, боловсруулсан байлаа. Олон газартай харилцааны гүүр барьж байгуулна гэдэг цаг хугацаа шаардсан, чухал ажил.

Миний хувьд, энэ тухай сонсоод, сэтгэлээр унасан гэхэд ч багадмаар. Би тэр пасторын талаар мэдэрч байгаа юмстайгаа хамаг хүчээрээ тэмцэлдэв. Бид чинь ажилтнаа боловсруулах гэж есөн сар болсон. Гэтэл тэр пасторт над руу залгаад, тэр эмэгтэйг ажилд авбал, манай байгууллагад аль зэрэг нөлөөлөх эсэхийг ч асуучих сэтгэл байдаггүй. Тэр пастор нийгэмд ажилладаг, аврагдаагүй хүн байсан бол, ойлгохсон. Гэтэл яг адилхан үйлчлэгч хүн байж, удирдагчтай нь ярилцалгүйгээр дорх хүнийг нь хөлсөлнө гэдэг Хаанчлалд ерөөсөө таарахгүй байв. Тэгээд ч тэр хүн миний найз шүү дээ.

Ийнхүү хэд хоног залбирахдаа, ууртайгаа тулалдав. Яаж аль болох түргэн өөр хүнийг олох билээ? Шинэ хүнийг бий болгох хайран хугацааны төлөө яс минь хавталзана. Дахиад л шүүмжилсэн бодол санаатайгаа тэмцэлдлээ. Тэр хүний үйлдлийн ухааныг олох гэж хичнээн хичээв ч, ямар ч учир зүй олдсонгүй. Хүн яаж ийм мэдрэмжгүй байж болдог байна аа? Хоёр, гурав хоногийн дараа Эзэн миний залбирал дундуур яриу: “Хүү минь, чи түүнд шинэ цагаа өг.”

Би аялж явахдаа, Ямайкийн дэлгүүрээс хөөрхөн цаг худалдаж авсан юм л даа. Үнэхээр гоё хийцтэй, эко ажиллагаатай, цоо шинэ Ситизен цаг. Би олон жил цаг худалдаж аваагүй байсан болохоор, цоо шинэ дэгжин цагандаа баярлаад ханахгүй байж билээ.

Гэтэл Бурханы үгийг сонсмогцоо, би Түүний ухааныг шууд ойлгосон юм. Бурхан надад пастор - найзынхаа зүг зүрхэндээ боловсруулж байгаа буруу бодлуудаа гаргаж хаяад, хүндэтгэлээр орлуулах боломж олгож байв. Бурхан намайг гомдлыг тэтгэхээс хамгаалж, Өөртэй нь ч, мөнөөх пастортой ч тогтоох харилцааг маань хамгаалж байлаа. Би залбирал дундаа инээмсэглэснээ, сүүлдээ бүр инээд алдаж эхлэв. Аавын маань ухаан, хайр хоёр намайг алмайруулав. Тэрбээр хоёр хүүгийнхээ хоёулангийнх нь төлөө ажиллаж байлаа. Би Бурхан Аавынхаа хүсэлтэд баяртайгаар “за” гэтэл, тэр даруй нөгөө пасторт хандах хамаг уур, эсэргүүцэл маань миний системээс юүлэгдээд алга болов. Тун хурдан чөлөөлөлт байлаа. Ийнхүү би өөрийнхөө хайртай зүйлийг Христ доторх ахан дүүдээ өгнө гэхээс баярлав.

Маргааш орой нь бид хоёр утсаар ярьсан юм. Дургүйцэл нэгэнт ор мөргүй арилсан учраас, миний зүгээс хар буруу санах юм байсангүй. Гэтэл тэр хүн бодлогогүй алдаа гаргаснаа хүлээгээд, сайтар тунгаалгүйгээр үйлдсэнээ зөвшөөрөөд, уучлал эрэв. Ийнхүү надтай нүүр тулан ярихдаа, тэрбээр буруу юм хийснээ ойлгожээ. Гэхдээ Бурхан эхлээд миний зүрхийг цэгцлээгүй байсан бол, бидний яриа тун эвгүйгээр эргэх байв. Миний дууны өнгө, хандлага харилцаанд маань чүдэнз зураад хаях байсан байх.

Тэгэхээр, би одоо нэг зүйл хэлмээр байна: нүүр тулж ярилцах нь сайн зүйл боловч, гол нь үүнийгээ зөв хандлагаар хийх ёстой. Өөрийнхөө төлөө бус, харин нөгөө хүнийхээ тусын тулд хийх ёстой. Би түүний хэрэглэсэн арга зам яагаад буруу байсныг тайлбарлахдаа, жинхэнэ хайраар илбэж тайлбарласан болохоор, түүний хувьд ч миний үгийг амархан хүлээн авав. Ярианыхаа төгсгөлд би түүний ажлаар ороод гарч болох эсэхийг асуутал, нөгөөх маань зөвшөөрөөд, цаг товлосон юм.

Намайг очих үед нөгөө хүн гайхсан янзтай угтав. Бид хоёр хэдийнээ хэргийг хаасан учраас, тэрбээр намайг яагаад ирж байгааг гайхжээ. Би ч түүнд цагаа бэлэглэх хүслээ хэллээ. Нөгөөх чинь хачин их догдлоод “Жон, надад цаг байхгүй, яг хэрэгтэй байсан юм” гэв. Би ч үүнийг сонсоод жигтэйхэн ерөөгдөв. Тэгээд гаргаад, хайрцгаас нь гаргатал, нөгөөх чинь зүүж үзтэл, таарсангүй. Миний бугуй түүнийхээ хавьгүй нарийхан ажээ. Гэтэл бид запас оосрыг нь Ямайкийн дэлгүүрт орхичихсон байлаа. Тэгэхээр нь би түүнд компаниас нь оосор захиалаад өгье гэв. Нөгөөх маань өөрөө захиалаад авчихъя хэмээн намайг ятгасан боловч, би хүнд хагас дутуу бэлэг өгмөөргүй байлаа.

Тэр цагаас хойш бид хоёр урьд урьдынхаасаа ойр дотно болцгоов.

Бид хоёр нэг нэгнээ улам ихээр хүндэтгэх болов. Найз маань тэр цагийг зүүж байгаа нь намайг өөрөө зүүснээс минь илүү баярлуулдаг. Түүнээс хойш хуучин ажилтантайгаа ч хэд хэдэн удаа уулзсан бөгөөд түүний ахиц дэвшилд сэтгэлээсээ баярладаг.

Гэхдээ, бид ажилтнаа алдсан гэдэг баримт мэдээж арилаагүй ч, Бурхан үүнд санаа тавина гэдгийг мэдэж байлаа. Би Бурханы хангамж орж ирэх үүдийг дэлгэх арга замаар үйлдсэн шүү дээ.

Тэгвэл одоо хүндэтгэлийн маань хариуд ирсэн шагналын тухай хуучилъя. Хэдэн долоо хоногийн дараа хүний нөөцийн ажилтан маань хуучин ажилтны орон тоон дээр Дарси гэдэг эмэгтэйд авав. Дарсиг зүгээр л бар - хатагтай гэмээр. Би даян дэлхийн итгэгч хүмүүсийн гар дээр Бурханы Үгийг хүргэхийн төлөө тэгтэл улайран дайрдаг хүнийг тун цөөхөн харж явсан байх. Дарси орж ирүүтээ л, хөрсийг эргүүлж гарав. Бусад ажилтнууд маань нөхцөл байдал хэрхэн эргэхийг хүлээдэг байсан бол, Дарси тэгэхгүй. Тэрбээр залбираад, манай номуудыг хэвлүүлэхийн төлөө олон улсын хэвлэлийн газрынхантай хөөцөлдөнө.

Өмнөх хатагтай сайн л ажилласан. Тэрбээр есөн сарын хугацаанд манай номыг эх хэл дээрээ хөрвүүлсэн улсын тоо 18 байсныг нь 23 болгосон бол, Дарси ажлынхаа эхний есөн сарын хугацаанд 23 байсныг нь 40 болгов! Тийм ээ, та зөв уншлаа. Өмнөх хатагтай 5 шинэ хэл нэмсэн бол, Дарси 17 шинэ хэл буюу гурав нугалж чаджээ. Одоо үүнийг бичиж байхад маань Бурханы нигүүлслээр хэдийнээ 100 хэл даваад байна. Үүнээс гадна бид 200 гаруй улсын пастор, удирдагч нарт 20 гаруй сая материал тарааж чадсан.

Манайд ажилладаг байсан хатагтайг ажилд авсан тэр пасторыг би хүндэтгээгүй байсан бол, ийм зүйл болох байсан гэдэгт би итгэж чадахгүй. Бид шагналаа хүлээн авсан; бидний захиран хариуцдаг Бурханы Үг сая, саяар нь үржүүлсэн хүний сүнсэнд хүрч байна. Сайн мэдээг хориглодог улс орны удирдагч нарын гарт хэдэн арван мянган ном хүргэх ажлыг хийж эхэлсэн нь Дарсигийн санаачилсан үй олон ажлын нэг байлаа. Үнэндээ ном маань хүрсэн зарим хавчлага, дайнтай газрын удирдагч нарыг хамгаалах үүднээс, би тэдний талаар туншүүддээ ч дэлгэж зүрхлэхгүй.

Бурханы Үгээр аль болох олон хүнд хүрэх боломжоос илүү том шагнал үнэндээ санаанд минь буухгүй байна. Гэхдээ Бурхан үүгээр дуусгасангүй. Өөр нэгэн том шагнал айсууг би зүүдлээгүй ч үгүй явсан юм. Хэдэн сарын дараа би нэгэн хотын Бүтэн сайны цуглаанд номлож байлаа. Цуглааны дараа пастор нь намайг өдрийн хоолонд

унив. Бидэнтэй өөр нэгэн бизнесмэн нийлэв. Рестораны угаалгын өрөөнд байж байтал, бизнесмэн надаас “Жон, та ямар цагтай болмоор байна?” гэх нь тэр.

Миний цочсоныг дурьдах юун. Тэгээд жаал ээрснээ “Би хэлж чадахгүй” гэлээ.

Бизнесмэн ч бууж өгсөнгүй. “Жон, та хэлж чадна аа. Ямар цагтай болмоор байна?”

Түүний шийдэмгий байдлыг үзээд, би “Би олон жил Брейтлинг цагийг мөрөөдсөн” гэж хэлэв.

Брейтлинг цагийг Бентли Мотор компаний салбарт үйлдвэрлэдэг. Маш үнэтэй, тэр бүр олдоод байдаггүй, ховор цаг. Өмнө нэг хүний бугуйнд байхыг нь үзээд биширч билээ. Дизайн нь хараа булааж, ийм л цагтай болохсон хэмээн өөрийн эрхгүй бодогдсон сон. Тэр цагийг анх нисгэгч хүмүүст зориулж үйлдвэрлэсэн бөгөөд би ч нисэх дуртай (гэхдээ би нисгэгч биш шүү). Тэгээд нэг удаа Лиза, бид хоёр тэр цагийг зардаг, томоохон хотын нэгэн дэлгүүрийг зориод очсон ч, үнэд нь нүд орой дээр гарч, тийм мөнгөөр цаг авч зүрхлээгүй ч, тэр цаганд дурласан хэвээрээ л үлдэж билээ.

Бизнесмэн миний хариултыг сонсоод, цувныхаа ханцуйг шууснаа, бугуйнаасаа саяхан худалдаж авсан, хамгийн өндөр зэрэглэлийн Брейтлинг Навитаймер цагаа тайлаад, миний бугуйнд зүүж өгснөө, мишээгээд “Жон, өнөө өглөө таныг цуглаан дээр ярьж байхад чинь Бурхан надад энэ цагийг танд өгөөрэй гэж хэлсэн юм” гэлээ.

Би ч зог тусаад, хэлэх ч үггүй, манарав. Бурхан хэлээгүй л бол, Брейтлинг миний хамгийн дуртай цаг гэдгийг тэр эрхэм мэдэх аргагүй. Бүр яг нисгэгчдийн загвар байж таарсан нь бүр ч догь. Тэгээд яг энэ загварыг тэр эрхэм зүүж явдаг нь зүгээр нэг тохиолдол гэж үү?

Гэнэт шинэ цагтай болох огцом цочролд орсноос хэдэн цагийн дараа би, хэдэн сарын өмнө нөгөө пасторыг хүндэтгэсэндээ, цоо шинэ цагаа өгснөө санах. Тийнхүү Бурхан эргээд намайг хүндэтгэнэ хэмээн амласан үгээ биелүүлж байгааг ойлгосон юм. Учир нь Бурхан “Намайг хүндэтгэгчийг Би хүндэтгэнэ” (1Самуел 2:30) хэмээсэн. Та “Жон, гэхдээ та Бурханыг биш, пасторыг хүндэтгэсэн шүү дээ” гэж хэлж магадгүй. Тэгвэл Есүс “Та нарыг хүндэтгэх нь Намайг хүндэтгэсэн хэрэг. Намайг хүндэтгэх нь Намайг Илгээгчийг хүндэтгэсэн хэрэг” (Матай 10:40, зохиогчийн хувилбар) хэмээн айлдсаныг санаарай.

Энэ үгийг бичиж байхдаа, бугуйн дахь цагаа харахад “Аавын минь бэлэг” хэмээн бодогдох. Өөрөө очоод, өөрөө худалдаж авснаас ч гоё.

Эсвэл мөнгөтэй хүний бэлэглэсэн, өөр үнэтэй цагаас ч илүү утга учиртай. Гол нь цагандаа бус, харин үүний цаад үүх түүх, сэтгэл л тийм нандин болой. Бурхан зарц нарыг нь хүндэтгэх замаар Өөрийг нь хүндэтгэсэн хүмүүсийн төлөө яг адилхан зүйл үйлдэнэ. Яахав, мэдээж арга зам нь өөр байж болно.

Ариун эмээхүйгээр зузаатгасан хайр

Одоо та арай тодорхой харж эхэлж байгаа байх аа: хүндэтгэх нь үнэн голоосоо хайрлах явдал юм. Жинхэнэ хүндэтгэлд ариун эмээхүй ч, болзолгүй хайр ч багтана.

Хайр нь хоёр нүүргүй байг. Муу муухайг жигш, сайнаас зуурч ав. Ах дүүсийн хайраар бие биенээ хайрла. Бие биенээ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл (Ром 12:9-10).

Энэ хоёрхон эшлэлд маш олон зүйл багтаажээ. Нэгдүгээрт - Паул жинхэнэ хайр хоёр нүүргүй байдгийг мэдэгджээ. *Хоёр нүүртэй байдлыг* “өөрийнхөө жинхэнэ зан чанар, сэдлийг хав дарах” (Уэбстэр, 1882) хэмээн тодорхойлжээ. Тэгэхээр, энэ нь гаднах үг, үйлдлээрээ хүндэтгэх мэт атлаа дотроо шүүмжилж, атаархаж, тэр байтугай нүд үзүүрлэдэг хүнийг тодорхойлж байна. Эсвэл ар нуруугаар чинь эсэргүүцэж, шүүмжилж, атаархаж, тэр байтугай гүтгэнэ. Америкийн Өмнөд нутагт яг ийм байдал руу амархан уруудуулдаг нэг янзын соёл бий болсон байдаг. Өмнөдийн зочломтгой зан, Өмнөдийн жентельмэн, Өмнөдийн хацар гоо гэдэг яриаг бид бүгдээрээ л мэднэ. Эдгээр нь Өмнөдийнхөн шиг нигүүлсэнгүй, хүндэтгэлтэй ёс дэгтэй улс байхгүй гэсэн л санаа. Гэвч хэрэг дээрээ зарим нь тийм зүрх сэтгэлтэй гэхээсээ илүү зүгээр л тийм дүр эсгэж өссөн улс байдаг.

Зарим Өмнөдийнхөн бусдыгаа эзгүй хойгуур үгийн муугаар хэлэх атлаа хожим нүүрэн дээр нь эгээтэй л мөргөх нь холгүй хүндэтгэж, хайрлаж, өргөмжлөхийг би харсан. Гэтэл нөгөөтэйгүүр, бусад нутгийнхан зүгээр л байдаг. Тэд элдэв өргөмжлөл хүртээгүй учраас, байгаагаараа л байна. Жишээ нь, Зүүн Хойд нутгийнхан шулуухан шүү дээ. Танд дургүй байвал, нүүрэн дээр чинь хэлж л орхино. Тэд манж занд суралцаагүй учраас, жаахан билэг танхай гэх үү.

Тэгэхээр, хоёр нүүргүй байж байж л жинхэнэ хүндэтгэлийг хэрэгжүүлнэ. Жинхэнэ хүндэтгэлийг хуурамчаар үйлдэх боломжгүй. Хуурамчаар үйлдэх аваас, өөрөө л мэхлэгдэх бөгөөд хуурамч юмд шагнал байхгүй. Паул “Хайр нь хоёр нүүргүй байг. Муу муухайг жигш, сайнаас зуурч ав” гэсэн. Мууг жигшиж, сайнаас зуурах нь Эзэнээс эмээхүй болой. Сургаалт үгс 8:13 дээр “ЭЗЭНээс эмээхүй нь ёрын мууг үзэн ядах явдал юм” гэдэг. Эзэнээс эмээхүй биднийг мэхлэгдэхээс сэргийлдэг. Өөрийгөө хоёр нүүртэй үйлдлээр сохлохоос маань сэргийлдэг. Энэ тал дээрх Бурханы засвар үгийг дахин шалгацгаая. Исаиа дээр Эзэн айлдруун: “Энэ ард түмэн амаараа ойртон, Уруулаараа л Намайг хүндлэвч, Зүрх нь Надаас алс хол байдаг. Тэд Намайг эмээн хүндлэхэд хүний тушаалаар (цээжээр) суралцжээ” (Исаиа 29:13).

Цээжээр гэдгийг “Анхаарал тавих юмуу зарчим болголгүйгээр үг, авиаг тасралтгүй давтах” хэмээн тодорхойлсон байна. Бурхан хүмүүсийг амаараа хүндэтгэдэг хэмээн мэдэгдсэн бол, Исаиа номын өөр хэсэг дээр тэднийг үйлдлээрээ ч хүндэтгэх атлаа зүрх нь оршдоггүй гэдэг. Энэ бол хоёр нүүртэй хүндэтгэл бөгөөд үндсэндээ хүндэтгэл биш хүндэтгэл юм. Яагаад тэд яагаад ийм зан үйлдэл суув? Эзэнээс эмээхүй байхгүй... “тэд Намайг цээжээр эмээн хүндэтгэж сурсан” учраас тэр. Зүгээр л дадал болгожээ.

Энэ байдлыг өнөөдөр чуулганы хүрээнээс олонтаа харна. Бид эелдэг байх дээрээ хэт анхаарсандаа, зүрхнээсээ ярьж чадахаа больсон. Жишээ хэлье л дээ. Стив хуралдаа яарч явж. Таван минут хоцорчихсон тул нэмж хоцрохгүйхэн шиг орох нь чухал. Тэгээд түм түчигнэсэн гудмаар уруудаж явахдаа, Жиймийг олж харна. Хавьд уулзаагүй, чуулганых нь танил - Жийм гудамжны нөгөө талаар угтаж айсуу. Стив бодно: “*Өө, балай юм. Жийм намайг битгий хараасай. Уулзах цаг ч алга. Би ч түүнд дургүй шүү дээ.*”

Гайтай юм шиг, Жийм Стивтэй харц мөргөлдөв. Стив ч дуртай дургүй, итгэл нэгт нөхөртэйгээ мэндлэхээр зам хөндлөн гарлаа. Танилын нүүр халуун шүү дээ. Тиймээс Стив өөрийг нь чиглэн айсуу Жиймийн өөдөөс очно. Стив яарч яваа учраас, яриагаа бушуухан дуусгахын тулд түрүүлж дуугарна: “Жийм, ямар сонин хүн бэ! Бурхан алдаршиг.”

Жийм ч хариу мэндлээд, Стивийн амар мэндийг асууна.

Стив хариулна: “Маш сайн. Найз нь хуралдаа хоцрох гээд, яарч явна. Дараа залгая. Сайхан хоолонд орёе.” Тэгээд салцгаана.

Жиймтэй хийсэн Стивийн харилцан ярианд товч дүн шинжилгээ хийе л дээ. Нэгдүгээрт - Стив тухайн үед Бурханы талаар огт бодоогүй.

Зүгээр л итгэл нэгт нөхөдтэйгээ уулзсандаа баяртай байгаагаа илтгэх үүднээс яриандаа суулгаж өгсөн дадал нь энэ. Хоёрдугаарт - Жийм Стивд огтхон ч сонин байгаагүй. Бүр битгий олоод харчихаасай гэж хүссэн. Тэгэхээр Стив эхний ганц өгүүлбэрээрээ л ямар ч итгэл үнэмшилгүй, мэх, худалд баригджээ.

Стивийн салахдаа хэлсэн үгийн тухайд? “Дараа залгая. Сайхан хоолонд орёе.” Стивд Жийм рүү залгах, хамтдаа хооллох ямар ч санаа байхгүй. Зүгээр л эвгүй нөхцлөөс бушуухан бултах арга заль нь. Бас л нэг худал.

Стив санаатайгаар худлаа ярих болов уу? Үгүй л болов уу. Тэгвэл яагаад ямар ч итгэл үнэмшилгүйгээр ингэж ярина вэ? Яагаад гэвэл тэрбээр амьдралдаа Эзэнээс эмээхүйг тээлгүйгээр худлаа хайрлаж сурсан учраас, тэр. Энэ түүнийг хөндий хоосон агуулгатай атлаа нэг л их хайр, хүндэтгэл илэрхийлсэн, цээжээр амьдардаг хэв маяг руу хөтөлжээ.

Эзэнээс эмээхүй инү Бурхан бидний бодол, сэдэл бүрийг, хэлэх үг бүртэй маань ширхэглэн мэддэг гэдэг үнэнийг бидэнд сануулж сэргийлдэг. Шүүх өдөр бид юу ч бодолгүйгээр, зүгээр л унагасан үг бүрийнхээ төлөө тайлагнана (Матай 12:36). “Хүүхдүүд ээ, та нар ирж, Намайг сонс. Та нарт ЭЗЭНээс эмээхүйг Би зааж өгье. ...Хэлээ муу муухайгаас, Уруулаа худал хэлэхээс сахин хамгаал! Муугаас салж, сайныг үйлд, Амар тайвныг хай, мөшгөл!” (Дуулал 34:11, 13-14) гэдэг шүү дээ.

Тийм ээ, бид үнэн дотор хайрлах ёстой бөгөөд үүнийг гагцхүү гал халуунаар хүсч, Эзэнээс эмээхүй дотор явснаар л хийнэ! Дүр эсгэн, мэхлэгдэх нь юутай аймшигтай. Бурханлаг эмээхүй л биднийг энэ урхиас сахин хамгаална.

Бусдыгаа өөрөөсөө дээгүүр үзэх

Ром ном дээр Паул цааш нь “Ах дүүсийн хайраар бие биенээ хайрла. Бие биенээ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл” (12:10) гэжээ. Хүндэтгэл нь бусдыгаа үнэлж, цэнэтэйд тооцохдоо, бусдыгаа бодолцдог. Паул өөр нэгэн захидалдаа ийн хэлжээ:

Ингэснээр та нар ертөнцийн гэрэл мэт гялалзан, гажууд үеийнхний дотор Бурханы өөгүй, буруугүй хүүхдүүд байх юм.
(Филиппой 2:15)

Бусдыгаа өөрөөсөө илүү цэнэтэйд тооцохуй нь хүндэтгэл болой. Бид эдгээр үгсийг амьдралынхаа бүхий л үйл хэрэг дээр нарийн сайн эргэцүүлж, тунгааж, бодож явах ёстой юм. Үүнийг өөрийнхөө дотор лав суулгаад, хийгээд сурчихбал, жинхэнээсээ хүндэтгэх бөгөөд аугаа ерөөл дотор явах болно.

Паул “Есүс Христэд байсан энэ л сэтгэлгээ та нарт ч байг” гэж хэлсэн байгааг тэмдэглэнэ үү. Намайг итгэлээр ч шинэ, насаар ч залуу байхад Эзэний хэлсэн үгийг би ер мартдаггүй юм. Машинаа жолоодож явтал, Эзэн “Жон, Би чамайг Өөрөөсөө дээгүүр үздэгийг чи мэдэх үү?” гэхийг сонсож билээ.

Ийм үг сонссон хүн чинь түгшиж, цочирдсон гэж. Тэгээд дайсан л миний дотор нүгэлтэй, бардам санаа тариалах гэж оролдож байна гэж бодов. Ертөнцийг хамаг байдагтай нь бүтээсэн Бурхан юу гэж л над мэтийн өчүүхэн хүнийг Өөрөөсөө дээр үзэх билээ? Тэгээд “Сатан аа, чи надаар нүгэл хийлгэх гэв, миний ард гар!” гэж хэлэх дөхлөө. Гэхдээ сүнснийхээ цөмд энэ үгийг Есүс айлдсан болохыг мэдэрсэн л юм даа. Тиймээс Эзэний үг “сүнсийг шалга” (1Иохан 4:1) гэж хэлдэг учраас, хэдийгээр итгээд удаагүй байсан ч, баталгаажуулахаар шийдэв.

Тэгээд бодлоо цэгцлээд: “Эзэн минь, Та надад Шинэ гэрээнээс гурван гэрч өгөхөөс нааш би үүнд итгэж чадахгүй нь” гэж хариуллаа. Би энэ үгийг хэлэхдээ, чичирж байсан ч, зөв юм хийж байгаагаа мэдэж байлаа.

Эзэн миний хүсэлтэд татгалзалгүй, харин ч бүр таалж байгааг нь зүрхэндээ мэдрэв. Эзэн тэр даруй “Филиппой 2:3 дээр юу гэдэг билээ?” гэв.

Би ч цээжээрээ мэддэг учраас, чангаар хариуллаа: “Юуг ч аминч санаархал эсвэл ихэрхэг зангаар бүү хий. Харин даруугаар бие биенээ өөрөөсөө дээр гэж үзэж...”

Эзэн надад “Эхний гэрч нь энэ” гэлээ.

Тэгэхээр нь би ч өөдөөс нь: “Үгүй ээ Эзэн минь, Паул ингэж хэлээгүй. Паул Филиппойн итгэгч нарт бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэхийг хэлснээс биш, Та намайг хэрхэн үзэж, хэрхэн ханддаг талаар яриагүй” гэж ирээд л аягүй эсэргүүцэв.

Тэгтэл Эзэн шууд л “Би Өөрийнхөө хийдэггүй юмыг хүүхдүүддээ хийгээрэй гэж хэлдэггүй!” гэлээ.

Би ч гэдрэг ухарлаа.

Тэгтэл Эзэн “Энэ бол маш олон гэр бүлийн асуудал. Аав, ээж нь өөрийнхөө хийдэггүй юмыг үр хүүхдээсээ шаарддаг. Эсвэл өөрийнхөө

хийдэг юмыг бүү хий гэдэг. Олон аав, ээж үр хүүхдүүдээ бүү муудалц гэдэг атлаа өөрсдөө үр хүүхдийнхээ нүдэн дээр байнга муудалцдаг. Тэгээд хүүхдүүд нь муудалцлаа гэж гайхдаг. Тэгвэл Би тэгдэггүй” хэмээн айлдав.

Би ч итгэл муутайхан л “Тэгвэл энэ чинь нэг л бичээс байна. Надад дахиад хоёр хэрэгтэй” гэж хэлэв.

Тэгтэл “Загалмай дээр хэн үхсэн? Чи юу би юу?” гэх нь сонсогдлоо.

Би зог тусав.

Тэгснээ дахиад “Би чамайг Өөрөөсөө дээгүүр үзсэн учраас л чиний нүгэл, өвчин, эмгэг, ядуурал, шүүхийг тээгээд загалмай дээр алуулсан” (Бурхан надад 1Петр 2:24-ээр эшлэлийг өгсөн юм).

Тэр үед л би Эзэний дуу хоолойг сонссон болохоо ухаарав. Бурхан намайг Өөрөөсөө дээгүүр хүндэтгэдэг (цэнэтэйд тооцдог). Эс бөгөөс юу гэж миний оронд шүүгдэж, миний оронд үхэх билээ. Ийнхүү би гурав дахь бичээс айсуу гэдгийг мэдлээ. Бурхан ч асуулгасан ч үгүй, шууд л “Ах дүүсийн хайраар бие биенээ хайрла. Бие биенээ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл” (Ром 12:10) гэдэг үгийг зүрхэнд минь хэлэв. Тэгээд дараа нь “Би Өөрийнхөө ах дүүсийн дунд ууган нь (Ром 8:29) бөгөөд ах эгч, дүүсээ Өөрөөсөө дээгүүр үздэг” гэлээ.

Мэдээж энэ үг ганц надад бус, Бурханы хүүхэд бүрт хамаатай. Бурхан бидний - хүн нэг бүрийг Өөрөөсөө дээгүүр хүндэтгэдэг. Үүнийг ойлгоход ухаан ч хүрэмгүй. Бурханы жинхэнэ хайр гэж энэ.

Та “Гэхдээ Жон, энэ чинь Есүс Христ шүү дээ. Бид хэзээ ч ингэж хайрлаж чадахгүй” гэж хэлэх байх. Тэгвэл бид чадна гэдэг гайхамшигтай баримтыг хэлье. Ариун Сүнс Бурханы хайрыг бидний зүрхэнд суулгасан гэдэг (Ром 5:5). Паулын өөрийнх нь үг гэрчилнэ. Тэрбээр элэг нэгт хүмүүстээ юу гэж хэлснийг үзнэ үү:

Би худал яриагүй, Христ дор үнэнийг хэлж байна. Миний мөс чанар Ариун Сүнсээр надад гэрчилж байгаачлан зүрхэнд минь маш их уйтгар гуниг, байнгын зовуур байна. Мах биеэрээ миний хамаатан болох ахан дүүсийнхээ төлөө би Христээс салгагдаж, өөрөө хараал болох минь гэж хүсэж байлаа.
(Ром 9:1-3)

Паулын энэ үгд зүгээр л дагжмаар. Паул элэг нэгт ах эгч, дүүс нь аврагдахыг харахын төлөө өөрөө Христээс, авралаас, мөнхийн амьдралаас ч таслагдахад бэлэн гэжээ. Үүнийг дүр эсгэж хэлэх

боломжгүй. Хүн яаж ийм хүндэтгэл, хайраар амьдрах вэ? Хүний хайраар бус, гагцхүү Есүсийн өгдөг Бурханы хайраар л ингэж хүндэтгэх боломжтой. Паулын зүрхэндээ үлэмж хүчтэй хөгжүүлсэн хайр хүндэтгэл нь л ийм орь дуу болон асгарчээ. Бас нэг зүйл хэлэхэд: Ариун Сүнс үнэхээр хэлье гээгүй л бол, үүнийг бичүүлэхгүй байсан. Бичээсийг үзэглэж байгаа нөхцөлд хүн мэхэлж, худлаа бичих боломжгүй.

Тэгэхээр, дахин төрсөн бид ямар хүчин чадалтай болохыг харж байна уу? Ром 5:5 дээр

“Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжин Бурханы хайр зүрхэнд маань цутгагдсан байдаг” (Ром 5:5) хэмээн онцлон хэлжээ. Тиймээс л Есүс бидэнд “Бие биенээ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун гэсэн шинэ тушаалыг Би та нарт өгч байна” (Иохан 13:34) гэдэг. Хуучин гэрээнд хүмүүс ийм хайр дор амьдарч чадахгүй байсан учраас, үүнийг шинэ тушаал болгон өгчээ. Бурханы хайр тэдний зүрхэнд хараахан цутгагдаагүй байв. “Би та нарыг хайрласан шиг” гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Есүс Өөрийгөө бидэнд бүтнээр нь өгчээ. Есүс Ааваасаа бүрэн таслагдаад “Бурхан минь, Бурхан минь, Та яагаад Намайг хаяв?” (Матай 27:46) хэмээн уйлсан байдаг. Есүс биднийг мөнхийн амьтай болгохын тулд сайн дураараа ядуурч, Бурханаас тасарсан. Есүс биднийг өндрөөс өндөр хүндэтгэсэн учраас л, Паул ч элэг нэгтнүүддээ яг ижил үгийг үнэн голоосоо хэлж чадсан билээ. Ай Аав минь, ингэж хайрладаг болоход минь туслаач! Та бидэнд хүчин чадал өгсөн. Одоо бид энэ хүчин чадлыг Ариун Сүнтэй хамтран хөгжүүлэх хэрэгтэй байна.

Бид итгэл нэгт нөхдөө цэнэтэйд тооцож, Есүсээр дутаж байгаа хүмүүсийг үнэлж, жинлэж, нандигнах чинь л хүндэт ахан дүүс минь, жинхэнэ хүндэтгэл шүү дээ. Энэ хүндэтгэл л биднийг Хаанчлалын ажилд боломжтой бүхий л арга замаар өргөж, үйлчилж, залбирах юмуу санхүүгээр дэмжихэд түлхэнэ. Энэ хүндэтгэл л биднийг Македоничууд шиг үйлдэхэд хүргэнэ. Тэр хүмүүсийн хүндэтгэл Христийнхтэй адилхан байсан бөгөөд Паул тэдний хайраар Коринтын итгэгч нарыг сэнхрүүлсэн байдаг:

Ах дүү нар аа, Македоны чуулгануудад өгсөн Бурханы нигүүлслийг та нарт мэдүүлэхийг бид хүсэж байна. Зовлонгийн үлэмж хатуу сорилтод байхдаа тэд баяр хөөрийн бялхалд байж, туйлын хоосрол нь тэдний өгөөмөр зангийн баялагт халгисан юм. Учир нь тэд хэр чадлаараа болон

хэрээсээ ч илүү, сайн дураараа өгснийг би гэрчилнэ. Ариун хүмүүсийн төлөөх үйлчлэлд оролцох ивээлийн талаар биднээс асар шаргуугаар гуйж, бидний найдаж байснаар бус, харин тэд өөрсдийгөө эхлээд Эзэнд, дараа нь Бурханы хүслийн дагуу бидэнд өгсөн. Иймээс урьдаас эхэлсэн шигээ энэхүү нигүүлслийн ажлаа та нарын дотор дуусгахыг бид Титээс гуйсан юм. Харин та нар юм бүхэнд, итгэл, үг, мэдлэг, аливаа оролдлого, та нарыг гэсэн хайранд маань бялхам байдгийн адил энэхүү нигүүлслийн ажилд ч бялхам байгаарай. Би үүнийг тушаалаар бус, харин хайрын чинь жинхэнийг бусдын зүтгэлээр тэнсэхийн тулд хэлж байна. Учир нь баян байсан ч та нарын тусын тулд хоосорсон Эзэн Есүс Христийн маань нигүүлслийг мөн Түүний хоосролоор баян болсноо та нар мэдэх билээ. Энэ нь та нарын төлөө тул би энэ зүйл дээр бодлоо хэлье. Жилийн өмнөөс та нар анхлан үүнийг хийхээр эхэлсэн төдийгүй мөн ингэхийг хүссэн шүү дээ. Харин одоо хийж байгаагаа дуусга. Үүнийг хүсэж эхэлсэн шигээ өөрт байгаагаараа дуусга. Хэрэв бэлэн байдалтай байвал, байхгүй зүйлийн дагуу бус байгаа зүйлийнхээ дагуу энэ нь тааламжтай. Бусдын хувьд хөнгөн болж, та нарт зовлон болоосой гэсэндээ бус, харин тэгш байхын үүднээс ингэв. Өнөө цагт та нарын элбэг дэлбэг байдал тэдний хэрэгцээг хангаснаар тэдний элбэг дэлбэг байдал бас та нарыг хангах болно. Тэгэхлээр тэгш байх болно. (2Коринт 8:1-14)

Паул Коринтын итгэгчдийг Бурханы итгэгч хүн бүрт суулгасан хайрыг гачигдал дунд байгаа хүмүүсийн төлөө харуул хэмээн сэнхрүүлэхийн төлөө Македончуудын хүндэтгэлийг хэрэглэжээ. Бурханы хайр бидний зүрхэнд бий. Үүнийг Ариун Сүнстэй хамтарч ажиллаж байж л хөгжүүлнэ. “Би тийм хүн биш, би тэгдэггүй” гэж бүү хэл. Ингээд байвал, та өөрөө л амьдралд чинь төдийгүй, ирэх амьдралд чинь зүрхийг чинь үнэхээр цатгаж, нөлөөлөл дор байгаа хүмүүст чинь баяр хөөр авчирч, жинхэнэ шагнал авчрах замаас хойш сууна. Тиймээс айж эмээлгүй итгэл нэгт нөхдөө хүндэтгэ. Үүнийхээ төлөө та хожим өнийн мөнхөд баярлаж явна.

Хариуцаж авсан хүмүүсээ хүндэтгэх

Та нарыг хүндэтгэдэг нь Намайг хүндэтгэдэг хэрэг юм. Намайг хүндэтгэдэг нь Намайг Илгээгчийг хүндэтгэдэг хэрэг юм. Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүндэтгэх хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүндэтгэх хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна. Үнэнээр Би та нарт хэлье. Ийм өчүүхнүүдийн нэгэнд, шавийнх нь хувьд уух аяга хүйтэн ус өгсөн хэн ч шагналаа эс алдана гэв. (Матай 10:40-42, зохиолчийн хувилбар)

Одоо бүгдээрээ хариуцаж авсан хүмүүсийнхээ талаар буюу бидний эрх мэдэл дор байгаа хүмүүсийн талаар үзье. Энэ бүлэг хүмүүсийн талаар Есүс “Ийм өчүүхнүүдийн нэгэнд, шавийнх нь хувьд уух аяга хүйтэн ус өгсөн хэн ч шагналаа эс алдана” хэмээн айлдсан бүлгээ.

Багачууд

Бичээс дээр “өчүүхнүүд” гэдэг үгээр бяцхан хүүхдүүдийг (багачуудыг) юмуу бидний эрх мэдэлд даалгасан хүмүүсийг тодорхойлжээ. Бүгдээрээ гэр бүлийн бүтэц дотроо авч үзбэл, эд бидний хүүхдүүд

бөгөөд эдний дээр төвлөрч ярилцъя. Олон, олон хүүхэд эрх мэдэлтний зүй бус авир хандлагыг үзэх юмуу тэр бүү хэл тэдний хүчирхийлэлд өртдөг. Энэ явдал Бурханы уур хилэнг хөдөлгөдөг бөгөөд Есүс ч ийнхүү анхааруулсан:

Надад итгэгч энэ балчруудаас нэгийг нь хэн бүдрүүлнэ, тэр нь хүзүүндээ тээрмийн чулуу зүүгээд, тэнгисийн гүнд живсэн нь дээр. Бүдрүүллийн улмаас ертөнц золгүй еэ! Юу гэвэл бүдрүүлэл ирэх нь зайлшгүй бөгөөд харин бүдрүүллийг гүйцэлдүүлэгч тэр хүн золгүй еэ!... Та нар энэ багачуудын нэгийг нь ч бүү басамжил. Би та нарт хэлье. Тэнгэр дэх тэдний тэнгэрэлч нар тэнгэрт байгаа Эцэгийн минь царайг байнга харж байдаг. (Матай 18:6-7,10)

Үнэхээрийн аймшигтай анхааруулга байна. Есүс золгүй гэсэн л бол, золгүй л байна гэдэгт итгээрэй. Есүс яагаад тийм хатуу хэлэв? Бурхан Өөрөө Хайр бөгөөд эрх мэдлийг хуваарилдаг Нэгэн тул эрх мэдлийг ч хайр, хамгаалалтын төлөө л өгдөг буюу. Тиймээс эрх мэдлээрээ хүчирхийлж, түрүү барьж, хүүхдүүдийг хорлож хохироох үйлдэл нь тухайн хүнийг шууд Бурханы эсрэг зогсооно. *Та Бурханы эсрэг зогсоох биш, Бурханы хүмүүсийн эсрэг зогсоож байгаа юм биш үү?* гэж бодох байх. Гэхдээ Есүс “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар энэ ах дүүсийн минь *дорд нэгэнд* ийн үйлдсэн бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40, тодруулгыг нэмэв) хэмээн айлдсан. Бид эрх мэдэл дорх хүмүүстээ хэрхэн хандана - Есүст тэгж л хандана. Хүүхдүүддээ, хань ижилдээ, ажилтнууддаа, оюутнууддаа... хэрхэн ханддагаа нэг бодоод үз дээ.

Эрх мэдэл дааж авсан хүмүүс засч, сахилга батжуулах үүрэг хариуцлагатай. Зарим удирдагч нар багачуудыг хэрэгтэй цагт нь засч залруулаагүй хойрго зангаараа тэднийг бүдрэхэд хүргэдэг. Тийн үл тоогдсон хүүхэд сайн руугаа явахаасаа илүү мууруугаа л явна. Паул Коринтод бичсэн захидлаараа Бурханлаг сахилга бат хичнээн чухал байдгийг харуулжээ. “Та нарыг устгахын тулд бус, босгон байгуулахын тулд Эзэний бидэнд өгсөн эрх мэдлийн талаар би хальж сайрхсан ч ичихгүй байхсан” (2Коринт 10:8). Коринтод бичсэн хоёр захидлыг уншиж байхад, Паул тэднийг нилээд хатуу үгээр донгодож байх нь шууд л харагдах. Паул тэр багачуудыг үнэлсэндээ л үгээрээ засч, хүмүүжүүлж байна. Гэвчиг, тэрбээр эрх мэдэл нь барьж байгуулахын төлөө буюу үйлчилж, хамгаалахын төлөө өгөгдсөн болохыг тодорхой

мэдэгддэг. Удирдагч хүн - та өөрөөсөө *Миний сэдэл юув?* гэж асуух ёстой. Та багачуудыг хүндэтгэдэг бол - ийм л сэдэлтэй хүн бөгөөд тийнхүү хэрэгтэй цагт нь та тэднийг засч залруулах л болно.

Нөгөөтэйгүүр, эсрэгээр үйлддэг хүмүүс байна аа. Тэд бол эрх мэдлээ амин хувийнхаа төлөө ашиглаж, багачуудыг бүдрээдэг хүмүүс. Тэдний засал залруулгын үг нь ч хор хөнөөлтэй. Тэд халамжин дорх хүмүүсийнхээ төлөө залбирах, тунгаан бодох арга замаар зүрхэндээ хайрыг боловсруулаагүй хүмүүс. Уг нь халамжин дорх хүмүүс маань хөгжин цэцэглэхийн төлөө зүрх маань дүрэлзэж байх ёстой юм шүү. Тэд алдаа хийх үү? Мэдээж. Та ч бас төлөвшөөгүй, залуу байснаа мартаа юу? Би ч бас л эрх мэдэлтнүүдийг зовоодог л байлаа. Би хөгийн гэмээр алдаа ч, нүгэл ч хийж явсан. Би огцом зантай, юмыг сайтар бодолгүйгээр эхлүүлдэг тэгээд ялангуяа буруу үедээ бодлогогүй мунхаг үг хэлдэг залуу байлаа. Тиймээс ийм хүнийг гаргуунд нь гаргаагүй удирдагч нартаа л мэхийх минь.

Олон жилийн өмнө гэргий, бид хоёр ажилтнуудаа сургаж байсан тэр цаг санагдана. Тэр үед бид хоёр итгэмжтэй хэдхэн л хүнтэй байлаа. (Харин одоо тавь гаруй ажилтантай болоод байна) Тэгээд бид хоёр тэдний алдаа болгонд санаа тавьдаг байж билээ. Тэгээд нэг удаа би хэн, хэнд маань зүгшрэл, ойлголт авчрах зөн үг хэмээн итгэсэн нэгэн санаагаа Лизад хэлснээ санаж байна. Би “Лиза, Бурхан бидний эрх мэдэл дор хүмүүсийг зүгээр ч нэг тавина гэж байхгүй. Тэдэнд бидний туслалцаа хэрэгтэй болоод л тавьсан байгаа” гэж хэлсэн юм. Тэгээд хоёулаа толгой дохиж билээ.

Чуулганы удирдлага

Энэ олон жил мянга мянган чуулганаар аялахдаа, би зүсэн зүйлийн л удирдлагатай уулзаж учирч явлаа. Тэр дундаа би бүтээлч сэтгэлгээтэй удирдлагад дуртай. Тэд Бурханы Өргөөг уламжлалт бус аргаар байгуулдаг. Арга зам нь аврагдаагүй байгаа хүмүүст илүү ээлтэй болдог гэх үү. Уламжлалт бүтэц маань итгэдэггүй хүмүүст хол хөндий байдаг бол, энэ нь итгэдэг хүмүүсийг зочлоход таатай байдаг. Хэдхэн жишээ дурьдахад л, бид албан маягийн хувцаслалт, эртний дуу, чуулганы хэллэгээсээ салж, зарлал, үйл ажиллагааг гүйцэтгэдэг байсан хуучны арга барилаа орчин үеийн мультимедиа хэрэгслээр солив. Би л хувьдаа үүнийг Бурханы цэц ухаан гэж боддог.

Нэг зүйлийг тэмдэглээрэй - Бурхан төөрөгсдөд ээлтэй арга барилыг үргэлж дэмждэг Бурхан шүү. 1Коринт 10:33 дээр элч Паул “Над шиг бай. Би олныг аврагдаг гэж, өөрийн бус олны ашгийг хайн, бүх зүйлд бүгдийн таалалд нийцүүлдэг” хэмээн мэдэгдсэн. Тэрбээр “бүх зүйлд бүгдийн таалалд нийцүүлдэг” хэмээн мэдэгдэхдээ, арга барилынхаа тухай өгүүлж байгаа юм. Паул төөрөгсдийн төлөө Есүсийн хийснийг л үлгэрлэн дууриажээ. Гэхдээ байна шүү - Бурхан төөрөгсдөд “ээлтэй” Үгийг хэзээ ч дэмждэггүй. Төөрөгсдөд “ээлтэй” Үгийн тухайд нөгөө л Паул маань “Учир нь эдүгээ би хүмүүсийн тааллыг эрж байна уу? Эсвэл Бурханыхыг уу? Эсвэл би хүмүүст таацуулах уу? Хэрэв би эдүгээ хүртэл хүмүүст таацуулсаар байсан бол би Христийн зарц биш байх байсан” (Галат 1:10) хэмээн мэдэгддэг. Бид хүмүүст “янзалчихсан” Сайн мэдээ хүргэж хэрхэв ч болохгүй. Тэгэх аваас, нэг л өдөр Есүсээс “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч нь л орно. Тэр өдөр Надад олноороо “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгийг үйлдэж байсан бус уу?” гэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” (Матай 7:20-23) гэдэг үгийг дуулах, хуурамч дагалдагч нарын чуулганыг байгуулна. “Бид хүн бүрийг Христэд төгс болгохын тулд бүх мэргэн ухаан дотор хүн бүрд сануулж, хүн бүрд заан Түүнийг тунхаглаж байна” (Колоссай 1:28).

Ариун Сүнс “Тэр ирэхдээ нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаар ертөнцийг зэмлэнэ” (Иохан 16:8) гэдгийг Есүс тодорхой айлдруун. Нөгөө “ээлтэй” Сайн мэдээ нь нүглээрээ амьдарч байгаа хүмүүсийг сэнхрүүлэхгүй аваас, тэр чуулган Илчлэл ном дээр гардаг Лаодик чуулганаас ялгаагүй болно. Тэр чуулган Ариун Сүнсээр дамжуулан Есүсийн бурханлаг цэвэршүүллийг хүлээж авахгүй байсан учраас, Есүс тэднийг бөөлжиж гаргадгийн даваан дээр ирээд байжээ. Эцэст нь Есүс чуулганаасаа “Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна” (Илчлэл 3:20) хэмээн учирлан гуйжээ. Энэ бүхэн нь төөрөгсдөд “ээлтэй” Сайн мэдээ дамжуулсны л гай.

Харин төөрөгсдөд ээлтэй арга барилын тал дээр элч Паул мөн ингэж хэлжээ:

Учир нь би бүгдээс чөлөөтэй атлаа илүү олныг олж авахын тулд өөрийгөө бүгдэд боол болгосон. Иудейчүүдийг олж авахын тулд би иудейчүүдэд иудей адил, хуулийн доор

байгсдыг олж авахын тулд би өөрөө хуулийн доор бус атлаа хуулийн доор байгсдад хуулийн доор байгч мэт, хуульгүйчүүдийг олж авахын тулд (хэдийгээр би Бурханы хуулиас ангид бус харин Христийн хууль дор байдаг атлаа), хуульгүйчүүдэд хуульгүй нэгэн адил, сул доройчуудыг олж авахын тулд би сул доройчуудад сул дорой нэгэн адил болсон юм. Бүхий л аргаар заримыг нь аврахын тулд би бүгдэд бүх юм болж байлаа. (1Коринт 9:19-22)

Түүний “илүү олныг олж авахын тулд өөрийгөө бүгдэд боол болгосон” гэдэг үгийг нь үзнэ үү. Би саяхан хэдэн зуун пастортай ярилцаж байхдаа, цуглаандаа зочин шиг орж ирээд, чуулганд явдаггүй хүний нүдээр нэг хараад үз гэж хүссэн юм. Тэгээд “Хэрэв шударга бөгөөд нээлттэй байвал, олонх чинь олон тооны өөрчлөлт хийнэ дээ” гэсэн.

Христийн бие дотор бид хамгийн сүүлийн үеийн харилцаа, технологийг хэрэглэх ёстой. Бидний бүтээлч байдал, санаачилгаас дэлхий санаа авч байх ёстой юм. Яахаараа дэлхийн талбар онцсайныг эзэгнэж, харин Бурханы хаанчлал хоёрдугаар зэргийн үйл ажиллагаагаар тодорхойлогдох ёстой гэж? Үгүй ээ. Даниел тэргүүтэй Еврейчүүд дэлхийн хамгийн аугаа гүрэн - Вавилоны хөвгүүдээс ухаантай байсан шиг, санаачилга биднээс л төрөх ёстой юм.

Бурханы Үгийг ямар ч найруулгагүйгээр, шууд л Ариун Сүнсний хүчээр тунхаглаж бас заахдаа, чуулганд явдаггүй хүмүүст ч хүрэхээр баглаа боодолтой түгээе. Үг маань дуулгаваргүй бөгөөд аврагдаагүй хүмүүст ч зүрхний бат ухаарлыг авчрах ёстой. Тэднийг Есүс Христэд бүрэн төгс захирагдаж буюу нүгэл, бурханлаг бус байдал, дэлхийн хүслээ гэмшиж, дээрээс нь Түүнийг амьдралаараа 100% дагахад дуудах ёстой. Бид үүнийг шинэлэг санаачилгаар давхарласан баяр хөөртэй амьдралаараа хийж чадна. Христэд итгэгч байна гэдэг нь баяр хөөр, бүтээлч байдлаа алдана гэсэн үг биш. Харин ч эсрэгээрээ, эдгээр чанараар баян байх ёстой. Бид багачуудаа хүндэтгэх юм бол, тэдний төлөө бүтээлч сэтгэлгээ маань ундрах л болно. Энэ маань ч Бурханд таашаагдана.

Хүчжүүлэгч эсвэл доройтуулагч

Харин одоо Петр чуулганы удирдагч нарт юу гэж хэлснийг үзэгтүн:

Тиймээс би та нарын ахлагч, Христийн зовлонгийн гэрч мөн илчлэгдэх алдрыг хуваалцагчийнхаа хувьд та нарын дундах ахлагчдыг ятгаж байна. Та нарын дунд байгаа Бурханы хонин сүргийг хариул. Албадлагаар бус, харин сайн дураараа, Бурханы хүслийн дагуу харгалзан, бохир ашгийн төлөө бус, харин хичээл зүтгэлээр, өөрсдөд чинь даалгасан хүмүүсийг ноёлох бус, харин хонин сүрэгтээ үлгэр дуурайл бол.

(1Петр 5:1-3)

Та Хорин нэгдүгээр зууны чуулган доторх удирдлагын хэлбэрийг: уламжлалт, прогрессив, хуульчирхаг, багийн ажиллагаатай, дарангуйллын, хүчжүүлэгч, бичил - менежменттэй гэх зэргээр ер нь хүссэнээрээ л нэрлэж болно. Гэхдээ энэ их жагсаалтыг ерөнхийд нь: хүчжүүлэгч эсвэл доройтуулагч хэмээн хоёр ангилж болно. Гол ялгаа нь удирдагч хүний зүрхнээс олдох.

Зарим удирдагч нар гаднаасаа өндөр ололт амжилттай атлаа ардаа үй олон хөхөрсөн, шархалсан, тэр бүү хэл үхсэн дагалдагч нарыг үлдээгээд явдаг. Нөгөөтэйгүүр, зарим нь ялгаагүй л ололт амжилттай явдаг ч, үүнийхээ хажуугаар удирдаж байгаа хүмүүсээ улам л боловсруулдаг. Энэ бүхэн нь удирдагчийн зүрхэнд хүндэтгэл байгаа эсэхтэй л нягт холбоотой ажээ.

Алсыг тодорхойлогч эрчүүд, эмэгтэйчүүд үйлчлэлд хоёр янзаар хандаж болно. Хүндэтгэхгүй мэддэггүй, багачуудыг бүдрүүлэгч удирдагч нь хүмүүсийг уналга болгож, өөрийнхөө алсын хараанд хүрдэг бол, амьдрал байгуулагч жинхэнэ удирдагч хүн өөрийнхөө алсын харааг уналга болгож, хүмүүст үйлчилдэг. Энэхүү удирдагч маань халамжин дорх хүмүүсээ хүндэтгэдэг. Удирдагч нарын зүрхний сэдлээс ундрах ялгаа нь хүмүүсийн амьдралд тэнгэр, газар шиг тусдаг нь гайхмаар. Есүс “мэргэн ухаан үйлсээрээ зөвтгөгддөг” (Матай 11:19) гэсэн буюу. Зарим чуулганы хүмүүс нь сэтгэл санаагаар хөх няц болсон байдаг бол (цөөхөн байдаг нь сайхан), зарим чуулганыхан эрүүл саруул гишүүд, гэр бүлээр дүүрэн. Энэ бүхэн хүндэтгэлийн л асуудал.

Хүмүүсээ хүндэтгэдэг удирдагч - хүмүүсийнхээ хөгжлийг урамшуулан дэмжинэ. Хайр халамжин дорх хүмүүс нь Бурхантай ойр дотно байж, амьдралынхаа дуудлага дор цэцэглэж байхыг харах шиг баяр хөөр түүнд байхгүй. Христэч амьдралын энэ хоёр үндсэн талын нэгдэл нь үнэн дотор амьдрахуйг багтаана. Иохан халамжин дорх хүмүүсийнхээ талаар юу гэснийг үзнэ үү: “Ах дүү нар ирж,

чиний үнэнийг, чамайг үнэн дотор хэрхэн явааг гэрчилсэнд би маш их баярласан. Миний хүүхдүүд үнэний дотор буйг сонсохоос эрхэм баяр баясгалан гэж надад үгүй билээ” (3Иохан 1:3-4).

Үнэн дотор амьдрахуй нь Бурханыг мэдэх бөгөөд үйлчлэхийг хэлнэ. Шүүх өдөр Өөрийнх нь нэрээр аугаа үйлсийг бүтээсэн зарим хүмүүст Есүс “Би та нарыг огт танихгүй, Надаас зайл” хэмээн мэдэгдэнэ гэсэн. Тэд авралын хамгийн чухал талыг буюу Бурханыг дотно таньж мэдэхүйг орхигдуулжэ.

Нөгөөтэйгүүр, Бурханыг мэддэг атлаа дургүйцлийг нь ихэд хүргэж амьдарсан хүмүүс ч байна. Бурханд тэдэнд өргөөг минь барьж байгуулахын төлөө ашиглаарай хэмээн бэлэг хариуцуулсан байтал тэд үүрэг хариуцлагаа биелүүлээгүй аж. Бэлгээ булсан тэр хүмүүсийг Шүүх өдөр Эзэн: “Олиггүй муу, залхуу боол!” (Матай 25:26) гэж дуудна.

Итгэгч бүр Бурханы өргөөг барьж байгуулах дуудлагатай. Ефес 2:10 дээр “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ” гэдэг. Бид хэн нэг хүн байхаар төдийгүй, ямар нэг юм хийхээр бүтээгджээ. Гэтэл хүмүүс балансгүй заадаг нь харамсалтай. Зарим номлогч нар “Бидний хийж байгаа юм чухал бус, хэн гэдэг маань л чухал. Бид чинь машин биш, хүн” гэж ярихыг би сонссон. Энэ нь сонсголонтой хэдий ч, Христэч амьдралын тэнцвэрийг алдагдуулсан сургаал юм. Бид Есүст итгэхдээ, хүнийхээ ажил хөдөлмөрийг зогсоодог. Тийм боловч, бид аврагдсаныхаа дараа Эзэний ажил хөдөлмөрт шамдаж эхэлдгийг Бичээс хэлдэг. Бид үр жимс гаргах ёстой бөгөөд үр жимс маань бидний итгэл үнэн болохыг баталдаг (Иаков 2).

Бидний хийх ёстой дуудлагыг саармагжуулж, хэн болохыг маань тодруулдаг сургаал нь хүмүүсийг Бурханы өргөөнд суулгагдаж, идэвхи зүтгэлтэй байхыг нь мохоож, зүгээр л чуулгандаа явахыг л хөхүүлэн дэмжих. Гэтэл чуулган дотроо суулгагдсан хүмүүс л дуудлага дээрээ хөгжин цэцэглэх бөгөөд хожим Христийн шүүх сэнтийн өмнө үлэмж том мөнхийн бэлэг хүлээж авна. Бид тодорхой ажил гүйцэтгэхээр Есүс Христийн дотор бүтээгдсэн бөгөөд эдгээр нь “төрхөө олоогүй хөврөл байхад минь Таны нүд харж л байсан. Надад тогтоогдсон өдрүүд болоогүй байхад Бүгд номд тань бичигдсэн байжээ” (Дуулал 139:16).

Удирдагч хүний хүндэтгэлтэй зорилго гэдэг нь багачуудыг үнэн дотор хол явахыг харах явдал болой. Жинхэнэ аав хүн, ээж хүн үр хүүхдээ өөрөөсөө хавь илүү яваасай л гэж хүсдэг. Есүс ч “Өөрийнх нь хийснээс ч аугаа ажлыг хийгээсэй” хэмээн бидний төлөөх хүслээ

мэдэгдсэн. Бид ч дагалдагч нарынхаа тал дээр ийм л хүсэлтэй байх хэрэгтэй. Иоханы захидалд гардаг шиг, удирдагч хүмүүс дагалдагч нарынхаа төлөө яг ингэж зүрх сэтгэлдээ шатаж явах ёстой. Үүнээс илүү баяр хөөр бидэнд байх ч учиргүй.

Эдгээрийг бод

Урт хугацааны, ухаалаг удирдагч нь өөрийнхөө амжилтын гавъяаг ямагт дорх хүмүүстээ дамжуулдаг. (Тийм ээ, мэдээж бүх гавъяа, хүндэтгэл, талархал, алдар нь Бурханых боловч, Бурхан хүмүүсээр дамжуулж ажилладгийг бүү мартаарай) Удирдагч хүн багийнхаа хүмүүсийн хүчин зүтгэлийг магтан сайшааснаараа, багаа хүндэтгэж байгаагаа харуулдаг. Үүнийг өнгөц биш, зүрхнээсээ л хийх боломжтой. Миний бие ч удирдагч хүнийхээ хувьд - манай даалгаврыг гүйцэлдүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүмүүсийг өндрөөр үнэлдэг. Тэд бол тэнгэрийн бэлэг. Би ажилтнуудынхаа талаар сөргөөр бодохоос биеэ сэргийлдэг. Ингэснээрээ тэднийг хүндэтгэх зүрхнийхээ хүндэтгэлийг хадгална. Паул:

Эцэст нь, ах дүү нар аа, юу нь үнэн, юу нь хүндэтгэлтэй, юу нь зөв, юу нь ариун, юу нь сайхан, юу нь сайшаалтайг, мөн аливаа сайн үйл байвал, магтууштай ямар нэгэн юм байгаа бол эдгээрийг тунгаацгаа (Филиппой 4:8) гэсэн.

Нэг хэсэг Лизагийн талаарх миний бодол их төөрөлдөж явсныг санаж байна. Үнэндээ, түүнд шал дургүй хүрдэг байв. Энэ увайгүй хандлага маань хэдэн сар үргэлжлэн бэхжив. Сайжрах бус, улам л дордов. Тэгээд нэг удаа муудалцахдаа, хаалгаа савж гараад, эзгүй хээр зүглэлээ. Лизатай ойрхон ч байхыг хүссэнгүй. Эзгүй хээр очин очтолоо Лизагийн талаар өөртөө ч, Эзэнд ч гомдоллов. Тэгээд очтол, зүрхэнд маань “Хүү минь, чи Лизагийн сайн чанаруудыг бодоод, тэр болгонд Надад таларх” гэсэн тод дуу сонсогдов.

Мэдээж тэр үед надад ширхэг ч эерэг бодол байгаагүй боловч, нэг сайн тал нь шууд орж ирлээ: Лиза сайн ээж. Тийм боловч, өөр сайшаачих юм гарч ирнэ гэж санасангүй. Тэгээд Лизаг сайн ээж байгаагийнх нь төлөө Бурханд талархсны дараа удаах нь гараад ирэв. Ийнхүү хэсэг хугацаа өнгөрсний дараа би гайхамшигт эхнэрээ бишрэн догдолж суулаа. Тэгтэл тун сонирхолтой явдал болов: Би

нөхцөл байдлаа тэс өөр өнцгөөс харж эхэлсэн бөгөөд энэ маань намайг эхнэрийнхээ талаар бодолдоо төөрөлдсөн, тун тааруухан эр нөхөр байснаа ухаарахад хүргэсэн юм. Ийнхүү би ухаан орж, байдлыг эрүүл ухаанаар харж эхэллээ. Өөрөөр хэлбэл Бурханы хараагаар харав.

Би харьж ирээд, эхнэрийнхээ хамаг л сайн сайхныг нь эцэсгүй магтан сайшаалаа. Зүрхнээс минь ундраад л байв, ундраад л байв. Гэхдээ өөрийг нь хаяж явсанд Лиза туйлгүй хилэгнэсэн байсан болохоор, харилцаагаа сэргээхэд эхлээд амаргүй байв. Гэвч би Лизаг зүрхнээсээ хүндэтгэсэн бөгөөд надаас аяндаа л асгараад байсан хүндэтгэлийн ачаар бид хоёр удалгүй эвлэрсэн билээ. Тэр өдрөөс хойш бид хоёрын харилцаа эдгэрч, сэргэж эхэлсэн ба дахиж хэзээ ч тэр үеийнх шигээ уруудан доройтоогүй юм.

Бид Филиппой 4:8-ын дагуу үйлдбэл, үр хүүхэд, ажилтан, оюутан, чуулганы гишүүдтэй маань яг л адилхан зүйл болно. Халамжин дорх хүмүүсийнхээ хайр хүрмээр, сайн, таатай чанарыг бод. Тэд Бурхан Аавдаа ямар үнэ цэнэтэй хөвгүүд, охид нь болохыг бод. Хараахан аврагдаагүй бол, тэдний төлөө Есүс үхсэн гэдгийг бод. Ингэж бид зүрхээ үл хүндэтгэлээс хамгаална. Эргээд өөрсдөө ч ерөөгдөнө.

Гэхдээ засч залруулах ёстой үед нь чангалах ёсгүй гэсэн үг биш шүү. Тийм боловч, засал залруулгаа үр нөлөөтэй, ухаалгаар хий. Бидний сэтгэлд хор хонзон байхгүйг үр хүүхэд, ажилтнууд маань мэднэ. Тийм ээ, бид хагуу үедээ хатуурхдаг ч, хайртай хүмүүс маань засал авсан бол, бид эргээд л тоглоом шоглоом хийгээд л, инээж ханиагаад л явж байдгийг манайхан хэлдэг. Би үүнийг Бурханаас Өөрөөс нь сурсан юм. Бид Бурханы сахилгын арга хэмжээг зүй ёсоор хүлээн авбал, Аав маань дорхноо уучлаад, умартдаг. Хор хонзон тээхгүй. Биднийг ичгүүрээр гинжлэх ажлыг Бурхан бус, дайсан хийдэг. Бурхан бидний алдааг мартагналын далайд булшилдаг бөгөөд гагцхүү сахилгажууллаас нь нэгийг сурч, алдаагаа дахиж давтахгүй байгаасай л гэж хүсдэг. Аавын маань бидэнд хандсан хайр, хүндэтгэл, найдварын бодлууд нь дэлхий дээрх бүхий л элсэн ширхэгээс ч давсан, багцаагүй олон ажээ (Дуулал 139).

Удирдагч хүний багачуудаа хүндэтгэх хүндэтгэл нь тэдний амьдрал дээр Бурханы бэлгийг буулгадаг. Хүмүүсийнх нь бэлэг цэцэглэж, түүгээр дамжин удирдагч хүний алсын хараа биелэхэд, тэрбээр эргээд ашгаа хүртэнэ. Ажилтнууддаа муухай ханддаг пасторуудыг гайхмаар. Тэд ажилтнуудтайгаа хахир, шаардсан өнгө дуугаар ярьж, яг л мангар хүнтэй мэт харилцана. Тэгснээ “Чадварлаг хүмүүсийг олох хэцүү

юм. Сайн ажилтнуудтай болох сон” гэдэг. Юугаа ч яриад байгаа юм. Хүмүүсээ үнэлдэггүй хүн чинь хүндэтгэлийн шагналыг хүртэхгүй.

Санхүүгээр

Удирдагч нараа санхүүгээр хүндэтгэдэг шигээ багачуудаа ч санхүүгээр хүндэтгэ. Хэдэн жилийн өмнө би Лизагийн туслахад хувийнхаа санхүүг зохицуулж сурахад нь тусалж билээ. Бид хоёр сар тутмын төсөв гаргав. Тухайн үед бид ажилтнуудаа Колорадо Спрингсийн үйлчлэгч нарын тогтоосон жишиг ханшаар л цалинжуулдаг байлаа. Тэгээд би түүний зардлыг нэмээд, мөнгө нь хүрэлцэхгүй байгааг мэдэв. Тэгснээ “Ийм цалингаар чинь яаж хүн шиг амьдрах вэ дээ” гээд хэлчихэв. Хажууд маань зогсож байсан эхнэр маань ч үг дуугүй зөвшөөрлөө.

Би тэр даруй ахлах нягтлан руугаа залгаад “Би сая Лизагийн туслахын төсөв дээр ажиллаад дууслаа. Бид түүнд хангалттай цалин өгдөггүй юм байна. Манай ажилтнууд ийм бага цалин авч болохгүй. Би ажилтнуудынхаа жилийн цалинг ийм төвшинд (нэг тоо дурьдсан) нэммээр байна. Шуудан илгээдэг, утасны дуудлагад хариулдаг, ер нь юу ч хийдэг байсан хамаагүй, бүгдийнх нь цалинг...” гэж хэллээ.

Ахлах нягтлан маань утасны цаана хэсэг чимээгүй байснаа, “Тэгэх юм бол, манай хотын үйлчлэгч нар таны төлөө л ажиллахыг мөрөөддөг болох байх даа” гэв.

Тэгэхээр нь би “Учир нь үүндээ биш ээ. Манай багийнхан бидэнтэй хамт Бурханд үйлчлэх гэж амь амьдралаа зориулж байгаа. Тэдний хангамж өндөр байх ёстой” гэлээ.

Тэр өдөр олон ажилтнууд маань цалингаа сайн нэмүүлэв. Энэ мэдээ тэдний хувьд гэнэтийн бөгөөд ер бусын баярт мэдээ болсон юм. Нэг залуу ажилтан бүсгүй тэр долоо хоногт халагдах өргөдлөө өгөх гэж байжээ. Санхүүгийн нөхцөл байдал нь туйлын хүнд байсан болохоор, тэрбээр өөр мужид байдаг төрсөн гэр рүүгээ нүүх санаатай байж. Гэтэл жилд сарын таван мянган долларын цалинтай болсон учраас, ажлаасаа гарах шаардлагагүй болсон юм.

Тэр бүсгүй бидэнтэй дахин 4 жил ажиллаад, хэлтсийн дарга болоод дэвшээд алга болж билээ. Тэгээд манай хамгийн үр бүтээлтэй, үнэ цэнэтэй ажилтнуудын нэг болсон юм. Тэрбээр төдийгээс өдий хүртэл алхам алхмаар тасралтгүй өссөөр ирсэн билээ. Бага цалингаас болж

ажлаасаа гарчихсан бол, бүсгүй өөрөө ч, Мессенжер байгууллага ч ямар их алдагдал хүлээх байсныг төсөөлөхөөс ч аймшигтай.

Энэ үйл явдлын шагнал тэр бүсгүйгээр тогтохгүй, үйлчлэлийг маань бүхлээр нь хамрав. Тэр цагаас хойш ажилтнуудын маань ажлын бүтээмж бүхэлдээ өссөн гэмээр. Бид үр нөлөөллийн цоо шинэ төвшин рүү ахив. Бид ажилтнуудаа хүндэтгэдэг бөгөөд энэ маань ч илүү үр бүтээмжтэй байдлын шагнал авчирдаг.

Энд анхаарууштай нэг зүйл бий. Хүндэтгэлийг шахан шаардах нь Бурханы зүрхийг сөргөөдөг болохыг би өмнө хэлсэн. Бид хоёр шалтгаанаар хүндэтгэлийг хүсэх ёстой: Нэгдүгээрт - хүлээж авсан хүндэтгэлээ эргээгээд зүрхэндээ Бурханд өргөхийн төлөө. Хоёрдугаар - хүндэтгэл өгч байгаа хүнийхээ тусын тулд. Учир нь тэрбээр шагнал хүлээн авах болно. Би үйлчлэлээ эхлүүлж байхдаа, том чуулганд туслах пастораар үйлчилдэг байлаа. Хамгийн доод хэмжээний цалин л авна. Сарынхаа цалингаар бүх төлбөр тооцоогоор барагдуулаад, цаана нь хувцас, тавилга зэрэг илүү юм авах мөнгө үлдэхгүй. Бид ч энэ цалин зөвшөөрсөн. Дөнгөж ажилд орж байж, өндөр шаардлага ч тавихыг хүссэнгүй.

Жил өнгөрлөө - цалин нэмсэнгүй. Хоёр жил өнгөрлөө - бас л нэмсэнгүй. Одоо манайх нэг биш, хоёр нялх хүүхэдтэй болоод байлаа. Зардал маань өсөөд байдаг ч, бид анх эхэлсэн тэр л төвшиндөө хэвээрээ л.

Миний найз болох өөр нэгэн туслах пастор маань тэр хоёр жилийн хугацаанд хэд хэдэн удаа манай албан өрөөгөөр орж ирээд, өөр хэдэн туслах пастортой нийлээд цалин нэмүүлэх талаар тэргүүн пастортой болоод удирдах зөвлөлтэй уулзалдах талаар асууж билээ.

Би ч хариуд нь би ийм юманд оролцохгүй, чи ч бас оролцоод дэмий. “Өөрийгөө хүнээр албадан хүндлүүлнэ гэдэг миний байр суурь биш” гэж л хариулдаг байлаа.

Гэтэл нөхөр маань “Жон, эхнэр бид хоёр гэр бүлээ чадан ядан авч явж байна. Хөгшин аав, ээж хоёроосоо мөнгө авч байж л сардаа хүргэж байна” гэж хариулна.

Би ч үүнд нь харамсаж байгаагаа илэрхийлээд... гэвч би Бурхандаа найдна аа л гэдэг байлаа. Би найздаа бидний эх үүсвэр бол цалин биш, харин Бурхан гэдгийг ойлгуулж, итгэлийг түгээх гэж оролдов ч, нэг л бүтэхгүй байв.

Би манай гэр бүл зовоогүй гэж хэлэхгүй. Бид зовсон. Гэхдээ тэр хугацаанд бид юугаар ч дуталгүй, амар амгалан байсан юм. Манайд

тавилга гээд байх юм ч байсангүй. Манай доод давхарт толгойгүй орны мод, хоёр жижиг сандал, хэдэн туслах ширээ, гэрэл, гал тогооны ширээ, сандал - эдгээр л байв. Гэхдээ жилийн дотор Бурхан гайхамшгаараа гэрийг маань тавилгаар - тавилга тавилгадаа бүр нэрт дизайнеруудын, гар хийцийн тавилгаар дүүргэхийг бид нүдээр үзэж билээ. Бурханы хангамж биднийг алмайруулдаг.

Хоёр жилийн дараа пастор маань биднийг аялан - үйлчлэлд томилон гаргаж өгөв. Ингээд бид цалингүй болсон юм. Хадгаламжиндаа гурван зуун доллартай, байр, машины сар тутмын мянга гаруй долларын лизингтэй. Байдлыг бүр онц сонирхол болгох гэсэн шиг, залбирч байхад минь Эзэн надад пасторуудаас үйлчлэх боломж царайчилж утсаар ярих юмуу захидал бичихийг хориглосон чиглүүлэг өгөөд, Өөрт нь найд л гэлээ.

1989 оны 11-ээр сарын адаг гэхэд надад заах хуваарьтай хоёрхон газар л байв. Эхнийх нь Өмнөд Каролинад салах ёслолын байранд цугладаг, зуугаад хүнтэй жижиг чуулган. Тэнд 1-ээр сарын эхний долоо хоногт очиж заах хуваарьтай байв. Нөгөөх нь 2-аар сарын сүүлээр Теннесси дэхь хоёр зуугаад хүнтэй жижиг чуулганд очиж заах хуваарьтай байв. Гэтэл бид 12-аар сарын сүүлийн долоо хоногт сүүлчийн цалингаа авах байлаа. Тиймээс Бурханд итгэхээс өөр ямар ч зам байсангүй.

Би туслах пастор байхдаа л санхүүгийнхээ төлөө Бурханд найдаж сураагүй байсан бол, шинэ үйлчлэл эхлүүлэхтэй маань зэрэгцэж ирсэн, тэр их дарамтыг яагаад ч дийлэхгүй байсан юм. Тэр дарамт надад дэндүү ахдах байв. Би Бурханаас бус, хүнээс хангамж хайх байв. Би шаардлагатай мөнгөө босгохын тулд янз бүрийн схем зохиох юмуу бусдыг царайчлах байсан бөгөөд үүндээ хамаг хүчин зүтгэлээ зарцуулахдаа, надаар дамжуулж хүмүүст хүргэх гэсэн Бурханы үгийн ажлыг алдагдуулах байсан байх.

Чуулганаасаа авдаг байсан багахан цалин маань үнэндээ ер бусын ерөөл байж таарчээ. Би тэргүүн пастораасаа цалин (хүндэтгэл) нэхэхийг хүссэн найзаа сонссон бол, өнөөгийн энэ байр сууринд хүрэх байсан эсэхийг мэдэхгүй. Үйлчлэлийнхээ эхний жил бид Бурханд долоо хоног бүр мянган доллараар хангаж өгөөсэй хэмээн итгэх ёстой байв. Харин үүнийг бичиж байгаа энэ үеэр бид үйлчлэлээ явуулахын тулд Бурханд долоо хоног тутам \$125,000-ын төлөө итгэх төвшинд хүрээд байна. Гэхдээ хамгийн гайхамшигтай нь би энэ үйлчлэлийг эрхэлсэн гучин жилийнхээ хугацаанд санхүү мөнгөнөөс болж гучин секундын нойроо ч хасч үзээгүй.

Та хүний төлөө ажилладаг бол, тохиролцсон цалин дээрээ тогтоод, бүхий л зүрхээрээ хөдөлмөрлө. Сайн ажлаараа ажил олгогчоо хүндэтгэж, 100 хувийн хүчин зүтгэл гаргабал, эргээд Бурхан таныг шагнана. Энэ шагнал нэг бол ажилтнаар чинь, үгүй бол Бурханы сонгосон аль нэг, өөр эх үүсвэрээс ирнэ. Товчхондоо, та шагнуулна. Чуулган маань бага цалин өгөх үед Бурхан биднийг том шагнасан. Байр маань тавилгаар дүүрч, машинтай болж, ширээ маань хоол хүнсээр дүүрсэн. Бид тийм цалингаар ингэж амьдрах боломжгүй дээ гэж дуу алдмаар л амьдардаг байсан. Бичээсийн “Зөв хүний жаахан юм нь Буруу олны элбэг дэлбэгээс хавьгүй дээр” (Дуулал 37:16) гэдэг үг бидний амьдралд бодитой болсон юм. Бурхан биднийг хүндэтгэжээ.

Дүгнэлт нь? Та ажилтан хүн бол, зүрхэнд тогтоогоод аваарай: Та ажил олгогчийнхоо төлөө 100 хүчин зүтгэж, Бурханыг хүндэтгэбэл, шагнуулна. Нөгөөтэйгүүр, хэрэв та ажил олгогч хүн бол, ажилтнуудаа хүндэтгэсний тань хариуд тэдний дотор хөгжин цэцэглэх бэлэг нь эргээд танд л ач тусаа өгнө гэдгийг мэдээрэй. Ажил олгогч, пасторууд та бүхний хүмүүсийн дотор битүүмжилсэн, Бурханы тэр аугаа шагнал ил гарч ирнэ.

Гэр бүл доторх хүндэтгэл - хүүхдүүд

Нутгийн чуулганд долоон жил үйлчилж, аялан - үйлчлэлд гуч гаруй жил зүтгэсэн энэ хугацаандаа би хүндэтгэл чуулганд юмуу ажлын газарт бус, харин гэр бүлд л ус агаар мэт дутагдаж байгааг ажиглаж билээ. Үнэндээ, аав ээж нар хүндэтгэлийг гэртээ үлгэрлэн харуулбал, энэ нь нийгмийн, иргэний, чуулганы талбарт үлэмж ач тусаа өгөх сөн. Учир нь гэр бүл доторх хүндэтгэл нь хүссэн хүсээгүй, бидний эргэн тойрны хүмүүст нөлөөлж байдаг.

Эцэг эхийн үгийн хүч

Бид урьд урьдын бүлгээрээ үр хүүхэд нь аав, ээжээ хүндэтгэх талаар үзсэн. Тэгвэл аав ээж нь үр хүүхдээ хүндэтгэх нь ялгаагүй чухал. Хүндэтгэх нь үнэлэх явдал. Үр хүүхдээ үнэлдэг л бол, дэлгэрч цэцэглэтэл нь хамаг л сайн сайхан үгээр ярина.

Заримдаа аав, ээжүүд үр хүүхдээ жихүүцмээр муухай доош нь хийж ярьдаг. Тухай нь, аав -хүн танхилхан охиноо ширүүн үгээр жанчих юмуу эсвэл талбай дээр тааруухан тоглолоо хэмээн хүүгээ зандардаг. Эсвэл ээж нь үр хүүхдээсээ ичсэндээ олны дунд шившиглэдэг гэх мэт энэ жагсаалт хөвөрнө.

Эхнэрийг маань өсвөр насанд байхад нь уг нь сэргийлж болох байсан нэгэн явдал тохиолджээ. Лиза тун хөдөлгөөнтэй охин байсан

бөгөөд жиндээ хэзээ ч зовдоггүй байжээ. Тэрбээр зуны зуслан дээр биеийн тамирын хичээл дээрээ жинлүүлж үзсэн бөгөөд жингийн нэмэгдэл бүр нь эрүүл өсөлтийн үзүүлэлт байв.

Лиза бүтэн жил шахуу хоёр багт сэлсэн байж. Тиймээс ер нь дуртай үедээ хүссэн юмаа идэж орхидог байжээ. Тэгтэл ахлах сургуулийнхаа эхний жилд гэмтээд, сэлэлгүй, сэлгээнд суудаг болсон байна. Тийнхүү хөдөлгөөн нь багассан ч, бэлтгэлийн үеэр иддэг байсан хоол тэжээлээ идсээр байж.

Нэг удаа Лизаг хичээлээсээ харьж явтал, аав нь дууджээ. Тэгээд охиноо дээрээс доош нь таагүй харцаар харснаа, эргээтэх гэжээ. Тэгж тэгж “Хүү минь, наад өмд чинь задрах нь! Жин чинь хэд юм?” гэж асууж. Лиза ч зуслан дээр үзсэн жингээ хэлсэн байна.

Гэтэл аав нь “Яалаа гэж тийм бага байдгийм! Дор хаяж 60кг биз! Явж жингээ үз!” гэжээ.

Лиза маань ихэд ичэж, эргэлзсээр хариад, аав ээжийнхээ угаалгын өрөөний жин дээр гарч зогссоноо бараг 65 кг заахыг нь үзээд, цочирджээ.

Лиза жингээ аавдаа хэлтэл, аав нь түүнд жаахан охинд дэндүү гэмээр хатуудсан үг хэлсэн байна. Ийм царай муутай, бүдүүн охиныг хөвгүүд ч тоохгүй. Аавын лекц дууссаны дараа Лиза өрөөндөө ороод, хувцсаа тайлаад, биеэ сайтар харснаа амьдралдаа анх удаа биеэ үзэн яджээ.

Түүнээс хойш Лизагийн амьдралыг жолоодогч хүч нь жин болсон байна. Тэрбээр биеийнхээ хэмжээнд бараг л донтож, өдөржин шөнөжин жингийнхээ талаар л боддог болж. Лиза гүйж, хоолоо хассан бөгөөд үр дүн ч гарч. Хөвгүүд ч Лизад анхаарч, Лиза ч үүнд баяртай байв. Эцэстээ түүний тархинд *Би туранхай байвал, хүчтэй, үнэ цэнэтэй, дурлам, анхаарал татам байна. Би тарган байвал, хэн ч биш* гэсэн ойлголт боловсорчээ.

Энэ сэтгэлгээ нь түүнийг уруудуулсаар, эцэстээ тэрбээр хэт өлсөх бас хэтрүүлж идэх өвчин туссан байна. Лиза хоолыг нэгэн зэрэг хайрлаж, үзэн яддаг болжээ. Сайхан хоолонд дуртай хэр нь таргалахыг үзэн ядна. Тэр гэдэс цэвэрлэх янз бүрийн цай, бэлдмэл хэрэглэх болсоор, коллежийн нэгдүгээр дамжаа гэхэд, бие нь тэдгээр эм бэлдмэлдээ донтсон байв. Эцэстээ бүтэн сараас илүү хугацаанд хүндрээгүй учраас, эмнэлэгт хэвтжээ. Хорин хоёр насанд нь Бурхан Лизаг тал бүрээр нь эдгээсэн бөгөөд тэрбээр энэ хүчирхэг гэрчлэлээ *You Are Not What You Weigh* гэдэг номдоо бичсэн байдаг.

Гэхдээ аав нь Лизагийн нөхцөл байдалд өөрөөр хандсан бол, энэ байдлаас сэргийлж болох байсан эсэх талаар та гайхаж байна уу? Аав нь охиныхоо төрхийг доош хийхийн оронд, байгаагаар нь хүлээж авсан, хайрласан үг хэлсэн бол, яах байсан бол? Хэвийн жинтэй байх, эрүүл хооллох талаар арай зөв зүйтэй аргаар хэлсэн бол? Лизагийн өөрийгөө харах имиж өөр байх байсан болов уу?

Энэ явдал бидний гэрлэлтийн амьдралд хэрхэн ажиллаж байгаагийн баталгааг би харсан. Лизатай анх гэрлэхэд тэрбээр 52 кг байв. Би ч эхнэрээ хичнээн ганган, хөөрхөн болохыг нь зогсоо зайгүй магтана. Би гэргийгээ гэрлээд жил өнгөрсөн хойно ч, бие давхар байхад нь ч, хүүгээ төрүүлснийх нь дараа ч магтаж, сайшаасаар л байлаа.

“Чи минь сайхан шүү. Намайг хорьтой байхад “эхнэр чинь гэрлээд олон жил өнгөрсөн хойноо ч хөөрхнөөрөө байсаар байна” гэж хэлсэн бол, би ч баярлаад барахгүй байх байсан! Чи минь анх гэрлэж байснаасаа ч илүү хөөрхөн болод байх юм” гээд л олон жилийн турш үнэн голоосоо л магтдаг байв. Би байнга л Лизаг босгон байгуулах арга замыг хайдаг байсан маань миний давуу тал байсан байх л даа. Энэ маань Лизагийн эр нөхөр миний Бурханаас хүлээж авсан нэгэн үүрэг байлаа.

Паул ч энэ талаар хэлсэн: “Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие адил хайрлах ёстой. Эхнэрээ хайрлагч нь өөрийгөө хайрладаг. Учир нь хэн ч хэзээ ч өөрийн махбодыг үзэн яддаггүй, харин ч *тэжээж*, халамжилдаг. Христ мөн чуулганд ийнхүү ханддаг” (Ефес 5:28-29, тодруулгыг нэмэв). *Тэжээх* (тордох) гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Энэ нь өсөлтөд шаардлагатай зүйлийг нь өгөх гэсэн утгатай. Тиймээс би ч гэргийгээ үгээрээ тордох арга замыг байнга хайдаг. Энэ нь хүндэтгэлийн нэгээхэн хэсэг учраас, би энэ талаар дараагийн бүлгээрээ дэлгэрэнгүй өгүүлнэ.

Тэгээд намайг гэргийгээ тордох хооронд Лиза ч Бурхан түүнийг эдгээх үедээ өгсөн амлалт, цэц ухаанд үргэлжлүүлэн итгэсээр байлаа. Бурхан ч Лизагийн зовниж байгаа юмсыг үргэлжлүүлэн тэгшитгэсээр байв. Миний дэмжлэг ч гэргийд маань Бурханд ямар ч саадгүй итгэх уур амьсгалыг бүрдүүлж өгчээ. Гучин долоон жилийн ханилж, дөрвөн хүүтэй болсныхоо дараа гэргий маань анх гэрлэхдээ тээж байсан жин дээрээ л байна. Лиза маань тэгтэл их дасгал хийдэггүй учраас, хүмүүс цаанаасаа таргалдаггүй хүн гэх байх л даа. Гэхдээ би хорь дөнгөж гарч яваа, жинтэйгээ тэмцэлдсэн, өөртөө итгэл муутай, аймхай охиныг мэднэ шүү дээ.

Хүүхдүүд бол шагнал

Аав ээж нар үр хүүхдээ сөрөг, хатуу хэл амаараа төдийгүй мөн хэрэгтэй цагт нь хүлээж авсан, магтан сайшаасан үгээ харамлах арга замаар үл хүндэтгэдэг. Хүүхдүүд урам, чиглүүлэг, баталгаагаар байнгын ус агаар шиг л дутагдаж явдаг. Тиймээ хайрлаж, үнэлж байгаагаа хэлэх, харуулах ёстой. Эс бөгөөс тэд эдгээрийг буруу газраас хайж эхлэх л болов уу. Хөвгүүд охид маань таалал хайдаг бөгөөд аав ээж нь төлөвшөөгүй байгаа, нялх чанар, сул тал дээр нь дэвслээд байвал, буруу ойлголт бүрэлдүүлж, хүүхдүүдээ өсгөж, төлөвшүүлэхэд шаардлагатай юмсаас яг эсрэг юмсыг нь хурааж авна.

Ганц сайхан үгээр зохицуулаад, хор хохирлоос сэргийлж болох байтал, заавал гүн шарх үүсгэж, яртуулж л байдаг. Гэхдээ ийм аав ээжүүд ирээдүйд бий болох үр дагавар дунд өөрийнхөө гүйцэтгэсэн үүргийг хардаггүй нь ээдрээ гэх үү. Тэд үр хүүхэд нь хэцүү хатуу байгааг амаа задартал муулдаг ч, шүүмжлээд байгаа чанарыг нь хүндэтгэлээр дамжуулан амархан илааршуулж болох нь олонтаа.

Аав ээж нарын үг үр хүүхдийнх нь амьдралд жинтэй тусдаг. Ялагдал, бүтэлгүйтэл, сул доройтлыг зөгнөсөн үг нь үр хүүхдийнх нь амьдралд наанадаж саад, цаашилбал бүр ч хүнд асуудал дагуулах чадалтай. Аав ээж нар үр хүүхдийнхээ таагүй гэж харсан зан авирт урам хугарснаас болж, энэ ёрын тойрог эхэлдэг юм. Тэр даруй анхаарал тавихгүй бол, энэ сөргөөнтэй харилцаа нь аав ээжийг Бурханаас үр хүүхдээр нь дамжиж ирдэг бэлгээс чангаана.

Харагтун, үр хүүхэд ЭЗЭНээс ирэх өв, Умайн үр жимс нь шагнал болой. (Дуулал 127:3)

Энэ бичээс бидэнд үр хүүхдээр маань дамжин ирэх шагналыг шууд хэлжээ. Аав ээж - үр хүүхдийн харилцааны энэ амлалтыг аав ээжүүд дээдэлдэг ч болоосой. Амьдрал дээр яг эсрэгээрээ өрнөх нь даанч их. Аав ээж нар өсч яваа үр хүүхдийнхээ талаар: “Ёоо, хорин нас хүртэл нь гинжилж байгаад л гэрээсээ нэг мөр явуулчихаж болдогсон бол. Энэ өсөлтийн нас нь яасан ч дуусдаггүй юм” гэхийг байнга сонсоно. Хөвгүүд маань нялх байхад л хүмүүсийн ийм үгийг сонсдог байлаа. Тэгээд санаа зовнин, дотроо *Хөвгүүд өсвөр насанд хүрэхээрээ мангас болчихдог юм байх даа?* хэмээн өөрийн эрхгүй бодох болж билээ.

Тийм боловч би бусад аав ээжүүдийн тэр бүр хардаггүй ухаарлыг олж

авсандаа олзуурхан, таныг бодсондоо л хуваалцмаар байна. Ууганаагаа хоёртой байхад, би залуусын пастораар үйлчилдэг байлаа. Пастор хүн чинь олон гэр бүлд зөвлөж, тэдний аж амьдрал руу өнгийж явахдаа, нэг их удалгүй нөгөө хэв загварыг олж харсан билээ. Үр хүүхдийнхээ сөрөг үйлдлийг шүүмжлэхэд л анхаарч, хамаг эрч хүчээ зарцуулдаг аав ээж нар үр хүүхэд нь улам л муудахыг хардаг аж. Харин аав, ээж нь үр хүүхдийнхээ дээр Бурханы амлалтыг тунхаглах юм бол, үр хүүхэд нь эцэстээ тэр үгээр хэлбэршдэг аж. Үүнийг ч Коринтод бичсэн Паулын хоёрдугаар захидал улам батжуулах: Бид үзэгдэх юмсыг бус, харин үл үзэгдэх юмсыг хардаг. Учир нь үзэгдэх юмс бол цаг зуурынх, харин үл үзэгдэх юмс мөнх билээ (4:18).

Бурханы амлалт нь Түүний үл хувирах Үг дотор тогтох, үл үзэгдэх үнэний талбар дотор орших бөгөөд бид үүн дээр л төвлөрөх ёстой юм. Лиза, бид хоёр үр хүүхдийнхээ дээр байнга Бурханы амлалтыг шивнэдэг. Хүүхдүүдээ ярьж эхлээ ч үгүй байхад л “Хамаг хөвгүүн чинь ЭЗЭНээр сургагдана, Хөвгүүдийн чинь амар тайван нь агуу их болно” (Исаиа 54:13), “Залуу хүний хөвгүүд Дайчны гарт буй сум адил” (Дуулал 127:4), “ЭЗЭНий надад өгсөн хүүхдүүдийг болон намайг харагтун. Бид, Сион уулан дээр оршигч, түг түмдийн ЭЗЭНээс Израильд өгсөн тэмдэг, гайхамшгууд мөн” (Исаиа 8:18) хэмээн дууддаг байлаа.

Бид хөвгүүдийнхээ нэр алдрыг ч үгийнх нь үндэс язгуурыг судлан байж, Бурханы чиглүүлгийн төлөө залбиран байж өгсөн. Чихэнд нь нэрийг нь шивнэнэ гэдэг шиг л нэрээр нь дамжуулж хувь тавиланг нь тунхаглах гэсэн юм. Ууган - Аддисон Давидын нэр “Итгэмжит, хайрлагдсан хүү” гэсэн утгатай бол, удаах хүү Аустин Майклын нэр “Бурханыг дуурайсан, язгууртан” гэсэн утгатай. Гурав дахь хүү Йошуа Александр маань “Бурхан хүн төрөлхтнийг аварч, хамгаалдаг” гэсэн нэртэй. Харин Отгон - Арден Кристоферын нэр “Христийг дуурайсан, гал цогт хүү” гэсэн утгатай билээ.

Нэрийг нь дуудах тоолондоо, бид хөвгүүдийнхээ дээр юу дуудаж байгаагаа мэддэг. Аав ээжийнх нь хувьд бид хоёр хөвгүүдийнхээ дээр ерөөл буулгах, Бурханаас заяасан эрх мэдэл, аз завшаантай гэдгээ ч мэднэ. Гэхдээ бид хоосон тунхагласан учраас биш, харин тунхагласан үгдээ итгэсэн учраас, хөвгүүд маань ч тус бүр нэр алдраа даган боловсорсоор байна.

Ерөөгөөд байхад л хөвгүүд маань эсрэгээр авирлах үе байсан уу? Байхгүй гэж бодох нь дэндүү гэнэн явдал болно. Тэд нэр нь

хүндэджээ гэмээр ааш авир гаргах үе зөндөө л байсан. Бид хоёр ч хөвгүүдээ засч залруулж, хүмүүжүүлсэн. Гэхдээ авир үйлдлийг нь тусад нь шийдвэрлээд, зан чанарыг нь хамгаалдаг байсан юм. (Дашрамд хэлэхэд: бурханлаг зөрчил нь сайн. Гэхдээ авир үйлдлийг нь шийдвэрлэхийн оронд зан чанар руу нь дайраад байвал, хүчин зүтгэл маань талаар өнгөрнө)

Гэр бүлийн эмгэнэл

Миний бие залуусын пастор байхдаа, амьдралаас өөр нэгэн том сургамж авч билээ. Энэ нь хэрэгтэй үед шаардлагатай сахилгажууллыг хэрэгжүүлэхгүй байхын эмгэнэл юм. Амьдрал дээр гэрчлэн харсан, тэр нэгэн явдлын талаар ярихаасаа өмнө эхлээд энэ талаар Бичээсээс жишээ татъя.

Давид хаан дөрвөн эхнэрээс олон хөвгүүдтэй болжээ. Бүгдээрээ түүний ууган хүү Амнон, гурав дахь хүү Абсалом дээр төвлөрөе. Амнон нь эцэг нэгтэй, эх өөртэй Абсаломын охин - дүү Тамарт жигшүүрт хэрэг үйлджээ. Амнон өвдсөн дүр эсгээд, ааваасаа Тамарын гараас зоог хүртмээр байна гэж гуйж. Тамарыг ирэхэд нь Амнон зарц нараа гаргаж байгаад, охиныг хүчиндсэн байна. Тэгмэгцээ харахаас жигшиж, өрөөнөөсөө хөөж явуулжээ. Амнон хааны онгон гүнжийг бузарлан, амьдралыг нь шившиглэн сүйрүүлэв.

Тамарын төрсөн ах Абсалом охин дүүг нь бузарласан, эцэг нэгт ах - Амноны үйлдлийг жигшин хилэгнэж, үзэн ядсан ч, хаан эцэг нь Амноныг шударгаар шүүж, сахилгын арга хэмжээ авах байлгүй хэмээн харж, чимээгүй хүлээжээ.

Цаг хугацаа өнгөрсөөр. Хаан хэдийгээр Амнонд дургүйцсэн ч, юу ч хийсэнгүй. Абсалом байж суух газраа олж ядав. Тэрбээр Тамар дүүгээ гэртээ авчраад, асран хамгаалжээ.

Тамар нэгэн цагт хааны онгон охин - хүүхдийн л өмсдөг язгууртны нөмрөгөөр гоёдог байсан бол, эдүгээ ичгүүр л нөмрөх болжээ. Нэгэн цагт хүн ардын хайрыг булаадаг байсан хацар гоо залуу охин эдүгээ хүн амьтны нүднээс далдуу амьдарна. Онгон биш хүүхнийг одоо хэн авахыг хүсэх билээ? Дэндүү гэмээр шударга бус явдал. Тэр охины амьдрал дуусчихаад байхад, ийм булай хэрэг үйлдсэн эр нь юу ч болоогүй мэт амьдарсаар л. Энэ явдлын өмхий самхайг амьдралгүй гэмээр болсон Тамар л ганцаараа үүрчээ.

Абсалом өдөр бүр гашуудалдаа идэгдэж суугаа охин дүүгээ харсаар. Гүнж хүний мөрөөдөл эдүгээ хар дарсан зүүд л болжээ. Абсалом жил хүлээсэн ч, аав нь юу ч хийсэнгүй. Ийнхүү Абсалом зүрхэндээ Амноныг үзэн ядахаас гадна одоо бас аавдаа зэвүүрхэх болов.

Хоёр жил өнгөрч, Амноныг үзэн ядах Абсаломын мэдрэмж нь охин дүүгийнхээ өшөөг авахын төлөө нарийн боловсруулсан аллагын санаа болж хувирчээ. Яагаад болохгүй гэж? Эрх мэдэлтнүүд нь юу ч хийхгүй байхад. Абсалом Давидын хөвгүүдэд зориулж найр наадам хийж байхдаа, юу ч гадарлаагүй Амноныг алж хаяад, өөрөө Гешур руу зугтжээ. Амноноос авах гэсэн Абсаломын хор хонзонгийн улайрал тайлагдав. Тийм боловч цөллөгт байх энэ хугацаандаа нүдэн балай аашилсан аавдаа улам л гоморхон харлах болсон байна. Дээрээс нь *Аав яагаад миний араас ирэхгүй байна?* гэсэн бодол гал дээр тос нэмнэ. Гомдол нь яваандаа үзэн ядалт болов.

Абсалом хорсолдоо хордох хоорондоо Давидын сул талын мэргэжилтэн болжээ. Шүүмжлэлийн өнгөлгөө амьдарлыг нь хэгэв. Тийм боловч, аав нь дуудуулах байх хэмээн горьдсоор. Гэтэл Давид дуудсангүй. Үзэн ядалт ч буцалсаар.

Абсалом дотроо ингэж л бодоо байх: *Хүмүүс аавын жинхэнэ төрхийг мэдэхгүйдээ л түүнийг алдаршуулдаг. Гэтэл тэр Бурханаар халхавчилсан, аминдаа хайртай амьтан. Үнэндээ тэр Саулаас ч долоон дор! Саул Амалекийн хааныг амь хэлтрүүлж, хэдэн тарган хонь, үхрийг нь авч үлдсэндээ, хаан суудлаа алдсан. Гэтэл аав журамт цэргийнхээ эхнэртэй садарлаж, нүглээ нуух гэж үнэнч цэргээ алуулсан. Аав алуурчин, завхай этгээд - тиймээс ч Амноныг шийтгээгүй!*

Абсалом Гешурт гурван жил амьдрал. Амноныг гэх Давидын гашуудал тайлагдмагц, Иоаб түүнийг Абсалом хүүгээ Иерусалимд эргүүлж авчир хэмээн ятгаж дөнгөжээ.

Цаг хугацаа өнгөрсөөр. Абсаломын үзэл ядалт лавширсаар, тэрбээр өөртэй нь адил аавд нь гомдолтой хүмүүсийг соронздох болов. Үүнийгээ ч Израильд санаа тавих аргаар гүйцэлдүүлжээ. Тэрбээр хүмүүсийн гомдлыг сонсохдоо, хаан маань тэдэнд тусладаг ч болоосой. Даанч туслахгүй юм даа хэмээн байдлыг гаргаж тавин, халаглана. Абсалом хааныхаа цаг гаргаж чадахгүй байгаа хэргүүдийг барьж аван, шийдвэрлэдэг болов. Магадгүй өөрөө амьдралдаа шударга бусыг үзсэндээ тийн үйлдсэн юм болов уу. Тэрбээр гаднаа хүмүүст үнэн голоосоо санаа тавих мэт харагдана. Библи, Абсаломыг Израилийн зүрхийг Давидаас өөртөө урвуулсан гэдэг. Гэвч Абсалом

үнэхээр хүмүүст санаа тавьж байв уу эсвэл үзэн ядах болсон төрсөн эцгээ зайлуулах арга зам хайж байв уу?

Абсалом Израилийг өөртөө урвуулж, аавыгөө сөрөн хүчирхэгжив. Зөрчил хурцадсаар, Давид хаан амиа авран оргохоос аргагүйд хүрчээ. Нэг хэсэг ч Абсалом юу юугүй шинэ хаан болохоор харагдаж байсан ч, Давидыг элдэж явахдаа амиа алдсанаар нь нөхцөл байдал эргэв. Давид хаан хүүд нь хуруугаа ч хүргэхгүй байхыг зарлигдсан ч, шүүх буужээ.

Абсалом өөрийнхөө үзэн ядалт, хорсолдоо идүүлжээ. Хаан ширээ залгалжлах заяатай, туйлын хүчин чадалтай залуу ид насан дээрээ амиа алдав. Аав нь Амноныг засч залруулсан бол, ийм явдлаас сэргийлж болох байсан уу? Өндөр магадлалтай. Тэгвэл Тамарын тухайд? Тэр охин гав ганцаараа гашуудсаар амьдралаа бараа байх. Аав нь Амноныг шийтгэсэн бол, Тамарын амьдрал өөрөөр эргэх байсан болов уу? Мэдээж. Давид хүүхдүүдээ хүндэтгээд, бурханлагаар хүмүүжүүлсэн бол, ийм айхтар аюулаас сэргийлж болох байсан гэж би итгэдэг. Давид хүүгээ сахилгажуулалгүй өнгөрснөөрөө, хүүхдүүдээ хүндэтгээгүй юм.

Эс сахилгажуулсны үл хүндэтгэл

Одоо бүгдээрээ намайг залуусын пастор байхад тохиолдсон, тэр нэгэн явдал руу эргэе. Аав ээж нар сахилгажуулалд итгэдэггүй учраас л үр хүүхдийнхээ асуудлаар миний албан өрөөнд олонтаа суудаг байлаа. Тэд Давид хаантай л адил үр хүүхдээ сахилгажуулахаас зайлсхийх. Тэд хүү, охиныхоо том толгойлох явдлыг “хайраараа” л хайлуулж эргүүлэх юм гэв ч, энэ нь бүтдэггүй байлаа. Үр хүүхэд нь авахын аргагүй нөхцөл байдалтай, хэн хэн нь хүндэтгэхийг огт мэдэхгүй, тэрслүү бөгөөд энэ хандлагаа ажил, сургууль, залуусын бүлэг гэх мэт амьдралынхаа тал бүр дээр цацдаг байв.

Хамгийн сонирхолтой нь сахилгажуулалтыг үзэлгүй, “хайрлуулж” өссөн тэр залуус ихэвчлэн аав ээжээ жигшдэг байлаа. Ээдрээтэй ч, эмгэнэлтэй ч явдал. Учир нь аав ээжийнх нь хийхийг хичээсэн яг л тэр зүйл буюу үр хүүхдийнхээ хайрыг олох гэсэн оролдлого нь харин ч эсрэгээрээ эргэж, талаар болжээ. Эмгэнэлтэй. Яагаад гэвэл тэр хүүхдүүд гэр бүл нь ирээдүйд яаж төлөөд ч барашгүй, аюул авчрах, урхагтай шийдвэр гаргасан юм.

Миний ажлын өрөөнд суугаа аав ээжтэйгээ зохисгүй харилцаж байгаа нэгэн охиныг зад загнаж зассан маань санагдана. Тэгээд

Яахаараа аав ээж нь биш, би үүнийг хийнэ вэ? гэж бодсон сон. Бурханы Үг хэлээд байхад л, аав ээж нь тэр задарсан охиныг хайраараа л засч залруулна хэмээн зүтгэсээр байлаа. Бурханы Үг дээр үр хүүхдээ хүмүүжүүлдэггүй аав ээж нар нь үнэндээ үр хүүхдээ үзэн яддаг гэдэг:

Хүүгээ саваанаасаа хэлтрүүлэгч нь түүнийг үзэн ядагч юм.
Хүүгээ сахилгажуулахдаа хойрго бус нь түүнийг хайрлагч юм
(Сургаалт үгс 13:24).

Тэр залуус өсч том болоод, замарсан амьдралтай хүмүүс болохыг би үзсэн. Тэд жаахан байхад нь зүй зохистой арга замаар сургаснаар сэргийлж болох байсан үй түмэн алдаа завхралд унадаг. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл “Саваа, гэсгээлт хоёр мэргэн ухааныг өгнө, харин зөнгөөр өссөн хүүхэд эхийгээ гутаах” (Сургаалт үгс 29:15). Яагаад тэр аав ээж Бурханы Үгийн зөвлөгөөг сонссонгүй вэ? Тэд өөрсдийгөө илүү ухаантай гэж бодохдоо, үнэндээ Бурханыг ч, үр хүүхдээ ч үл хүндэтгэжээ.

Яг л ижил загвар: Аав ээж нь үр хүүхдээ хүмүүжүүлэхгүй бол, үр хүүхэд нь том болоод аав ээжээ жигшдэг. Нөгөөтэйгүүр бас аав ээж нь хэтэрхий хатуу харгис бөгөөд үр хүүхдээ хүндэтгэдэггүй бол, үр хүүхэд нь аав ээжээ эсэргүүцэж өсдөг. Тэдний голдуу сэтгэлдээ олсон шарх нь зан чанарыг доголдолд хүргэдэг байна. Олонх нь айдастай тэмцэлдэж явдаг.

Үр хүүхэд маань буруу авир үйлдэл гаргах үед товч тодорхой сахилгажуулаад өнгөрөх нь хамгийн үр дүнтэй байдгийг бид сурсан. Хүүхэд буруугаа ойлгоо л бол, бүх юм дуусна. Үргэлжлүүлэн хорсоод л, уурлаад л байх нь эрүүл бус. Бид үтэр түргэн тэврэлдэж уучлалдаад л, инээлдэж хөхрөлдөөд л явчихдаг. Хүүхдүүдээ уучлаа л бол, юу ч болоогүй юм шиг л байцгаана. Бурхан ч биднийг уучилсан хойноо нүглийг дахин санадаггүй. Сахилгажуулалт гэдэг нь алдаанаас нь сургамж өгөх явдал бөгөөд ямар ч ял тээвэрлэдэггүй.

Лиза маань асаргаа, хайр, халамжаараа хүүхдүүдээ хүндэтгэхэд онцгойлон анхаардаг бол, миний хувьд, тууштай бурханлаг сахилгажуулалтыг дэмждэг. Бид хоёр бие биеийнхээ хүчинд түшиглэж сурсан. Би Лизагаас үг, биеэрээ хайраа харуулахыг сурсан бол, Лиза надаас сахилгажуулалтын үнэ цэнийг сурсан. Тус тусад маань өгсөн Бурханы хүчийг нэгтгэснийхээ ачаар бид хоёр Бурханы ерөөл үр хүүхдийн маань амьдралыг тойрон эргэлдэхийг харсан билээ.

Санаснаас түргэн ирсэн шагнал

Ууган хүү Аддисон маань ахлах сургуулиа тэргүүний сурагч өргөмжлөлтэй төгсөж, улсдаа шилдэг аравт багтдаг бизнесийн нэгэн их сургуульд элссэн билээ. 2005 оны 9-ээр сард хичээл нь эхлэх хуваарьтай байлаа.

Зуныхаа амралтаар Аддисон урьдын адил манай байгууллагад ажиллав. Долдугаар сарын эхээр хүүгээс дуудлага хүлээн авлаа. “Аав аа, тантай ярих юм байна” гэж хэлэхдээ, жаахан тэвдсэн санагдав.

Ноцтой юм хэлэхийг нь ойлгомгоцоо, би ч сэтгэлээ базаагаад: “Тэг л дээ. Миний хүү ярь, ярь” л гэлээ.

“Аав, би Их сургуульд сурмаагүй байна. Би байгууллагадаа үйлчилмээр байна. Ээж, та хоёрт Үгийг түгээхэд тусалмаар байна.”

Би ч хариулах гэж ядсангүй. Миний Хүү Бурхантайгаа хөл бат нийлүүлдэг залуу бөгөөд залбиралгүйгээр надтай ийм юм ярих хүн биш гэдгийг би мэднэ. Түүний зөв гэдгийг зүрх маань хүлээн зөвшөөрч, дотроос үлэмж хүндэтгэл, баяр хөөр олгойдов. Тэгээд “Ямар сайхан мэдээ вэ! Хүүгээ багтаа дуртайяа хүлээн авна” гэж хэллээ.

Тэгэхээр, одоо дараагийн жил хагасын дотор юу болсныг ярьж өгье. Аддисон ажилд ороод хэдхэн сар болж байтал, хүний нөөцийн захирал маань хүрч ирээд, Аддисоныг чуулган хариуцсан хэлтсийн захирлаар томилох санаагаа хэлэв. Тус хэлтэс нь хэдэн жилийн өмнө байгуулагдсан бөгөөд манай байгууллагаас гаргадаг олон тооны ном, сургалтын материалаар чуулган, пасторуудыг хангах ажлыг хариуцан гүйцэтгэдэг билээ. Үүнийг бичиж байх үеэр Америкт л гэхэд хорин тав орчим мянган чуулган, Австралид мянга гаруй чуулган манай материалыг хэрэглэдэг болоод байна.

Аддисон миний хүү учраас, тушаал дэвшүүлэх санал төрөөгүй ажээ. Би ч өөрийнхөө хүүхдүүдэд онцгой эрх олгохгүй гэдэг хатуу зарчимтай хүн. Үнэндээ, хүүхдүүд маань гэртээ хүүхэд минь, ажил дээрээ ажилтан маань болох ёстой учраас, харин ч бусдаас илүү дарамт үүрдэг байх. Тиймээс хүний нөөцийн захирал маань Аддисоны ажлын гүйцэтгэл, удирдах ур чадвар дээр үндэслэж л ийм хүсэлт тавьж байгааг ойлгов.

Би ч түүний саналыг хүлээж авсан ч, үр дүнг нь алмайрч билээ. Жилийн дотор чуулган хариуцсан хэлтэс маань гурав дахин өсөв. Би ч аялсан газар бүрээсээ л Аддисоны хэлтсийн мундаг залуустай маш сайхан гар нийлж ажиллаж байгаа гэсэн пасторуудын түүхийг сонсдог болов. Аддисон маань баг босгон байгуулах, хөдөлгөх бэлэгтэй бөгөөд

аюултай халдвартай, эрч хүчтэй залуу. Тэрбээр удирдах хугацаандаа цаг наргүй пасторуудын төлөө залбирна, асуултад нь хариулна, хүсэлтийг нь биелүүлдэг байв.

Тэгээд би нэг зүйлийг ухаарсан юм. Бурхан хүүгээ хүндэтгэсний минь төлөө, хүүгээр минь дамжуулан надаар тогтохгүй, манай байгууллагыг бүхлээр нь ерөөжээ. Есүс биднийг хамгийн бага нэгнийг хүндэтгэсэн ч, шагнуулна гэсэн. Ууган - Аддисон маань бидний ачаанаас хөнгөлж, харилцааг маань миний хэзээ ч төсөөлж яваагүй арга замаар тэлсэн билээ. Үнэндээ хаанчлалын зарим нэг гайхамшигтай харилцаа хүүгээр минь л дамжиж үүссэн байдаг. Хориодхон настай залуугийн дотор ийм их зүйл байх юм чинээ яаж мэдэх билээ? Үүгээр тогтохгүй, миний хэзээ ч очиж чадахгүй олон чуулган манай материалаар дамжин Бурханы Үгийг хүлээн авсан юм. Энэ чинь төдий чинээ л олон хүн мөнхийн нөлөөлөл хүлээн авсан гэсэн үг!

Хожим манай хүний нөөцийн захирлыг тэтгэвэрт гарах үед удирдлага маань санаа нэгтэйгээр Аддисоныг үйл ажиллагаа хариуцсан захиралд дэвшүүлсэн юм. Аддисон ч тэр байр суурийг хүлээн авсан бөгөөд хэдхэн жилийн дотор баг дотор маань үгээр илэрхийлэхийн ч аргагүй эв нэгдэл, үр нөлөө цогцлон бий болж билээ. Байгууллага маань төсөөлж ч яваагүй их үйл хэргийг гүйцэлдүүлэв. Ер бусын үр дүн, хөгжилтэй сайхан уур амьсгал - үйл хэрэг маань урамтай сайхан урагшилсаар явна.

Удаах хүү Аустин маань коллежоо төгсөөд, жилийн дотор л манай багт нэгдэн, маркетингийн менежер болсон бөгөөд ажиллаж эхэлсэн цагаасаа л үгийг түгээн дэлгэрүүлэх шинэ, шинэ санаа гаргаж ирэв. Аустины багийнхан Лизагийн бичсэн “*Өрсөлдөгчгүй*”, миний бичсэн “*Криптонитыг устга*” номыг Нью-Йорк таймсын бэстсэллэрийн жагсаалтаас гадна *USA Today* тэргүүтэй олон тооны үндэсний болоод олон улсын шилдгийн жагсаалтад оруулсан билээ. Лизаг дараагийнхаа номыг хэвлүүлэх үед хэвлэлийн газар нь сургчилгааны ажлыг нь Аустины багаар хийлгүүлэх санал хүртэл тавьсан юм шүү.

Гурав дахь хүү Алек маань инженерийн сургуулиа дүүргээд манай багт орсон. Хүүгийн маань ертөнцийг өвөрмөцөөр харах авъяас хүмүүсийн хуяг дуулгыг тайлж, хатуу үнэнийг хүргэдэг, богино хэмжээний кино хийх чадвар хайрлажээ. Хүчирхэг агуулгатай кино нь Ютүб, Фэйсбүүк дээр олон сая удаа тоглогдож, хүмүүсийн амьдралд жинтэй хүрсээр байна. Харин өнөөдөр хүү маань манай Мессенжер Студи гэдэг уран бүтээлийн компанийг удирдаж явна.

Отгон хүү Арден маань Виржиниа мужид болоод Австрали улсад нутгийн чуулгануудад амжилттай үйлчилж ирээд мөн л манай багт ажиллаж байна. Хүү маань ирснээсээ хойш эдүгээ цагийн 6-24 насны залууст Үгийг хүргэж, нөхөрлөл дээр тулгуурлан харилцах зорилготой “Хөвгүүд, охид” нэртэй Мессенжер Интернэйшнэлийн нэгэн салбарыг үүсгэн байгуулсан юм. Би ч энэ талаар очсон газар бүрээсээ л сонсдог бөгөөд эв нэгдэл, ариун амьдралыг онцлон тэмдэглэж, Есүсийн төлөө дэлхийг байлдан дагуулахаар шатаж байгаа залуусыг хараад жигтэйхэн баярладаг.

Би хөвгүүдээ биширдэг. Олон ч жил би: “Аав аа, энэ хөвгүүд миний хөвгүүд биш, Таны хөвгүүд. Би Таны хүүхдүүдийн нярав төдий л хүн. Тиймээс Эзэн минь, тэдний дотор хүссэнээ гүйцэлдүүлээрэй. Тэднийг авахыг таалбал, тааллаар тань л болог. Гэхдээ эхлээд амьдралд нь хандсан хүслээ заавал биелүүлээрэй” гэж залбирсан сан.

Би үнэн голоосоо залбирсан. Магадгүй хожмын нэг өдөр бид өөр, өөрийнхөө уралдааныг дуусгахын тулд зам салж болох ч, ямартаа ч өнөөдрийг хүртэл Бурхан бидэнд хөвгүүдтэйгээ хамтран ажиллахыг соёрхсон бөгөөд бид бүгдээрээ Бурханы хайрласан бэлгээр хүмүүсийн амьдралд нөлөөлөх үйлсдээ хайртай.

Лиза, бид хоёр тавиад насныхаа сүүлээс залгамжлал дээрээ анхаарах болсон бөгөөд шинэ үеийнхэн маань бидний мөрөөдөж ч зүрхлээгүй арга замаар цэцэглэн хөгжиж байгааг харах шиг жаргал алга. Хоёр хүү маань томоохон хэвлэлийн компанитай гэрээ байгуулсан болохоор, Бурхан хөвгүүдээр маань дамжуулан хүмүүсийнхээ төлөө юу хийхийг бишрэх л үлдлээ.

Ганц би биш, ер нь хөвгүүд охидоо хүндэтгэдэг хүмүүсийн амьдралд ийм л загвар хөвөрдөг. Үр хүүхдээ үнэ цэнэтэй гэж үзбэл, тэд цэцэглэж, тэднийг хүндэтгэсэн хүмүүсийг ч Бурхан баттай шагнана. Тэр шагнал нь хүмүүст өнө мөнхийн үр нөлөө авчрах үйлсийг маань улам л үр бүтээмжтэй болгоно. Энэ бол Бурханы Үг, энэ бол Бурханы төлөвлөгөө, энэ бол Есүсийн амаараа айлтгасан сүнсний хууль болой. Аав ээж нар үр хүүхдээ Бурханд хайртай, дуулгавартай хүмүүс болгохын төлөө хүндэтгэж, хайрлаж, хүмүүжүүлж чадбал, бидэнд бурханлаг шагнал амласан. Бид насныхаа бөгсөн дээр зовох биш, жаргалаа эдэлнэ. Энэ амлалт өтөл насны маань багана, хүч байх болно.

Гэр бүл доторх хүндэтгэл - гэргий

Айл гэрт дан ганц хүүхдүүд нь ч бус мөн гэргий нь ч эрх мэдэл дор байх ёстой юм. Бид өмнө гэргий хүн эр нөхрөө хүндэтгэх нь хичнээн чухал болох талаар ярилцсан. Хүүхдүүдтэй л нэгэн адил гэргийгээ хүндэтгэхгүй байх нь сөрөг үр дагавартай болно.

Гэргийгээ хүндэтгэ

Петр:

Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг хэврэгхэн сав мэт үзэн, та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож (хүндэтгэж) амьдар (1Петр 3:7) гэдэг.

Петр гэргийгээ хүндэтгэхийг онцгойлон хэлжээ. Зарим эрчүүд энэ эшлэлийг сүнсний юмс дээр эхнэрүүд нөхрөөсөө дор гэж ойлгоод байдаг. Үгүй юм аа. “Хэврэг (буюу эмзэг) сав” гэдэг нь гэргий тань танаас дор гэсэн үг бус, ердөө л таны хэмжээнд хүртэл штанг өргөж чадахгүй л гэсэн үг. Ер нь бол эмэгтэй хүний тамирын хүч эрэгтэй хүнийхээс бага шүү дээ. Амплифайд Библи дээр тус эшлэлийг “эмэгтэй хүнийг (бүл чадал) дорой хэмээн хүндэтгэ” гэсэн байна. Тэгтэл Петрийн энэ үгийг Нью Ливинг Транслэйшн дээр “Үүнтэй

адил, нөхрүүд та бүхэн гэргийгээ хүндэтгэ. Ойлгож ханд, ханьсаж амьдар. Гэргий чинь чамаас хүчгүй байж болох ч, Бурханы шинэ амьдралын бэлэг дотор эн тэнцүү түнш чинь билээ. Түүндээ зохих ёсоор хандахгүй байвал чиг, *залбирал чинь (Бурханы) сонорт хүрэхгүй*” гэдэг. (тодруулгыг нэмэв)

Бид эн тэгш түншүүд - нигүүлслийн хамтран өвлөгч нар. Гэхдээ эшлэлийн төгсгөл хэсэг дээр залбирлын хариутай холбоотой аюултай үг хэлжээ: эр нөхөр нь гэргийгээ хүндэтгэхгүй бол, Бурхан залбирлыг нь хүлээж авахгүй гэнэ. Паа, ёстой аюул байна! Үүнийг хүсэх хүн байхгүй л болов уу.

Бодоод үз: Та гэргийгээ хүндэтгэдэггүй бол, таны залбирлыг сэнтийн өрөөнд авч хэлэлцэхгүй, үг тань Бурханы сонорт хүрэхгүй нь байна. Би л лав үүнийг сонсоод, үг дуугүй номондоо орно. Энэ үг биднийг эр нөхрийн үүрэг хариуцлагаа сайтар эргэцүүлж үзэхийг уриалж байна. Гэхдээ эсрэг нь ч бас үнэн гэдэг нь сайхан мэдээ юм. Та гэргийгээ хүндэтгэбэл, Бурханы өмнө итгэл дүүрэн залбирах нь байна.

Би яг одоо эр нөхрүүдэд шууд хандаж хэлье. Та гэргийгээ үнэ цэнэтэй хэмээн ханддаг уу? Үгийг нь сонсдог уу эвсэл *Ёо, ядаргаатай юм* гэж бодоод, зугтаж байна уу? Би ч бас тэгж хандаад, махаараа ойлгосон. Дөнгөж гэрлээд байхдаа, би гэргийнхээ зөвлөгөөг үл тоодог байлаа. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам, гэргийн маань хэлдэг үгс эцэстээ Бурханы цэц ухаан болж таараад байгаа ахин дахин ажиглах болов. Гэтэл би өөрийгөө хамаагүй сүнслэг хүн гэж бодож явсандаа ичмээр.

Хэд хэдэн юман дээр Лизагийн зөв болж таарсны дараа энэ талаар залбирав. Тэгээд “Бурхан минь, би зарим өдөр хоёр цаг залбирдаг. Гэтэл Лиза арав, хорин минут л залбирдаг - тэгээд голдуу шүршүүрт орох зуураа амжуулдаг. (Би энэ тал дээр ч бас буруу байсан юм. Гэргий маань өдөр бүр Бурхантай цаг өнгөрөөж, тогтмол залбирдгийг нь бас л хожуу олж мэдсэн)

Тэгээд яахаараа аливаа юманд дээр миний буруу, түүний зөв болж таардаг юм бэ?” гэж ирээд л эсэргүүцлээ илэрхийлэв.

Эзэн ч дороо л хариуллаа: “Миний хүү, нэг цаасан дээр тойрог зураатах.”

Би ч зурлаа.

“Одоо тойрог дотроо хаа сайгүй “Х” тэмдэг тавь.”

Би ч тавьлаа.

“Одоо тойргийнхоо голоор дээрээс нь доош зураас тат. (Ийнхүү

хоёр хэсэг болов) Тэгэхээр, нөгөө “Х” тэмдэг чинь хоёр талдаа тэнцүү хуваарилагдаж байгаа биз?

Би ч хүлээн зөвшөөрлөө.

Тэгтэл Эзэн “Х” тэмдэг чинь чамайг ухаалаг шийдвэр гаргахад чинь хэрэгтэй, Миний цэц ухаан, зөвлөгөөг төлөөлнө. Тойрог чинь ганц. Гэвч хоёр хэсэгтэй. Нэг хэсэг нь чи, нөгөө хэсэг нь Лиза. Тойрог чинь нэг цул боловч, хоёр хэсэгтэй гэдэг нь та хоёр бие даасан хувь хүмүүс боловч, нэг бие гэдэг утгыг төлөөлнө. Гэхдээ хэрэв чи ганцхан өөрийнхөө хэсгийг л хараад байх юм бол, тойрог чинь цул болохгүй.

Миний цэц ухаан, зөвлөгөөний нэг хэсэг нь Лизагийн талд, нөгөө хэсэг нь чиний талд байгааг харж байна уу? Гэтэл чи гэр бүлийнхээ шийдвэрийг Надаас авсан, өөрийнхөө талын мэдээлэл дээр л үндэслэж гаргаад байна. Чи Лизад өгсөн Миний мэдээллийг үл хэрэгсэж байна. Би чамд ч хэрэгтэй мэдээллийг чинь өгдөг, Лизад ч хэрэгтэй мэдээллийг нь өгдөг ч, чи өрхийн тэргүүнийхээ хувьд эцсийн шийдвэр гаргахдаа, цэц ухаант удирдагч шиг Миний Лизад харуулсан зүйлийг татаж аваад, хамтдаа хэлэлцэх ёстой юм.

Бурхантай хийсэн энэ яриа миний гэрлэлтийн амьдралыг орвонгоор нь эргүүлж билээ. Тэр үед л би ганц бие эр байхдаа бүтэн тойрог байсан бол, эдүгээ гэрлээд гэргийтэйгээ нэг бие болсон болохоор, ганц бие байсан шигээ үйлдээд байж болохгүйг ухаарав.

Танаас эмзэг сав

Петрийн “Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг хэврэгхэн сав мэт үзэн, та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүлслийг хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ. Ингэвэл залбиралд чинь саад тогтор учрахгүй” гэдэг үгийг дахиад нэг үзье. Түүнчлэн бид гэргийтэйгээ ойлголцож амьдрах ёстой аж. Залбирч байхад минь орж ирсэн, Бурханы дээрх ухаан надад гэргийтэйгээ хэрхэн ханьсан жаргахыг ойлгуулсан.

Гэргийтэйгээ ханьсан жаргах яндашгүй ухааныг Бурханы Үгээс л олборлоно. Эмэгтэйчүүд эрчүүдээс юугаараа, хэрхэн өөр болохыг эрчүүд маань судлаж мэддэг сэн бол, олон гэр бүл элэг бүтэн үлдэх сэн. Булчинлаг, бүсгүйлэг хоёрыг зэрэгцүүлж харах аваас, Бурханы төгс дүр төрхийн бүрэн тусгалыг олж харна. Тийм ээ, Бурханыг дан эр юмуу дан эм хүйсээр үзэхгүй шүү. Яаж мэдэж байгаа юм гэж үү?

Бичээс дээр “Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр (эрэгтэй) хүнийг (*хүнийг буюу хүн төрөлхтнийг*) бүтээж, Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ” (Эхлэл 1:27, тодруулгыг нэмэв) гэдэг.

Бурхан “эрэгтэйг” Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн боловч, “эрэгтэй” гэдэг дор “эрэгтэй, эмэгтэй” хоёр хоёулаа багтана. Эрэгтэй, эмэгтэй хоёр нийлж байж хүн төрөлхтнийг төлөөлөх бөгөөд хүн төрөлхтөн нь Бурханы дүр төрхөөр бүтээгдсэнийг Бичээс зориуд дурьджээ. Тиймээс л Паул “Гэвч Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм” (1Коринт 11:11) гэжээ.

Петрийн үгээ дахин үзэхүл, тэрбээр эрэгтэй хүн гэргийгээ хоёр замаар хүндэтгэхийг хэлжээ: нэгдүгээрт - эмзэгхэн сав мэт, хоёрдугаарт - нигүүлслийн амьдралын хамтран өвлөгч мэт. Эхлээд нэгдүгээрхийг нь товч авч үзье. Бид гэргийгээ эмзэгхэн сав мэт хүндэтгэх ёстой. Энэ нь яг хатагтай шиг хандах ёстой гэсэн үг. Эрчүүд хүчтэй бөгөөд энэ хүчээрээ гэргийгээ хамгаалах ёстой юм. Энэ заавар нь хаалга үүд онгойлгож өгөх, зоогийн газар суудал тавьж өгөх, бүдүүлэг хүмүүсээс хамгаалах гэх зэрэг наад захын юмст ч хамаарна.

Эр нөхөр гэдэг гэрийн тэргүүн учраас, гэргийгээ эрхэмлэх ёстой. Энэ нь онцгой хүлээн авалтад нэг нь л шинэ хувцас авах мөнгө байгаа нөхцөлд өөртөө биш, эхнэртээ авч өгөх шийдвэр дээр зогсоно гэсэн үг. Амралтаа өнгөрөөх газраа сонгох үедээ та нэг газарт, гэргий тань өөр газарт дурлаж байгаа бол, түүнийхээр л бол. Хаанчлал дотор удирдах гэдэг нь ноёлох бус, үйлчлэх явдал шүү дээ. Эр нөхрийнхөө хувьд, та цорын ганц нөхцөлд л гэргийнхээ шийдвэрийг хоёрдугаарт тавих ёстой - шийдвэр тань гэргий, гэр бүл, Бурханы хаанчлалд хамгийн зөв сонголт гэдгийг баттай мэдэж байгаа үед л. Бусад тохиолдолд ямагт гэргийнхээ хүслийг өөрийнхөө хүслээс дээр тавьж бай. Та гэргийнхээ дээр удирдагчаар томилогдож, түүнийхээ төлөө амиа ч зориулахад бэлэн байх ёстойн нэгэн шалтгаан энэ билээ. Энэ бол гэргийгээ хүндэтгэх явдал. Та ерөөгдөж, шагнуулах бөгөөд залбирал чинь хариултаа хүлээн авна.

Хамтран өвлөгч

Петрийн хэлснээс үзбэл, бид гэргийгээ хүндэтгэх ёстойн нөгөө гоц шалтгаан нь тэрбээр нигүүлслийн амьдралын маань хамтран өвлөгч юм. Та эрэгтэй учраас, Бурханы өмнө давуу эрх эдлэхгүй. Эрэгтэй хүн илүү гэдэг энэ худалд зарим итгэгчид үнэн голоосоо итгэдэг

бөгөөд үнэхээр хөгийн юм. Энэ худалд итгэдэг шовинист эрчүүд хожим Бурханы сэнтийн өмнө зогсоод, тайлан тооцоогоо тавина даа. Би ч хориод жил аялан үйлчилж, хажуугаар нь Бичээст суралцахдаа, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс дорд үздэг гэр бүл, чуулганаас Бурхан тааллаа татдаг болохыг тодорхой харсан билээ. Үнэндээ, тэнд сүнсний дарлал, дарамт, хүлээс л тогтох.

Бид өөрөөсөө зарим нэг зүйлийг асуух ёстой. Яагаад зарим чуулган удирдах багтаа эмэгтэй хүнийг оруулдаггүй вэ? Яагаад эмэгтэй хүнд Бүтэн сайны өглөө үйлчлэхийг зөвшөөрдөггүй вэ? Яагаад зарим чуулган эмэгтэй хүнийг пасторын багтаа оруулдаггүй вэ? Яагаад удирдлагад ээжийн дуу хоолойгоос илүү аавын дуу хоолой зонхилно вэ? Эх хүний дуу хоолойгүй чуулган нь ээжгүй, аав нь хүүхдүүдээ өсгөж байгаа гэр бүлтэй л адил. Ингэж болно л доо, гэхдээ эмэгтэй хүний тэр амин нөлөөлөл үгүйлэгдэж, хүүхдүүд нь ч өнчирдөг. Ээж нь цаг бусаар нас барсан юмуу хаяад явсан гэр бүлд Бурхан хүүхдүүдээ эрүүл саруул өсгөх нигүүлсэл хайрладаг. Тэгэвч, чуулган эх хүний дуу хоолойг боогдуулбал, Бурханы цэц ухааныг боочихож байгаа учраас, нигүүлслийн хомсдолд орно.

Та “Гэхдээ Библи нэг эхнэрийн нөхөр хүн л удирдагч байх ёстой гэдэг биз дээ” гэж эсэргүүцэх байх л даа. Бүгдээрээ Паулын тэр үгийг авч үзье: “Тиймээс харгалзагч нь өө сэвгүй, нэг эхнэрийн нөхөр, биеэ барьдаг, хэрсүү, хүндэтгэгдсэн, зочломтгой ба заах чадвартай...” (1Тимот 3:2).

Удирдагч хүн ганц эхнэртэй байх ёстой. Үнэхээрийн л нийтэд нь хандсан бус, харин эр хүйс дээр онцгойлон төвлөрсөн мэдэгдэл байна. Тийм боловч, бид энэ үгийг Бичээсийн гэрлээр тусгаж эргэцүүлэх ёстой. Паул Хуучин гэрээгээр боловсорсон хүмүүст хандаж бичжээ. Гэтэл Хуучин гэрээнд эрчүүд олон эхнэртэй байх нь энүүхэнд. Абрахам, Давид хаан, Соломон, Иаков, Елкана (Ханна, Пенина хоёрын нөхөр) нар бол наад захын жишээ нь.

Гэх атлаа Хуучин гэрээнд эмэгтэй хүн олон нөхөртэй байх жишээ ганц ч үгүй. Энэ нь хуульд харш, байж болошгүй зүйл байв. Тиймээс Паул юу гэж л нэг нөхөртэй эмэгтэй хүн л чуулганд удирдаж болно гэж хэлэх билээ? Ингэж хэлэх нь илүүц болно. Та намайг хазайгаад явчихлаа гэж болох ч, хэрвээ бид Паулын захидлын үг бүрийг тэгтэл ёсчлон биелүүлдэг байсан юм бол, яахаараа ганц эхнэрийн нөхөр биш гэдэг шалтгаанаар нь ганц бие эрчүүдийг чуулганы удирдлагаас хасдаггүй билээ? Паул үүнийг л хэлэх гэсэн юм бол, өөрийгөө ч чуулганы

удирлагаас хасах байсан бус уу? Гэтэл энэ чинь инээдтэй хэрэг бус уу? Зарим маань энэ тал дээр арай л мухар бодолтой биш үү?

Энэ бүхэн чинь хүйсийн бус, харин хүний амьдрал дахь Бурханы дуудлага, бэлгийн асуудал шүү дээ. Гэргийгээ юмуу чуулганы эмэгтэйчүүдийг дуудлагаа биелүүлж үйлчлэх урмыг нь хугачдаг эрэгтэйчүүд өөрийнхөө гэр бүл, үйлчлэл дээгүүр тэнгэрийн цонхыг тас хааж байгаа юм. Мэдээж зарим нэг тал дээрээ ерөөгдөх нь ерөөгдөх боловч, тэнгэрийн ерөөлөөр дутагдана.

Эмэгтэй хүнийг үл хүндэтгэснээс болж, Христийн бие өрөөл дутуу болно. Гэхдээ сайн мэдээ байна аа: энэ байдал энэ чигээрээ байгаад байхгүй. Чуулганы эцсийн өдрүүдэд үйлчлэл дэхь эмэгтэйчүүдийн оролцоо бүрэн сэргэхийг эш үзүүлэгч Иоел, элч Петрийн хэн хэн нь Бурханы Сүнсээр зөгнөн айлдруун.

Тэр хоёр: “Бурхан айлдахдаа «Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ Бүх махбод дээр цутгана. Хөвгүүд, охид чинь эш үзүүлж, Залуус чинь үзэгдэл үзэн, Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно. Эр, эм гэлгүй боолуудынхаа дээр Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана. Тэд эш үзүүлэх болно (Үйлс 2:17-18) хэмээн мэдэгдсэн. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэн, хэн нь Бурханы Үгийг тунхаглах нь байна.

Үүнийг магтаалч ч хэлсэн: “Эзэн тушаал буулгадаг. Мэдээ тунхаглагч эмэгтэйчүүд олон” (Дуулал 68:11). Бурханы Үгийг онцгойлон хэн тунхаглана гэж байна? Бусад орчуулгыг үзэх юм бол, хариултыг нь олно: “Эзэн (хүчийн) үгийг өгөх ба (энэ мэдээг) тээж, түгээх эмэгтэйчүүд инү аугаа эзэд болой” (Дуулал 68:11, ЭйЭмСиПи Библи).

Магтаалч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд дээр нийтэд нь төвлөрөлгүй, харин дан ганц эмэгтэйчүүд дээр л төвлөрч байна. Тэгвэл өөр орчуулгаас үзье: “Эзэн тушаасан бөгөөд энэ мэдээг олон эмэгтэй тээхүй” (ЖиЭнТи). Мөн “Эзэн ялалтыг тунхаглах бөгөөд баярт мэдээг эмэгтэйчүүд бөөнөөрөө хашхирах” (ЭнЭлТи). Эмэгтэйчүүд Бурханы Үгийг тунхаглах бөгөөд тунхаглах тунхаглахдаа зөвхөн эмэгтэйчүүддээ бус, харин эрчүүдэд ч тунхаглах ажээ. Энэ үнэнийг Есүс ч баталсан. Анхны Сайн мэдээ дэлгэрүүлэгч нь Магдалын Мариа гэдэг бүсгүй хүн байсан нь сонин биш байна уу? Түүнийг бүр Есүс Өөрийн биеэр илгээсийм шүү. “Би Эцэгтээ хараахан дээш очоогүй байгаа тул Надад гар бүү хүр. Харин ах дүү нарт минь очиж, тэдэнд “Би Эцэгтээ буюу та нарын Эцэгт, Бурхандаа буюу та нарын Бурханд дээш очно” гэдгийг хэл гэлээ. Магдалын Мариа ирж, шавь нарт —Би Эзэнийг харлаа гээд, Есүсийн өөрт нь айлдсаныг тэдэнд хэлэв” (Иохан 20:17-18).

Цааш нь үзье. Лукийн Сайн мэдээг үзбэл, Мариа гол номлогч байсныг харна. Есүс Өөрийгөө үхлээс амилуулагдсаныг элч нарт мэдүүлэхээр Мариаг төдийгүй, бусад эмэгтэйчүүдийг ч илгээсэн байдаг. “Тэд бол Магдалын Мариа, Иоанна, Иаковын эх Мариа нар мөн тэдэнтэй хамт байсан бусад эмэгтэйчүүд байв. Тэд элч нарт энэ тухай хэлсэн” (24:10). Тэгэхээр, эмэгтэйчүүд Бурханы Үгийг эрчүүдэд тунхагласан бөгөөд тэднийг Есүс Өөрөө илгээсийм!

Аврагч айлчлан ирснийг сүм дотор эрэгтэйчүүдэд ч, эмэгтэйчүүдэд ч хэлсэн хүн нь Анна гэдэг эш үзүүлэгч эмэгтэй байсан нь сонирхолтой биш байна уу? Хэдийгээр Симеон түрүүлж Иосеф, Мариа хоёртой ярилцсан ч, Анна л эхэлж энэ мэдээг сүм дотор хүмүүст дуулгасан буюу. “Энэ мөчид Анна хүрч ирж, Бурханд талархал өргөөд, Иерусалимын солилцыг хүлээж байсан бүхэнд Түүний тухай үргэлжлүүлэн яриу” (Лук 2:38).

Филиппийн дөрвөн охин Эзэний үгийг өгүүлдэг байсан. “Тэр хүн эш үзүүлэгч дөрвөн онгон охинтой байв” (Үйлс 21:9) гэдэг. Тэд Эзэний Үгийг тэнгэрийн хүчээр тунхагладаг байж. Христийн өрөөл биеийг дуудлагаа биелүүлэхэд нь үл хүндэтгэчихээд, Аугаа захирамжийг яаж биелүүлэх гээд байгаа улс вэ бид? Эрчүүд гэргийнхээ амьдралын дуудлагыг тордох аваас, аугаа шагналтай. Би үүнийг өөрийнхөө амьдралаар мэднэ.

(Жич: Өнгөц харбал, миний бичсэнтэй зөрчилдөөд байгаа мэт Шинэ гэрээний хэд хэдэн бичээс бий. Эдгээр бичээсийн цаад санааг олж мэдэхийн тулд судалгаа хэрэгтэй. Харин энэ ном маань арай өөр зорилготой. Гэхдээ тэдгээр эшлэлийг нарийн судласан, нэр хүндтэй удирдагч нарын материал олон бөгөөд тэдгээрийн нэг нь Лорен Каннинхам, Давид Жоел Хамилтон нарын бичсэн *Why Not Women?* гэдэг ном болно.)

Миний гэргий

Лиза мань таван настайдаа нэг нүдээ алдсан юм. Тэрбээр ретинобластома буюу энгийнээр хэлбэл нүдний хорт хавдар тусжээ. Лиза маань сургуульд орсон цагаасаа өнөөдрийг хүртэл баруун нүдэндээ хиймэл нүд зүүдэг. Жаахандаа сургуульд шоглуулж, элдэвлүүлдэг байсныг нь та ойлгосон байх аа. Ангийнх нь юугаа ч мэдэхгүй жаалуудын Лизаг элдвээр хочилдог нэг нэр нь Духан дундаа ганц нүдэт Дува сохор

байлаа. Зарим өдөр Лиза хичээл ид дундаа орж байхад, уйлсаар гэр рүүгээ гүйдэг байж. Ээж нь дээрэлхүү хүүхдүүдийг бүү тоо, зоригтой бай хэмээн урамшуулав ч, бяцхан зүрх нь шархалсаар.

Ахлах сургуульд Лиза сургуулиа төгсөхөд нь шийдвэрлэх үүрэгтэй, хоёр хичээл түүнийг хамгийн ихээр айлгаж зовоож байгааг мэджээ. Нэг нь аман хичээл, нөгөө нь бичгийн машин дээр шивэх хичээл. Аль, аль дээр нь унасныхаа дараа Лиза маань зөвлөх багштайгаа уулзаад, энэ хоёр хичээлээс чөлөөлж өгөхийг гуйжээ. Яаж хүмүүсийн өмнө зогсоод, үр нөлөөтэй ярих юм бэ? Орон зайн баримжааны мэдрэмжээ алдсан учраас, бичгийн машин дээр бичих ямар ч боломжгүй байжээ. Зөвлөх ч нөхцөл байдлыг ойлгоод, Лизаг хоёр хичээлээс чөлөөлөөд, оронд нь өөр хичээл нэмж өгсөн байна.

Лиза маань коллеж төгсөх үедээ Есүс Христэд итгэснийг би өмнө ярьсан. Төдөлгүй бид хоёр гэрлээд, Даллас руу нүүгээд, тэндхийн маш том чуулганд явдаг болов. Тэр үед Лиза маань маш бүрэг, дотогшоо байлаа. Чуулганы эмэгтэйчүүд түүний зан байдлыг биеэ тоосон, ярвагар гэж дүгнэв. Гэтэл хэрэг дээрээ тэрбээр тэс өөр хүн байлаа. Лиза нүдээ авахуулсан явдал, түүнээсээ болж сургуульд элэг доог болсон явдлаас ургасан зүсэн зүйлийн айдастай зөрчилдөж байсан юм.

Шинэхэн гэр бүлээ босгох гэж хоёул хоёулаа ажиллах хэрэгтэй байсан болохоор, Лиза гоо сайхны бүтээгдэхүүний фирмд худалдааны зөвлөхийн ажилд орсон юм. Би зарим нэг хичээлд нь суухдаа, гэргий маань энэ талбар дээр бэлэгтэй бөгөөд бүтээгдэхүүнээ маш сайн мэддэг болохыг нь ойлгосон юм. Гэтэл Лиза сүрдэж байв. Бүтээгдэхүүнийхээ талаар хүмүүст ярихаас айдаг байсан болохоор, түүнийг хүмүүстэй харилцаа үүсгэж, танилцуулгаа хийх боломжийг нь нээж өгөх үүргийг би гүйцэтгэдэг байлаа.

Жилийн дараа Далласын томоохон их дэлгүүрээр хэсч явахдаа, би “Лиза, чи гоо сайхны барааны худалдагчийн орон тоонд нь анкетаа бөглөөд үз. Гоо сайхны бараа, оо энгэсэг тавих тал дээрээ чи ямар ч худалдагчийг дагуулахгүй” гэлээ.

Лиза намайг буруу ярьж байна хэмээн маргаад өнгөрсөн ч, тэр долоо хоногоос тус дэлгүүрийн өөр тасагт ажиллаж эхэлсэн бөгөөд хаалгаар орж ирэх тоолонд нь миний хэлсэн үг чихэнд нь хангинах болжээ. Тиймээс нууцаар явж очоод, анкетаа бөглөөд өгчихсөн чинь ажилд орчихож!

Лиза Елизабет Арден гоо сайхны брэндийн төлөөлөгчөөр ажиллах болов. Өмнөх худалдагч нь нилээд зүдэрдэг байсан юмсанж. Гэтэл

Лиза орж ирээд л, хэдхэн долоо хоногийн дотор бүх барааг нь зараад дуусгачихсан байна. Нэг өдөр лангуун дээр нь гар цүнхний пад хийх чимээ гарахаар нь хартал, компанийх нь гүйцэтгэх захирал байв. Тэрбээр “Лиза, хамт өдрийн хоолонд орно оо. Одооноос чи худалдагч хийхгүй!” гэжээ.

Гүйцэтгэх захирлынхаа шаардлагаар Лиза маань ажлын ярилцлагад ороод, Даллас, Форт Уортын 16 дэлгүүр, Шинэ Мексик дэхь нэг дэлгүүр, Оклахома дахь нэг дэлгүүрийг хариуцсан, худалдааны зохион байгуулагчийн орон тоо руу дэвшив. Хоёр ч хүрэхгүй жилийн дотор дахин компанийхаа суртчилгааны төлөөлөгч болтлоо дэвшээд, найман мужийг хариуцан ажиллах болсон юм. Тэрбээр өндөр цалин, дээрээс нь янз бүрийн хангамж хүлээн авах болсны дунд компанийхаа Форд Тандербёрд гэдэг цоо шинэ машиныг хөлөглөн давхих болсон юм. Тэр өндөр цалингийн үр ашгийг өөр бас хэн эдлэх үү? Мэдээж би. Энэ чинь л хүндэтгэлийн шагнал байхгүй юу!

Хэдэн жилийн дараа манайх Флорида руу нүүсэн бөгөөд тэнд би маш том чуулганы залуусын пастораар үйлчлэх болсон юм. Хэдэн сарын дараа би залуустаа дараагийн долоо хоногт миний оронд Лиза үйлчилнэ гэж хэлэв. Эзэн Лизад маш их зүйл өгсөн бөгөөд тэрбээр гэртээ зааж, харилцаж чадаж байгаа бол, хэсэг хүмүүсийн өмнө ч чадна гэдгийг нь мэдэж байлаа.

Миний зарлал томоохон эсэргүүцэлтэй тулсныг хэлэх юун - залуусын зүгээс бус, харин Лизагийн зүгээс ирсэн эсэргүүцэлтэй. Тэрбээр “Чи ямар дураараа юм. Би тэр залууст чинь үйлчилж чадахгүй. Би юугаа хэлэх юм?” гээд л бүтэн долоо хоног эсэргүүцлээ илэрхийлэв. Би ч өөдөөс нь “Чи чадна. Бурхан тусална” хэмээн батлан хэлэхээс өөр юм хийсэнгүй. Би Лизад байгаа бэлгийг харсан учраас, тэр бэлгийг ажиллагаагүй байлгахыг хүсээгүй юм.

Лиза долоо хоногийн дараа номлосон. Номлох номлохдоо маш мундаг номлов. Залуус маань ч Лизагийн номлолд хөөрөв. Ийнхүү манай хүн ирэх хэдэн сарын турш хэд хэдэн удаа номлов. Гэхдээ тухай бүр нөгөө л эсэргүүцлээ илэрхийлнэ. Тухай бүр “Би мэддэг чаддаг бүхнээ заачихсан” гэж маргана.

Тэгэхээр нь би инээгээд “Найз нь долоо хоног бүр номлодог. Тэгээд шинэ долоо хоног бүр Бурханд найддаг” гэж хэлдэг байлаа. Энэ үг маань нэг их тус болохгүй. Гэхдээ Лиза номлох бүрийдээ, улам, улам л баялаг болоод байдаг байлаа. Залуус маань ч түүнд хайртай гэж жигтэйхэн.

Пастораараа томилуулаад, чуулганыхаа ажлаас гарч, өнөөгийн энэ үйлчлэлээ эхлүүлэх үедээ ч би урьдынхаа адил үйлдэж эхэлсэн юм. Жижиг конференц, чуулган дээр номлохдоо, хааяа хааяа Лизад урьчилж хэлэлгүйгээр, дараагийн хичээлийг Лиза заана гээд зарлаж орхино. Анх ийм хэрэг үйлдэхэд маань Лиза дэлбэртлээ уурласандаа, шөнөжин намайг унтуулаагүй юм даг. “Яахаараа би чиний хичээлийг заадаг юм. Энэ чинь чиний залуусын цуглаан биш, харин өөр чуулганы хүмүүс. Энэ миний биш, чиний ажил” гээд л.

Тэгснээ дараа нь намайг өнгөрсөн хичээл дээр юу заасныг минь асуув. Учир нь Лиза намайг зааж байх хойгуур хүүхдүүдээ унтуулах гээд өрөөндөө байсан болохоор мэдээгүй өнгөрч. Тэгээд хариултал, бүр сүйд болов. “Чи оройн цуглаан дээрээ миний мэддэг ганц сэдвийг заачихаж. Маргааш өглөө би тэгээд юугаа заах юм бэ?” гээд л.

Ийм маягаар үүрийн гурван цаг хүртэл маргав. Сүүлдээ би инээд алдаад “Хонгор минь, чи өглөө есөн цагт заана. Чамд зургаахан цаг байна. Жаахан унтах хэрэгтэй шүү” гэж хэлж билээ. Мэдээж, өглөө нь Лиза заадгаараа заасан. Заах заахдаа маш сайн заасан. Хүмүүс ч маш сайхан хүлээж авсан. Энэ явдал олон хотод үргэлжилсэн бөгөөд Лизагийн үйлчлэл улам л хүчирхэгжсээр байлаа.

Тэгэхээр, би нэг зүйлийг хэлье. Энэ бүхэн Лизад амархан байсан уу гэвэл үгүй юм. Лиза анх оюутан, ажилчин залууст номлосон бөгөөд тэдний дунд байсан багахан тооны эрчүүд эмэгтэй хүний номлолыг сонсохгүйгээ илтэд илэрхийлэн, сүр сар хийсээр орхиж гарч билээ. Тэр үед Лиза өөрөө ч тэднийг дагаад гарчихмаар байсан гэдэг. Лиза хэзээ ч хүмүүсийн өмнө гарч тодрохыг хүсээгүй, зүгээр Бурханд дуулгавартайдаа л үүнийг хийсэн билээ.

Ном бичих тал дээр ч...

Ном бичих тал дээр ч дээрх явдал давтагдсан түүхтэй. Намайг гурван ном бичихэд, Лиза хянан тохиолдуулдаг байв. Би ч Лизаг бэлэгтэй зохиолч болохыг нь ойлгосон бөгөөд “*Сатаны урхи*” гэдэг гурав дахь ном маань үндэсний шилдэг борлуулалттай номоор шалгарсан юм. Би хэвлэлийн компанитайгаа уулзаад “Тэргий маань хэрхэн Бурхан түүний амьдралыг зарим талын айдас, хүлээсээс чөлөөлсөн талаар ном бичиж чадна. Та энэ талаар Лизатай ярилцах хэрэгтэй байх. Гэхдээ надаар дамжуулж биш, шууд өөртэй нь ярилцаарай” гэж хэлсэн юм.

Хэдэн долоо хоногийн дараа хэвлэлийн компанийн ажилтан манай гэрт ирэв. Гэтэл Лиза түүнийг надтай биш, өөртэй нь уулзахаар ирснийг мэдсэнгүй. Тэр над руу “Жон гуай, энд юу болоод байна?” гэх шиг л харав.

Тэр хүн Лизад зүрхэндээ байгаа санаагаа ажилтанд нь тайлбарлаж, ярилцах цаг товлож өгөөд, хэсэгхэн хугацааны дараа “Танай зүрхэнд ном болгож, түмэнд түгээх хэрэгтэй, амин чухал үг байгаа гэж нөхөр чинь хэлсэн юм л даа. Тантай ярилцаад, би ч бас тэгж бодлоо” гэж хэлсэн юм.

Өнөөг хүртэл Лиза маань олон ном бичсэний дунд зарим нь *Нью-Йорк Таймс тэргүүтэй* олон газрын шилдэг борлуулалттай номоор шалгарсан билээ. Лиза маань номынхоо нөлөөллөөр даян дэлхийн үй олон хүнд хүрсэн. Эдүгээ тэрбээр жил бүр хэдэн арван мянган хүний өмнө гараад зааж байна.

Бодоод үз. Ярих, бичих чадвараараа тэнцэлгүй, хасагдаж явсан түүхтэй тэр охин өнөөдөр өдөр тутам юу хийж явна? Тайз, зурагт зэрэг олон янзын сувгаар мянга мянган хүнд номлож, дээрээс нь ном бичиж явна. Үүнийгээ хэрхэн хийж байна? Тэрбээр Бурханы нигүүлслийн хүчээр айдастайгаа нүүр тулжээ. Бурханы охиндоо өгсөн бэлгийг нь олж хараад, хүндэтгэсэн нөхрийнх нь түлхэлтээр өнөөдөр олон хүний амьдрал ерөөгдөв. Тэгвэл, чуулган дахь эр нөхрүүд бүгдээрээ гэргийгээ хүндэтгээд эхэлбэл, юу болох бол?

Би гэргийгээ хүндэтгэснийхээ хариуд ямар шагнал авсан? Тоочиж гүйцээхийн аргагүй олон бий. Лизагийн амьдрал дан үйлчлэл гэлтгүй, бүх тал, бүх төвшиндөө цэцэглэсэн. Хүн чөлөөлөгдсөн л бол, үнэхээр чөлөөлөгддөг. Миний амьдрал дээрх нигүүлсэл Лизад үүд нээж өгсөн шиг, эдүгээ түүний бэлэг ч надад ижлийг үйлдэв. Лизагийн ачаар надад дэлхий даяар чухал, чухал үүд нээгдсэн юм. Хэд хэдэн газрын удирдагч нар намайг урихдаа “Гэргий тань эмэгтэйчүүдэд маань ер бусын хүчтэй нөлөөлсөн болохоор, бид таныг урих ёстой байлаа” гэж хэлж билээ.

Өөр нэгэн шагнал нь би сэтгэл дүүрэн бүсгүйтэй хамт амьдарч байна. Амьдралд нь хандсан Бурханы дуудлагыг биелүүлээгүй хүн Бурханы үйлдүүлэхээр бүтээсэн тэр зүйлийг нь илэрхийлж амьдрахгүй учраас, зүрх нь хөндүүртэй, дарамттай явдаг. Харин та Бурханы хүсэл дотор байгаа бол, Түүний ачаа нь хөнгөн (Матай 11:28-30) хэмээн Есүс айлдруун. Хэдийгээр дайралт улам л томорч, улам л олшров ч, Бурханы төлөө, Түүний төлөвлөгөө дотор багтаж хөдөлмөрлөх нь зовлонгүй бөгөөд ер бусын жаргал тээдэг юм. Гэргий маань Бурханы охин, гэргий,

ээж, Сайн мэдээний үйлчлэгчийнхээ хувьд улам л аз жаргалтай, улам л эрч хүчтэй болсоор. Эдгээр бүтцийн аль нэг нь гачигдбал, бусад тал нь дагаад зүдэрдэг. Гэргий маань амьдралаа зөв эрэмбэлэх тал дээрээ ихэд анхаардаг бөгөөд гэр бүлээ үйлчлэлээсээ дээгүүр тавьдаг болохоор, гэр бүл маань ч ээжийгээ аялж, дуудлагаа биелүүлээрэй хэмээн илгээх үед бидний дээр ер бусын нигүүлсэл оршдог билээ. Амьдралд маань хандсан Бурханы дуудлагыг биелүүлснээр, гэрлэлт маань хэзээ ч ийм дүүрэн, хайр маань хэзээ ч ийм баг бөх байсангүй.

Лиза Бурханы Үгийг тунхагласны хамгийн аугаа шагнал бол мөнхийн мөнхөд өөрчлөгдсөн хэдэн зуун мянган хүний амьдрал гэж би итгэдэг. Хожмын өдөр бид Бурханы сэнтийн өмнө Лизагийн ажил хөдөлмөрийн зах хязгааргүй үр нөлөөллийн хүчийг харна. Нэг удаа би хөвгүүдээсээ: “Хөвгүүд ээ, аав, ээж нь байнга аялж байгаа нь та нарт ядаргаатай байна уу? Ямар нэг юмаа алдчихсан юм шиг санагдаж байна уу? Эсвэл өөдрөгөөр хараад, даян дэлхийн гачигдаж дутагдсан хүмүүсийн амьдралд аав, ээжийгээ өгснөөрөө, өөрсдийгөө энэ үйлчлэлд оролцож байна гэж боддог уу?” гэж асуусан юм.

Ууган маань түрүүлж хариулав: “Бид үүнийг үйлчлэлд оруулж байгаа хувь нэмрээ гэж боддог. Хаанчлалын хүмүүст бид ингэж л тусалж чадах байх.” Бусад нь ч зөвшөөрч билээ.

Тэр үед Лиза, бид хоёр бие бие рүүгээ хичнээн жаргалтай харцаар харсан гэж санана. Өөрийг нь зүгээр л дагаж байгаа зарц нар дээрээ Бурхан ямар аугаа нигүүлсэл буулгадгийг бид ухаарч билээ. Хөвгүүд маань энэ амьдралдаа төдийгүй, Христийн шүүх сэнтийн өмнө ч аугаа шагнал хүлээж авна. Хүндэтгэлийн шагналыг үзэх юутай сайхан. Бид анхандаа хардаггүй байлаа. Гэхдээ Бурханы Үг “Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНд дуулгавартай байж, миний өнөөдөр чамд тушааж буй Түүний бүх тушаалыг хичээнгүйлэн дагаж мөрдвөөс ЭЗЭН Бурхан чинь чамайг газар дэлхий дээрх бүх улс үндэстний дээгүүр өндөрт тавина. Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНд дуулгавартай байвал энэ бүх ерөөл чам дээр бууж, чамд хүрнэ” (Дэд хууль 28:1-2) хэмээн амласан шигээ л нэг л мэдэх нь ээ, биднийг эзлээд авсан билээ.

Бид шагнал авахын төлөө л хүндэтгэдэг юм биш. Бурхан ийм зүрх сэтгэлтэй бөгөөд бид үүнд нь дуртай учраас, хүндэтгэдэг юм. Гэхдээ шагнал нь үр ургахаараа ургац авчирдагтай л адил баталгаатай. Бүхий л жинхэнэ хүндэтгэлийг шагнал дагалдана. Тиймээс, нөхрүүд ээ, цаг бүү алд. Гэргийгээ хүндэтгэхүйг амьдралаа болго. Тэгвэл, гэргийгээрээ дамжуулан Бурханаас зүүдэлж ч яваагүй шагналаа хүлээж авна шүү.

Бүгдийг хүндэтгэ

Бүгдээрээ гэр бүл, чуулган, ажлаас гадна байдаг хүмүүсийн талаар товч авч үзье. Товчхондоо, өдөр тутмын амьдралдаа тулгардаг хүмүүсийг. Петр тун энгийнээр:

Бүх хүнийг хүндэл (1Петр 2:17) гэжээ.

Үүнээ тодохой яаж хэлэх билээ. Бусад орчуулгыг ч үзэцгээе: “Бүх хүнд хүндэтгэл үзүүл (тэдэнд хүндэтгэлтэй ханд)” (ЭйЭмПиСи), “Хүн бүрт өндөр хүндтэй ханд (ЭмЭсЖи), “Бүх хүнд хүндэтгэл үзүүл” (ЭнЭлТи). Эдгээр хүмүүсийг Есүс бидний “хөрш” хэмээн дотночлон дуудсан. Та мөнөөх алдарт түүхийг мэднэ буй за:

Есүс хариуд нь —Нэгэн хүн Иерусалимаас Иерихо орохоор явж байжээ. Тэр дээрэмчдийн дунд орчихож. Тэд түүнийг нүцгэлэн зодоод амьтай төдий орхиод оджээ. Тохиолдлоор нэгэн тахилч тэр замаар явж байгаад, түүнийг харуутаа дэргэдүүр нь өнгөрөөд явчихав. Түүнчлэн нэгэн леви хүн мөн тэнд хүрч ирээд, түүнийг харуутаа дэргэдүүр нь өнгөрөөд явчихжээ. Харин түүгээр явж байсан нэгэн самари хүн түүнтэй таарчээ. Тэр түүнийг харуутаа өрөвдөн, түүн дээр ирж, шарханд нь тос, дарс асгаж боогоод, унаан дээрээ тэгнэн дэн буудалд хүргэж ирэв. Тэгээд түүнийг асарчээ. Маргааш нь тэр, хоёр денар авч буудлын эзэнд өгөөд, “Түүнийг асарч байгаарай. Та илүүг зарвал би буцахдаа танд дахин төлье” гэжээ. Энэ гурвын хэн нь дээрэмчдийн гарт

орсон тэр хүний хөрш болсон гэж чи бодож байна? гэхэд тэр — Түүнд энэрлийг үйлдсэн нь гэв. Есүс түүнд —Явж, үүний адил үйлдэгтүн гэжээ. (Лук 10:30-38)

Тахилч нар ч, Левичүүд ч үхэх дөхсөн тэр хүнийг хүн гэж үзээгүй. Гэтэл Самари хүн буюу харь хүмүүс үзжээ. Бичээс “өрөвдсөн” гэдгийг нь онцгойлон хэлсэн бөгөөд бүх жинхэнэ хүндэтгэл зүрхнээс л ундардаг буюу. Самари хүн шархтай хүнийг амьдруулахын төлөө шаардлагатай бүхнийг бас шаардлагатайгаас ч илүүг үйлдэн, дэн буудалд ч оруулж хэвтүүлсэн байна. Дээрээс нь огт танихгүй тэр хүнийг асруулахаар хоёр хоногийн хөлсийг нь төлсөн байна. Тэрбээр Бурханаас Үг сонсох гэж хүлээгээ ч үгүй, залбираа ч үгүй. Зүгээр л өрөөлийг хайрлаж, энэрч, хүндэтгэсэн зүрхнийхээ улмаас л шаардлагатай бүхнийг үйлджээ. Энэ бол хүнийг хүн гэдэг утгаар нь хүндэтгэхийн сонгодог жишээ.

Орчин цагийн жишээ

Ийм нэгэн орчин цагийн жишээ миний найз Билл Уилсонд тохиолдсон билээ. Биллийг 11 настай жаалхүү байхад нь ээж нь эргэж иртэл нь томоотой сууж байгаарай гэж хэлээд, усны хоолой дээр суулгаж орхиод яваад өгчээ. Гэхдээ хэзээ ч эргэж ирээгүй аж. Биллийг нэгэн Христэд итгэдэг хүн олж аваад, төлбөрийг нь төлөөд зуны зусланд явуулжээ. Тэр хүний сайхан сэтгэлийн үйлдэл нь Биллийн дотор нэгэн зүйлийг доргиосон байна.

Олон жилийн дараа Билл долоо хоног тутам Нью-Йорк хотод хорин мянган хүүхдэд хүрч үйлчилдэг Метро үйлчлэлээ үүсгэн байгуулж, өнөө хэр нь удирдсаар явна. Тэрбээр одоо ч албан ёсны болоод сайн дурын ажилтнуудаа дагуулан автобусаа жолоодсоор, эмзэг бүлгийнхэнд Сайн мэдээг үгээрээ ч, үйлсээрээ ч түгээсээр явна. Түүний үйлчлэл нь Нью-Йорк хотод төдийгүй, өөр бусад газарт ч мянга мянган амийг аварсан, гайхамшигтай үйлчлэл билээ. Билл манай Америкчуудад ч, гадаад хүмүүст ч хаягдсан хүүхдүүдийг үнэлэхийн үнэ цэнийг ухааруулж, Метро үйлчлэлээ дэлхий даяар байгуулсан юм.

Билл шиг эмзэг бүлгийн хүмүүст тусалж яваа хүмүүс үй олон бий. Бид ч тэдэнд тусалж чадна. Хэрхэн? Тэдний үйлчлэлийг залбирлаараа болоод мөнгөөрөө дэмж. Эдгээр үйлчлэлд Христэд итгэдэг хүн бүр сар

бүр тодорхой хэмжээний мөнгө өгдөг бол, юу болохыг төсөөлж байна уу? Хичнээн хүн Хаанчлалд орохыг төсөөлж байна уу? Есүсийн өгүүлсэн сургаалт үлгэрт гардаг шархтай хүнийг үл итгэгч, Самари хүнийг итгэгч гээд төсөөлөөд үз. Тэрбээр тэнхрээд ирэхээрээ Сайн мэдээг уриалгахнаар сонсоно. Харин тахилч юмуу Леви хүн Христэд итгэдэг байсан бол, шархтай хүн Сайн мэдээг сонсохыг хүсэхгүй л болов уу. Зүрх маань Бурханы хайраар дүрэлзэж байгаа цагт бид хүн бүрийг үнэ цэнэтэйд тооцож, гачигдаж дутагдсан хүмүүст туслахын зэрэгцээ Сайн мэдээг түгээдэг дээрх шиг байгууллагыг санхүүгээр дэмжих байсан.

Тэдэнд туслах өөр нэгэн арга нь нэгэн баг болох явдал юм. Та Брүүклин, Нью-Йорк зэрэг Биллийн үйлчлэл байршдаг, алс холын хот руу нүүх шаардлагагүй. Зүгээр л өөрийнхөө нутгийн чуулганы үйлчлэлд гар бие оролц. Сард ганцхан өдрийг зориулсан ч, шаардлагатай хүмүүсийн амьдралд зохион байгуулалттай төвшинд хүрлээ гэсэн үг. Хэдийгээр, Самари хүний үлгэрлэн харуулсан хувь хүний хүчин зүтгэлийг үгүй хийж болохгүй ч, нөгөөтэйгүүр бид гар нийлбэл, ганцаараа хийснээсээ хавьгүй ихийг гүйцэлдүүлж чадна. Бусадтайгаа нэгдэн нийлэхийн хүчийг Бичээс ч цохон тэмдэглэдэг: “Таван хүн чинь зууг элдэн хөөх ба зуун хүн чинь арван мянгыг элдэн хөөх бөгөөд дайснууд чинь та нарын өмнө илдэнд унах болно” (Леви 26:8).

Биднийг нэгдэх үед үр нөлөө маань өснө. Бурхан чуулганыг маань бие биеэсээ хамааралтай байж байж л үр нөлөөтэй ажиллахаар тогтоосон. Христийн биеийн эрхтнүүд нь нийлэн ажиллах үед л Христийн бие өсөхийг Паул мэдэгдсэн (Ефес 4:16). Зохион байгуулалттай, нутгийн чуулганд суулгагдахын бас нэг чухал шалтгаан нь энэ болой. Товчхондоо, итгэгч бүр хувиараа ч, зохион байгуулалттай үйлчлэлээр ч дамжуулж өөрийнхөө хувийг хийгээд байх юм бол, хичнээн олон Билл Уилсоны түүх төрөх бол?

Билл Уилсоны үйлчлэл зөвхөн үүгээр хязгаарлагдаж болохгүй. Дэлхий дээр мөн ядуу гэж хэлэгдэхгүй, хэрэгцээ нь хангагдсан эсвэл бүр тансаг чинээлэг амьдралтай атлаа сэтгэлдээ шархтай, цөхөрсөн хүмүүс үй олноороо бий. Тэд жирийн нэг хорооллоор тогтохгүй, бүр баячуудын хороололд ч байж болох. Товчхондоо, тийм хүмүүс газар сайгүй. Та тэдэнтэй хүнсний дэлгүүрт, их дэлгүүрт, албан газарт тааралдана. Тэд ганцаардаж, шархалсан хүмүүс бөгөөд тэдэнд үнэ цэнэ хэрэгтэй. Тэд - бидний хөршүүд.

Бид энэ хүмүүстэй өдөр тутам тааралддаг. Заримдаа өөрийнхөө ажил дээр хэт төвлөрсөндөө, тэдний хэрэгцээг анзааралгүй өнгөрдөг. Нас явах

тусам, үнэндээ хүмүүст хүрч харилцах хичнээн хялбар байдгийг ухаарах юм. Зүгээр л бүх хүнийг хүндэтгэх хүндэтгэлээр л зүрхээ цэнэглэхээс эхэлнэ. Ингэж чадбаас, илүү мэдрэмжтэй болж, ихэвчлэн өөрөө ч мэдэлгүй Бурханы Сүнсээр хөтлүүлж, өдөр тутмын амьдрал маань үргэлжилсэн үйлчлэл болдог.

Та хүмүүсийг хүндэтгэх аваас, амьдралд тань Бурханы учруулж байгаа хүмүүсийг үл тоох юмуу бүдүүлэг муухай хандалгүй, зүрхэндээ ангасан хүмүүст амийн усыг хүртээх тэнгэрлэг урсгалтай хөл нийлүүлэх болно. Тэр хүмүүсийн талаарх миний хамгийн хайртай нэгэн Бичээс болбоос Исаиа 50:4 билээ: “Эцэж ядарсан хүнд үгээр туслахыг мэдээсэй хэмээн Эзэн БУРХАН Надад шавийн хэл өгсөн. Тэр өглөө бүр Намайг сэрээн шавь мэт сонсохын тулд Чихийг минь Тэр нээн”.

Та энэ амлалтын төлөө Бурханд итгэж болно. Олон хүн өөрийгөө тэнэг юм ярьчих байх гэж эмээсэндээ хүмүүстэй ярилцахаас айдаг. Та дээрх бичээс дээрх Бурханы Үгд зүгээр л итгэж байгаа бол, үг тань сэтгэлдээ цуцаж, цөхөрсөн хүмүүст амь, эдгэрэл, хүч авчирна гэдгийг бат мэдэх л болно.

Гэхдээ бас л болоогүй. Бүгдээрээ дахиад цаашаа явцгаая. “Бүх хүн” гэдэг нэр нь цөхөрсөн хүмүүсээр ч тогтохгүй. Бид харилцаж байгаа хүн бүрээ хүндэтгэх аваас, тэд бүгдээрээ цэцэглэнэ. Зүрхнээсээ хэлсэн эелдэг үг бүр маань сонсогчийн амьдралд үйлчилнэ. Үүнд үндсэндээ, магадгүй бидний амьдралдаа ганц л удаа уулзаад өнгөрөх, өдөр тутам халт харилцаад өнгөрдөг үй олон хүн багтана. Цахилгаан шатан дотор таарах хүн, онгоцны үйлчлэгч эсвэл харилцаа холбооны ажилтан. Бид тэднийг эелдэг мэндчилгээгээрээ юмуу эсвэл дулаан мишээлээрээ хүндэтгэж чадна.

Нэг удаа намайг Лондонгийн цэцэрлэгээр алхаж явтал, Ойрхи Дорнод зүгийн нэгэн эмэгтэй газар ширтсээр өөдөөс ирж явж билээ. Түүнийг өрөвдөөд л явчихав. Яагаад ч юм түүнийг хэн нэг хүн - магадгүй эр хүн нь огт үнэлдэггүй юм шиг санагдлаа. Би тэр эмэгтэйд өрөвдөөд, зориуд инээмсэглээд, чангаар мэндчилэв. Тэрбээр итгэж ядсан аятай, над руу том харлаа. Дотроо ч *Яагаад энэ цагаан арьстай эрэгтэй хүн танихгүй хүнтэй - бүр над шиг эмэгтэй хүнтэй ингэтэл эелдэг ярина вэ?* гэж бодож байгаа нь надад бараг л сонсогдов.

Гэхдээ бодол нь лавшрахаас өмнө түүний үнэ цэнэтэй байх хүсэл нь дийлээд, байр байдал нь бүхлээрээ хувирснаа, ичэнгүйрэн хариу мэндчиллээ. Би энэ амьдралд түүнтэй дахиад хэзээ ч таарахгүй л байх.

Гэхдээ зүрхнээс маань сунасан Бурханы хайр түүний дотор хожмын нэгэн өдөр үр жимсээ өгөх үрийг суулгасан гэж итгэдэг. Бид итгэх ёстой. Сүнс дотор амьдарч, өөрсдийгөө зүгээр нэг оршигсад бус, харин хүмүүсийн амьдралд амийг түгээхээр Бурханы ер бусын хүч дотор амьдарч байгаа элчин сайдууд гэдэгтээ итгэе.

Хүн рүү инээмсэглэх хэцүү байна уу? Танихгүй хүнд сайхан үг хэлэх хэцүү байна уу? Бидний эгэл үг тэдний амьдралд юм хийнэ гэдэгт итгэх хэцүү байна уу? Тэгвэл, та Бурханы хүчинд итгэх итгэлээр дутаж байна, зүрх чинь хүмүүсийг хүндэтгэх хүндэтгэлээр дутаж байна. Харин Бурханаас амиа зориулан үхсэн хүмүүсийг нь чин зүрхнээсээ хүндэтгэх хүндэтгэлийг асуун гуйвал, Бурхан үүнийг хүсдэг учраас, заавал өгнө.

Зүгээр л амьдар

Зүрхэнд тань хүмүүсийг гэх хүндэтгэл суулгахыг Бурханаас гуйсан бол, амьдрал тань өөрчлөгдөнө. Та зөөгчид өөрөөр ханддаг болно. Та цэсээ харж байгаад л хоолоо захиалаад явуулчихдаг биш, харин зөөгчийнхөө нүд рүү нь хардаг, мэнд усыг нь асуудаг болно. Хоолоо захиалахаасаа өмнө зөөгчийнхөө нэрийг асуудаг болно. Тэгээд нэрээр нь дууддаг болно. Хоолныхоо дараа сайхан үйлчилсэнд нь амаараа ч талархана, мөнгөөр ч гарыг нь цайлгаж, талархана. Үнэхээр талархаж байгаа л бол, мянган төгрөг биш, харин хоолныхоо үнийн дүнгийн хорин хувийг нь талархал болгож өг.

Үргэлж жишгээр дээгүүр үйлдэж бай. Дундаж хэмжээнд бүү тэмүүл. Тэр зөөгч аль хэр үнэ цэнэтэй болохыг өөрөөсөө асуу. Хариултыг нь ч та мэдэж байх ёстой. Есүс түүнийг амиа өгтлөө л нандигнасан шүү дээ.

Гэтэл намайг хоолонд урьсан пасторууд зөөгчдөө нүүр улаймаар гар цайлгах мөнгө өгсөн тохиолдол ганц нэг гарч байсан нь ичгүүртэй. Яг ийм нэгэн тохиолдол дээр би бүр ямар нэг юм хийхгүй л бол, байж суух чадахаа больж билээ. Тэгээд тэр пастортой зогсоол руу явж байхдаа, зүгээр л: “Та машинаа гаргаж бай. Би ресторан руу буцаж орох шаардлагатай болчихлоо” гэж хэлж билээ. Пасторыг машинаа гаргаж байх хойгуур нь би ширээн дээр нь овоо ахиухан гар цайлгах мөнгө тавьчихаад буцаж билээ. Бидэнд үйлчилсэн хүнд яаж тийм арчаагүй хандах билээ? Тэр зөөгч чинь биднийг цуглаанаа тараад явж

байгаа Бурханд үйлчилдэг хүмүүс гэдгийг мэдсэн шүү дээ.

Нэг удаа Лиза, бид хоёр зөөгчийнхөө гарыг хоолныхоо үнийн дүнгийн тавин хувьтай тэнцэх хэмжээний мөнгөөр цайлгаж билээ. Тэр бүсгүй биднийг Бурханы үйлчлэгч нар гэдгийг ярианаас маань мэдсэн л дээ. Бид хоёр түүнийг Бурхантай холбох холбоос нь болсон бөгөөд Бурхан өөрийг нь яаж үнэлж байгааг тэр мэдэх ёстой. Бид ч бүсгүйг мэдэхээс нь өмнө яваад өгөв. Гэхдээ мэдэх үедээ баярлаж, Аврагчийн анхилуун үнэрийг тээж хоцорсон гэдэгт итгэлтэй байна. Паул “Учир нь аврагдаж буй болон мөхөж буйчуудын дунд бид, Бурханд зориулсан Христийн анхилуун үнэр юм” (2Коринт 2:15) гэдэг шүү дээ. Тэр бүсгүй Бурханы үйлчлэлийг эерэгээр л харсан байх. Үүнийхээ улмаас ч ирээдүйд улам нээлттэй байх болов уу.

Танд үйлчилж байгаа хүмүүсийг хүндэтгэх үедээ та ихэвчлэн сайхан үйлчилгээ л хүлээн авна - их хувь, нэмэлт хоол, сайхан үйлчилгээ гэх мэт гэнэтийн бэлэг. Мэдээж итгэгч - бид үүний төлөө хүндэтгэх ёсгүй ч, энэ ч бас ерөөл мөн. Лиза, бид хоёр онгоцны буудлын түрээсийн зогсоолыг байнга хэрэглэдэг. Бид хоёр байнга аялдаг учраас, манай хэд ч бид хоёрын машиныг бүр таньдаг болчихсон. Хэд хэдэн хүн ажиллаж байвал, бидэнд түрүүлж үйлчлэх гээд л уралдчихна. Яагаад? Яагаад гэвэл бид тэдний гарыг сайн цайлгадаг. Түүнчлэн яриа хөөрөө дэлгэж, гэр бүл, аж амьдралыг нь асуудаг. Онгоцны буудлын нэг зогсоол л цаг агаарын нөхцөл байдлаас хамгаалсан битүү дээвэртэй, бусад нь хамгаалалтгүй задгай зогсоол байдаг юм. Миний машин дандаа тэнд байршдаг шүү. Үүнийг чинь хүндэтгэлийн шагнал гэдэг юм.

Ойролцоох хүнсний дэлгүүрт ч ялгаагүй. Манай хотод айлчилж ирсэн зочид Лиза, бид хоёртой хамт хүнсний дэлгүүр орохоороо, “Энд дэлгүүрт та хоёрыг таньдаггүй хүн алга аа?” гэдэг сэн. Бид алдартай зохиолч, үйлчлэгч нар учраас тэр биш л дээ. Үнэндээ тэд биднийг хэн болохыг ч мэдэхгүй. Зүгээр л бид тэдэнтэй яриа дэлгэдэг, аж амьдралыг нь асуудаг учраас л тэр. Биднийг хэн болохыг мэддэг нь заримдаа хүнд хэцүү үедээ залбирч өгөөч ч гэж гуйдаг. Биднийг орж ирэхэд, гэрэлтээд л явчихдаг сан. Тэгээд мөн ч олон удаа бусдад өгдөггүй нэмэлт хувь юмуу хямдралаа үзүүлдэг сэн. Тэгэхээр, дахиад асууя. Бид ашиг хонжоо харж тэднийг хүндэтгэдэг үү? Үгүй, хэзээ ч үгүй. Бурхан бидэнд бүгдийг хүндэтгээрэй хэмээн тушаасан учраас л бид хүндэтгэдэг.

Бодит жишээ

Амьдрал дээр бүх хүнийг хэрхэн хүндэтгэхийг бодитоор жишээлэн тайлбарлая л даа. Та хүнтэй уулзахдаа, нүд рүү нь хар, эелдгээр дууд, танд чухал хүн гэдгийг нь мэдрүүл. Өөрийнхөө захиалга, хүсэлт, наймаа зэрэг үндсэн зорилгоо л гүйцэлдүүлэхэд бүү анхаар. Харин хэсэгхэн хугацаа гаргаад, ажил хэргийг нь асуу. Цаг бөгөөд боломж нь байгаа бол, ганц асуулт тавиад зогсчилгүй, эрэл хайгуул хийгээд тэр хүнд юу чухал болохыг олж мэд. Тэрбээр танд чухал болохоо мэдэрсэн бол, эдүгээ түүнд дэлхий дээрх хамгийн том бэлгийг буюу Есүс Христийн сайн мэдээг барих үүд нээгдлээ л гэсэн үг. Харин та хүмүүсийг юмын чинээ бодохгүй байж, Сайн мэдээг хэлэх гэвэл, тэдэнд ашиглуулсан мэт мэдрэмж төрнө - өөрийгөө таны ээлжит нэгэн шашны төсөл л гэж санана.

Та хүмүүст тэдний “санаанд оромгүй” ямар бэлэг барьж болохыг бодоод үз - бяцхан бэлэг барих, зүгээр үедээ гарыг нь цайлгах юмуу ажилд нь туслах гэх мэт. Хог зөөдөг хүнийг ганц ундаагаар дайлчих эсвэл ойр хавьд чинь ажил хийж байгаа хүмүүсийг хоолоор дайл. Хөршийнхөө үүдний цасыг нь цэвэрлээд өгчих, гэнэтийн бэлэг болгоод зүлгийг нь тайраад өгчих. Хүмүүсийг санаандгүй байхад нь хүндэтгэх нь үнэндээ маш зугаатай ажил. Бяцхан юмс л таныг онцгойруулж, хүмүүсийн зүрхэнд Есүс Христийн мэдээг сонсох хүсэл оргилуулдаг билээ.

Дахин хэлэхэд, Бурханаас жинхэнээсээ хүндэтгэдэг зүрхийг гуй. Хүндэтгэх зүрх сэтгэлгүй байж, хүндэтгэх гээд байвал, шал хуурамч юмуу эвсэл тун гүехэн хүндэтгэл болно. Бүр найдаж байснаас чинь ч эсрэгээр эргэж болох. Чин сэтгэлийн бус зүйл амархан мэдэгддэг. Номынхоо сүүлчийн бүлгийн төгсгөлд бүгдээрээ зүрхэнд маань жинхэнэ хүндэтгэл байхын төлөө Бурханаас залбиран гуйна. Энэ номон доторх Бурханы Үг хүндэтгэлийг эрмэлзэх, хүндэтгэлээр цангах итгэлийг тань байгуулсаар ирсэн бөгөөд бид зүгээр гуйгаад авахад л болно. Гэхдээ түүнээс өмнө сүүлчийн, хамгийн чухал нэгэн зарчмыг мэдэх хэрэгтэй байна.

Бурханыг хүндэтгэхүй

Эцэст нь хэлж байгаа боловч, үнэндээ хамгаас чухал зарчим болбоос жинхэнэ хүндэтгэлээр амьдрах цорын ганц зам нь нэн тэргүүнд Бурханыг хүндэтгэхүй болой. Бурханыг бүхнээс бөгөөд бүгдээс дээгүүр үнэлж байж л, урт удаан настай хүндэтгэл оршино. Сургаалт үгс 3:9 бидэнд “Эзэнийг хүндэтгэ” хэмээн тушаасан.

Бид Эзэнийг бүхнээс бөгөөд бүгдээс дээгүүр үнэлэх, цэнэлэх, хүндэтгэх, эмээх ёстой юм. Тэр бол Аугаа их Хаан. Тэр бидний хагас хугас хүндэтгэлийг бус, харин хамаг хүндэтгэлийг маань авах бүрэн эрхт Бурхан. Ганцхан Бурханд зориулсан хүндэтгэл маань мөргөл болж очдог юм.

Эцсийн зорилго нь Бурханыг л хүндэтгэх явдал болохыг санаарай. Эрх мэдэлтнүүд, нэг зиндааныхан, “багачуудыг” хүндэтгэх хүндэтгэл маань бүгд Есүст очиж, цаашаа Аавд хүрдэг билээ. Тиймээс Бурханаа даваад, хүнийг хүндэтгээд, дагаад унах нь мөнх настай хүндэтгэл бус, харин мөхөх хүндэтгэл буюу шүтээн шүтэх явдал болно.

Мөхөх хүндэтгэл

Ели тэргүүн тахилч байсан. Тэрбээр Самуелыг жаалхүү байхад майхан сүмийг хариуцдаг байв. Хөвгүүд нь гэж Эзэнийг, Түүний хүмүүсийг, тахилчийнхаа ажил үүргийг ч хүндэтгэдэггүй, олиггүй амьтад байв. Тэд тахилын аль өнгөтэй өөдтэйг нь өөртөө авдаг бөгөөд сүсэгтэн олон гомдол гаргах юм бол, хүчээр булааж авдаг байжээ.

Ели хөвгүүдийнхээ энэ жигшүүрт явдлыг ч мөн майхан сүмийн үүдэн дээр үйлчилдэг, залуу хүүхнүүдийг оролддог явдлыг нь ч мэддэг байв. Тэгж тэгж эцэстээ: “Би энэ ард олноос ёрын муу хэргийг чинь сонслоо. Та нар ийм хэрэг юунд үйлдэнэ вэ? Ингэж болохгүй, хүүхдүүд минь. ЭЗЭНий хүмүүсийн дунд яригдаж буй, надад сонсогдсон энэ сураг сайн юм огт биш” (1Самуел 2:23-24) хэмээн хөвгүүдээ зэмлэжээ.

Ели хэдийгээр хөвгүүдтэйгээ нүүрэлдсэн ч, тахилчийнх нь ажлаас буулгасангүй. Учир нь Елид энэ нь ашигтай байж. Тэрбээр асар ховдог бүдүүн хүн байсандаа, хөвгүүдийнхээ олж ирсэн махнаас хүртдэг байв. Ели үнэхээрийн л Бурханыг хүндэтгэдэг байсан бол, хөвгүүдээ албан тушаалаас нь буулгах л байсан. Тэгээд оронд нь Бурханд ч, хүмүүст ч чин сэтгэлээр үйлчилдэг, зөвт хүмүүсийг тавих байсан. Тэгэхээр, эш үзүүлэгчээрээ дамжуулан Елид хэлсэн Бурханы Үгийг үзнэ үү:

ЭЗЭН айлдахдаа “Чиний эцгийн гэр Египетэд Фараоны гэрт байхад Би Өөрийгөө тэдэнд илэрхийлсэн бус уу? Миний тахилчид байж, Миний тахилын ширээн дээр тахиж, утлага уугиулж, Миний өмнө ефод зүүлгэхийн тулд Би Израилийн хамаг овгоос тэднийг сонгосон бус уу? Израилийн хөвгүүдийн бүх галан тахилыг Би чиний эцгийн гэрт өгсөн бус уу? Миний орших газарт Миний тушааснаар Надад өргөсөн өргөл, тахилууд дээр та нар яагаад дэвсэлж бас Миний ард түмэн Израилийн тахил бүрийн дээжээр нь өөрсдийгөө таргалуулан хөвгүүдээ Надаас илүү *дээдэлж (хүндэтгэж)* байна вэ?” гэлээ (1Самуел 2:27-29, тодруулгыг нэмэв).

Эш үзүүлэгч Елигийн сэдлийг гаргаж тавьжээ - Ели түрэмгийллээр олж авсан, аль сайн өргөлд дурласандаа, шударга үнэнийг дардаг байж. Ели Бурханаас илүү хөвгүүдээ *дээдэлж (хүндэтгэж)* байгааг Бурхан эш үзүүлэгчээрээ дамжуулан мэдэгджээ. Ингэснээрээ ямар ч шагнал хүртэхгүйгээр барахгүй, харин ч эсрэгээрээ - хов хоосон хоцорно. Бурхан эш үзүүлэгчээрээ юу айлдсаныг л үз:

Тиймээс Израилийн Бурхан ЭЗЭН ийнхүү тунхаглаж байна. “Чиний гэр болон чиний эцгийн гэр Миний өмнө мөнхөд явна хэмээн Би айлдсан билээ.” Харин одоо ЭЗЭН тунхаглан “Тэгэх нь Надаас хол байг! Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ.

Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна. Харагтун, Би чиний тэнхээг, чиний эцгийн гэрийн тамирыг тасалж, гэрт чинь өвгөн настан үгүй болох өдөр айсуу. Израильд сайнаар соёрхдог бүхний дунд [Миний] орших газар гамшиг болохыг чи үзнэ. Чиний гэрт настай хүн үүрд үгүй болно. Гэсэн ч нүдийг чинь нулимсаар сохолж, сэтгэлийг чинь гансруулахын тулд Би танай бүх хүнийг Өөрийн тахилын ширээнээс зайлуулахгүй. Чиний гэрийн бүх үрс харин ид залуугаараа үхнэ. Чиний хоёр хүү Хофни, Финехас нарт тохиолдох зүйл нь чамд тэмдэг болно. Тэр хоёр нэг өдөр үхнэ. Харин зүрх болон сэтгэлд минь таалагдахаар үйлдэх үнэнч тахилчийг Би Өөртөө гаргаж ирнэ. Би түүнд бат үнэн гэрийг барьж өгнө. Тэр үргэлж Миний тосолсон хүний өмнө алхах болно. Чиний гэрт амьд үлдэгсэд бүгд задгай мөнгөн зоос, үмх талхны төлөө түүнд сөгдөхөөр ирж, «Үмх талхтай болмоор байна, тахилчийн ямар нэг албанд намайг тавьж өгөөч» гэж гуйх болно” гэсэн гэв (1Самуел 2:30-36).

Бурхан өөртөө юмуу хүмүүст таалагдахыг эрэлхийлэхээсээ илүүтэй Өөрийг нь дагадаг, итгэмжит тахилчаа гаргаж ирэхээ айлджээ. Энэ бол жинхэнэ хүндэтгэл. Елиг орлох энэ тахилчийн шагнал болбоос тэрбээр өөрөө ч, үр удам нь ч байр сууриа хэзээ ч алдалгүй, элбэг дүүрнээр ерөөгдөх ажээ.

Абрахамын ерөөл

Абрахам Бурханыг яг ингэж хүндэтгэжээ. Абрахамд Исаакаас чухал хэн байх билээ? Хорин таван жил хүлээлгэн байж, төрсөн үр нь шүү дээ. Абрахам хүүгээ хэнээс ч, юунаас ч илүү хайрладаг байсан. Гэтэл нэг шөнө Бурхан Абрахам дээр айлчлаад, хүүгээсээ илүү Өөрийг нь хүндэтгэхийг хүсчээ. Бурхан Абрахамаас хүүгээ алахыг хүссэн. Бурхан Абрахамд яасан хэцүү юм дуулгах нь энэ вэ? Үүнээс бусдыг нь Абрахам цөхөх юмгүй хийчихнэ шүү дээ. Үр удмыг нь үргэлжлүүлэх хүүгээ алахаас, бүх эд хөрөнгөө алдах нь хавьгүй амар. Цааш нь уншбал “Абрахам өглөө эртлэн босоод илжгээ эмээллэж, хоёр зарц залууг хүү Исаакийнхаа хамт дагуулж, шатаалт тахилын мод хагалж аваад Бурханы өөрт нь айлдсан тэр газар уруу явжээ” (Эхлэл 22:3)

гэжээ. Абрахам түдгэлзээгүй, маргааш өглөө нь л гэхэд Бурханы тушаалыг биелүүлэхээр, замдаа гарчээ.

Абрахам Бурханыг бүхнээс бөгөөд бүгдээс дээгүүр хүндэтгэдэг байж. Иймээс л Исаакийг алахын даваан дээр тэнгэрэлч гарч ирээд “Хөвгүүний эсрэг гар бүү далай! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй тул чамайг Бурханаас эмээдгийг чинь одоо Би мэдлээ” (12) хэмээн хашхирчээ. Тэгэхээр, жинхэнэ хүндэтгэл бүр нь ариун эмээхүйн дайвар бүтээгдэхүүн ажээ. Одоо үйлсийнхээ төлөө Абрахамын хүлээж авсан дээд шагналыг сонсоно уу:

Тэнгэрээс ЭЗЭНий тэнгэрэлч, Абрахамыг хоёр дахиа дуудаж — ЭЗЭН ийн айлдаж байна. “Чи ийнхүү үйлдэж, хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй учир Би Өөрөөрөө тангараглаж байна. Би үнэхээр чамайг ерөөж, үр удмыг чинь тэнгэрийн одод, далайн эргийн элс мэт асар олон болгоно. Үр удам чинь дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэх болно. Чи Миний үгийг дуулгавартай дагасан учир үр удмаар чинь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөх болно” гэв. (Эхлэл 22:15-18)

Бурханыг Өөрийг нь шууд хүндэтгэнэ үү, зарц нарыг нь хүндэтгэх байдлаар - шууд бусаар хүндэтгэнэ үү - хүндэтгэл нь ямагт шагнал дагуулдгийг санаж яваарай.

Мосегийн буруу сонголт

Мосе - өөр хүнийг Бурханаас илүү хүндэтгэснээсээ болоод хамаг байдгаа алдах дээрээ тулсан бас нэгэн хүн билээ. Тэрбээр тун аюултай алдаа гаргасан тул Бурхан ч тун их хилэгнэж, хариугүй Мосегийн амийг авах шахжээ. “Зам дахь хоноглох газарт ЭЗЭН түүнтэй уулзаад, түүнийг үхүүлэх гэв” (Гэтлэл 4:24).

Эхлээд бүгдээрээ үүнээс өмнөх үйл явдлыг товч үзье. Эзэн Мосетэй галт бутан дээр уулздаг. Тэгээд түүнийг Израилийг Египетээс удирдан гаргах хүнээр томилж байгаагаа мэдэгдсэн. Мосе уулнаас буугаад, Бурханы айлдсаныг биелүүлэхийн тулд эхнэр, хүүхдээ аваад Египет рүү хөдөлжээ. Буудалласан анхных нь шөнө Бурхан Мосег алахаар ирж. Юу? Хүмүүсийг нь чөлөөлнө гэж хэлсэн хүнээ алах ий? Бурхан

шизотой юм уу? Үгүй ээ, мянгантаа үгүй! Тэгэхээр, энэ бүхэн ямар учиртай вэ?

Мосе галт бутан дээр Бурхантай уулзчихаад, уулнаас бууж ирэх үедээ хамгийн түрүүнд гэргийтэйгээ уулзсан байдаг. Гэргий нь ч эр нөхөрт нь тохиолдсон ер бусын явдлыг мэдээд, шалгаажээ. Тэдний хооронд нэг иймэрхүү яриа өрнөсөн байх: “Хонгор минь! Надтай Бурхан уулзаад, Египет рүү буцаж очоод, Миний хүмүүсийг Фараоны дарлалаас чөлөөл гэлээ. Тэгэхээр, нөгөө яригдсаар ирсэн чөлөөлөгч нь би байх нь” хэмээн Мосег ярихад, гэргий Зиппора нь ч: “Тайхмаар юм аа. Би хамт явна шүү. Бүгдээрээ хэзээ явах уу?” гэж.

Мосе гэргийдээ: “Шууд хөдөлье. Гэхдээ урьдаар нэг юм хийх хэрэгтэй. Уулан дээр Бурхан надад Абрахамтай байгуулсан гэрээгээ танилцуулсан. Тэгээд хоёр хүүгийнхээ хөвчийг хөндөх ёстой гэсэн” гэв.

Гэргий нь ч: “За за. Тэгвэл ууган хүү Гершомоосоо эхлэх үү” л гэж.

Мосег хөвч хөндөх зан үйл хийхийг нь Зиппораг харж зогсов.

Тэгэхээр, нэг зүйл хэлье. Би гурав дахь хүүгээ хөвч хөндүүлэхийг нь харсан юм. Хөвч хөндөхөөс өмнө эмч бидэнд зүрхээ чангалахыг сануулав. Алекийг тэгтэл өвдөхийг нь эхний бөгөөд эцсийн удаа харна гэж билээ. Тэгээд эмч хавчиж байгаад, зүстэл Алекийн эд эс бүр нь чарлаад л явчихыг харсан юм. Хүүгээ тэгтэл өвдөхийг харах шиг аймшиг үгүй юм билээ.

Тэгвэл үүнийг Зиппора дээр хэрэгжүүлж үзье дээ. Ээж нь том хүүгээ өвчиндөө тарчлан, орилж, чарлахыг харсан. Тэгээд айгаа л байх. Нөхөр нь хайртай хүүгээ тэгтэл тамлах гэж? Тэр өөрийгөө хэнтэй суучихав аа гэж л бодсон байх. Уулан дээр гараад, яачихаад ирэх нь энэ вэ? Тэр Бурхан нь цусанд дуртай, харгис Бурхан юм болов уу?

Тэгээд хөндлөнгөөс оролцжээ. Тэрбээр нөхөр, отгон хүү Елиезерийнхээ дундуур ташаагаа тулан хөндөлсөөд, хөлөө дэвслээд, чангаар эсэргүүцлээ илэрхийлээ байх. Өөрөөр хэлбэл, энэ үйлдлээрээ *Мосе гуай, хүүд минь хүрээд үзээрэй* гэж ойлгуулжээ. Зиппора “Энэ чинь миний нялх хүүхэд. Чи хүүд минь хүрэхгүй шүү. Гершомыг тамласан чинь хангалттай. Ямар гээчийн эр нөхөр вэ, чи?!” л гэж.

Тэгээд тэр гэр бүлд бөөн хэрүүл дэгдээ байх. Зиппора маргалдаад л, орилоод л, магадгүй бүр Мосег заналхийлээ байх. Ийм маягаар өдөржин, шөнөжин тэгээд өглөө болтол үргэлжилсэн л болов уу. Хоолоо ч хийхгүй, цаг ирэх тусам, улам л догширсоор. Мосе сүүлдээ энэ эцэс төгсгөлгүй хэрүүлээс залхаж ядраа байх.

Тэгж тэгж Мосе “Би энэ хэрүүлээс залхаж байна. Надад хийх ажил байгаа. Би улс үндэстнээ чөлөөлөх дуудлагатай. Ажлаа хийх минь” гэж бодоод, эхнэрийнхээ хүчтэй эсэргүүцэлд буугаад өгсөн байх. Тэгээд: “За ойлголоо ш дээ. Зүгээр явцгаая” гэжээ.

Эзэн тэдний Египет рүү явах зам зуураа буудалласан газарт нь бууж ирээд, Бурханаас илүү гэргийгээ хүндэтгэсэн Мосег алах гэв. Бурхан сонгосон удирдагчдаа ийм зүйлийг зөвшөөрөхгүй. Бурхан Мосег алж хаячихаад, өөр хүнийг олчихно. Гэтэл хэрэг явдал бишидснийг үзсэн гэргий нь ухаалаг зан гарган, хүүгийнхээ хөвчийг хөнджээ. “Тэгэхэд Зиппора цахиур чулуу авч, хүүгийнхээ тээрхийн арьсыг танаад Мосегийн хөлд хаяж — Чи үнэхээр миний цуст хань гэж хэлэв” (Гэтлэл 4:25).

Ингэмэгц нь “Эзэн Мосег тавьжээ” (26). Намайг нэг өдөр залбирч байтал, Бурхан: “Би Мосег алахаар бууж ирсэн үү, гэргийг нь алахаар бууж ирсэн үү?” хэмээн асууж билээ.

Би ч “Мосег” гэж ирээд л анхааралтай хариулав.

Тэгтэл Бурхан надад “Тийм ээ. Яагаад гэвэл Би хөвгүүдийнхээ хөвчийг хөндөөрэй гэж Мосед айлдсан. Тэр өрхийн тэргүүн бөгөөд тэр л гэргийнхээ тулган шаардалтыг Миний тушаалаас дээгүүр тавьсан. Тэр хариуцлагатай” хэмээн хэлж билээ. Энэ явдал надад эрх мэдэл дор байгаа хүмүүстээ таалагдахын төлөө үнэнийг хөсөрдүүлэх нь ямар аюултай болохыг харуулсан юм.

Мосе энхийг тогтоохын оронд энхийг сахих гэж үзжээ. Матай 5:9 дээр Есүс “Энхийг сахигч нар ерөөлтэй” гэж хэзээ ч хэлээгүй, харин “Энхийг тогтоогч нар ерөөлтэй” гэж л хэлсэн билээ. Энхийг сахигч нар нь хуурамч энх тайвнаа хадгалж үлдэхийн тулд үнэнийг хөсөрдүүлдэг хүмүүс юм. Энэ урхинд удирдагч нар ихээхэн унадаг. Үндсэндээ, энэ нь нүдэнд харагдах хүнийг нүдэнд харагдахгүй Бурханаас дээгүүр хүндэтгэх явдал юм. Энэ үйлдлийг Бурхан жигшдэг.

Нөгөөтэйгүүр, энхийг тогтоогч нь жинхэнэ энх тайвныг авчрахын төлөө шаардлагатай бол, нүүрэлдэж ч чаддаг. Тиймээс л Есүс “Баптисч Иоханы өдрүүдээс өнөөг хүртэл тэнгэрийн хаанчлал хүчирхэгжихэд, хүчирхийлэгчид ч бас хүчээ авав” (Матай 11:12) хэмээн айлджээ. Мөн “Бурханы хаанчлал бол... амар тайван” (Ром 14:17) учраас, бид жинхэнэ амар тайвны төлөө заримдаа нүүр тулах үе ч гарна.

Энхийг сахигч нар нь голдуу амиа л боддог. Тэд амьдралынхаа тав тухыг алдах дургүй. Мөн нүүрэлдэх ёстой хүмүүсийнх нь буянаар сул орж ирж байгаа олз ашигт дурладаг. Яг л хөвгүүдээ зогсоогоогүй Ели шиг.

Дээрх явдал Мосед сургамж болсон бөгөөд тэрбээр дахиж хэзээ ч хүний дураар үнэнийг хөсөрдүүлэхгүй. Үндсэндээ үйлчлэлийнхээ аман дээр гаргасан алдаа нь Мосег насан турш аугаа удирдагч хүн болгох бат итгэл үнэмшлийг зүрхэнд нь хадаж өгсөн тэмдэглэгээ, сургамж болж өгчээ.

Гэтэл Ели өөр байсан. Тэр Мосе шиг шинэхэн удирдагч байгаагүй, харин ч туршлагатай ахмад удирдагч байсан. Ели юу хийж байгаагаа сайн мэдэж байсан. Гэтэл Мосе сайн нөхөр байх гэж л хичээсэн байх даа. Мосе сэтгэлээсээ боловч, үнэн голоосоо буруу байжээ.

Гэр бүлийн асуудал

Энэ бүлэгт миний дүрсэлсэн бүх жишээг ажиглабал, бүх асуудал гэр бүл дотор л өрнөж байгааг та анзаараа байх. Ели, Абрахамын хүүхдүүдийн асуудал, Мосегийн гэргийн асуудал. Яг энэ цэг дээр Есүсийн дараах үг маш ойлгомжтой болж ирж байна:

Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү бод. Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм. Хүүг эцгийнх нь эсрэг, охиныг эхийнх нь эсрэг, бэрийг хадам эхийнх нь эсрэг болгохын тулд Би ирсэн. Хүний дайсан нь гэр бүлийнхэн нь болно. Эцгээ юмуу эхээ Надаас илүү хайрлагч нь Миний хувьд зохистой нэгэн биш. Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрлагч ч Миний хувьд зохистой нэгэн биш ээ (Матай 10:34-37, тодруулгыг нэмэв).

Хэн нэг хүнийг - нэн ялангуяа гэр бүлийнхээ гишүүнийг хүндэтгэхийн төлөө Бурханы Үгээрээ илчилсэн хүслийг хөсөрдүүлбэл, бид үндсэндээ Бурханы эсрэг нүгэл өдөөнө. Үүний жинг ойлгосон хэмээн найдъя. Есүс шулуун шударга айлдруун. Учрыг нь дээрх түүхүүдээс ойлгосон байх аа. Елигийн хувьд, гэр дээр нь буусан шүүхээс зайлаагүй. Хөвгүүдээ Бурханаас дээгүүр тавьсан явдлынхаа хариуд өндөр төлөөс төлжээ.

Үүнд хүндэтгэлийн зохистой тэнцвэр оршино. Бид номоо эхнээс нь дуустал хүндэтгэлийн талаар л өгүүлсэн болов ч, Бурханаас давсан хүндэтгэл нь Бурханыг үл хүндэтгэсэн явдал буюу шүтээн шүтлэгийн ангилалд багтах агаад ихэвчлэн аймшигтай үр дагавартай

тусдаг. Бурханаас дээгүүр хэнийг ч, юуг ч хүндэтгэж үл болно. Тэр бол Бурхан, Хаан бөгөөд Аврагч. Бид үүнийг бүхнийхээ оройд сахиж байх ёстой.

Хүндэтгэлийг дуулгавартай үйлдлээр л харуулна

Хүмүүс хүнийг Бурханаас дээгүүр хүндэтгэсэн жишээ Бичээсээр дүүрэн. Аль нь ч таатай үр дагавар авчраагүй. Бид эрх мэдэл дорх хүмүүсээ Бурханаас дээгүүр хүндэтгэхийн үр дагаврыг үзсэн. Адилхан зэрэг зиндааны хүмүүс, биднээс дээгүүр эрх мэдэлтнүүдийн тухайд ч ялгаагүй.

Хаад ном дээр гардаг ахмад, залуу хоёр эш үзүүлэгчийн жишээ миний орой руу ордог юм. Бурхан Иудагийн залуу эш үзүүлэгчид Бетелд очоод, Иеробоам хааны тахил өргөдөг, шүтээний тахилын ширээг нь зэмлэн хашхирахыг тушаажээ. Тэр ч биелүүлэв. Бурхан тахилын ширээг нь хоёр хувааж хаяад, үнс нь ч яг л залуу эш үзүүлэгчийн хэлснээр асгарав.

Бурханы Үг ийм хурдан биелсэнд Иеробоам хаан ч алмайрч, Бурханы хүчээр гар нь эдгэрэв. Тиймээс хаан эш үзүүлэгчийг амрааж, шагнахаар ордондоо урьтал, эш үзүүлэгч: “Та өөрийнхөө гэрийн тэн хагасыг надад өгөх байсан ч би тантай хамт явахгүй мөн энэ газарт байхдаа би талх ч идэхгүй, ус ч уухгүй. Учир нь ЭЗЭНий үгээр надад “Чи талх ч идэж, ус ч ууж болохгүй, тэр ч бүү хэл ирсэн замаараа ч буцаж явж болохгүй” гэж тушаагдсан юм” (1Хаад 13:8-9) гэж хариулжээ.

Тэгээд өөр замаар Иуда руугаа буцав. Гэтэл замд нь нэгэн ахмад эш үзүүлэгч таараад, гэртээ зоог барихыг урьжээ. Залуу эш үзүүлэгч ахмад эш үзүүлэгчид мөн л идэж уух болохгүй, ирсэн замаараа буцаж болохгүй гэсэн Бурханы үгийг хэлээд, явж чадахгүй гэжээ. Гэтэл ахмад эш үзүүлэгч: “Би ч бас чамтай адил эш үзүүлэгч. Тэнгэрэлч, ЭЗЭНий үгээр надад хэлэхдээ “Түүнийг гэртээ дагуулж ирээд талх идүүлж ус уулгаарай” гэсэн юм” (18) гэв.

Залуу эш үзүүлэгч ахмад эш үзүүлэгчийн үгийг хүндэтгээд, гэрт нь очжээ. Тэгээд гэрт нь идэж ууж байтал, залуу эш үзүүлэгчид “дуулгаваргүй зангийнхаа улмаас өвгөдийнхөө булшин дээр очиж чадахгүй болно” гэсэн Эзэний үг ирэв.

Залуу эш үзүүлэгч цааш Иуда руугаа хөдлөөд, замдаа арслантай тааран, тэр араатанд алуулжээ. Гэхдээ арслан түүний хүүрийг ч идсэнгүй, унаж явсан илжгэнд нь ч хүрсэнгүй бас идсэнгүй. Ахмад эш үзүүлэгч залуу эш үзүүлэгчид тохиолдсон явдлыг сонсохдоо: “Тэр ЭЗЭНий үгийг зөрчсөн, Бурханы хүн юм. ЭЗЭН түүнд хэлсэн ёсоороо түүнийг арсланд өгч тасчуулжээ” (26) гэжээ.

Залуу эш үзүүлэгч ахмад эш үзүүлэгчийг хүндэтгэсэн. Магадгүй хар багаасаа л ахмадаа хүндэтгэхийг сурсан байх. Бурханд өөрөөс нь удаан үйлчилж яваа хүмүүсийг хүндэтгэх нь сайн чанар болохыг яс махнаасаа л мэддэг байсан байх. Гэхдээ, зохистой тэнцвэр гэж нэг юм бий. Ахмад үзүүлэгчийн үгийг Бурханы үгээс давуулан хүндэтгэсэн алдаа нь залуу эш үзүүлэгчийн аминд хүрчээ.

Шинэ гэрээнд Петрийн амьдралаас ч энэ жишээг харж болно. Элч Паул ингэж бичсэн байдаг:

Харин Кефийг Антиохт ирэхэд би түүнийг нүүрэн дээр нь эсэргүүцэв. Учир нь тэр буруутан болоод байлаа. Иаковын хэдэн хүнийг ирэхээс өмнө харийнхантай хооллодог байсан атлаа тэднийг ирэхэд тэр хозлуулагсдаас цэрвэж, харийнхнаас холдон зай барьсан юм. Бусад иудейчүүд ч түүний хамт хоёр нүүр гаргацгаасан. Түүнчлэн Барнаб хүртэл хоёр нүүрт байдалд нь автсан юм. (Галат 2:11-13)

Яагаад Петр, Барнаб, өөр Еврей итгэгч нар гадаад итгэгч нартай өмнө нь зүгээр л идэж байснаа дараа нь идэхээ больчихов? Хариулт нь энгийн - тэд нөхдөө үнэнээс дээгүүр хүндэтгэснээсээ болоод аймхай, хоёр нүүртэй зан авир гаргажээ. Петр үнэнийг мэдэж байсан. Түүнийг Иоппад байхад нь энэ үнэн үзэгдлээр дамжин илчлэгдсэн. Нарийндаа Эзэн түүнд “Бурханы цэвэр болгосон юуг ч бузар гэж бүү нэрлэ” (Үйлс 10:15) хэмээн айлдсан.

Заримдаа нүдэнд харагдахгүй Бурханыг хүндэтгэж байхаар нүдэнд харагдах хүнийг хүндэтгэх нь амархан байдгийг би мэднэ. Гэхдээ ингэж болохгүй юм. Бид хариу үйлдлээ зохицуулахын тулд итгэл үнэмшлийн хил хязгаараа бат тогтоож байх ёстой. Тэр цагт хүндэтгэдэг, хайртай хүн маань биднээс Бурханы Үгийг зөрчсөн юм гуйх, өдөөх, ятгах гэж оролдох үед нь бид тэднийг хүслийг Бурханы хүслээс дээгүүр хүндэтгэхгүй.

Хүндэтгэлээ азнах

Хүндэтгэлийг азнах үе бас байна. Ховор хэдий ч, нүгэлд унахгүйн тулд үүнийг хийх үе байна.

Зунаар цас, ургацнаар бороо гэгчээр Мунхагт алдар хүнд үл зохино (Сургаалт үгс 26:1).

Мунхагт алдар хүнд өгөх нь Дүүгүүрт чулуу холбож бэхлэхтэй адил (Сургаалт үгс 26:8).

Дүүгүүрт чулуу бэхэлбэл, танаас бусад нь гэмтэхгүй. Энэ бүхэн өдөр тутмын амьдрал дээр хэрхэн хэрэгжих вэ? Нэгдүгээрт - мунхаг гэж хэнийг хэлнэ вэ? Тэрбээр Бурхан байхгүй гэж зүрхэндээ хэлдэг нэгэн (Дуулал 53:1), базаахгүй үг тараагч нэгэн (Сургаалт үгс 10:18), ёрын мууг дурлан үйлдэгч (Сургаалт үгс 10:23), бурханлаг зөвлөгөөг үл хайгч, өөрийнхөө нүдэнд хэзээд зөв байгч нэгэн (Сургаалт үгс 12:15), аманцар (Сургаалт үгс 14:3), цэц ухаан, мэдлэгийг жигшигч, үг авдаггүй, өөртөө эрдсэн нэгэн (Сургаалт үгс 15:5, 18:2). Бичээс дээрх мунхгийн дүрслэлээс цөөхнийг жишээлсэн маань л энэ. Товчхондоо, Шинэ гэрээ ийм хүнийг анти-христ хэмээн олонтаа нэрлэх. Учир нь тэд Есүс Христийн сургаал, замаас яг эсрэгээр амьдардаг.

Бид ийм хүнийг, түүний тэнэглэлийг хүндэтгэбэл, өөрийгөө хохироож, дүүгүүр дэхь чулуу маань эргээд биднийгээ онох аюултай. Элч Иохан хоёр дахь захидал дээрээ үүнийг тодорхой хэлсэн:

Хэн нэгэн нь та нар дээр ирэхдээ энэ сургаалыг авчрахгүй бол, түүнийг гэртээ бүү оруул, бүү мэндэл. Түүнтэй мэндэлж буй нь ёрын үйлсэд нь оролцож буй хэрэг юм (2Иохан 10-11).

Христийн доктрины эсрэг итгэл, хүндэтгэлгүй зан авирыг хүндэтгэх нь ухаалаг бус явдал. Ингэвээс бид тэдний нүглийн хамсаатан болно.

Хүндэтгэлийг шахан шаардах

Эцэст нь, хүндэтгэлийг шахан шаардах нь Бурханы зүрхийг сөрсөн үйлдэл болохыг өмнө хэлсэн билээ. Хүндэтгэлийн талаар сургаал

сонсчихоод, хариад эхнэр, хүүхдээсээ хүндэтгэл шаардаж байгаа нөхөр хүн хүндэтгэлийн амийг ойлгоогүй ажээ. Энэ үнэн эрх мэдлийн бүх байр суурь дээр хэрэгжинэ. Нөгөөтэйгүүр, бусдын хүндэтгэлийг байлдан дагуулахын тулд юу хийж болохыг Бичээс бидэнд заадаг:

Мэргэн ухааныг, ухаарлыг олж ав Амнаас минь гарсан үгнээс бүү эргэ, бүү март! Мэргэн ухааныг бүү огоор Тэр чамайг хамгаална. Түүнийг хайрла Тэр чамайг сэргийлнэ. Мэргэн ухааныг ол Олсон бүхнээсээ Ухааран ойлгохуйг ол Энэ нь мэргэн ухааны эхлэл. Мэргэн ухааныг өндөрт үнэл, Тэр чамайг *өргөмжилнэ (хүндэтгэнэ)* Түүнийг тэвэр, тэр чамайг алдаршуулна (Сургаалт үгс 4:5-8, тодруулгыг нэмэв).

Цэц ухааныг хайрлах аваас, тэрбээр чамд хүндэтгэлийг авчирна. Цэц ухааны гараа нь Эзэнээс эмээхүй ажээ. Бид Эзэнээс эмээхдээ, амьдралынхаа тал бүр дээр Бурханы Үгд итгэж, даган биелүүлнэ. Библийг өөрийнхөө итгэл, амьдралын хэв маягт тааруулах гэж оролддог хүмүүс байдгийг би харсан. Тэд Библийг уншихдаа, *унисан зүйлдээ итгэхийн* оронд *итгэдэг зүйлээ л унишж* таардаг. Эхнийх нь цэц ухаанд хүргэдэг Эзэнээс эмээхүй бол, хоёр дахь нь худал хуурмаг юм.

Бурханы өмнө үнэн, хайр, нигүүлслээр амьдарч, даруухнаар алхахыг тэмүүлдэг хүмүүс үтэр түргэн гэмшиж бас итгэдэг. Тэд шаардлагатай үедээ үг авдаг.

Библи: Сургамжийг үл ойшоогчдод ядуурал ба үл хүндлэл. Гэсгээлтийг сахигчдад алдар хүнд (Сургаалт үгс 13:18) гэдэг. Бурханлаг чанарыг мөшгих аваас, Бурхан хүндэтгэлийг амладаг. Тэр даруй ирэхгүй байж болох ч, ирэхдээ л ирнэ. Би өдий олон жил үйлчлэхдээ, Бурханы хязгааргүй ерөөл дунд алхалж яваа хүмүүсийг харсан. Тэдний хувьд итгэмжтэй байдал нь ямар ч шагналгүй мэт цаг улирал зөндөө байсан ч, тэд цөхрөшгүй тэвчээрийнхээ хүчээр аугаа хүндэтгэл, ерөөлийг үзжээ.

Хүндэтгэлийг тээх

Сүнс дотроо даруу байж байж л хүндэтгэлийг тээнэ. Бурхан биднийг цүл пал хийтэл ерөөсөн байсан ч, бид өөрт байгаа бүхнээ бусдаас л

хүлээж авсан гэдгийг хэзээ ч мартаж болохгүй. Лиза, бид хоёр анх үйлчлэлээ эхлүүлэхдээ нэг их юмтай ч байсангүй, юмтай болох гэж хөөцөлдөж ч байсангүй. Бид хоёр Бурханы нээж өгсөн үүдээр орсон шиг орно гэж шийдэж билээ.

Хэрэгцээ маань эцсийн эгшинд хангагдахыг олон жил харсны эцэст нэг удаа Бурхан миний залбиралд “Хүү минь, Би чамайг, гэр бүл, үйлчлэлийг чинь яаж ерөөхийг чи төсөөлөхгүй. Чи арвин хангамжийг эдэлж, үйлчлэлийн чинь үр нөлөөлөл энгүй хүчирхэг болно. Гэхдээ энэ нь нөгөө талаараа чамайг шалгана. Хуурай цагт чи бүх зүйлийнхээ төлөө Надад найдсан - юу ярих, мөнгө төгрөгөө хэрхэн зарцуулах, хаашаа явах гээд л. Тэгвэл Би чамайг арвин ихээр ерөөх үед чи Надад саналаа хэлдэг болох уу эсвэл юу ярихаа Надад даатгах уу. Мөнгөө дураараа зарцуулах уу эсвэл Миний зөвлөгөөг сонсох уу. Хаашаа очиж, юу хийхээ дураараа шийдэх үү. Хэн байснаа мартах уу?” хэмээн айлдсан юм.

Тэгээд дараа нь “Хүү минь, ихэнх хүмүүс хуурай улиралд бус, баян улиралд л унадаг юм шүү” гэж билээ.

Би гэртээ хариад (Би гэрийнхээ ойролцоох эзгүй газарт очиж залбирдаг байлаа), гэргийдээ энэ бүхнийг ярьснаа санаж байна. Тэгтэл гэргий маань над руу ноцтой харцаар хараад: “Жон, чи Бурхан биднийг арвин ихээр ерөөнө гэдэг эхний хэсгийг нь л хэлсэн бол, би баярласандаа бүжиглэх байлаа. Харин Бурханы анхааруулгыг сонсоод, ариун айдаст автаж байна” гэж билээ.

Би ч санал нийлэн, толгой дохисон юм.

Паул бүх насаараа өөрийгөө “элч нарын хамгийн бага нь, ариун хүмүүсийн хамгийн бага нь, нүгэлтнүүдийн толгойлогч” гэж дуудсан байдаг. Тэрбээр өөрийгөө хаанаас гарч ирснийг бас түүнд байгаа бүхэн Бурханаас ирсэн гэдэг мөнхийн үнэнийг хэзээ ч мартаагүй ажээ. Тиймээс ч “Үнэндээ хэн чамайг илүү гэв? Чи байгаагаа хүлээж аваагүй гэж үү? Үнэхээр хүлээж авсан юм бол аваагүй юм шиг чи юунд сайрхана вэ?” (1Коринт 4:7) гэж бичсэн билээ. Ийм маягаар Бурханы өмнө даруухнаар амьдарбал, бидний хөдөлмөр талаар болохгүй. Энэ номыг эхлүүлсэн эшлэлийг санаж байна уу? “Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна” (2Иохан 1:8). Биднийг ажил хөдөлмөрийнхөө үр жимсийг бүү алдаасай гэсэндээ “Хүний бардам зан өөрийг нь дорд болгох. Даруу сүнс алдар хүндийг (хүндэтгэлийг) хүлээх (тээх)” (Сургаалт үгс 29:23, тодруулгыг нэмэв) хэмээн анхааруулжээ.

Хүлээх буюу тээх гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Эзэнээс эмээж, даруухнаар амьдарбал, бид хүндэтгэлээ тээнэ ч, өсгөнө ч. Есүс таныг ямар гээчийн том үхлээс чөлөөлснийг хэзээ ч бүү март. Түүнчлэн тантай уулзаж, учирч байгаа хүн нэг бүрийг Есүс яг тийнхүү хайрлаж, үнэлдгийг ч сана. Тиймээс Есүс тэднийг хүндэтгээд, амиа өгсөн шиг, та ч бас тэднийг хүндэтгэбэл, эргээд өөрөө хүндэтгэл, шагнал хүлээн авч, түүнийгээ тээж амьдарна.

Дүгнэлт

Жинхэнэ хүндэтгэл зүрхнээс л төрдийг би ахин дахин, ахин дахин хэллээ. Хүний зүрхийг өөрчлөх хамгийн үр нөлөөтэй арга нь залбирал болой. Бурханы хайр, ариун айдас, хүндэтгэл зүрхэнд чинь тогтмол оршихын төлөө өдөр бүр залбирч яваарай. Номын хуудас маань дуусах боловч, таны зүрхэнд амилсан үг хэзээ ч дуусалгүй, амьдралд тань үр жимс ургуулсаар байна. Тиймээс, амьдралд чинь Бурханы тохиолдуулж байгаа хүмүүсийг гэх чин хүндэтгэлээр зүрхийг тань дүүргэхийн төлөө бүгдээрээ хамтдаа залбирцгаая. Тэднийг хүндэтгэж чадаагүй бол, эхлээд гэмшин залбиръя. За эхэлье:

Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, энэ номоор дамжуулан Үгээ хэлсэнд баярлалаа. Би Таны өмнө ирээд, уучлал эрж байна. Миний амьдралд тохиолдуулсан хүмүүсийг хүндэтгэж чадаагүйг минь уучлаарай. Мөн эрх мэдэлтэй хүмүүсийг хүндэтгэж, тэдэнд захирагдаагүйг минь бас найз нөхөд, надад хариуцуулсан хүмүүсийг тэгээд амьдралдаа таарч явсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг бүгдийг нь үнэлж чадаагүй, хүндэтгэж чадаагүйг минь уучлаарай. Есүсийн цусаар намайг цэвэрлээч. Би онцгойлон хүндэтгэж чадаагүй зарим хүмүүсийнхээ төлөө гэмшиж байна.

Та миний зүрх, сэтгэлийг жинхэнэ, цэвэр хүндэтгэлээр булхаач.

Зүрх маань Эзэнээс эмээхүйгээр болоод тэнгэрийн хайраар цалгиасай гэж би хүсч байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг үнэлж, хайрлаж, хүндэтгэж, дээдэлдэг Таны зүрхийг би өвлөхийг хүсч байна. Би энэ бүхнийг яг одоо итгэлээр хүлээн авч байна. Есүсийн нэрээр залбирлаа. Амень.

Энэ залбирлыг өдөр бүр залбирч, Бурханы Үгэнд орж явбал, та өөрийгөө Бурханы хаанчлалын жинхэнэ онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд болж хувирахыг үзнэ. Та аугаа шагналаа ч хүлээн авна, сэтгэл дүүрэн байдал, чин зүрхний баяр хөөрийг ч эдэлнэ. Хааныхаа төлөө халуун хайраар хүчин зүтгэж яваад тань талархаж байна.

Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен (Иуда 1:24-25).

Хавсралт

Бүгдэд нээлттэй аврал

Бурхан таныг бүрэн дүүрэн амьдраасай гэж хүсдэг. Тэрбээр таныг гэхээр л сэтгэл нь дүрэлздэг бөгөөд амьдралд чинь хандсан төлөвлөгөө зэхсэн байдаг. Гэхдээ хувь тавиландаа хүрэх замыг эхлүүлэх цорын ганц арга нь: Бурханы Хүү Есүс Христээр дамжин авралыг хүлээн авах.

Есүсийн үхэл, амиллаар дамжуулан Бурхан таныг Өөрийнхөө хайртай хүү, охин болгон хаанчлалдаа угтан авах зам гаргажээ. Есүсийн загалмай дээрх тахил нь танд мөнхийн баялаг амьдралыг нээж өгчээ. Аврал нь танд өгсөн Бурханы бэлэг бөгөөд та авралыг юугаар ч олж авч чадахгүй.

Энэ үнэт бэлгийг хүлээн авахын тулд эхлээд Бүтээгчээсээ тусгаар, дураараа амьдарсан нүглээ хүлээн зөвшөөр. Энэ нь таны хийсэн нүглийн хамаг үндэс юм. Энэ гэмшил нь авралыг хүлээн авахад амин чухал хэсэг болно. Үйлс ном дээр таван мянган хүн аврагдсан тэр өдөр Петр үүнийг тодорхой хэлсэн: “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ” (Үйлс 3:19). Хүн бүр нүглийн боол болж төрснийг Бичээс мэдэгддэг. Энэ боолчлол нь санаатай дуулгаваргүй байдлын үлгэр загварыг эхлүүлсэн Адамын нүглээс үндэстэй. Гэмшил нь өөртөө бөгөөд худалчдын эцэг Сатанд дуулгавартай байх явдлаас салж, таны төлөө амиа өгсөн, шинэ Эзэнтэн Есүс Христ рүүгээ дуулгавартай эргэх сонголт юм.

Та Есүсийг Эзэнээ болгож, амьдралынхаа жолоог атгуулах ёстой. Есүсийг “Эзэн” болгоно гэдэг нь өөрт байгаа, өөрийн гэх бүхнээ - амьдралынхаа (сүнс, сэтгэл, биеийнхээ) мэдлийг өгнө гэсэн үг юм.

Тэр таны амьдрал дээр төгс мэдлээ тогтооно. Үүнийг хиймэгц, Бурхан таныг харанхуйгаас чөлөөлж, Хаанчлалынхаа гэрэл, алдарт гаргана. Та үхлээс амь руу нэвтэрч, Түүний хүүхэд болно!

Хэрэв та Есүсээр дамжих авралыг хүлээн авмаар байвал, дараах залбирлыг хэлнэ үү:

Тэнгэрийн Бурхан минь, би өөрийгөө нүгэлтэн бөгөөд Таны зөвт байдлаас хол дутна гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Би нүглээсээ болж мөнхийн шийтгэл авах зохистой хүн. Гэхдээ Та намайг энэ чигээр минь үлдээгээгүйд баярлалаа. Та миний төлөө Өөрийнхөө цорын ганц хайртай Хүү Есүс Христийг илгээсэн. Тэр онгон Мариагаас мэндлэж, миний төлөө миний шийтгэлийг үүрэн Загалмай дээр үхсэн. Гэвч Тэрбээр гурав дахь өдрөө дахин амилуулагдаж, одоо миний Эзэн бөгөөд Аврагч болон Таны баруун гарт залран суугаа гэдэгт би итгэж байна. Тиймээс энэ өдөр би Танаас тусгаар, дураараа байдлаа гэмшин, амьдралаа бүхлээр нь Есүс Эзэний мэдэлд өргөж байна.

Есүс ээ, Та одоо миний Эзэн бөгөөд Аврагч. Сүнсээрээ амьдралд маань ирээд, намайг Бурханы хүүхэд болгооч. Би урьд нь холбоотой байсан харанхуйн юмсаасаа бүрэн салж, өнөөдрөөс эхлэн өөрийнхөө төлөө амьдралгүй, харин нигүүлслээрээ намайг мөнх амьдруулахын төлөө Өөрийгөө өгсөн Таны төлөө амьдарна.

Эзэн минь, баярлалаа. Одоо миний амьдрал бүхлээрээ Таны гарт очлоо. Тиймээс Таны хэлснээр би одоо хэзээ ч ичихгүй. Есүсийн нэрээр. Амень.

Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Өөрийнхөө баярт мэдээг бусад итгэгч нартайгаа хуваалцаарай. Библид итгэдэг нутгийн чуулганд хамрагдаж, шинэ итгэлийг чинь урамшуулан дэмждэг хүмүүстэй холбогдох нь чухал шүү.

Ийнхүү та хамгийн ер бусын аян замд гарлаа. Өдөр өдрөөр Бурхантай илчлэл, нигүүлсэл, нөхөрлөлөөр өсөх болтугай!

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

*Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч
үнэ цэнэтэй байх амьдрал*



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх насгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанаа ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үржүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

АФФАБЕЛ

Өнө мөнх рүү өнгийх цонх
(Сонсдог жүжиг)



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтай, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

Татаж аваарай:  MessengerX.com

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар*



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайртай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчихоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдлоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгдөж, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар
(Монгол бичгээр)*



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүсэлтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг CloudLibrary.org хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

САЙНЫГ ҮҮ, БУРХАНЫГ ҮҮ?

Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

Татаж аваарай:



MessengerX.com

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж, сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

КРИПТОНИТЫГ УСТГА

Хүчийг чинь сорогч зүйлийг устга



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

Цөл дунд зорилготой бөгөөд хүчтэй байх



Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зориллогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ ганцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.

Татаж аваарай:



MessengerX.com

ЭРСЛЭН СЭРЭВ

Сэрээд, ертөнцөө өөрчил



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

Татаж аваарай:



MessengerX.com

Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл



Та Бурханы Хаанчлал дотор үзэгч юм шиг мэдрэмж тээж явна уу? Үйлчилмээр байгаа боловч хэрхэн гэдгээ мэдэхгүй байна уу? Бурханд үйлчлэхийг хүсдэг ч дараах асуултад хэрхэн хариулаахаа мэдэхгүй зөрчилдөж явна уу: Надад хандсан Бурханы хүслийг алдаагүй гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Бурханы Хаанчлалын төлөө надад өгөгдсөн бэлэг авъяас ямар үүрэгтэй вэ? Бурханы өгсөн хүчин чадал дотор амьдарч байгаа гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Би “Чуулганд” бүтэн цагаар үйлчилдэггүй. Тэгэхээр миний дуудлага чухал биш гэсэн үг үү гэх мэт асуулт танд байна уу?

Тэгвэл энэ бүх асуултад энэхүү ном хариулах болно. Бурханаас хүлээн авсан бэлэг авъяасаа үржүүлэн Түүнийг алдаршуулж амьдрахад тань энэ ном чиглүүлж тусална.


Татаж аваарай:



MessengerX.com

X MessengerX

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

Жон Бивэр библийн үгийг маш уран чадварлагаар тайлж өгчээ. Түүний тайлж өгсөн зарим нэг цоо шинэ санаа уншигч нарыг сэрээх нь лавтай.

— USA PUBLISHERS WEEKLY

Христэд итгэдэг хүн Бурханыг хязгаарлахыг хүсэхгүй ч, олонх маань "хүндэтгэл" хэмээх сүнсний нэгэн зарчмыг мэдэхгүйгээсээ болоод амьдралд маань хүрэлцэх Бурханы чадварыг санаандгүйгээр хумидаг байна.

Хүндэтгэл нь манай соёлд мартагдах шахсан ойлголт болсон хэдий ч, энэ нь Бурханы хаанчлалыг бидний амьдралын тал бүр дээр нэвтрүүлэгч гол судас болохыг та энэ номын хуудсаас харах болно.

Хүндэтгэлийн шагнал номдоо Жон Бивэр таныг Бурханы үнэлэмжийн системтэй зэрэгцүүлж, Бурханы ерөөл бүрийг хүлээн авах байр сууринд гаргах хүндэтгэх дуудлагыг хэрхэн хүлээж авахыг зааж өгчээ.

Библийн хөдлөшгүй үнэнийг эдгээр зарчмыг үйл хөдлөл болгох хүчирхэг түүхтэй хавсаргасан энэ ном танд энэхүү мартагдсан чанарыг цоо шинээр харах хараа өгөхөөс гадна хамгийн чухал нь үүнийгээ амьдралынхаа тал бүр дээр хэрэгжүүлэх гал халуун хүсэл тэмүүллийг авчирна.



ЖОН БИВЭР - Олон улсын номлогч, шилдэг борлуулалттай номын зохиолч, Бурханы Үгийг ямар ч найраагүй зоригтой заадаг багш. Жон гэргий Лизатайгаа дэлхийг өөрчлөгч Христийн үнэнч дагалдагч нарыг хөгжүүлэх зорилготой Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үүсгэн байгуулсан болно. Харин тэрбээр Колорадо дахь гэртээ байхдаа гэр бүлтэйгээ өрсөлдөөнтэй картан тоглоом тоглож, Лизаг гольф руу урвуулах гэж оролддог.



MessengerX

Үнэ төлбөргүй материал, видео дамжуулалтыг
MessengerX.com хаягаас хүлээн авна уу.



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэхүү ном нь Зохиолчийн бэлэг,
ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

Илүүг эндээс

